

ЕВАНГЕЛИЙН ҮНДСҮҮД



ЕВАНГЕЛИЙН ҮНДСҮҮД

Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс
хэвлэн гаргав.
Солт Лейк Сити, Юта мужулс
Translation of *Gospel Fundamentals* Mongolian

Зохиогчийн эрх 1997 © Исүс Христийн Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлогчийн Нэгдэл
Хэвлэх эрхийг хуулиар хамгаалсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.
Англи эхийн зөвшөөрөл: 7/91
Орчуулгын зөвшөөрөл: 6/96

АГУУЛГА

Оршил.....	v
Тэнгэр дэх Бурхантай Хамт Бидний Амьдрал Нэгдүгээр хэсэг	
1-р бүлэг Бурхан Орших нь.....	2
2-р бүлэг Бидний Тэнгэр дэх Амьдрал.....	6
3-р бүлэг Бидний Аврагч.....	11
4-р бүлэг Бид Сонгох Эрх Чөлөөтэй.....	16
Бурхны Дэргэдээс Холдох нь Хоёрдугаар хэсэг	
5-р бүлэг Исүс Газар Дэлхийг Бүтээсэн нь.....	23
6-р бүлэг Адам Ева Хоёр.....	27
Бурхантай Харилцах нь Гуравдугаар хэсэг	
7-р бүлэг Ариун Сүнс.....	32
8-р бүлэг Тэнгэрлэг Эцэгтэйгээ Ярилцах нь.....	37
9-р бүлэг Зарлагууд.....	42
10-р бүлэг Судрууд.....	48
Бидний Аврагч, Исүс Христ Дөрөвдүгээр хэсэг	
11-р бүлэг Исүс Христийн Амьдрал.....	57
12-р бүлэг Исүс Христийн Цагаатгал.....	65
Исүс Христийн Евангели Тавдугаар хэсэг	
13-р бүлэг Исүс Христэд Итгэх нь*.....	73
14-р бүлэг Наманчлал.....	78
15-р бүлэг Усан Баталгаа.....	84
16-р бүлэг Ариун Сүнсний Бэлэг.....	89
Исүс Христийн Сүм Зургадугаар хэсэг	
17-р бүлэг Исүс Христийн Дагалдагчид.....	103
18-р бүлэг Исүсийн Зохион Байгуулсан Сүм.....	111
19-р бүлэг Исүс Христийн Сүм Өнөөдөр.....	117
20-р бүлэг Зэрэгтний Хүчийн Зохион Байгуулалт.....	126
21-р бүлэг Зан Үйлүүд.....	134
*Багш нар эдгээр бүлгүүдийг ярилцахдаа нэгээс илүү хичээлийн цагийг зориулж болно.	

Исүс Христийг Дагах нь Долдугаар хэсэг	
22-р бүлэг Дуулгавартай Байх нь.....	149
23-р бүлэг Золиослол	155
24-р бүлэг Хүндэтгэлийн Өдөр.....	163
25-р бүлэг Ариун Явдлын Хууль.....	168
26-р бүлэг Шударга Ёс.....	174
27-р бүлэг Мэргэн Үг.....	178
28-р бүлэг Өглөг Барьц ба Аравтын Татвар.....	183
Гэр Бүлээ Хадгалах нь Наймдугаар хэсэг	
29-р бүлэг Гэр Бүл Бол Чухал.....	191
30-р бүлэг Гэр Бүлийн Гишүүддээ Туслах нь Бидний Үүрэг Мөн .	196
31-р бүлэг Евангелийг Зааж Түгээх нь Бидний Үүрэг Мөн	204
32-р бүлэг Гэр Бүлээрээ Үүрд Хамт Амьдрах нь	209
Исүс Христийн Хоёр Дахь Ирэлт Есдүгээр хэсэг	
33-р бүлэг Исүс Христийн Хоёр Дахь Ирэлт.....	219
34-р бүлэг Мянган Жил.....	224
Үхлийн Дараах Амьдрал Аравдугаар хэсэг	
35-р бүлэг Үхлийн Дараах Амьдрал.....	229
36-р бүлэг Мөнхийн Амьдрал*.....	235
Итгэлийн Тунхаг**	242
**Хичээлүүдийг заах, сэргээн бататгахдаа багш Итгэлийн Тунхагийг ашиглаж болно.	
Мэдвэл Зохих Үгс	244

ОРШИЛ

Энэ ном танд Исүс Христийн Евангелийн үндсэн зарчмуудыг судлах болон бусдад заахад тань тусална. Эдгээр зарчмуудыг мэдсэнээр та амьдралын утга учрыг ойлгож, явал үнэхээр аз жаргалтай байхыг мэдэх болно. Энэхүү номд тайлбарласан зарчмууд үнэн юм. Та эдгээр зарчмуудыг судлаад дотроо тунгаан бодож, залбирваас та өөрөө түүнийг мэдэх бөгөөд Ариун Сүнс энэ бүхэн үнэн болохыг танд гэрчлэх болно.

Та энэ номыг тал бүрийн зорилгоор ашиглаж болох юм. Та өөрөө бие даан суралцахдаа хэрэглэж болно. Мөн яриа бэлтгэхдээ, түүнчлэн бусдад евангелийг тайлбарлахдаа ч ашиглаж болно.

Та энэ номыг гэрийн сургалт болон гэр бүлийн үдшийн цуглаандаа хэрэглэж болно. Хичээл болгоны ард танд зориулсан эцэг эхийн болон багшийн хувьд хүүхдүүдээс хичээлийг хэр ойлгосныг шалгах асуултууд бий.

Энэ номоор хичээл заахдаа нэг бүлэгт нэг хичээлээс илүү цаг зориулж болно. Өөр сэдэвт шилжихийн өмнө сурагчид тань тухайн зарчмыг сайн ойлгосон эсэхийг шалгаж байх хэрэгтэй. Хэрэв танд орчуулагдсан судрууд байвал тус номд буй судрын ишлэлүүдийг үзэж, ярилц.

Багшийн хувьд та энэ номоор нэг жил хичээл заахад 46-50 цагийн хичээл шаардлагатайг анхаарах хэрэгтэй. Бүтэн жил заахаар хичээлээ төлөвлө. Энэ нь 10 буюу түүнээс их хичээлүүд дээр нэг долоо хоногоос илүү хугацаа зарцуулна гэсэн үг юм. Үүнийг ялангуяа 2, 3, 10, 11, 13, 16, 19, 20, 21, 30, 32, 36 дугаар бүлгүүд дээр анхаарах хэрэгтэй. Ингэхдээ та ангийнхаа хэрэгцээг харгалзан шийдэх учиртай.

Жилийн эцэст та энэ номд буй Итгэлийн Тунхагийг хэлэлцэхэд нэг, хоёр цагийн хичээл зарцуулахыг хүсч болох юм. Түүнчлэн хичээлүүдийг давтан бататгахад Итгэлийн Тунхагийг ашиглаж болно.

Эцэг эх болон багш нар аа, та бүхэн эдгээр хичээлүүдийг бэлтгэх, заах явцдаа удирдамж авч байхын үүднээс залбирч байна уу. Тэдгээрийг ойлгож, зааж сургахад тань Ариун Сүнс туслах болно. Мөн гишүүн бүр боломжийн хэрээр бүлгүүдийг урьдчилан уншиж, бусад гишүүдтэй ангид хийх ярилцлагад бэлтгэсэн байвал зохино.

Энэ номын зурагнууд зааж буй зарим сургаал, зарчмуудыг ойлгоход туслах болно.

Хэрэв * тэмдэглэгээ бүхий үг тааралдвал түүний утгыг номын араас харж болно. Мөн өөр бусад үгийг ч ойлгоход тань дөхөм болгох зорилгоор тэнд оруулсан буй.

Энэхүү номын үнэн зүйлсийг сүсэглэн судлахад тань Бурхан таныг ивээх болтугай!

ТЭНГЭР ДЭХ БУРХАНТАЙ ХАМТ БИДНИЙ АМЬДРАЛ

Нэгдүгээр хэсэг



БУРХАН ОРШИХ НЬ

1-р бүлэг

Заримдаа хүмүүс өөрөөсөө: Бурхан байдаг болов уу? Хэрэв Бурхан байдаг бол тэр ямар дүр төрхтэй вэ? Яаж би түүний талаар мэдэж авах вэ? гэж асуух нь байдаг.

Бурхан Байгааг Олон Зүйлс Бидэнд Харуулж Байна

Бид энэ газар дэлхий дээрх олон гайхамшигт зүйлсийг хараад тэдгээрийг хэн нэгэн ухаантай, сайн хүн төлөвлөж, бүтээснийг ухаардаг билээ. Бид шөнө үй олон од гаригууд өөрсдийн байршилдаа үргэлж хөдлөн буйг хараад энэ бүхнийг аугаа хүчит нэгэн бүтээгээд удирдан байна гэж мэддэг. Энэ бүх зүйлсийг бүтээсэн эзэн нь Бурхан юм.

Зарим сайн хүмүүс Бурхныг харж, түүнтэй ярилцжээ. Тэд бидэнд Бурхны дүр төрхийн талаар, мөн тэр биднээр юу хийлгэхийг хүсч байгааг хэлж өгсөн юм. Тэр хүмүүс ариун судруудыг бичсэнээр бид Бурхны тухай мэдэх болсон юм.

Бидний хэн нь ч Бурхан оршин байдаг, тэр бол бид бүхний Тэнгэр дэх Эцэг мөн гэдгийг мэднэ. Тэр өөрийгөө үнэн бодитой болохыг мэдэхэд бидэнд тусалж, ингэснээр бид түүний тухай улам ихийг мэдэх болно.

Ярилцлага

- Бурхан байгааг харуулсан ямар зүйлс байна вэ?

Бидний Тэнгэр дэх Эцэг Төгс Төгөлдөр Хүн Юм

Тэнгэр дэх Эцгийг маань харсан тэр сайн хүмүүс түүнийг үнэн бодитой гэдгийг хэлж өгсөн. Тэр амьдарч байна. Тэр хүн шиг л харагддаг.

Тэнгэр дэх Эцэг маань ямар нэг онгон шүтээн, ан амьтан биш. Тэрээр яс, махнаас бүтсэн бие цогцостой. Түүний бие хүнийх шиг харагдах боловч ялгаатай юм. Түүний бие махбод хэзээ ч үхэхгүй, өвдөхийг мэдрэхгүй, мөн өвчин эмгэг үл тусна.

Тэр мэдрэхүйтэй. Тэрээр баяр баясгалан, уйтгар гунигийг мэдэрнэ. Тэр бүх хүмүүст хайртай бөгөөд тэднийг аз жаргалтай байхыг хүсдэг. Тэр нинжин сэтгэлтэй, үнэнч шударга. Тэрээр үргэлж сайн үйлийг бүтээж, зөвхөн үнэнийг л ярина. Тэр бүгдийг мэдэж, бүгдийг хийж чадна. Түүний гэрэл гэгээ, гоо үзэсгэлэн бидний үзэж харсан юутай ч зүйрлэшгүй аугаа билээ.

Тэнгэр дэх Эцэг маань бидний бишрэн шүтэх цорын ганц бодгаль мөн. Тэрээр тэнгэр хэмээх орчлонд амьдардаг. Энэ нь газар дэлхийгээс илүү сайхан газар билээ.

Ярилцлага

- Бурхан ямар хүн бэ?
- Бурхан биднээс ямар ялгаатай вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Хайр Энэрлээ Бидэнд Олон Байдлаар Үзүүлдэг

Тэнгэр дэх Эцэг маань өөрийн хүчин чадлыг бидэнд туслахад зориулж байдаг. Түүний хүү Исүс Христ тэнгэр газрыг бүтээсэн юм. Тэр түүгээр нар, сар, од эрхсийг бүтээлгэжээ. Мөн түүнд газар дэлхий дээр ургамал, ан амьтдыг бий болгохыг даалгасан байна. Тэнгэр дэх Эцэг маань энэ бүгдийг бидэнд хайртай учраас хийсэн билээ. Биднийг сайн сайхан, аз жаргалтай байхад маань туслахыг тэр хүсдэг.

Тэнгэр дэх Эцэг маань өөрийн мэдлэгийг бидэнд туслахад зориулдаг. Тэр урьд болж өнгөрсөн, одоо болж буй, мөн ирээдүйд болох бүх зүйлийг мэднэ. Тэрээр бид бүгдийн бодол санааг мэднэ. Тэр нэгэнт бүгдийг мэдэх учраас бидний аз жаргалтай байхад юу хэрэгтэйг бас мэддэг юм. Үнэхээрийн аз жаргалтай байа гэвэл бид сайн хүмүүс байх хэрэгтэйг тэр мэднэ. Тэр бидэнд хайртай учраас биднийг сайн хүмүүс байхад маань туслахыг хүсч байна.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хайр энэрлээ хэрхэн үзүүлдэг вэ?
-

Тэнгэр дэх Эцэг Маань Биднээс Өөрийг нь Танин Мэдэхийг Хүсдэг

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хайртай учраас бидэнд амьдрал, дээр нь амьдрах үзэсгэлэнт сайхан газар дэлхийг өгсөн билээ. Тэр биднийг хийх ёстой зүйлсээ мэдэж байхыг хүсдэг. Бид түүнийг танин мэдэх болно гэдгийг тэр бидэнд амласан юм.

Дараах зүйлс бидэнд Тэнгэр дэх Эцгийнхээ тухай улам ихийг мэдэхэд тусална.

1. Бид түүний бүтээсэн дэлхий ертөнцийг хараад түүнд талархаж болно.
2. Бид Тэнгэр дэх Эцэг маань бодитой бөгөөд бидэнд хайртай гэж итгэж болно.
3. Бид сайн хүмүүсийн Тэнгэр дэх Эцгийн маань тухай бичсэн зүйлсийг уншиж болно.
4. Бид түүний биднээс хүсч буй бүх зүйлсийг сурч, хийж болно.
5. Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ ярьж, өөрийнх нь тухай мэдэж авахад бидэнд туслахыг хүсч болно.

Тэнгэр дэх Эцгийнхээ тухай мэдэх нь бидний амьдралд тустай. Түүнийг мэдэх нь бидэнд аз жаргалтай, айх аюулгүй байхад маань тусална. Тэрээр сайн санаатай бөгөөд бидэнд муу зүйлийг огтхон ч хийхгүй. Түүний биднээр хийлгэхийг хүсч буй зүйлсийг бид мэдэж авна. Бид түүний тусламжийг хэрхэн гуйхаа мэдэх болно. Бид илүү сайн, аз жаргалтай хүмүүс болж чадна.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцгээ танин мэдэж, ойлгохын тулд бид юу хийж болох вэ?
- Тэнгэр дэх Эцгээ мэдэх нь бидэнд ямар тустай вэ?

Лавламж

Бурхан Байгааг Олон Зүйлс Бидэнд Харуулж Байна

- Үйл явдал 7:55-56 (Ариун хүн Бурхныг харжээ.)

Бидний Тэнгэр дэх Эцэг Төгс Төгөлдөр Хүн Юм

- Үүсэл гарал 1:26-27 (Бурхан хүнийг өөртэйгөө адилаар бүтээжээ.)

Тэнгэр дэх Эцэг Маань Хайр Энэрлээ Бидэнд Олон Байдлаар Үзүүлдэг

- Үүсэл гарал 1:1-25 (Бурхан тэнгэр, газар, түүн дээр орших бүгдийг бүтээсэн.)
- Лук 12:6-7 (Бурхан өөрийн бүтээсэн бүх юмст анхаарал тавьдаг.)

Тэнгэр дэх Эцэг Маань Биднээс Өөрийг нь Танин Мэдэхийг Хүсдэг

- Дэлгэрэнгүй хууль 4:29 (Бурхныг мэдэхийг хүссэн хүмүүс түүнийг мэдэх болно.)
- Жон 17:3 (Бид Бурхныг танин мэдэж чадна.)
- 1 Жон 2:3 (Хэрэв бид Бурхны үгийг дагавал түүнийг мэдэж болно.)
- Мосайяа 4:9 (Бид Бурханд итгэх хэрэгтэй.)

БИДНИЙ ТЭНГЭР ДЭХ АМЬДРАЛ

2-р бүлэг

Энэ ертөнцөд мэндлэхээсээ өмнө бид хаана амьдарч байсан бэ? Бид тэнд юу хийж байв?

Бид Бүгдээрээ Тэнгэр дэх Эцгийн Хүүхдүүд

Бид энэ газар дэлхий дээр мэндлэхийнхээ өмнө тэнгэрт амьдарч байжээ. Тэнгэр дэх гэр орон маань бидний мэдэх газар дэлхийн ямар ч зүйлээс хавгүй илүү гайхамшигтай, сайхан байлаа. Тэнд бид бүгдээрээ нэгэн гэр бүл байсан юм. Бид аз жаргалтай, бие биенээ хайрладаг байлаа. Тэнгэр дэх Эцэг маань бидний сүнсний эцэг учир бид энэ шалтгаанаар түүнийг үргэлж Тэнгэрлэг Эцэг хэмээн нэрлэдэг юм. Тэр бидний Эцэг учраас биднийг хайрлаж, халамжилж байдаг билээ.

Энэ газар дэлхий дээр амьдарч буй хүн бүр тэнгэрт бидний ах, эгч, дүү маань байсан. Манай тэнгэрийн гэр бүлийн ууган хүү нь *Исүс Христ байлаа. Тэр бидний том ах байсан юм.

Бид тэнгэрт амьдарч байхдаа одоогийнх шигээ яс, махнаас тогтсон биетэй байсангүй. Бид сүнснүүд байлаа. Сүнс хүнтэй адил дүрс хэлбэртэй. Сүнс байхдаа бид хоорондоо ярьж, хөдөлж, сонголт хийж, мөн сайн муугийн ялгааг мэдэх чадвартай байв.

Тэнгэрт бид цөмөөрөө адилхан байсангүй. Яг л одоогийнх шигээ өөр хоорондоо ялгаатай байсан юм. Бид өөр өөр хүсэл эрмэлзэл, авьяас чадвартай байлаа.



Тэнгэр дэх Эцэг маань бидэнд энэ дэлхийн хаана ч байхгүй гайхамшигтай сайхан тэнгэрлэг гэр орныг өгсөн билээ.

Ярилцлага

- Бидний тэнгэрийн гэр орон маань ямар байсан бэ?
- Бидний Эцэг хэн байсан бэ?
- Бидний хамгийн том ах хэн байсан бэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бид Түүнтэй Адил Болж Чадахыг Мэдэж Байв

Тэнгэр дэх Эцэг маань бидний сүнсний Эцэг байсан учраас биднийг маш сайн мэддэг байлаа. Тэр бидэнд хайртай байсан юм. Тэрээр бид түүний мэдэж буй зүйлсийг хийх болон өөртэй нь адил болох чадварыг түүнээс авсан гэдгийг мэдэж байв. Тэр биднийг үргэлж түүн шиг сайн хүмүүс байхыг хүсдэг. Түүнтэй адил болох чадварыг маань дээшлүүлэхэд туслахыг тэр хүсч байдаг юм.

Ярилцлага

- Бид Тэнгэр дэх Эцгийнхээ мэддэг зүйлсийг сурч, түүнтэй адил болж чадах уу?
- Та тэнгэрт өөрийн Эцэгтэй юм байна гэдгээ мэдэхэд танд ямар сэтгэгдэл төрж байна вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Туслахаар Төлөвлөгөө Зохиов

Тэнгэрт байхдаа бид олон зүйлийг сурч, чадлынхаа хэрээр өөрсдийгөө хөгжүүлж байсан ч тэнд бидний сураагүй, хийгээгүй зүйлс бас байсан юм. Биднийг улам ихийг сурч, мэдэхэд маань зориулж Тэнгэр дэх Эцэг маань нэгэн төлөвлөгөө зохиожээ.

Тэр биднийг тэнгэрт дуудан цуглуулав. Бид бүгд тэнд байлаа. Тэрээр бидний суралцахад туслах төлөвлөгөөгөө тайлбарлаж, хэрэв бид түүний төлөвлөгөөг дагавал түүнтэй адил болж чадна гэлээ.

Тэнгэр дэх Эцэг маань дээр нь бид хэсэг хугацаагаар амьдрах газар дэлхийг бүтээж өгөхөө хэлэв. Тэр дэлхий дээр бид урьд нь түүнтэй хамт тэнгэрт амьдарч байснаа үл санах болно. Бид сайныг эсвэл мууг сонгох чадвартай байна. Энэ нь бид Тэнгэр дэх Эцгээсээ холдоод түүнийг дагах эсэхийн маань шалгуур болох юм.

Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөө ёсоор бид яс, махнаас бүтсэн биеийг хүлээн авах болно. Энэхүү бие махбод нь бидэнд түүний мэддэгийг мэдэж, хийдгийг хийхэд хэрэгтэй юм. Хожим нь бид

үхэж, бидний сүнс бие махбодыг маань орхин одох болно. Гэвч сүнс маань биетэйгээ эргэн нэгдэх бөгөөд бид дахин хэзээ ч үхэхгүй. Тэнгэр дэх Эцгийн биднийг хий гэсэн зүйлсийг биелүүлсэн тэр хүмүүс түүнтэй мөнхөд хамт амьдрахаар буцаж ирэх болно.

Бид бүгд газар дэлхий дээр өвчин эмгэг, газлан зовлон, үхэл зэрэг бэрхшээлүүдтэй тулгарна гэдгээ мэдсэн юм. Гэвч тэр бүгдээс суралцах болно гэдгийг бид ойлгож байлаа. Тэдгээр бэрхшээлүүд бидэнд бие биенээ хайрлаж, туслахыг зааж өгөх учиртай.

Тэнгэр дэх Эцэг маань хүн бүрийн газар дэлхийд мэндлэх орон зай, цаг хугацааг нь товлох болно. Тэр биднийг дэлхийн аль газар нутагт илгээвэл өөрт хэрэгтэй зүйлсээ сурч мэдэж чадахыг маань мэдэж байлаа. Бид бүгдээрээ олон төрлийн зүйлийг хийх бололцоотой болно. Тэнгэр дэх Эцэг маань биднийг сайн үйл хийж, өөрт нь эргэн ирэхийг хүсч байсан юм. Гэхдээ бидэнд хэзээ ч ямар нэгэн зүйлийг хийхийг үл албадах болно.

Бидний зарим нь түүнийг дагахыг сонгох байв. Хэрэв бид түүнийг дагавал түүнтэй улам илүү адил болж, түүнтэй хамт амьдрахаар буцан ирнэ.

Тэнгэр дэх Эцгийнхээ бидэнд зориулсан энэ төлөвлөгөөг сонсоод бид маш их баяртай байлаа. Бид сурч мэдэж, өөрсдийгөө хөгжүүлэх боломжтой болохыг хүсч байв. Газар дэлхий дээр амьдарсан хүн болгон түүний төлөвлөгөөний дагуу амьдрахаа зөвшөөрдөг юм.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцгийн маань бидэнд зориулсан төлөвлөгөө юу байсан бэ?
- Бид яагаад тэнгэр дэх орон гэрээ орхин явах хэрэгтэй болов?
- Тэнгэр дэх Эцэг маань биднийг газар дэлхий дээр юу хийхийг хүсч байна вэ?

Лавламж

Бид Бүгдээрээ Тэнгэр дэх Эцгийн Хүүхдүүд

- Лук 24:39 (Сүнс яс, махан бие цогцосгүй байдаг.)
- Еврейчүүд 12:9 (Бурхан бол бидний сүнсний Эцэг юм.)

Тэнгэр дэх Эцэг Маань Бид Түүнтэй Адил Болж Чадахыг Мэдэж Байв

- Матвей 5:48 (Исүс биднийг Тэнгэр дэх Эцэг шигээ болохыг хүссэн юм.)
- 3 Нифай 12:48 (Исүс биднийг өөр шигээ, мөн Бурхан эцэг шигээ төгс төгөлдөр болохыг хүссэн юм.)
- 3 Нифай 27:27 (Бид Исүсийн жишээг дагаж, түүнтэй адил болох хэрэгтэй.)

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Туслахаар Төлөвлөгөө Зохиов

- Жон 14:2-3 (Тэнгэр дэх Эцэг маань биднийг түүн дээр эргэн ирж чадна гэж хэлсэн.)
- Үйл явдал 17:26 (Тэнгэр дэх Эцэг маань биднийг энэ дэлхий рүү өөрийн төлөвлөгөөний дагуу тодорхой газар нутаг, цаг хугацаанд илгээсэн.)
- 1 Нифай 17:36 (Тэнгэр дэх Эцэг маань өөрийн хүүхдүүдэд амьдран суух газар дэлхийг нь бүтээж өгчээ.)
- 2 Нифай 9:13; Алма 42 (Бурханд бидэнд зориулсан төлөвлөгөө бий.)

БИДНИЙ АВРАГЧ

3-р бүлэг

Биднийг Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиход удирдан залах тэр хүн хэн бэ? Яагаад бид түүнийг дагах ёстой вэ?


Бидэнд Удирдагч Хэрэгтэй Байлаа

Тэнгэр дэх Эцэг маань биднийг энэ дэлхийд байх үедээ түүнтэй хамт амьдарч байснаа санахгүй гэдгийг мэдэж байв. Түүн дээр эргэн очихын тулд юу хийх ёстойгоо бид мэдэхгүй байх болно. Мөн тэр биднийг нүгэл үйлдэхийг мэдэж байлаа. Өөрсдийн гэм нүглээсээ болж бид түүнээс үүрд хагацах шийтгэлийг хүлээх болно. Ингээд биднийг үхэхийн цагт яс, махан бие цогцос маань бидэнд дахин хэзээ ч үл олдох байлаа.

Эдгээр асуудалтай тулгарахад бидэнд туслах хэн нэгэн хүн хэрэгтэй байсан юм. Энэ хүн бидэнд Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очихын тулд юу хийх учиртайг зааж өгөх байв. Тэр бидэнд гэмт үйлдлээ даван туулахад маань туслах болно. Үхсэнийхээ дараагаар бие махбодоо дахин олж авах арга замыг тэр бэлтгэх байлаа. Энэ хүн бидний Аврагч хэмээн нэрлэгдэх болно. Зөвхөн тэр л биднийг хийсэн гэмт үйлийн маань шийтгэлээс аварч чадна. Зөвхөн тэр л бидэнд Тэнгэр дэх Эцгээ хэрхэн дуулгавартай дагахыг сурахад туслах байв. Зөвхөн тэр л үхлийн дараа бие махбодоо дахин олж авах боломжийг нээж өгөх байлаа.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэг маань энэ дэлхий дээр бидэнд тулгарах ямар бэрхшээлүүдийг мэдэж байсан бэ?
- Яагаад бидэнд туслах Аврагч хэрэгтэй болсон бэ?



Тэнгэр дэх Эцгийн маань заавраар Исус Христ газар дэлхийг бүтээв.

Тэнгэр дэх Эцэг Маань Исүсийг Бидний Аврагчаар Сонгов

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хайртай учраас бидэнд тусламж хэрэгтэй болохыг мэдэж байлаа. Хэрэв бид бие махбодоо эргүүлэн олж авч чадахгүй, мөн түүн дээр эргэн очих боломжгүй болбол биднийг ихэд харуусах болно гэдгийг тэр мэдэж байсан юм. Бидэнд туслах хэн нэгэн хэрэгтэй байв. Тэнгэр дэх Эцэг маань хэн нэгнийг бидний Аврагч болохыг хүслээ. Ах дүүсийн маань хоёр нь Аврагч болохоор санал гаргав.

Бидний хамгийн том ах Исүс Христ өөрийг нь илгээхийг Тэнгэр дэх Эцгээс маань хүсэв. Тэрээр түүний төлөвлөгөөг дагана гэлээ. Тэр газар дэлхийд ирж, Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очихын тулд хийх хэрэгтэй зүйлсийг бидэнд зааж сургах болно. Тэр бидний хийсэн муу үйлийн төлөөнөөс үхэх болно. Тэр мөн бидэнд үхлийн дараа дахин амьдрах боломжийг олгох болно. Тэр бидэнд Тэнгэр дэх Эцгээ дагах эсэхээ өөрсдөө сонгохыг зөвшөөрнө.

Юу хийхээ өөрсдөө сонгох нь бидэнд чухал гэдгийг Исүс мэдэж байлаа. Хэрэв хэн нэгэн хүн биднийг дуулгавартай байлгах гэж хүчлэх юм бол бид сурч мэдэж, Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болж чадахгүй байх билээ. Тэнгэр дэх Эцгийг маань бүх алдар суу, хүндэтгэлийг хүртэж байхыг Исүс хүссэн юм.

Сатан гэгдэх өөр нэгэн ах маань түүнийг Бидний Аврагчаар сонгохыг мөн Тэнгэр дэх Эцгээс маань хүслээ. Тэрээр газар дэлхийд ирж, бидний хийх ёстой зүйлсийг хүчээр хийлгэнэ гэж хэлэв. Бидний хэн нь ч үл хаягдах болно. Тэр бидэнд өөрсдөө сонголт хийхийг зөвшөөрөхгүй гэлээ. Тэрээр бидний нүглийн золиос болж үхэхийг хүссэнгүй. Шагналд нь тэрээр Тэнгэр дэх Эцгийн маань бүх алдар суу, нэр төрийг авахыг хүсч байв. Сатан бидний Бурхан байхыг хүсчээ.

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хайртай учраас Исүсийг бидний Аврагчаар сонгов. Ийм учраас Исүсийг ямагт Исүс Христ гэж нэрлэдэг юм. Христ гэдэг нь Аврагч болохоор Тэнгэр дэх Эцгээр маань сонгогдсон гэсэн утгатай. Тэнгэр дэх Эцэг маань Сатанаас илүүтэйгээр Исүсийг сонгосны учир нь тэр биднийг өөрсдөө сонгох эрхээ алдахыг хүсээгүй юм. Тэрээр биднийг аливаа сайн үйлийг хэн нэгэн хүнээр албадуулж биш, харин өөрсдийн хүслээр хийх ёстой гэдгийг мэдэж байв.

Ярилцлага

- Исүс бидний төлөө юу хийхийг хүссэн бэ?
- Сатан юу хийхийг хүссэн бэ?
- Яагаад Тэнгэр дэх Эцэг маань Исүсийг бидний Аврагчаар сонгосон бэ?

Исүс Бол Бидний Аврагч, Удирдагч Мөн

Тэнгэр дэх Эцгийн Исүсийг сонгосон нь Сатаны уур хилэнг ихэд хүргэжээ. Тэрээр тэнгэрт байсан сүнснүүдийн гуравны нэгийг өөрийгөө дагахыг ятгаж чадав. Тэд хамтдаа Исүс болон түүний дагалдагчдын эсрэг тэмцжээ. Тэд Тэнгэр дэх Эцгээр маань Сатаны төлөвлөгөөг хүчээр хүлээн зөвшөөрүүлэхийг хүсч байв. Тэнгэр дэх Эцэг маань Сатаныг дагалдагчдынх нь хамтаар тэнгэрээс хөөн зайлуулсан юм.

Сатан болон түүний дагалдагчид хэзээ ч яс, махан бие цогцсыг олж авч чадахгүй. Тэд хэзээ ч эргэн ирж, Тэнгэр дэх Эцэгтэй маань хамт амьдарч чадахгүй. Зөвхөн Исүсийг өөрсдийн Аврагч хэмээн хүлээн зөвшөөрсөн тэр л хүмүүс яс, махан бие цогцсыг хүлээн авах болно.

Бид яс, махан биетэй байгаа учраас Исүсийн дагалдагчид байхаар хүлээн зөвшөөрснөө мэдэж байна. Бид тэнгэрт зөв зүйлийг сонгосон. Энэ дэлхийд ч зөвийг сонгохоо үргэлжлүүлэх хэрэгтэй. Бид Исүсийг дагах ёстой. Ганцхан тэр л бидэнд хэрхэн Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очихыг зааж өгч чадна. Тэр бидэнд хийж буй буруу үйлдлээ даван туулж, Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болтлоо сайн үйлийг хийхэд маань тусалж чадна.

Тэнгэр дэх Эцэг маань биднийг Исүсийг дуулгавартай дагахыг хүсч байна. Исүс бидэнд аливаа зүйлсийг хийх өөрийн замыг үргэлж заах болно гэдгийг тэр мэднэ. Тийм учраас Исүсийг дуулгавартай дагана гэдэг маань Тэнгэр дэх Эцэгтээ дуулгавартай байна гэсэн үг юм. Мөн Исүсийн зарлиг тушаал бол Тэнгэр дэх Эцгийн маань зарлиг тушаал юм.

Ярилцлага

- Бид Исүсийг өөрсдийн Аврагчаар сонгосноо хэрхэн мэддэг вэ?
- Тэнгэр дэх Эцэгтээ хэрхэн очихыг маань үзүүлж чадах ганц хүн хэн бэ?
- Бид яагаад Исүсийг дагах ёстой вэ?

Лавламж

Бидэнд Удирдагч Хэрэгтэй Байлаа

- Жон 14:6 (Исүс бол бидний Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очихын тулд дагах ёстой хүн маань билээ.)
- 1 Питер 2:21 (Бид Исүс Христийн мөрөөр явах ёстой.)
- 2 Нифай 31:13, 16 (Аврагчийнхаа жишээг дагавал бид аврагдах болно.)

Тэнгэр дэх Эцэг Маань Исүсийг Бидний Аврагчаар Сонгов

- 1 Жон 4:14 (Тэнгэр дэх Эцэг маань Исүсийг дэлхий ертөнцийн Аврагч болгохоор сонгов.)
- 2 Нифай 9:6-26 (Исүс бидний төлөө үхсэн юм.)
- 3 Нифай 27:13-14 (Исүс Христ бидний Аврагч болохоор газар дэлхийд ирэв.)

Исүс Бол Бидний Аврагч, Удирдагч Мөн

- Матвей 1:21 (Исүс биднийг нүглээс маань аврахаар ирсэн юм.)
- 3 Нифай 11:10-11 (Исүс Христ хүн төрөлхтний нүглийн өмнөөс зовж шаналсан юм.)
- 3 Нифай 18:16 (Исүс бидэнд дагах үлгэр дуурайл үзүүлсэн.)
- 3 Нифай 27:21 (Исүс бидэнд юу хийхийг маань үзүүлсэн.)

БИД СОНГОХ ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ

4-р бүлэг

Бид бүгдээрээ өдөр болгон сонголт хийж байдаг. Тэнгэр дэх Эцэг маань бидэнд өөрсдийнхөө төлөө сонголт хийх эрхийг олгосон билээ. Бид яагаад зөв сонголт хийхийг хичээх ёстой вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Сонголт Хийх Эрхийг Олгодог

Бид тэнгэрт сонголт хийх эрх чөлөөтэй байжээ. Бид Исүсийг эсвэл Сатаныг дагаж болох байлаа. Тэнгэр дэх Эцгийн маань хүүхдүүдийн олонх нь Исүсийг дагахаар сонгосон юм. Бусад нь Сатаныг дагахаар сонгов. Тэнгэр дэх Эцэг маань хүн бүрт өөрөө сонголт хийхийг зөвшөөрсөн юм.

Мөн Тэнгэр дэх Эцэг маань бидэнд газар дэлхий дээр ч өөрсдөө сонголт хийхийг зөвшөөрсөн юм. Биднийг энэ дэлхийд ирэхэд тэр өөртэй нь хамт амьдарч байсныг мартуулсан. Бид түүнтэй хамт биш байхдаа өөрсдөө сонголт хийхэд суралцах хэрэгтэй байв.

Ярилцлага

- Танаар ямар нэгэн зүйлийг хийлгэхээр албадахад танд ямар санагддаг вэ?
- Хэн нэгэн хүн хийх гэж хүсч буй зүйлээ сонгохыг тань зөвшөөрөхөд танд ямар санагддаг вэ?

Тэнгэр дэх Эцгийн Маань Төлөвлөгөө Зөвхөн Биднийг Сонголт Хийх Эрх Чөлөөтэй Байхад л Хэрэгжинэ

Сайн муу зүйлсийн аль аль нь байх газар дэлхийд биднийг илгээх нь Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөөний нэг хэсэг байлаа. Тэр биднээс зөв сонголт хийхийг хүсч байдаг. Сатан бидэнд муу муухайг

сонгохыг ятгахыг хичээж байна. Бид сайн муугийн хооронд сонголт хийх эрх чөлөөтэй.

Бид зөв сонголт хийснээр Тэнгэр дэх Эцгийнхээ биднийг хийгээсэй хэмээн хүсч буй зүйлсийг хийх илүү боломжтой болдог. Тэдгээр зүйлсийг хийснээр бид түүнтэй улам илүү адил болно. Бид өөрсдийнхөө хувьд хамгийн илүү сонголтыг мэдэж авна. Биднийг баяртай, эсвэл гунигтай болгодог зүйлсийг бид илүү сайн ойлгоно.

Хэрэв бид өөрсдийнхөө төлөө сонголт хийж чаддаггүй байсан бол Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болох боломжгүй юм. Бид хамгийн сайн сонголт юу болохыг мэдэж авч чадахгүй байх байлаа. Мөн Тэнгэр дэх Эцэгтээ түүнийг хайрладаг хийгээд түүнийг дагахыг хүсч буйгаа үзүүлж чадахгүйсэн билээ.

Ярилцлага

- Бид яагаад сонголт хийх эрхтэй байх ёстой вэ?

Тэнгэр дэх Эцгээ Дагахыг Сонгосноор Бид Аз Жаргалтай Байх Болно

Зөв сонголт бидэнд сайн үр дүн, муу сонголт хор уршиг авчирдаг. Хэрэв бид Тэнгэр дэх Эцгээ дагахаар сонговол бид илүү аз жаргалтай, сайн хүмүүс болох юм. Хэрэв түүнийг үл дагахаар сонговол бидний сэтгэл гунигтай байж, бид өсөн дэвжиж чадахгүй.

Бид зөв сонголт хийснээрээ илүү аз жаргалтай болж буйгаа харж байна. Бид улам их сайн зүйлсийг хийх хэрэгтэйгээ ухаардаг. Сайн зүйлийг сонгосноор аз жаргалтай болж буйгаа хараад бид улам их зөв сонголт хийх, сайн хүмүүс болохыг хүсдэг. Үр дүн нь сайн байхыг мэдэх учраас бид сонголтыг амархан хийж чадна. Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болоход маань хэрэгтэй зүйлсийг бид сурч, хийж байна.

Бид буруу сонголт хийчихээд түүндээ харамсаж, ичдэг. Хэрэв бид буруу үйл хийсээр байх юм бол Сатан биднийг эрхшээлдээ оруулж эхэлнэ. Ийнхүү зөв сонголт хийхэд улам хэцүү болж, Тэнгэр дэх Эцгийнхээ төлөвлөгөөг дагахаа больдог.

Ярилцлага

- Өөрийнхөө хийж байсан зарим сонголтыг бодно уу. Тэдгээрийн үр дагавар ямар байсан бэ?

- Та аз жаргалтай байх, мөн Тэнгэр дэх Эцэг дээрээ эргэн очиж амьдрахын тулд ямар сонголт хийж чадах вэ?
- Зөв сонголт хийх нь цаашид зөвийг сонгоход тань яаж тусалдаг вэ?
- Буруу сонголт хийх нь цаашид сайн сонголт хийхэд тань ямар саад учруулдаг вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Зөв Сонголт Хийхэд Тусална

Тэнгэр дэх Эцэг маань биднийг сайн сонголт хийхийг хүсдэг бөгөөд чухам ингэснээр бид түүний мэддэгийг мэдэж, хийдгийг хийж, түүнд байгаа бүхнийг өөртөө байлгаж чадах юм. Хэрэв бид зөвийг сонговол аз жаргалтай байж, түүн дээр эргэн очиж амьдрах болно гэдгийг тэр мэднэ.

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд зөв сонголт хийхэд туслахыг хүсч байдаг. Түүний тусламжтайгаар бид өөрийнх нь хүссэн болгоныг гүйцэтгэх тийм сонголт хийж чадна. Хэрэв бид түүнд хандан гуйваас Сатаны уруу таталтыг эсэргүүцэхэд маань тэрээр туслах болно. Тэр бидэнд зөв сонголт хийх хүч тэнхээг өгнө. Тэр бидэнд түүний төлөвлөгөөг дагаж, түүнтэй адил болоход маань тусална.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэг маань яагаад биднийг зөв сонголт хийхийг хүсдэг вэ?
- Тэр бидэнд зөв үйл хийхийг хүчээр тулгах уу? Яагаад?

Лавламж

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Сонголт Хийх Эрхийг Олгодог

- Жон 14:15 (Хэрэв бид Исүст хайртай бол түүний зарлигийг дагана.)
- 2 Нифай 2:27-29 (Бид Исүсийг дагахаа сонгох эрх чөлөөтэй.)
- Хеламан 14:30-31 (Тэнгэр дэх Эцэг маань биднийг сайн муугийн хооронд сонголт хийх эрх чөлөөтэй болгожээ.)

Тэнгэр дэх Эцгийн Маань Төлөвлөгөө Зөвхөн Биднийг Сонголт Хийх Эрх Чөлөөтэй Байхад л Хэрэгжинэ.

- 2 Нифай 2:11 (Сайн юм болгоны эсрэг түүнтэй тэмцэлдэх муу зүйл оршино.)

- Алма 41:3-5 (Хэрэв бид сайн үйл хийвэл Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж чадна.)
- 3 Нифай 27:14-15 (Юу хийхээр сонгосноор маань биднийг шүүх болно.)

Тэнгэр дэх Эцгээ Дагахыг Сонгосноор Бид Аз Жаргалтай Байх Болно.

- 2 Нифай 9:18 (Тэнгэр дэх Эцэгт маань итгэж байсан хүн бүр аугаа их баяр цэнгэлийг амсах болно.)
- Мосайя 2:41 (Тэнгэр дэх Эцгийн маань зарлигийг дагадаг хүмүүс адис ивээлийг нь хүртдэг тул аз жаргалтай байдаг.)


Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Зөв Сонголт Хийхэд Тусална

- Дуулал 5:12 (Сайн хүмүүсийг Тэнгэр дэх Эцэг маань ивээх болно.)
- Дуулал 25:9 (Сайныг сонгосон хүмүүст Тэнгэрт дэх Эцэг маань тусалдаг юм.)
- Ромынхан 12:9 (Бид сайн үйл хийх ёстой.)
- 1 Коринфынхан 10:13 (Тэнгэр дэх Эцэг маань биднийг уруу татах хүч бидний эсэргүүцлээс илүү байхыг зөвшөөрөхгүй.)
- Моронай 7:28 (Тэнгэр дэх Эцэгт маань итгэдэг хүмүүс сайныг хийхийг хүсч байдаг.)

БУРХНЫ ДЭРГЭДЭЭС ХОЛДОХ НЬ

Хоёрдугаар хэсэг





Исус бидэнд үзэсгэлэнт сайхан дэлхийг бүтээж өглөө.

ИСҮС ГАЗАР ДЭЛХИЙГ БҮТЭЭСЭН НЬ

5-р бүлэг

Хэн газар дэлхийг бүтээсэн бэ? Юуны учир бүтээсэн бэ?

Бидэнд Дэлхий Хэрэгтэй Байлаа

Биднийг тэнгэрт байхад Тэнгэр дэх Эцгийн маань тайлбарлаж өгсөн төлөвлөгөөний нэг хэсэг нь тодорхой хугацаагаар тэнгэрийг орхиж явах байсан юм. Бидэнд түүний дэргэдээс холдож, яс, махан бие цогцсыг олж авч, зөв сонголт хийх эсэхээ шалгуулах тийм газар хэрэгтэй болов. Түүнд энэхүү газрыг бүтээх хэн нэгэн хэрэгтэй байлаа. Тэрээр үүнийг гүйцэтгүүлэхээр Исүсийг сонгосон юм.

Ярилцлага

- Бурхан яагаад бидэнд газар дэлхийг бүтээж өгөхөөр төлөвлөсөн бэ?

Исүс Газар Дэлхийг Бүтээсэн нь

Исүс газрыг бүтээв. Тэр өдөр, шөнийг бий болгож, нар, сар, од мичдийг бүтээлээ. Тэрээр усыг хуурай газраас тусгаарлаж, далай тэнгис, нуур, гол горхийг бий болгов. Тэр өвс ногоо хийгээд өөр олон янзын ургамал тарьжээ. Үүнийхээ дараа тэрээр дэлхийд ан амьтан, загас, шувууд болон хорхой шавьжийг суурьшууллаа. Исүс энэ бүгдийг хийж дууссаны дараа газар дэлхий дээр хүмүүс амьдрахад бэлэн болов.

Ингээд Тэнгэр дэх Эцэг маань эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв. Эрэгтэйг нь Адам, эмэгтэйг нь Ева хэмээн нэрлэжээ. Тэр хоёр Тэнгэр дэх Эцгийн маань адил яс, махнаас бүрдсэн биетэй байлаа. Газар дэлхий болон түүн дээрх амьд байгалийг бүтээсэн энэ бүх

ажлыг Бүтээлт гэж нэрлэдэг юм. Тэнгэр дэх Эцэг маань өөрийнх нь Исүст зааварласны дагуу бий болсон дэлхий ертөнц, түүн дээрх бүх юмсад нэн сэтгэл ханамжтай байлаа.

Ярилцлага

- Адам Ева хоёр Бурхны бүтээсэн бусад юмсаас ямар ялгаатай байсан бэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Хайртай Учраас Газар Дэлхийг Бүтээсэн Юм

Бид одоо Тэнгэр дэх Эцгийнхээ Исүст зааварлаж бүтээсэн үзэсгэлэнт сайхан дэлхийд амьдарч байна. Нар бидэнд илч дулаан, гэрэл гэгээгээ хайрлаж, хур бороо ургамал ногоог төлжүүлж, хүн амьтныг ундаалж байдаг билээ. Газар дээрх амьтан, ургамал бид бүхнийг хувцас, хоол хүнсээр хангаж байна.

Энэ бүгдийг Исүс бидний төлөө, Тэнгэр дэх Эцгийнхээ удирдлага дор хийсэн юм. Түүнийг бидний төлөө энэ бүх зүйлийг хийснийг хараад Тэнгэр дэх Эцэг маань биднийг хайрлан халамжилдгийг бид ойлгоно.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцгийн маань бидэнд зориулан бүтээсэн зарим зүйлийг эргэцүүл.
- Тэнгэр дэх Эцэг маань биднийг хайрлаж, халамжилж байдгийг бид яаж мэддэг вэ?

Бидэнд Газар Дэлхийг Өгсөнд Талархаж Буйгаа Бид Харуулж Чадна

Тэнгэр дэх Эцэг маань дэлхий дээр байгаа бүх юмсыг бидний төлөө бүтээснийг бид үргэлж санаж явах учиртай. Хэрэв бид үүнийг мартвал тэр хэрхэн баяртай байх билээ. Бид газар дэлхий дээрх юмсыг ухаалгаар хэрэглэвэл түүнд талархаж буйгаа үзүүлж буй хэрэг болох юм. Энэ дэлхий дээрх юуг ч бид үрэн таран хийж болохгүй. Бид газар дэлхийгээ хайрлан хамгаалж, цэвэр цэмцгэр байлгаж ёстой. Бид Тэнгэр дэх Эцэгтээ хандан залбирахдаа энэ үзэсгэлэнт дэлхийг бидэнд өгсөнд нь талархаж байх учиртай. Түүнчлэн түүний хүсч буй зүйлсийг хийснээрээ түүнд талархсан сэтгэлээ илэрхийлж болно.

Ярилцлага

- Дэлхий ертөнцийг бидэнд өгсөнд нь талархаж буйгаа бид Тэнгэр дэх Эцэгтээ хэрхэн илэрхийлж болох вэ?

Лавламж

Бидэнд Газар Дэлхий Хэрэгтэй Байлаа

- Исайяа 45:18 (Бурхан хүн төрөлхтөнд амьдрах дэлхийг нь бүтээж өглөө.)
- 2 Нифай 2:15 (Бурхан бидэнд зориулсан төлөвлөгөөнийхөө дагуу газар дэлхийг бүтээсэн юм.)

Исүс Газар Дэлхийг Бүтээв

- Исайяа 45:12 (Бурхан газар дэлхийг бүтээлээ.)

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Хайртай Учраас Газар Дэлхийг Бүтээсэн Юм

- Үүсэл гарал 1 (Бурхан газар дэлхий дээрх бүх зүйлийг бидний төлөө бүтээсэн.)
- Ромынхан 8:38-39 (Бурхны хайраас биднийг юу ч салгаж чадахгүй.)

Бидэнд Газар Дэлхийг Өгсөнд нь Талархаж Буйгаа Бид Харуулж Чадна

- Ефесчүүд 5:20 (Бурханд бид бүх зүйлийн төлөө талархах ёстой.)
- Мосайяа 2:20-25 (Биднийг бүтээсэн Бурхандаа талархах ёстой.)



Адам Ева хоёр Эдений Цэцэрлэгээс хөөгдсөн нь.

АДАМ ЕВА ХОЁР

6-р бүлэг

Адам Ева хоёр гэж хэн байсан бэ? Тэд бидэнд туслах юу хийсэн бэ?

Адам Ева Хоёр Энэ Газар Дэлхийд Ирсэн Анхны Хүмүүс Байлаа
Тэнгэр дэх Эцэг маань дэлхий дээрх анхны хүмүүсийг Адам, Ева гэж нэрлэжээ. Тэд түүний хамгийн сайн хүүхдүүдийн хоёр нь байсан юм. Тэдний ачаар бид цөм энэ дэлхийд ирэх боломжтой болсон юм.

Тэнгэрт байхад нь Адамыг Майкл гэдэг байлаа. Тэр удирдагчдын маань нэг байсан юм. Тэрээр биднийг Сатантай хийсэн тэмцэлд тэргүүлсэн билээ. Майкл сайн хүн байсан бөгөөд Тэнгэр дэх Эцгийнхээ хий гэснийг хийж байсны учир энэ газар дэлхийд ирэх анхны хүн болсон юм.

Ева Тэнгэр дэх Эцгийн маань сайн охин нь байв. Тэнгэр дэх Эцэг маань Еваг газар дэлхийд Адамын хань болж, түүнд туслуулахаар илгээсэн юм. Ганцаар байх нь Адамд таатай биш байх болно гэдгийг Тэнгэр дэх Эцэг маань мэдэж байлаа. Мөн Адам ч ганцаараа бид бүгдэд энэ дэлхийд ирэх боломжийг нээж өгч чадахгүй байсан юм. Евагийн энэ төлөвлөгөөнд гүйцэтгэсэн үүрэг Адамын нэгэн адил чухал билээ.

Ярилцлага

- Яагаад Тэнгэр дэх Эцэг маань Адам Ева хоёрыг энэ дэлхийн анхны хүмүүсээр сонгосон бэ?
- Яагаад Тэнгэр дэх Эцэг маань Еваг Адамтай хамт байлгахаар илгээсэн бэ?

Эдений Цэцэрлэг Адам Ева Хоёрын Анхны Орон Гэр Байлаа

Тэнгэр дэх Эцэг маань дэлхий дээр Адам Ева хоёрт зориулан нэгэн үзэсгэлэнт газрыг бүтээв. Түүнийг Эдений Цэцэрлэг гэдэг байлаа. Адам Ева хоёр Эдений Цэцэрлэгт байхдаа хэзээ ч үл үхэх яс, махан бие цогцостой байсан юм. Тэдэнд үр хүүхэд байсангүй. Тэд өөрсдийн хэрэгцээг хангахын тулд тариа тарьж, ургац хураах мэтээр хөдөлмөрлөх хэрэггүй байв. Тэд тэнгэр дэх амьдралаа үл санах бөгөөд сайн муу гэж юу болохыг мэддэггүй байлаа.

Эдений Цэцэрлэгт Адам Ева хоёр Тэнгэр дэх Эцэгтэй маань хамт алхаж, ярилцах боломжтой байлаа. Тэрээр тэдний хийх ёстой зүйлийг хэлж өгдөг байв. Тэр тэдэнд цэцэрлэгийг арчилж, сайхан байлгахыг даалгажээ. Мөн тэнд буй нэг модноос бусад аль ч модны жимсийг дураараа идэж болно гэлээ. Тэнгэр дэх Эцэг маань тэдэнд сайн мууг танин мэдэх модны жимсийг идэхийг хориглоод, хэрэв тэр жимсийг идвэл үхэх болно хэмээн анхааруулжээ.

Ярилцлага

- Адам Ева хоёрын Эдений Цэцэрлэг дэх амьдрал өнөөдрийн бидний амьдралаас ямар ялгаатай байсан бэ?
- Тэнгэр дэх Эцэг маань Адам Ева хоёрт юу хийхийг хэлж өгсөн бэ?

Адам Ева Хоёр Тэнгэр дэх Эцгээс Маань Салсан нь

Сатан Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөөг нурааж чадна хэмээн боджээ. Тэрээр Эдений Цэцэрлэгт ирж, Еваг ятган сайн мууг танин мэдэх модны жимснээс идүүлэхийг оролдов. Тэр жимсийг идэхэд үл үхэх бөгөөд Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил сайн муу хоёрыг ялган таних мэдлэгтэй болно гэж түүнд хэлжээ. Ева Сатанд итгэн жимснээс идэв. Ева уг жимснээс идсэнээ Адамд хэлэхэд тэрээр түүнийг цэцэрлэгийг орхиж явах учиртай болсныг ойлгожээ. Ингээд хоёул хамт байхын тулд Адам ч жимсийг идсэн байна.

Тэнгэр дэх Эцгийн маань идэхийг хориглосон жимсийг идсэнээр Адам Ева хоёрын амьдрал өөрчлөгдөв. Тэнгэр дэх Эцэг маань тэднийг Эдений Цэцэрлэгээс хөөн явууллаа. Ийнхүү тэд дахин түүнтэй хамт алхаж, ярилцах боломжгүй болсон юм. Энэ цагаас хойш хүн төрөлхтөн Тэнгэр дэх Эцгийнхээ дэргэдээс салсан юм. Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт байх боломжгүй болсныг *сүнсний үхэл гэж нэрлэдэг. Адам Ева хоёр үзэсгэлэнт цэцэрлэгийн гаднах

ертөнцөд амьдрах болов. Тэд өөрсдийн хэрэгцээг хангахын тулд ажиллах хэрэгтэй болсон байна.

Тэдний бие махбодод өөрчлөлт гарч, хүүхэд төрүүлэх боломжтой болов. Мөн өвчин эмгэг тусч, уй гашууг мэдэрч, хэзээ нэгэн цагт хорвоогийн мөнх бусыг үзэх боллоо. Адам Ева хоёрт гарсан эдгээр өөрчлөлтүүдийг Адамын уналт гэж нэрлэдэг юм.

Эдгээр өөрчлөлтүүд Адам Ева хоёрын бүх үр удамд нь нөлөөлжээ. Тэдний нэгэн адилаар бид ч гэсэн хүүхэд төрүүлж, өвчин зовлон, уй гашуу, үхлийг амсах болно.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөөг нураахын тулд Сатан юу хийсэн бэ?
- Сайн мууг танин мэдэхийн модны жимсийг идсэнээс хойш Адам Ева хоёрын амьдрал яаж өөрчлөгдсөн бэ?
- Сүнсний үхэл гэж юу вэ?
- Адамын уналт гэж юу вэ?

Адамын Уналт Тэнгэр дэх Эцгийн Маань Төлөвлөгөөний Нэг Чухал Хэсэг Байсан Юм

Тэнгэр дэх Эцэг маань өөрийн хүүхдүүдийг газар дэлхийд ирж, яс, махан биеийг олж авахаар төлөвлөжээ. Адам Ева хоёрыг Эдений Цэцэрлэгээс хөөсний дараа тэд үр хүүхэдтэй болж эхэлсэн байна. Хожим нь тэдний хүүхдүүд гэрлэж, мөн үр хүүхэдтэй болжгоов. Ийнхүү Тэнгэр дэх Эцгийн маань өөртэй нь хамт амьдарч байсан сүнсэн хүүхдүүд түүний төлөвлөсөн ёсоор газар дэлхийд ирцгээх боллоо. Адам Ева хоёрын ачаар бид бүгд газар дэлхийд ирж, яс махнаас бүрдсэн биеийг хүлээн авах боломжтой болсон юм.

Мөн Тэнгэр дэх Эцэг маань хүүхдүүдээ хэрэгцээнийхээ болон хүссэн зүйлээ өөрсдийн хөдөлмөрөөр олж байхаар төлөвлөжээ. Адам Ева хоёр Эдений Цэцэрлэгийг орхин одсон цагаас хойш Тэнгэр дэх Эцгийн маань хүүхдүүд өөрсдийн хэрэгцээг болон хүссэн зүйлээ ажил хөдөлмөрөөрөө олоход хүрсэн юм.

Адам Ева хоёр Тэнгэр дэх Эцгийн маань идэхийг хориглосон жимсийг идсэний дараа тэд сайн муугийн ялгааг мэдэж авчээ. Одоо газар дэлхий дээр хэн маань ч гэсэн сайн муугийн хоорондох ялгааг мэдэж, сайн эсвэл муу үйл хийхээ өөрөө сонгох чадвартай билээ.

Тэнгэр дэх Эцэг маань Адам Ева хоёрыг Эдений Цэцэрлэгээс хөөсний дараа тэд түүний тэднээр хийлгэхийг хүсч байсан зүйлсийг мэдэж авахыг хичээдэг байв. Тэд түүний үгийг дагаж, хүүхдүүддээ түүнийг дуулгавартай дагахыг заан сургадаг байлаа. Хүн бүр Тэнгэр дэх Эцэг маань биднээр юу хийлгэхийг хүсч байгааг мэдэж, түүнийг дуулгавартай дагаж, мөн түүнийг дагахыг үр хүүхдэдээ сургах хэрэгтэй.

Ярилцлага

- Сатан Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөөг нурааж чадсан уу?
- Бид яагаад Адам Ева хоёрын хийсэн зүйлст талархах ёстой вэ?

Лавламж

Адам Ева Хоёр Энэ Газар Дэлхийд Ирсэн Анхны Хүмүүс Байлаа

- Үүсэл гарал 1:26-27 (Бурхан эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээлээ.)
- Үзэгдэл 12:7-9 (Тэр үед Майкл гэгдэж байсан Адам цэгц шударга сүнснүүдийг Сатаны эсрэг тэмцэлд тэргүүлсэн юм.)
- 1 Нифай 5:11; 2 Нифай 2:19-20 (Адам Ева хоёр хамгийн анхны эцэг эх байлаа.)

Эдений Цэцэрлэг Адам Ева Хоёрын Анхны Орон Гэр Байлаа

- Үүсэл гарал 2:15 (Тэнгэр дэх Эцэг маань Адам Ева хоёрт Эдений Цэцэрлэгийг арчилж тордохыг даалгав.)
- Үүсэл гарал 2:16-17 (Тэнгэр дэх Эцэг маань Адам Ева хоёрт сайн мууг ялган таних модны жимсийг идэхийг хориглов.)

Адам Ева Хоёр Тэнгэр дэх Эцгээс Маань Салсан нь

- Үүсэл гарал 3:1-5 (Сатан Еваг хуурав.)
- Үүсэл гарал 3:23-24 (Бурхан Адам Ева хоёрыг Эдений Цэцэрлэгээс хөөв.)
- Хеламан 14:16 (Адам Ева хоёрт Бурхны байгаа газарт үлдэхийг үл зөвшөөрчээ.)

Адамын Уналт Тэнгэр дэх Эцгийн Маань Төлөвлөгөөний Нэг Чухал Хэсэг Байсан Юм

- 2 Нифай 2:22-25 (Адамын уналт байгаагүй бол бид газар дэлхийд ирж чадахгүй байх байлаа.)
- Алма 12:26-32 (Адамын уналт нь Бурхны төлөвлөгөөний нэг хэсэг байсан юм.)

БУРХАНТАЙ ХАРИЛЦАХ НЬ

Гуравдугаар хэсэг



АРИУН СҮНС

7-р бүлэг

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд мэдүүлэхийг хүсч буй зүйлээ дамжуулахаар хэн нэгнийг сонгожээ. Энэ хүн хэн бэ? Бид хэрхэн Тэнгэр дэх Эцгийнхээ илгээмжүүдийг ойлгоход суралцах вэ?

Бидэнд Туслахын Тулд Ариун Сүнс, Тэнгэр дэх Эцэг Болон Исүстэй Хамтарч Ажилладаг

Ариун Сүнс, Тэнгэр дэх Эцэгтэй маань болон Исүстэй хамтран ажилладаг. Тэр бидэнд тэднийг амьдарч байгаа, мөн бидэнд хайртай болохыг гэрчилдэг. Бидний мэдэх, хийх хэрэгтэй зүйлсийг маань заахад тэр тэдэнд тусалж, мөн тэдний зарлиг тушаалыг дагахад маань бидэнд тусалдаг юм. Түүнд Тэнгэр дэх Эцэг болон Исүсийнх шиг яс, махнаас бүрдсэн бие цогцос байхгүй. Тэр бол сүнс. Тэр яг хүн шиг харагдана.

Бидний Тэнгэр дэх Эцэг, Исүс Христ, Ариун Сүнс нь гурван өөр хүн юм. Бидний мэдэх, хийх ёстой зүйлсээ ойлгож, сурч авахад маань туслахын тулд тэд хамтарч ажилладаг юм. Биднийг Тэнгэр дэх Эцгээсээ илгээмж хүлээн авахад түүнийг авчирч буй хүн нь үргэлж Ариун Сүнс байдаг билээ. Түүний зарлигийг дагахад маань тэр мөн тусалдаг.

Ярилцлага

- Ариун Сүнс хэнтэй хамтарч ажилладаг вэ?
- Ариун Сүнс бидний Тэнгэр дэх Эцэг болон Исүс Христээс ямар алгаатай вэ?

Ариун Сүнсний Ажил

Ариун Сүнс бидэнд Тэнгэр дэх Эцгийн маань болон Исүсийн тухай заадаг. Тэднийг амьдарч байгаа, мөн бидэнд хайртай болохыг тэр хэлж өгдөг. Тэрээр Тэнгэр дэх Эцэг маань бидний Сүнсний Эцэг гэдгийг, мөн Исүс бол бидний Аврагч гэдгийг хэлж өгдөг билээ.

Тэнгэр дэх Эцгийнхээ болон Исүсийн тухай, мөн тэнгэрт эргэн очихын тулд юу хийх ёстойгоо ойлгоход маань Ариун Сүнс бидэнд тусалдаг. Түүнчлэн тэр үнэнийг мэдэж, ойлгоход маань тусална.

Ариун Сүнс бидэнд Тэнгэр дэх Эцгийнхээ болон Исүсийн зарлигийг дагах хүч тэнхээг хайрладаг. Хоёр үйлдлийн дунд сонголт хийх болсон үед маань тэр зөв шийдвэр гаргахад тусалж, хүнд хэцүү үед маань энх амгаланг өгөх болно.

Ярилцлага

- Ариун Сүнсний ажил гэж юу вэ?
- Юуг мэдэхэд маань Ариун Сүнс бидэнд тусалж чадах вэ?
- Юуг хийхэд маань Ариун Сүнс бидэнд тусалж чадах вэ?

Ариун Сүнс Биднийг Хүчирхэг Замаар Сургадаг

Ариун Сүнс бидэнд юу зөв, юу буруу болохыг хэлж өгдөг. Энэ нь хэзээ ч үл мартагдахуйц хүчтэй баталгаа байдаг юм. Ариун Сүнс бидэнтэй харилцахдаа бидний чихэнд сонсогдохоор ярьдаггүй билээ. Үүний оронд тэрээр бидний уншсан болон сонссон зүйл маань үнэн гэж бодох, эсвэл мэдрэхэд хүргэдэг. Тэдгээр мэдрэмжүүд маш хүчтэй байдаг.

Ариун Сүнсний чадлыг олон хүн зэрэг мэдэрч чадна. Үүнийг сайтар ойлгохын тулд нарыг төсөөлөгтүн. Хэдий ганцхан нар байдаг боловч түүний гэрэл гэгээ, илч дулааныг олон газарт хүмүүс зэрэг мэдэрч байдаг. Ариун Сүнсийг үүнтэй нэгэн адилаар ойлгож болно. Тэр өөрөө тодорхой цаг үед нэг л газар орших хэдий ч түүний хүчин чадлыг өөр өөр газар байх хүмүүс зэрэг мэдэрч байдаг юм.

Ярилцлага

- Бидний мэдэх ёстой зүйлсийг Ариун Сүнс хэрхэн хэлж өгдөг вэ?
- Ариун Сүнс хэрхэн олон хүмүүст нэгэн зэрэг тусалж чаддаг вэ?

Ариун Сүнс Хүн Бүрт Туслах Болно

Тэнгэр дэх Эцгийг маань Адам Ева хоёрыг Эдений Цэцэрлэгээс хөөн явуулсны дараагаар тэд түүнд хандан залбирч, юу хийх ёстойг асуужээ. Тэнгэр дэх Эцэг маань тэдэнд өөрийнх нь болон Исүсийн тухай, мөн юу хийвэл зохихыг нь заалгахаар Ариун Сүнсийг илгээсэн байна. Ариун Сүнс тэдэнд Тэнгэр дэх Эцгийн сургаал үнэн болохыг хэлжээ. Тэнгэр дэх Эцгийн тэднээр хийлгэхийг хүсч буй зүйлсийг хийх хүч тэнхээг тэр тэдэнд хайрлав.

Мөн тэрээр Тэнгэр дэх Эцгийн тэдний төлөө хийсэн зүйлст талархаж, хүлцэнгүй даруу байхад нь тусалсан юм.

Ариун Сүнсний удирдамж зааврын ачаар Адам Ева хоёр хэрэв Исүс болон түүний зарлигуудыг үргэлж дагавал, хэзээ нэгэн өдөр Тэнгэр дэх Эцэгтэйгээ дахин амьдарч чадна гэдгээ мэдсэн юм. Ариун Сүнсний удирдамж тэднийг маш ихээр баярлуулав.

Тэнгэр дэх Эцэг маань бид бүгдэд хайртай. Тэр бидэнд үнэнийг зааж сургахаар Ариун Сүнсийг илгээдэг. Гэхдээ биднийг түүний Тэнгэр дэх Эцгээс маань болон Исүсээс авчирсан зарлиг тушаал, удирдамжийг үнэн сэтгэлээсээ дагахыг хичээсэн тохиолдолд л Ариун Сүнс бидэнд туслах болно. Хэрэв тэдгээр зарлигуудыг дагахыг үнэн сэтгэлээсээ хичээхгүй, эсвэл Ариун Сүнсийг бидэнд заахыг хүсэхгүй бол тэр бидэнд юу ч хэлж өгөхгүй. Ариун Сүнсний сургасныг дагавал бидний амьдрал илүү сайхан болно.

Ярилцлага

- Ариун Сүнс Адам Ева хоёрт хэрхэн тусалсан бэ?
- Ариун Сүнсний туслалцааг авахын тулд бид юу хийх ёстой вэ?

Лавламж

Бидэнд Туслахын Тулд Ариун Сүнс, Тэнгэр дэх Эцэг Болон Исүстэй Хамтарч Ажилладаг

- Жон 14:26; 2 Нифай 33:1 (Сурсан зүйлээ санахад маань Ариун Сүнс бидэнд туслах болно.)
- Жон 15:26 (Исүсийн тухай үнэнийг Ариун Сүнс бидэнд үзүүлнэ.)
- 1 Жон 5:7 (Ариун Сүнс, бидний Тэнгэр дэх Эцэг болон Исүстэй хамтран ажилладаг.)

- 3 Нифай 28:11 (Ариун Сүнс бидэнд Тэнгэр дэх Эцгийн маань болон Исүсийн тухай мэдлэгийг өгдөг.)

Ариун Сүнсний Ажил

- 1 Коринфынхан 12:3; Еврейчүүд 10:15 (Исүсийн Аврагч гэдгийг Ариун Сүнс бидэнд сургаж байна.)
- 2 Нифай 32:5 (Хийвэл зохих зүйлээ мэдэхэд маань Ариун Сүнс туслах болно.)

Ариун Сүнс Биднийг Хүчирхэг Замаар Сургадаг

- Моронай 10:5-7 (Аль нь үнэн, аль нь худал болохыг Ариун Сүнс бидэнд хэлж өгдөг.)

Ариун Сүнс Хүн Бүрт Туслах Болно

- Жон 16:13 (Ариун Сүнс биднийг бүх үнэний зүг дагуулах болно.)
- Ромынхан 8:16-17 (Бид Тэнгэр дэх Эцгийнхээ хүүхдүүд гэдгээ мэдэхэд маань Ариун Сүнс тусалдаг.)



Бид өглөө, оройд ганцаараа, эсвэл гэр бүлээрээ залбирч байх хэрэгтэй.

ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГТЭЙГЭЭ ЯРИЛЦАХ НЬ

8-р бүлэг

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд маш их хайртай. Хэзээ хүссэн цагтаа түүнтэй ярилцаж байх замыг тэр бидэнд бэлтгэж өгчээ. Бид хэрхэн Тэнгэр дэх Эцэгтэйгээ ярьж болох вэ?

Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ Ярьж Болно

Тэнгэр дэх Эцэгтэйгээ ярилцахыг залбирал гэж нэрлэнэ. Хэдий Тэнгэр дэх Эцэг маань тэнгэрт амьдардаг ч бид түүнтэй ярилцаж болох бөгөөд тэр биднийг сонсч байдаг. Тэр бидэнд туслахыг хүсдэг. Биднийг өөртэйгөө ярилцаж байхыг тэр хүссэн юм. Хэрэв бид түүнтэй ярилцвал тэр бидэнд өөрсдөд маань сайн зүйлсийг хийхэд туслах болно.

Бид юу бодож санаж байгаагаа Тэнгэр дэх Эцэгтээ хэлж болно. Мөн түүнийг хайрладгаа хэлж болно. Түүний бидэнд өгсөн зүйлст нь хэчнээн талархалтай байдгаа хэлж, түүнээс бидэнд туслахыг хүсч болно.

Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ хэзээ хүссэн үедээ ярилцаж болох юм. Бид ганцаараа байхдаа түүнтэй ярьж байх хэрэгтэй. Энэ үедээ бид түүнд хувийнхаа санал бодол, хэцүү төвөгтэй асуудлуудаа ярих боломжтой. Түүнтэй ядаж өглөө, орой бүр ярилцаж байх нь зүйтэй.

Бид мөн гэр бүлээрээ хамтран түүнтэй ярилцаж болно. Үүнийг бид өглөө, орой бүр, түүнчлэн хоол идэхийнхээ өмнө түүнд талархлаа илэрхийлэх зэргээр хийх боломжтой.

Тэнгэр дэх Эцэг маань биднийг өөртэй нь ярихыг үргэлж хүсч байдаг. Тэр үргэлж биднийг хайрлаж, бидэнд туслахыг хүсч байх болно. Биднийг буруу зүйл хийсэн байлаа ч тэр хайрласаар л байх болно. Тэр биднийг сонсч, бидэнд тусална.

Ярилцлага

- Бид яагаад Тэнгэр дэх Эцэгтэйгээ ярилцах ёстой вэ?
- Бид хэзээ түүнтэй ярилцах хэрэгтэй вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Түүнтэй Хэрхэн Ярилцахыг Хэлж Өгсөн

Бид залбирахдаа Тэнгэр дэх Эцэгтээ өөрсдийн бодол санаа, хэрэгцээ бүгдийг хэлж байх нь зүйтэй. Түүнтэй ярих бүртээ нэгэн ижил үгсийг давтах нь утгагүй юм. Бид залбирлаа аялгуулан уншиж, орилж хашгирах хэрэггүй.

Түүнтэй хэрхэн ярилцаж байхыг тэр бидэнд хэлж өгсөн. Бид шууд түүнд хандан “Тэнгэр дэх Эцэг минь” гэхчилэн эхлэх хэрэгтэй. Түүнийг хайрлаж хүндэтгэсэн байдлаар яривал зохино.

Дараа нь бидний төлөө хийсэн зүйлст нь талархах хэрэгтэй.

Түүнд талархвал зохих зарим зүйлсийг доор жагсаав. Үүнд:

1. Бид үзэсгэлэнт сайхан газар дэлхий, бидний хоол хүнс, хувцас хунар болон бусад эзэмшлийнхээ төлөө түүнд талархах хэрэгтэй.
2. Бид түүний сургаал, мөн өөрсдийн түүний тухай улам ихийг мэдэх чадварынхаа төлөө талархах хэрэгтэй.
3. Бид гэр бүл, найз нөхөд, эрүүл мэнд, ажил төрлийнхөө төлөө түүнд талархах хэрэгтэй.

Ингээд дараа нь түүнээс өөрсдийн хэрэгцээт зүйлсийг хүсч болно. Түүнээс асууж болох зүйлийн заримаас дор дурьдав. Үүнд:

1. Бид түүнээс юу үнэн, юу худал болохыг мэдэхэд маань туслахыг хүсч болно.
2. Бид түүнээс биднийг болон гэр бүл, хөршийг маань хамгаалахыг хүсч болно.
3. Бид түүнээс биднээр хийлгэхийг хүсч буй тэр зүйлсийг хийхэд туслахыг хүсч болно.
4. Бид түүнээс зөв үйл хийхийг сонгоход маань туслахыг хүсч болно.

5. Бид түүнээс нүглээ наманчлан гэмшихэд туслахыг хүсч болно.
6. Бид түүнээс өдөр тутамдаа хангалттай хоол хүнстэй байхад маань туслахыг хүсч болно.
7. Бид түүнээс хэцүү төвөгтэй асуудлуудаа шийдэхэд маань туслахыг хүсч болно.
8. Бид түүнээс бидний гэр бүл, найз нөхдөд маань тулгарсан бэрхшээлтэй асуудлыг шийдэхэд туслахыг хүсч болно.

Бид залбирлаа “Исүс Христийн нэрээр, Амен.” гэж хэлэн дуусгах ёстой. Энэ нь бидэнд Исүс бол бидний Аврагч мөн гэдгийг санаж байхад тусална. Исүс Тэнгэр дэх Эцгийн маань удирдлагын дор бидний хэрэгцээтэй бүгдэд туслахаар ажиллаж байдаг юм. Бид Исүсийн нэрийг хүндэтгэлтэйгээр хэлж байх хэрэгтэй.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэгтэйгээ ярилцахдаа бид хэрхэн эхэлдэг вэ?
- Түүнийг талархаж болох ямар зүйлс байна вэ?
- Түүнээс хүсч болох ямар зүйлс байна вэ?
- Тэнгэр дэх Эцэгтэйгээ ярилцаж дуусахдаа бид юу гэж хэлдэг вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Үргэлж Хариулдаг

Тэнгэр дэх Эцэг маань биднийг сонсч байдагт бид итгэлтэй байж болно. Бидний хувьд юу хамгийн сайн болохыг тэр мэдэж байдаг. Тэр ямагт бидэнд туслахад бэлэн байдаг юм.

Тэнгэр дэх Эцэг маань хариултаа ихэвчлэн Ариун Сүнсээр дамжуулан илгээдэг. Ариун Сүнс бидний мэдэх, хийх хэрэгтэй зүйлээ ойлгоход маань туслах болно. Заримдаа Ариун Сүнс бидэнд туслуулахаар өөр хүнийг илгээдэг.

Бид Тэнгэр дэх Эцгийнхээ бидэнд өгч буй хариултыг хүлээн авах хүсэлтэй байх хэрэгтэй. Магадгүй тэр бидний хүссэн зүйлийг өгөхгүй ч байж болох юм. Мөн тэр бидний хүсэн хүлээж байсан замаар хариулахгүй ч байж болно. Гэвч тэрээр бидэнд юу сайн болохыг мэдэж байдаг.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хэрхэн хариулдаг вэ?
- Тэр яагаад бидний хүссэн зүйлийг үргэлж өгөөд байдаггүй вэ?

Бид Залбирснаар Илүү Сайн Хүмүүс Болдог

Бид ямар зүйлийг хийвэл зөв болохыг мэдэхгүй байж болно. Бид айж болно. Бид өөрсдийн төвөгтэй асуудлыг яаж шийдэхийг мэдэхгүй байж болно. Бид юу үнэн, юу худал болохыг мэдэхгүй байж ч болно. Бид ямар зүйлийг хийвэл зөв болохыг мэдлээ ч түүнийг хийх хангалттай хүчин чадал бидэнд дутаж болох юм.

Тэнгэр дэх Эцэгтэйгээ үргэлж ярилцаж байвал тэр бидний төвөгтэй асуудлыг шийдэхэд тусална. Тэр зөв зүйлийг мэдэж, хийхэд маань туслах болно. Зөвийг мэдэж, түүнийг хийснээр бид улам илүү сайн хүмүүс болдог. Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ илүү адил болно.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэгтэйгээ ярилцсанаар бид хэрхэн илүү сайн хүмүүс болдог вэ?

Лавламж

Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ Ярьж Болно

- Дуулал 55:16-17; 2 Нифай 32:9 (Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ үргэлж ярилцаж байх ёстой.)
- Лук 18:1 (Бид үргэлж залбирах хэрэгтэй.)
- Алма 37:37 (Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ өөрсдийн хийж буй бүх зүйлийн талаар ярих хэрэгтэй.)

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Түүнтэй Хэрхэн Ярилцахыг Хэлж Өгсөн

- Матвей 6:6-13 (Бидэнд хэрхэн залбирахыг хэлж өгчээ.)
- Жеймс 1:5 (Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ олон зүйлийн талаар ярьж болно.)
- Алма 34:17-27 (Энд бидний тэдгээрийн талаар Тэнгэр дэх Эцэгтэй хандан залбирвал зохих зарим зүйлс бий.)
- 3 Нифай 19:6, 24 (Исүс бидэнд Тэнгэр дэх Эцэгтэйгээ хэрхэн ярилцахыг зааж байна.)

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Үргэлж Хариулдаг

- Сургаал үгс 15:29 (Тэнгэр дэх Эцэг маань бидний залбирлыг сонсдог.)

- Матвей 7:7 (Асуувал чи хариулт авах болно.)
- Моронай 7:26; 3 Нифай 18-20 (Бид өөрсдөдөө сайн байх болгоныг хүсэх юм бол тэдгээрийг хүлээн авах болно.)

Бид Залбирснаар Илүү Сайн Хүмүүс Болдог

- Лук 22:40 (Хүч тэнхээг хүсэн залбир, тэгвэл та нар уруу таталтад автахгүй.)
- Жеймс 5:15-16 (Үнэнч шударга хүмүүсийн залбирал сайн сайхан олон зүйлийг авчрах болно.)

ЗАРЛАГУУД

9-р бүлэг

Өнөөдөр газар дэлхий дээр хэн Тэнгэр дэх Эцгийн маань нэрийн өмнөөс ярьж, юуг Тэнгэр дэх Эцэг маань биднийг мэдээсэй, хийлгээсэй гэж хүсч буйг бидэнд хэлж өгдөг вэ?

Зарлага бол Тэнгэр дэх Эцгийн Маань Нэрийн Өмнөөс Ярьдаг Хүн Юм

Тэнгэр дэх Эцэг маань газар дэлхий дээр өөрийнх нь нэрийн өмнөөс ярих хүнийг сонгодог. Тэр хүнийг зарлага гэж нэрлэнэ. Зарлага Тэнгэр дэх эцгийг маань хайрлаж, түүгээр хийлгэхийг хүссэн зүйлсийг хийнэ. Тэнгэр дэх Эцэг маань биднийг мэдэж, хийх ёстой зүйлийг түүнд заадаг бөгөөд зарлага тэдгээрийг бидэнд хэлж өгдөг юм. Зарлага Тэнгэр дэх Эцгийн маань нэрийн өмнөөс ярихдаа хэрэв Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хандан яривал хэлэх байсан тэр зүйлүүдийг хэлдэг билээ.

Зарлагын бидэнд хэлж өгдөг зарим зүйлийг дурьдав. Үүнд:

- Тэр бидэнд Исүс бол Тэнгэр дэх Эцгийн маань Хүү, бидний Аврагч бөгөөд Исүсийн сургаал үнэн гэдгийг хэлж өгдөг.
- Тэр бидэнд Тэнгэр дэх Эцгийн маань биднийг хийх ёстой гэсэн зүйлийг хэлж өгнө.
- Тэр бидэнд муу үйл хийхээ зогсохыг сануулдаг.
- Тэр бидэнд ирээдүйд болох зүйлийг хэлж өгдөг.

Зөвхөн Тэнгэр дэх Эцэг маань л зарлагыг сонгож чадна. Зарлагыг хүмүүс сонгож чадахгүй. Хүн өөрөө өөрийгөө зарлагаар сонгож мөн чадахгүй. Тэнгэр дэх Эцэг маань зарлагад өөрийнх нь нэрийн өмнөөс ярих, ажиллах эрхийг өгдөг. Энэ эрхгүйгээр хэн нэгэн хүн Тэнгэр дэх Эцгийг маань төлөөлж чадахгүй.



Жозеф Смит



Бригэм Янг



Жон Тэйлор



Уилфорд Вудрафф



Лоренсо Сноу



Жозеф Ф. Смит



Хебер Ж. Грант



Жорж А. Смит



Дэвид О. МакКей



Жозеф Филдинг Смит



Харольд Б. Ли



Спенсер В. Кимболл



Эзра Тафт Бенсон



Ховард В. Хантер



Гордон Б. Хинкли

Тэнгэр дэх Эцэг маань зарлагуудаа бидний үед ч илгээсээр байна.

Ярилцлага

- Зарлага хэний нэрийн өмнөөс ярьдаг вэ?
- Зарлага бидэнд ямар зүйлсийг хэлж өгдөг вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Туслахаар Зарлагуудыг Үргэлж Илгээж Байсан

Тэнгэр дэх Эцэг маань газар дэлхийд буй хүүхдүүддээ үргэлж анхаарал халамж тавьсаар ирсэн. Адамын үеэс эхлэн тэрээр өөрийн хүүхдүүдэд туслахаар зарлагуудыг илгээсээр байсан юм. Тэр хүмүүсийг аюулаас сэрэмжлүүлэхээр зарлагыг илгээдэг. Тэрээр хүмүүсийг зовлон гамшгаас нь удирдан гаргуулахын тулд тэднийг явуулдаг. Аугаа их үйл явдлуудад хүмүүсийг бэлтгүүлэхээр тэднийг мөн илгээдэг. Тэнгэр дэх Эцгийн маань илгээсэн зарлагуудын заримаас дурьдвал:

1. Ной: Тэр хүмүүст хэрэв тэд өөрсдийн муу үйлийг зогсоохгүй бол Тэнгэр дэх Эцэг маань усан галав юүлүүлж, тэднийг устгах болно гэдгийг сануулсан.
2. Абрахам: Тэр Тэнгэр дэх Эцгээ дуулгавартай дагаж, үр хүүхдэдээ Тэнгэр дэх Эцгийг дуулгавартайгаар дагахыг сургаж байв. Тэнгэр дэх Эцэг маань Абрахам болон түүний үр удамд олон зүйлийг өгөхөөр амласан билээ.
3. Моүзес: Тэр Израилийн ард түмнийг Египетээс удирдан гаргаж, Тэнгэр дэх Эцгийн маань урьдчилан бэлдсэн газарт аваачсан юм.

Бидний энэ үед ч гэсэн Тэнгэр дэх Эцэг маань зарлагуудыг илгээсээр байна. Саяхан амьдарч байсан зарлагуудын нэг нь Жозеф Смит гэдэг хүн байлаа. Тэр Америкийн Нэгдсэн Улсад амьдарч байв. 1820 онд Жозеф Смит 14 настай байлаа. Тэр үед олон хүмүүс үнэний сүмийг эрэн янз бүрийн сүмд элсэцгээж байв. Жозеф сайн хүн байж, Тэнгэр дэх Эцгийн маань үнэн сүмийг олохыг хүсч байжээ.

Жозеф нэгэн өдөр Библи хэмээх ариун номыг уншиж байлаа. Тэрээр хэрэв чи ямар нэгэн зүйлийг мэдэхийг хүсвэл Тэнгэр дэх Эцгээсээ асуух хэрэгтэй, Тэнгэр дэх Эцэг чамд хэлж өгөх болно гэснийг уншжээ. Тэнгэр дэх Эцэг маань үнэхээр түүний хийх ёстой зүйлийг хэлж өгнө гэдэгт тэр итгэв. Тэрээр Тэнгэр дэх Эцэгтээ хандан онцгой залбирал хийхээр шийдсэн байна.

Нэгэн өглөө Жозеф залбирахаар бяцхан төгөлд очжээ. Түүнийг залбирч байтал нарны гэрлээс ч хурц нэгэн гэрэл тэнгэрээс доошлон ирэв. Тэрээр уг гэрлийн дунд Тэнгэр дэх Эцгийг Исүс Христийн хамтаар олж харлаа. Тэнгэр дэх Эцэг маань Исүсийг зааж, “Энэ бол миний Хайртай Хүү. Түүнийг сонсогтун!” гэжээ.

Жозеф Исүсийн хэлснийг бүгдийг сонсч, түүний өгсөн зааврыг дагасан байна.

Жозефыг том болоход Тэнгэр дэх Эцэг маань түүнийг өөрийн зарлагаар сонгосон юм. Тэр аугаа их зарлага байлаа. Тэрээр хүмүүст Тэнгэр дэх Эцгийн маань тэднээр хийлгэхийг хүссэн зүйлсийг заадаг байв.

Жозеф Смит 1844 онд нас нөгчсөн билээ. Түүнийг үхсэний дараагаар Тэнгэр дэх Эцэг маань өөр хүнийг зарлагаар сонгосон юм. Өнөөдөр, зарлагыг нас бармагц, Тэнгэр дэх Эцэг маань өөр хэн нэгнийг газар дэлхий дээр өөрийн нэрийн өмнөөс яриулахаар сонгосоор байна.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцгийн маань сонгосон ямар зарлагууд байсан бэ?
- Жозеф Смит юу хийсэн бэ?

Өнөөдөр Газар Дэлхий Дээр Зарлага Бий

Тэнгэр дэх Эцэг маань өнөөдөр газар дэлхий дээр буй өөрийн хүүхдүүдэд хайртай байдаг. Бидэнд олон бэрхшээлтэй асуудлууд байгаа гэдгийг тэр мэднэ. Тэр бидэнд туслахаар зарлага илгээсэн билээ. Эртний зарлагуудтай ярьж байсан шигээ тэрээр өнөөдрийн зарлагатай ярьдаг. Бүх дэлхийн хүн ардад Тэнгэр дэх Эцэг маань зарлагаар дамжуулан удирдамж өгч байдаг билээ. Тэрхүү энэ дэлхийн бүх хүн ардад зориулсан удирдамж зааврыг Тэнгэр дэх Эцгээс маань авч чадах цорын ганц хүн нь зарлага юм.

Өнөөдөр амьдарч буй зарлага бол аугаа хүн юм. Тэр Тэнгэр дэх Эцгээ хайрлаж, түүнийг дуулгавартай дагахыг хүсч байдаг. Тэнгэр дэх Эцэг маань биднийг мэдэж, хийхийг хүссэн зүйлээ зарлагад хэлж өгдөг.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэг маань яагаад өнөө үед зарлагаа илгээсэн бэ?
- Зарлага хэнд зориулсан удирдамжийг авдаг вэ?
- Бид яагаад зарлагын хэлсэн бүгдэд итгэж болох вэ?

Зарлагад Өгсөн Удирдамжийг нь Дагавал Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Тусалдаг

Зарлагыг түүний нэрийн өмнөөс ярьж байхад зарлагыг дагахыг Тэнгэр дэх Эцэг маань бидэнд тушаасан юм. Тэнгэр дэх Эцгийн маань зарлагадаа өгсөн удирдамж зааврыг нь дагавал бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ хэрхэн илүү адил болохыг мэдэж авна. Бид өөрсдийн хийх ёстой зүйлсийг мэдэж авна. Хэрэв бидэнд хэцүү төвөгтэй асуудлууд байгаа бол тэдгээрийг хэрхэн шийдэхээ бид мэдэж чадна. Тэнгэр дэх Эцэг маань бидэнд тусалж, бидний зүрх сэтгэл тайван амгалан байх болно.

Ярилцлага

- Бид яагаад зарлагын хий гэж хэлсэн зүйлийг сонсч байх ёстой вэ?
- Түүний зарлагаараа дамжуулан бидэнд хийхийг зааварчилсан зүйлсийг хийвэл Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хэрхэн туслах вэ?

Лавламж

Зарлага бол Тэнгэр дэх Эцгийн Маань Нэрийн Өмнөөс Ярьдаг Хүн Юм

- Тоолол 12:6; Лук 1:70 (Тэнгэр дэх Эцэг маань зарлагуудаараа дамжуулан ярьдаг.)
- Иеремия 1:5, 7 (Тэнгэр дэх Эцэг маань юу хэлэхийг нь зарлагууддаа хэлж өгдөг.)

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Туслахаар Зарлагуудаа Үргэлж

Илгээж Байсан

- Амос 3:7 (Тэнгэр дэх Эцэг маань үргэлж зарлагуудаараа дамжуулан ярьдаг.)
- Еврейчүүд 1:1 (Эрт цагт Тэнгэр дэх Эцэг маань хүмүүстэй зарлагуудаараа дамжуулан ярьдаг байсан юм.)

Өнөөдөр Газар Дэлхий Дээр Зарлага Бий

- 2 Нифай 3:7-24 (Тэнгэр дэх Эцэг маань хожмын үед ч зарлагаа сонгохыг амласан.)

Зарлагад Өгсөн Удирдамжийг нь Дагавал Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Тусалдаг

- Дэлгэрэнгүй хууль 18:18-19 (Зарлагуудын үгийг үл сонсох хүмүүс тэдний заасны дагуу л шүүгдэх болно.)
- 3 Нифай 28:34 (Тэнгэр дэх Эцэг маань түүний зарлагуудын үгийг үгүйсгэсэн хүмүүсийг өөртэйгөө дахин хамт амьдрахыг үл зөвшөөрөх болно.)

СУДРУУД

10-р бүлэг

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд туслах зорилгоор дөрвөн ариун номыг өгчээ. Та эдгээр дөрвөн номын нэрийг мэдэх үү?

Тэнгэр дэх Эцэг Маань Ариун Бичвэрүүдийг Бидэнд Хайрласнаар Өөрийн Хайрыг Илэрхийлдэг

Тэнгэр дэх Эцэг маань түүнээс бидэнд мэдүүлэхийг хүсч буй зүйлсийг бичихийг зарлагууддаа тушаажээ. Эдгээр бичвэрүүдийг судрууд хэмээн нэрлэдэг. Тэдгээрт буй зүйлс бидний Тэнгэр дэх Эцгээс ирдэг учраас ариун нандин юм. Тэдгээр нь Тэнгэр дэх Эцгийн маань тусламжгүйгээр хүний бичиж чадах ямар ч зүйлээс илүү чухал, аугаа их билээ.

Тэнгэр дэх Эцэг маань энэ бичвэрүүдийг бидэнд туслахаар өгчээ. Тэдгээрийг уншсанаар бид Тэнгэр дэх Эцгийнхээ бидэнд зориулсан аугаа их төлөвлөгөөг мэдэж авна. Бид энэ дэлхийд мэндлэхээсээ өмнөх түүнтэй хамт байсан амьдралынхаа тухай мэдэх болно. Бид Исүс Христийн тухай мэдэж авна. Бид аз жаргалтай байж, Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болохын тулд юу хийх ёстойгоо мэднэ.

Эдгээр бичвэрүүд нь Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хайртай бөгөөд биднийг зөв зүйтэй юм хийхийг хүсч буйг мэдэхэд маань тусалдаг. Мөн Тэнгэр дэх Эцгийн маань тухай мэдсэн бусад хүмүүсийн талаар бидэнд хэлж өгдөг. Тэдгээр нь түүний бүх хүмүүст хайртай гэдгийг хэлж өгч байдаг юм. Хэрэв хүмүүс Тэнгэр дэх Эцгийг маань дуулгавартай дагахаар сонговол тэд аз жаргалтай байж, түүний

тусламжийг хүртдэг болохыг бид энэ судруудаас уншдаг. Түүнийг дагаагүй тохиолдолд тэд аз жаргалгүй байхаас гадна түүний тусламжийг авч чаддаггүй байна.

Ярилцлага

- Судрууд гэж юуг хэлдэг вэ?
- Судраас бид юу мэдэж авч чадах вэ?

Бидэнд Судрын Дөрвөн Ном Бий

Судар болох эдгээр дөрвөн ном нь Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Асар Үнэт Сувд болно. Тэдгээр нь бүгд Тэнгэр дэх Эцгийн маань болон Исүс Христийн үгийг агуулдаг. Мөн бүгд Тэнгэр дэх Эцэг, Исүс Христийн үнэн сургаалыг номлодог юм.

Библи

Библи нь Адамын үеэс эхлэн Исүсийн Төлөөлөгчдийн* амьдарч байсан үеийг хүртэлх улс түмнүүдэд хүргэгдсэн Тэнгэр дэх Эцгийн маань айлдварыг агуулдаг юм. Эдгээр үгс нь өнөөдрийн бидний хувьд ч судалж, дагах ёстой зүйлс билээ. Библи нь Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ гэсэн хоёр хэсгээс бүрддэг.

Хуучин Гэрээ нь Тэнгэр дэх Эцгийн маань хэрхэн газар дэлхийг бүтээж, анхны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг илгээсэн тухай түүхээр эхэлдэг. Хуучин Гэрээ Ной, Абрахам, Израиль, Моүзес, Исайяа болон Илия нарын олон зарлагуудын түүх намтрыг агуулсан байна. Эдгээр түүхүүд нь сайн үйл хийсэн хүмүүст Тэнгэр дэх Эцгийн маань тусалж байсныг өгүүлдэг. Мөн зарлага нарын үгийг үл сонсч, Тэнгэр дэх Эцгийн маань сургаалыг дуулгавартай дагадаггүй хүмүүс түүний тусламжийг хүртэж чадахгүй болохыг тайлбарладаг.

Шинэ Гэрээ нь Библийн хоёр дахь хэсэг юм. Энд Исүс Христийн газар дэлхий дээр хэрхэн мэндэлсэн болон түүний амьдралын талаар өгүүлдэг. Мөн түүнчлэн Исүсийн зарим сайхан сургаалуудаас гадна түүний хүмүүсийг хэрхэн хайрлаж, тэдэнд тусалж байсан тухай олон өгүүллийг багтаасан байдаг. Энэ номд Исүс дагалдагч нарынхаа дундаас өөрийн Төлөөлөгчдийг хэрхэн сонгосон болон тэдэнд хэрхэн сургаалаа хайрлаж, өөрийнх нь ажил үйлийг хийж гүйцэтгэх эрх мэдэл олгосон талаар гардаг. Түүний дагалдагчид нь түүнийг Их Эзэн мөн гэдгийг мэддэг байлаа. Хожим нь судар номд түүнийг Их Эзэн, Исүс Христ гэж бичих болсон юм.

Шинэ Гэрээнд Исүс хэрхэн бүх хүн төрөлхтний төлөө зовж шаналж, нас барсныг өгүүлдэг. Шинэ Гэрээ нь түүний Төлөөлөгчид хүмүүст түүний тухай хэрхэн зааж байсан болон Исүсийг дахин ирэхийн өмнө тохиолдох олон зүйлсийн талаар, мөн дэлхий ертөнцийн төгсгөлийн тухай өгүүлсэн түүхүүдээр төгсдөг.

Энэ дэлхийн хүмүүс Төлөөлөгчдийн үгийг хүлээн аваагүйгээр барахгүй, тэднийг доромжлон тохуурхаж, мөшгин мөрдөж, эцэст нь амийг нь хороосон юм. Бүх Төлөөлөгчид, зарлагуудыг нас барахад Тэнгэр дэх Эцгийн маань үгийг бичих нэг ч хүн үлдсэнгүй.

Үнэн зөв орчуулагдсан тохиолдолд Библи нь Тэнгэр дэх Эцгийн маань үгийг агуулсан байдаг юм.

Мормоны Ном

Мормоны Ном нь Тэнгэр дэх Эцгийн маань Америк тивд амьдарч байсан хүмүүст зориулагдсан сургаалыг агуулсан байдаг юм. Энэ судрын зарим хэсэг нь Исүс Христийг мэндлэхээс 2,000 жилийн өмнө бичигджээ. Нөгөө хэсэг нь Исүс Христээс 600 жилийн өмнө эхлээд түүний мэндэлснээс 400 жилийн дараа төгсдөг. Энэ ном Тэнгэр дэх Эцгийн маань чухал сургаалыг агуулдаг юм. Исүс бол бүх дэлхийн Аврагч мөн гэдгийг мэдэхэд нь эрт эдүгээгийн хүмүүст туслахын тулд Мормоны Номыг бичжээ.

Мормоны Номын ихэнх хэсэг нь Иерусалимаас Америк тивд нүүдэллэн суурьшсан хэсэг хүмүүсийн тухай өгүүлдэг. Тэд энэ аяллаа Исүс Христийг мэндлэхээс 600 жилийн өмнө хийсэн байна. Тэднийг Лихай хэмээх нэгэн зарлага өөрийн хүү Нифайн хамтаар удирдан дагуулжээ. Нифайн хоёр ах нь муу хүмүүс байсан бөгөөд эцгийнхээ үгийг дагасангүй. Тэднийг Ламан, Лемуил гэдэг байлаа.

Лихайг нас барсны дараагаар түүний гэр бүлийнхэн хоёр бүлэгт хуваагджээ. Нифайг дагасан хүмүүсийг Нифайчууд, Ламаныг дагасан хүмүүсийг Ламаничууд гэж нэрлэх болов. Эдгээр жижиг бүлгүүд аугаа их улс үндэстэн болон өргөжсөн байна. Нифайчууд, Ламаничууд өөр хоорондоо олон тооны дайн тулаан хийдэг байлаа. Тэнгэр дэх Эцэг маань өөрийнх нь зарлигийг дагасан тэр ард түмнийг адислан ивээж, хамгаалж байв.

Тэнгэр дэх Эцэг маань Америкт буй өөрийнх нь ард түмнийг дагуулан сургах олон зарлагыг сонгожээ. Тэдний амьдрал, сургаалын тухай түүх Мормоны Номд бичигдсэн байдаг. Энэ номд дурьдагдсан гол зарлагууд нь Нифай, Жейкоб, Бенжамин, Алма, Мормон, Моронай нар юм. Эдгээр хүмүүс бүгд Америк тивд амьдарч байсан Тэнгэр дэх Эцгийн маань ард түмний түүхийг бичсэн байдаг. Мормон энэ зарлагуудын бичсэн тэмдэглэлүүдийг нэгтгэж, нэг ном болгосон юм.

Исүс Иерусалим дахь ажлаа дууссаны дараагаар тэдний газар нутагт ирнэ гэж зарлагууд хүмүүст хэлж байлаа. Үнэхээр ч Исүс Америкт байсан сайн хүмүүс дээр ирсэн юм. Тэрээр тэдэнд өөрийн *Евангелийг болон үхсэнийхээ дараа Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очихын тулд юу хийх ёстойг нь зааж өгсөн байна.

Хүмүүс Исүст итгэж, түүнийг олон жилээр дагажээ. Тэд сайн хүмүүс байж, амгалан тайван амьдарч байв. Гэвч тэд Исүсийн тухай мартаж эхэлсэн байна. Тэд зарлагуудын үгийг сонсохоо больж, муу үйл хийцгээх боллоо.

Энэ номын сүүлчийн зарлага нарын нэг болох Мормон өөрийн ард түмэн Нифайчуудын түүхийг хүү Моронайдаа дамжуулсан байна. Өөрийнх нь бүх хүмүүс Ламаничуудтай хийсэн аугаа их тулалдаанд үхэж үрэгдсэний дараа Моронай зарлагуудын бичсэн өөрийн ард түмний түүхийг нэгэн ууланд булж нуусан ажээ.

Ийнхүү тэр түүх ууланд булаастай хэвээр олон зуун жилийг өнгөрөөв. Эцэст нь 1820 онд Тэнгэр дэх Эцэг маань Жозеф Смитийг өөрийн зарлагаар сонгож, уг түүхийг нуусан газрыг Жозефт үзүүлэхээр *дахин амилсан Моронайг илгээжээ. Жозеф тэр түүхийг англи хэлнээ хөрвүүлсэн юм. Эдүгээ түүнийг Мормоны Ном гэдэг билээ.

Мормоны Ном нь Тэнгэр дэх Эцэг маань газар дэлхийн хаана ч байгаа хүмүүсийг мэддэг, хайрладаг гэдгийг үзүүлэхийн тулд бичигдсэн юм. Исүс бол газар дэлхийн бүх ард түмний Аврагч, Тэнгэр дэх Эцгийн маань Хүү гэдгийг Мормоны Ном заадаг.

Сургаал ба Гэрээ

Сургаал ба Гэрээ нь өнөө үеийн хүмүүст хандсан Тэнгэр дэх Эцгийн маань үгийг агуулна. Энэ номд Исүс Христийн Сүмийн зохион байгуулалт, удирдлагын талаар өгүүлэх бөгөөд сүмийн удирдагчид болон гишүүдийн үүрэг хариуцлагыг тусгасан байдаг. Түүнээс гадна урт удаан хугацаагаар газар дэлхийн хүмүүст хүртээл болж чадаагүй сургаал номлолыг агуулсан, мөн Библийн зарим сургаалыг тайлбарласан байдаг.

Сургаал ба Гэрээ нь эдүгээ амьдарч буй та бидэнд зориулсан илгээмжийг агуулдаг юм. Энэхүү судар бидэнд Тэнгэр дэх Эцгээ үл дагавал учирч болох зүйлсийн тухай сануулж, түүнийг дагавал хүртэж болох Тэнгэр дэх Эцгийн маань бидэнд бэлтгэсэн гайхамшигт зүйлсийн талаар өгүүлнэ.

Асар Үнэт Сувд

Асар Үнэт Сувд нь Моүзесийн Ном, Абрахамын Ном болон Жозеф Смитийн намтар түүхээс бүрдэнэ.

Моүзесийн Ном нь Тэнгэр дэх Эцгийн маань Моүзест харуулсан үзэгдлүүдийн тухай юм. Энэ нь газар дэлхийг хэрхэн бүтээснийг тайлбарлаж, Библийн судраас алдагдаж гээгдсэн сургаалуудыг агуулдаг.

Абрахамын Ном нь газар дэлхий дээрх бүтээлтийн болон Тэнгэр дэх Эцэг, түүний хүчин чадлын тухай өгүүлдэг юм.

Жозеф Смитийн түүх нь Тэнгэр дэх Эцэг түүнийг хэрхэн зарлага болгохоор дуудсан тухай өгүүлнэ. Энд мөн түүний Библийн орчуулгын хэсгээс гадна Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн итгэл бишрэлийг тайлбарласан үгс бий. Тэдгээрийг Итгэлийн Тунхаг гэдэг.

Өнөөдөр амьдарч буй Тэнгэр дэх Эцгийн маань зарлага ч түүнд Тэнгэр дэх Эцгийн маань хэлсэн зүйлсийг бичсээр байдаг. Тэнгэр дэх Эцэг маань эртний зарлагуудад олон тооны аугаа их, чухал зүйлсийг мэдүүлсэн билээ. Тэр одоо ч өөрийн зарлагад тэдгээр зүйлийг мэдүүлсээр байна.

Ярилцлага

- Бидэнд ямар дөрвөн судар ном байгаа вэ?
- Яагаад бидэнд ном нэг бүр чухал байдаг вэ?

Судруудыг Уншиж Судлахад Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Тусална

Судруудад Тэнгэр дэх Эцэг маань биднийг түүнд эргэн очиход туслах төлөвлөгөөгөө заадаг. Судрыг уншиж судалснаар бид түүний биднийг мэдэж, хийхийг хүсч буй зүйлсийг мэдэх болно. Хэрэв судрыг уншихгүй юм бол түүнд юу байгааг бид мэдэж авч чадахгүй билээ. Бид Тэнгэр дэх Эцгийнхээ биднээс юу хийхийг хүсч буйг мөн мэдэж чадахгүй.

Бид судрыг өдөр бүр унших хэрэгтэй. Мөн судраас гэр бүлийнхэндээ уншиж өгч, тэдгээрийг ойлгоход нь тусалж байх нь зүйтэй. Эдгээр ариун ном судрууд Тэнгэр дэх Эцгээс маань ирсэн болохыг бид өөрсдийн үр хүүхдэд зааж сургах хэрэгтэй. Тэднийг эдгээр номнуудад юу агуулагдаж буйг мэдэхэд нь, мөн тэдгээрт талархалтай байхад нь бид туслах ёстой юм.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэг маань биднийг судар уншиж судлахад хэрхэн туслах вэ?

Лавламж

Тэнгэр дэх Эцэг Маань Ариун Бичвэрүүдийг Бидэнд Хайрласнаар Өөрийн Хайрыг Илэрхийлдэг

- 2 Тимофей 3:16-17 (Тэнгэр дэх Эцэг маань бидэнд туслахаар судруудыг өгдөг.)
- 2 Нифай 29:3-13 (Тэнгэр дэх Эцэг маань түүнийг дагасан бүх хүмүүст судраа хайрладаг.)
- 2 Нифай 33:10 (Судрууд бидэнд Исүс Христийн үгийг өгдөг.)

Бидэнд Судрын Дөрвөн Ном Бий


- 2 Нифай 3:12, 2 Нифай 29 (Тэнгэр дэх Эцэг маань олон зарлагад судар бичихийг тушаажээ.)
- Сургаал ба Гэрээ 20:9 (Мормоны Ном нь Исүсийн заасан евангелийг агуулдаг.)


Судруудыг Уншиж Судлахад Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Тусална

- Жон 5:39 (Судраа уншицгаа. Тэдгээр нь бидэнд Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиход туслах болно.)
- Мормон 7 (Бидний мэдэх ёстой зүйлсийг судар зааж өгдөг.)
- Моронай 10:3-5 (Судруудыг үнэн гэдгийг мэдэхэд Ариун Сүнс бидэнд туслах болно.)

БИДНИЙ АВРАГЧ ИСУС ХРИСТ

Дөрөвдүгээр хэсэг





Бидний Аврагч, Исус Христ ердийн нэг саравчин доор мэндэлсэн билээ.

ИСҮС ХРИСТИЙН АМЬДРАЛ

11-р бүлэг

Исүс Христ бол биднийг Тэнгэр дэх Эцэгт маань эргүүлэн аваачиж чадах цорын ганц хүн юм. Та түүний тухай юу мэдэх вэ?

Олон Хүн Исүс Христийн Ирэхийг Маш Ихээр Хүсэн Хүлээж Байжээ

Исүс бидний Аврагч болохыг хүссэн юм. Тэрээр бидэнд хэрхэн Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж болохыг үзүүлэхээр газар дэлхийд ирнэ гэж хэлжээ. Исүсийг мэндлэхээс өмнө амьдарч байсан олон хүн түүнийг тэдний Аврагч болохоор заларч ирнэ гэдэгт итгэж байсан юм. Тэд түүний ирэхийг хүлээж байлаа. Өөрсдийн гэм нүглээс болж хүлээх мөнхийн шийтгэлээс тэднийг аварна гэдгийг тэд мэдэж байв.

Исүсийг мэндлэхээс өмнө амьдарч байсан бүх зарлагууд түүний ирэхийг хүмүүст хэлдэг байлаа. Тэнгэр дэх Эцэг маань Исүс газар дэлхийд ирэх болно гэдгийг Адамд хэлүүлэхээр тэнгэрийн элчээ илгээж байсан юм.

Исүсийг мэндлэхээс олон жилийн өмнө Исай хэмээх нэгэн зарлага Исүс бидний нүгэл хилэнцийг төлөхийн тулд зовж шаналж байгаа үзэгдлийг харжээ. Хүмүүс Исүсийг үзэн ядаж, үл ойшоох бөгөөд Исүс маш ихээр эмгэнэн гашуудна гэдгийг Исай хэлсэн байна.

Мормоны Номд гардаг зарлага Нифай Исүсийн хийж гүйцэтгэх зүйлсийг харжээ. Нифай тэдгээрийг Исүсийг мэндлэхээс олон жилийн өмнө харсан юм. Тэрээр эхийнхээ гар дээр байгаа нялх Исүсийг харжээ. Тэнгэрийн элч Нифайд тэр нялх хүүхэд бол Тэнгэр дэх Эцгийн маань Хүү болохыг хэлсэн юм.



*Балчир хөвгүүн байсан хэрнээ Исүс ариун сүмд эрдэм номтой
хүмүүст сургаал айлдаж байв.*

Карл Блок. Дани улсын Фредериксбург Шилтгээний Дуган дахь эх зураг.
Фредериксбург музейн зөвшөөрлөөр нийтлэв.

Бид Мормоны Номд Бенжамин хэмээх нэгэн зарлагын тухай уншдаг. Тэр хүмүүст Исүс удахгүй газар дэлхийд ирнэ гэж хэлжээ. Бенжамин хүмүүст Исүс өвчтөнийг эдгээж, тахир татууг явдаг болгож, сохор хүнд хараа, дүлий хүнд сонсгол оруулах болно гэж хэлсэн юм. Тэрээр мөн муу ёрын сүнсүүдийг зайлуулж, үхсэн хүмүүсийг амьдруулах болно. Исүс хүмүүст Тэнгэр дэх Эцгээ болон бие биесээ хайрлаж явахыг заана гэдгийг Бенжамин хэлж байв.

Исүсийг мэндэлсний дараагаар амьдарч байсан зарлагууд ч бидэнд түүний ирсэн гэдгийг хэлсээр байлаа. Исүс Христгүйгээр Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөө бүтэмжгүй болох байсан юм.

Ярилцлага

- Исүс яагаад газар дэлхийд ирэхийг хүссэн бэ?
- Түүнийг ирнэ гэдгийг гэрчилж байсан ямар зарлагууд байна вэ?

Исүсийн Мэндэлсэн нь Дэлхий Ертөнцөд Асар Их Баяр Баясгалан Авчирсан Юм

Исүс Бэтлэхэм гэдэг нэгэн жижиг хотод төржээ. Түүнийг мэндлэхэд бурхны элч нар баярласандаа дуулцгааж байлаа. Тэнгэрт нэгэн шинэ од гарчээ. Хоньчид болон мэргэн хүмүүс түүнийг харж, мөргөхөөр ирцгээсэн юм. Одоо ч дэлхий даяар олон хүн түүний мэндэлсэн өдрийг тэмдэглэсээр байгаа билээ.

Исүс бусад хүүхдүүдээс их ялгаатай байлаа. Исүсийн аав нь Тэнгэр дэх Эцэг маань билээ. Тэнгэр дэх Эцэг маань зөвхөн түүний сүнсний эцэг ч биш, мөн яс, махан бие цогцосных нь эцэг байсан юм. Бусад хүнд байхгүй тийм хүчин чадлыг Исүс Эцгээсээ хүлээн авсан юм. Түүнийг өөрөө зөвшөөрөхөөс нааш хүмүүс түүний амийг хороож үл чадах байлаа. Үхсэнийхээ дараа тэрээр өөрийн биеийг дахин амилуулах чадалтай байжээ.

Исүсийн эхийг Мария гэдэг байв. Тэрээр одоогоос 2,000 жилийн тэртээ Израиль хэмээх газар амьдарч байсан цэвэр ариун бүсгүй юм. Түүнийг хараахан гэрлэж амжаагүй, ариун онгон байх үед нь Тэнгэр дэх Эцгийн маань элч түүн дээр хүрч очжээ. Бурхны элч түүнийг Исүс Христийн эх болно, мөн Исүсийн эцэг нь Тэнгэр дэх Эцэг маань байх болно гэдгийг хэлэв. Энэ дэлхийн ямар ч эр хүн түүний эцэг болох учиргүй.

Тэр элч мөн Мариягийн гэрлэх гэж байсан хүн дээр очжээ. Түүнийг Жозеф гэдэг байв. Элч түүнд удалгүй төрөх хүүхэд бол энэ дэлхийн хэн нэгэн хүний хүүхэд биш, харин Тэнгэр дэх Эцгийн маань Хүү байх юм гэдгийг хэлжээ. Элч түүнийг Мариятай гэрлэх хэрэгтэй гэснээр Жозеф, Мария хоёр гэрлэсэн ажээ. Исүсийг төрсний дараа Жозеф түүнийг өөрийн хүү шигээ хайрлан халамжилсан юм.

Эх нь жирийн хүн байсан учраас Исүс өлсөж цангах, өвдөж зовохыг мэдэрч, үхэж ч болох байлаа.

Ярилцлага

- Исүсийн мэндэлсэн нь чухал үйл явдал байсан гэдгийг бид хэрхэн мэддэг вэ?
- Исүс Эцгээсээ ямар хүчин чадлыг хүлээн авсан бэ?
- Эх нь газар дэлхийн жирийн хүн байсан тул Исүс юуг мэдрэх чадвартай байсан бэ?

Исүс Бидэнд Өөрийн Евангелийг Заахаар Ирсэн Юм

Исүс Нүгэл Хилэнцгүй Байлаа

Исүс нүгэл хилэнцгүй байлаа. Тэрээр Тэнгэр дэх Эцгийнхээ түүнээс хийхийг хүссэн бүх зүйлийг хийдэг байв. Исүс бусад хүүхдүүдийн нэгэн адил өсч торнисон юм. Том болохын хэрээр тэр ухаалаг болж байлаа. Түүнд Тэнгэр дэх Эцгийн маань хүчин чадал байв.

Исүс 12 орчим настай байхдаа Тэнгэр дэх Эцэг маань түүнийг ямар нэгэн зүйл хийлгэхээр илгээснийг мэджээ. Газар дэлхий дээр түүний хийх ёстой онцгой ажил үйлс буйг тэр мэдэж байлаа.

Нэгэн өдөр тэр Жозеф, Мария нарын хамтаар Иерусалимыг зорьжээ. Жозеф, Мария хоёр гэртээ харих замдаа Исүс тэдний хажууд алга байгааг мэдэв. Тэд түүнийг хайхаар Иерусалим руу буцав. Гурав хоногийн дараа тэд түүнийг ариун сүмд мэргэн хүмүүстэй ярилцаж, тэдний асуултад хариулж байхад нь олжээ. Түүнийг сонссон хэн боловч асар их зүйл мэдэж, тэдний асуултад хариулж чадаж байгааг нь гайхаж байлаа. Жозеф, Мария хоёр түүнийг олсондоо баярласан боловч тэднээс үлдэж хоцорсонд нь сэтгэл дундуур байв. Исүс тэдэнд Тэнгэр дэх Эцгийнхээ ажлыг хийх ёстой байснаас тийнхүү үлдсэн юм гэж хэлжээ.

*Исүс *Усаар Батлуулав*

Исүс 30 настай байхдаа усаар батлуулахаар Жон Баптист дээр очжээ. Исүс ямар нэгэн нүгэл хилэнц хийгээгүй тул түүнийг усаар батлах ёсгүй гэж Жон боджээ. Гэвч Исүс өөрийг нь усаар батлахыг Жоноос хүсэв. Исүс Тэнгэр дэх Эцгийнхээ бүх хууль зарлигийг дагахыг хүсч байлаа. Жон Исүсийг усанд далд ортол нь дүрээд дахин өргөж босгон усаар баталжээ. Исүсийг усаар батлуулсны дараа Тэнгэр дэх Эцэг маань тэнгэрээс ярьж, Исүс бол түүний Хүү бөгөөд Тэр- Тэнгэр дэх Эцэг маань түүнд маш их баяртай байгаагаа хэлсэн байна. Мөн Исүсийг усаар батлуулсны дараа Ариун Сүнс түүнд иржээ.

Сатан Исүсийг Ятгасан нь

Усаар батлуулсныхаа дараа Исүс ганцаар байж, мацаг барин залбирахаар цөлд очив. Түүнийг 40 хоног мацаг барьсны дараагаар Сатан ирж, түүнийг ятгажээ. Хэрэв Исүсээр нэг л нүгэл хийлгэж чадах юм бол тэр өөрийн хийхээр зорьж ирсэн зүйлсээ гүйцэтгэх боломжгүй болно гэдгийг Сатан мэдэж байв. Тэгвэл Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөө нурах байлаа.

Исүс Сатаны бүх ятгалгыг эсэргүүцэн давж чаджээ. Эцэст нь тэр Сатанд явахыг шаардсан бөгөөд Сатаныг явсны дараа бурхны элч нар Исүс дээр ирж бараалхсан юм.

Исүс Бидэнд Тэнгэр дэх Эцгээ Болон Бие Биесээ Хайрлахыг Заасан Юм

Сатаныг няцаасныхаа дараа Исүс хүмүүст зааж эхлэв. Түүний газар дэлхийд ирсэн нэг шалтгаан бол бидэнд хэрхэн амьдрахыг зааж өгөх явдал байсан юм.

Исүс бидэнд Тэнгэр дэх Эцгээ бүх сэтгэл зүрх, бодол санаа, хүч чадлаараа хайрлахыг заасан юм. Мөн бид бусдыг өөрийн адил хайрлах хэрэгтэй гэж Исүс сургажээ. Бид бусдыг уучлан өршөөж, тэдэнд үйлчилж байх хэрэгтэй. Эдгээр зүйлсийг яаж хийхийг Исүс бидэнд үзүүлсэн юм. Тэнгэр дэх Эцгийн өөрийг нь хийхийг хүссэн бүгдийг биелүүлж байснаараа тэр Тэнгэр дэх Эцгээ хайрладаг болохоо харуулсан билээ.

Исүс Бүх Хүнийг Хайрладаг Байсан

Исүс бүх хүнд хайртай байв. Тэр өвчтөнийг эдгээж, сохор хүнд хараа оруулж, тахир татуу хүнийг явдаг болгож байлаа. Тэр хүүхэд багачуудыг гартаа өргөж, тэднийг адислан ерөөдөг байсан юм.

Исүс нүгэл хилэнц хийсэн хүмүүст ч хайраа үзүүлдэг байв. Тэр тэдэнд нүгэл хийсэндээ гэмшиж, дахин нүгэл үйлдэхгүй байхыг зааж өгдөг байлаа. Тэдний төлөө тэр Тэнгэр дэх Эцэгтээ залбирдаг байсан юм. Исүс бидэнд тэр биднийг хэрхэн хайрлаж байсны адилаар бие биесээ хайрлахыг сургасан билээ.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэгтээ хайраа үзүүлэхийн тулд бид ямар зүйлсийг хийж болох вэ?
- Бусдад хайраа үзүүлэхийн тулд бид юу хийж болох вэ?

Исүс Сүм Байгуулав

Исүс бүх хүмүүсийг Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очих замыг мэдээсэй гэж хүсч байв. Түүний энэ замыг Евангели гэж нэрлэдэг. Исүс бүх хүмүүст Евангелийн сургаалтай танилцах боломжийг олгохоор сүм байгуулжээ.

Сүмийг удирдах Төлөөлөгчид буюу арван хоёр хүнийг Исүс сонгов. Түүнийг тэнгэрт буцсаны дараа тэд хүмүүст Евангелийг заах учиртай байлаа. Исүс Арван Хоёр Төлөөлөгчдөд түүнийг төлөөлөх эрх мэдэл өгсөн юм. Тэд бүх хүнд Евангелийн сургаалыг зааж, тэднийг усаар батлах болно. Тэд Евангелийг бусдад зааж, Исүсийн хийх гэж хүсч байсан зүйлийг хийхэд нь тусалж чадах хүмүүсийг сонгож чадах болжээ.

Ярилцлага

- Исүс ямар учраас Арван Хоёр Төлөөлөгчдийг сонгосон бэ?

Исүсийн Тухай Судалж Мэдсэнээр Бид Түүний Ямар Аугаа Их Хүн Болохыг Ойлгодог

Исүс бидэнд хэрхэн амьдрахыг өөрийн биеэр харуулсан билээ. Бид түүнтэй адил болохыг сурч байхдаа биднийг аз жаргалтай болгож чадах тэр зүйлсийг мэдэж авдаг. Мөн бид Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиход маань туслах зүйлсийг сурах болно.

Исүс биднийг хайрладаг гэдгийг мэдэхэд бидэнд амар тайван байдаг. Бид айх аюулгүй байгаагаа мэдэрдэг. Тэр бидний Аврагч байж чадна гэдгийг бид мэднэ. Тэр бидний бэрхшээл зовлонг ойлгоно. Түүний сургаалууд бидэнд аливаа бэрхшээлийг даван туулахад тусалдаг. Исүсийн бидний төлөө хийсэн бүх зүйлийг ойлгоход түүнийг хайрлах хайр маань улам нэмэгддэг билээ. Бидний хайр түүнийг дагах хүслийг бий болгоно. Түүнтэй хамт байх тэр цагийг бид хүсэн хүлээж байна.

Ярилцлага

- Исүсийн тухай мэдлэг бидэнд яаж тусалдаг вэ?
- Исүсийн тухай мэдэх тусам та юуг мэдэрдэг вэ?

Лавламж

Олон Хүн Исүс Христийн Ирэхийг Маш Ихээр Хүсэн Хүлээж Байжээ

- Исай 53:3-7 (Исай Исүсийн Тухай хэлжээ.)
- Мосайя 3:5-7 (Бенжамин Исүсийн хийх зүйлсийг өгүүлжээ.)

*Исүсийн Мэндэлсэн нь Дэлхий Ертөнцөд Асар Их Баяр
Баясгалан Авчирсан Юм*


- Лук 2; 3 Нифай 1 (Исүс мэндэлсэн нь)

Исүс Бидэнд Өөрийн Евангелийг Заахаар Ирсэн Юм

- Матвей 3:15-17 (Исүс усаар батлуулав.)
- Матвей 4:1-11 (Сатан Исүсийг ятгав.)
- Матвей 25:35-46; Жон 15:12 (Исүс биднийг бусдад туслахыг хүсч байна.)
- Марк 1:34; Матвей 14:14 (Исүс өвчтэй хүмүүсийг анагаав.)
- Лук 2:40 (Исүс хүүхэд ахуй цагаасаа нэн ухаалаг болжээ.)
- Лук 2:46-47 (Исүс ариун сүмд эрдэм номтой хүмүүст сургаал айлдсан нь.)
- Жон 8:28-29 (Тэнгэр дэх Эцгийнхээ түүнээс хийхийг хүссэн бүх зүйлийг Исүс хийж гүйцэтгэсэн.)

*Исүсийн Тухай Судалж Мэдсэнээр Бид Түүнийг Ямар Аугаа
Их Хүн Болохыг Ойлгодог*

- Матвей, Марк, Лук, Жон (Исүсийн амьдрал ба сургаал)



*Гетсиманы Цэцэрлэгт Исүс бүх хүн төрөлхтний
гэмийг өөртөө хүлээсэн юм.*

ИСҮС ХРИСТИЙН ЦАГААТГАЛ


12-р бүлэг

Бидний нүгэл хилэнцээс болж Исүс ихэд зовж шаналж байлаа. Тэр яагаад бидний төлөө амиа золихыг сонгосон бэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Исүс Христийг Бидний Аврагч Болгохоор Газар Дэлхийд Илгээжээ

Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болохын тулд яс, махнаас бүрдсэн биетэй байх хэрэгтэй боловч, Адам Ева хоёр Тэнгэр дэх Эцгийг маань дуулгавартай дагаагүй тул бид бүгдээр мөнх бусыг үзэж, бие махбодоосоо сална гэдгийг Тэнгэр дэх Эцэг маань мэдэж байв. Тэнгэр дэх Эцгийн маань хориглосон жимсийг идсэнээр тэд өөрсдөө болон хожмын үр удам нь мөнх бусыг үзэх болсон юм. Түүнчлэн Тэнгэр дэх Эцэг маань бид бүхнийг газар дэлхий дээр байх хугацаандаа нүгэл үйлдэж, улмаар өөрсдийн гэм нүглийн уршгаар түүнтэй хамт амьдрахаар эргэн очих боломжгүй болно гэж мэдэж байлаа. Нүглийнхээ төлөөсийг барагдуулж, Тэнгэр дэх Эцгээ дуулгавартай даган, ингэснээр түүн дээр эргэн очиход маань бидэнд тусламж хэрэгтэй байсан юм. Мөн үхсэний дараа яс, махан бие цогцсоо эргүүлэн авахад маань тусламж хэрэгтэй байв. Исүс бидэнд тусална гэж хэллээ. Тэр бидний Аврагч байх болно.

Бидний гэм нүглийн төлөөсийг барагдуулахад нүгэл хилэнцгүй хэн нэгэн хүн хэрэгтэй байв. Үүнийг хийж чадах ганц хүн нь Исүс байсан юм. Тэр ямар ч нүгэл үйлдээгүй. Түүнд үхлийг давах хүчин чадал байсан тул бид үхлийн дараа бие махбодоо эргүүлэн авахад маань тэр тусалж чадах байлаа. Тэр бидэнд маш их хайртай байсан юм. Биднийг гэм нүглээс маань ангижруулахын тулд тэр бидний



Исус бүх хүмүүсийн гэм нүглийн өмнөөс загалмай дээр нас эцэслэжээ.

нүглийн өмнөөс ямар ч зовлонг туулахад бэлэн байлаа. Биднийг үхлийн дараа дахин амьдруулахын төлөө тэр амиа өгөхөд бэлэн байв. Исүсийн энэ золиослолыг Цагаатгал гэж нэрлэдэг юм.

Ярилцлага

- Яагаад Тэнгэр дэх Эцэг маань Исүсийг газар дэлхийд зайлшгүй илгээх шааардлагатай болсон бэ?

Исүсийн Туулсан Зовлон нь Тэр Болон Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Ямар Их Хайртай Болохыг Харуулдаг Юм

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд маш их хайртай тул өөрийн Хүү, Исүсийг газар дэлхийд илгээж, бидний төлөө зовлон эдэлж, амиа зориулахыг зөвшөөрсөн билээ. Исүс ч бидэнд хайртайдаа бидний өмнөөс шаналан зовж, амиа золиослосон юм. Исүс түүний зовлон шаналал асар их байхыг мэдэж байлаа. Энэ нь түүний хувьд тэсэхүйеэ бэрх байсан хэдий ч тэр бидэнд Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болох боломжийг олгохыг хүсч байв.

Исүс Гетсиманы Цэцэрлэг хэмээх нэгэн газар очжээ. Тэрээр сөхөрч суугаад Тэнгэр дэх Эцгээсээ тусламж хүсэн залбирав. Тэр Тэнгэр дэх Эцгээс маань хэрэв боломжтой бол түүнийг үл зовоохыг хүсчээ. Гэхдээ Тэнгэр дэх Эцгийнхээ өөрөөр нь хийлгэхийг хүсч буй бүх зүйлийг хийх болно гэв. Исүсийн зовлон эдлэхийг хэн ч албадаагүй. Энэхүү зовлонг даван туулах нь Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөөний нэг хэсэг нь бөгөөд ингэснээр биднийг нүглээс ангижруулах байсан тул тэр өөрөө энэ замыг сонгож авсан юм.

Гетсиманы Цэцэрлэгт Исүс бүх хүн төрөлхтний нүглийн өмнөөс өөрөө тэр нүглийг үйлдсэн мэт ихэд шаналан зовжээ. Эдгээр гэм нүглийн өмнөөс тийнхүү зовлон эдэлсэн нь бидний бодож төсөөлөхөөс хавьгүй хүнд бэрх байсан юм. Тэрээр маш их өвдсөнөөс дагжин чичирч байлаа. Түүний биеийн нүх сүв болгоноос цус асгарч байв.

Дараа нь хорон муу санаатнууд ирж, түүнийг Иерусалимын захирагчдад хүргэв. Тэнд тэд түүнийг доромжлон нулимж, зодож жанчжээ. Тэд өргөст бутаар титэм хийн түүний толгойд өмсгөж, түүнийг шоолон инээлдэж, доог тохуу хийж байлаа.

Захирагчид Исүсийг цовдлохыг цэргүүдэд тушаав. Тэд Исүст хүнд модон загалмай үүрүүлж, цовдлох газар луу туун аваачив. Тэд түүний гар хөлийг загалмайд хадаасаар хадан цовдоллоо. Ийнхүү Адамын дуулгаваргүй байдал болон бидний гэм нүглийн өмнөөс эдэлсэн түүний шаналал зовлон тэр загалмай дээр эцэс болсон юм.

Тэр дүүжлээстэй хэвээр олон цаг болжээ. Хэдийгээр тэр зовж шаналан, зарим хүмүүс түүнийг элэг доог хийж байсан ч тэр чимээгүй, тэвчээртэй байлаа. Эцэст нь тэрээр Тэнгэр дэх Эцэгтээ хандан өөрийн сүнсийг түүнд буцааж буйгаа хэлээд нас эцэслэсэн билээ.

Исүст өөрийгөө үхлээс аврах хүчин чадал байсан юм. Тэр амьдарсаар байж болох байсан боловч, биднийг Тэнгэр дэх Эцэгтэй маань дахин хамт амьдруулахын үүднээс үхлийг сонгосон байна.

Исүсийг үхэхэд түүний сүнс биеийг нь орхижээ. Үхсэнээс нь хойш гурав хоногийн дараа түүний сүнс биедээ эргэн ирж, тэр дахин амилсан юм. Сүнсний биедээ эргэн ирэхийг дахин амилах гэнэ.

Исүс дахин амилсныхаа дараа өөрийн Төлөөлөгчид болон бусад хүмүүст үзэгджээ. Тэрээр Төлөөлөгчдөдөө гар хөлөн дээрх хадаасны шархыг харуулав. Тэд тэдгээр шарх сорвийг тэмтэрч үзээд тэдний удирдагч, Исүс дахин амилсныг мэджээ. Тэр тэдэнтэй явж, хамт хооллов.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хайраа хэрхэн үзүүлсэн бэ?
- Исүс бидэнд хайраа хэрхэн үзүүлсэн бэ?

Исүс Биднийг Нүгэл Хилэнцээсээ Ангижрах Боломжтой Болгожээ

Зөвхөн Исүс л бидний гэм нүглийн төлөөсийг барагдуулж чадсан юм. Бид түүнийг амьдарч байгаа гэдэгт итгэж, хууль зарлигийг нь сахин мөрдсөнөөр түүний эдэлсэн зовлонг өөрсдөдөө хэрэгтэй болгодог. Бид хийсэн нүгэлдээ гэмших ёстой. Тэдгээрийг дахин үйлдэхгүй байх ёстой. Бид Исүс Христийн сургаалыг дагах ёстой. Ингэсэн цагт Тэнгэр дэх Эцэг маань бидний гэм нүглийг өршөөх болно.

Ярилцлага

- Яагаад та бүхнийг гэм нүглээ даван туулахад Исүсийн тусламж хэрэгтэй болдог вэ?
- Исүсийн цагаатгалаар өөрийн гэм нүглийг төлөхийн тулд та юу хийх ёстой вэ?

Исүс Бид Бүгдийг Бие Махбодоо Дахин Олж Авах Боломжтой Болгожээ

Исүс өөрийн хүслээр нас барсан бөгөөд дахин амилсан хамгийн анхны хүн болсон юм. Тэр өөрийгөө дахин амилуулах хүч чадал бүхий цорын ганц хүн байв. Ийнхүү тэр биднийг ч мөн дахин амилах боломжтой болгосон юм.

Бид хэдий үхэх боловч дахин амьдрах болно. Биднийг үхэхэд сүнс маань бидний биеийг орхин одох бөгөөд Исүс үхлийг даван туулсны учир бидний сүнс бие хоёр дахин нэгдэх болно. Ингээд бид хэзээ ч дахин үхэхгүй. Энэ бол газар дэлхийд мэндэлсэн хүн бүрт өгсөн Исүсийн бэлэг юм.

Ярилцлага

- Исүс бидэнд дахин бие махбодоо олж авах боломжийг хэрхэн олгосон бэ?
- Хэн дахин амилах вэ?

Лавламж

Тэнгэр дэх Эцэг Маань Исүс Христийг Бидний Аврагч Болгохоор Газар Дэлхийд Илгээжээ

- Матвей 16:21 (Исүс өөрийн Төлөөлөгчдөд үхээд дахин амилах тухайгаа хэлжээ.)
- Алма 34:9-16 (Бидний нүглийг цагаатгаж чадах ганц хүн нь Исүс байсан юм.)

Исүсийн Туулсан Зовлон нь Тэр Болон Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Ямар Их Хайртай Болохыг Харуулдаг Юм

- Лук 22:39-46 (Исүс Гетсиманы Цэцэрлэгт очсон нь)
- Жон 3:16 (Тэнгэр дэх Эцэг маань бидэнд маш их хайртай тул Исүсийг биднийг аврахаар илгээжээ.)

Исүс Биднийг Нүгэл Хилэнцээсээ Ангижрах Боломжтой Болгожээ

- Ромынхан 5:12-17 (Исүсийн ачаар бид дахин амилах бэлгийг хүлээн авсан билээ.)
- 1 Коринфынхан 15:21-22 (Бид Адамаас болж үхэх, Исүсийн ачаар дахин амилах болсон.)
- 1 Питер 1:18-20 (Исүсийн асгарсан цусны ачаар бид аврагдсан юм.)
- 1 Жон 1:7 (Исүс биднийг нүглээс ангижрах боломжтой болгосон юм.)
- 2 Нифай 9:21-22 (Хэрэв түүний хууль зарлигийг дагавал Исүсийн зовлон биднийг аврах болно.)
- Хеламан 14:15-18 (Исүс бидний төлөө үхсэнээр бид дахин амьдрах байлаа.)
- Мормон 9:12-14 (Дахин амилалт бидэнд үхлийг даван туулах боломжийг өгдөг.)


Исүс Бид Бүгдийг Бие Махбодоо Дахин Олж Авах Боломжтой Болгожээ

- Жон 5:28-29 (Бид бүгд дахин амилах болно.)
- Алма 11:40-45 (Бие махбод маань төгс төгөлдөр байдалд шилжих болно.)

ИСУС ХРИСТИЙН ЕВАНГЕЛИ

Тавдугаар хэсэг





Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очихын тулд бид Исүс Христэд итгэх хэрэгтэй.

ИСҮС ХРИСТЭД ИТГЭХ НЬ

13-р бүлэг

Бид хэдий хараагүй ч гэсэн Исүс Христэд хэрхэн итгэж чадах вэ?

Бид Исүс Христэд Итгэл Найдвараа Өгч Чадна

Итгэлтэй байна гэдэг нь үзэж хараагүй хэрнээ хэн нэгэнд эсвэл ямар нэгэн зүйлд үнэмшиж, энэ үнэмшлийнхээ дагуу үйл ажиллагаа явуулахыг хэлнэ. Жишээлбэл, тариачин хүн үр суулгаж, түүнийгээ арчилж тордвол тэр нь ургах болно гэсэн итгэлтэй байдаг. Ийм ч учраас тэр үрээ суулгаж, усалж, арчилж торддог билээ. Ингэснээр тэр ургац авч, хоол хүнсээ хангадаг.

Исүст итгэлтэй байна гэдэг нь хэдий түүнийг хараагүй ч гэсэн түүнийг амьдарч буйд итгэж, дуулгавартай дагахыг хэлдэг. Бид Исүст итгэлтэй байгаа бол дараах хэдэн зүйлд итгэдэг:

1. Бид Тэнгэр дэх Эцэг маань бидэнд түүний төлөвлөгөөг дагаж мөрдөхөд маань туслахаар Исүсийг илгээсэн гэдэгт итгэдэг.
2. Бид Исүсийг бидний Аврагч гэдэгт итгэдэг.
3. Бид түүнийг энэ дэлхийд Тэнгэр дэх Эцгийн маань Хүү болон мэндэлсэн гэдэгт итгэдэг.
4. Бид түүнийг бидэнд Тэнгэр дэх Эцэгтээ хэрхэн эргэн очихыг зааж өгөхөөр газар дэлхийд ирсэн гэж итгэдэг.
5. Бид тэр бидэнд хайртай гэдэгт итгэдэг.
6. Бид түүнийг бидний гэмийн өмнөөс шаналан зовсон, тэгснээр бид нүглээ гэмшин наманчилж, шийтгэл хүлээхгүй байж чадна гэдэгт итгэдэг.
7. Бид тэр үхээд дахин амилсан гэдэгт итгэдэг.

8. Бид түүний сургаалууд үнэн гэдэгт итгэдэг.
9. Бид хэрэв Исүсийг дагавал Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очих болно гэдэгт итгэдэг.

Исүст итгэх нь Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очихын үндэс юм. Хэрэв бид түүнд итгэдэг, найддаг бол түүний тухай мэдэхийг хүсдэг. Исүс бол биднийг Тэнгэр дэх Эцэгт маань дагуулан аваачиж чадах цорын ганц хүн юм. Зөвхөн түүнд итгэдэг, түүнийг дуулгавартай дагадаг хүмүүс л Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж чадна.

Ярилцлага

- Итгэл гэж юу вэ?
- Исүст итгэх итгэл гэж юуг хэлэх вэ?
- Исүсийн тухай бид ямар зүйлст итгэдэг вэ?
- Бид яагаад Исүс Христэд итгэх хэрэгтэй вэ?

Исүс Бидэнд Түүнд Итгэх Итгэлийг Гүнзгийрүүлэх Арга Замыг Өгчээ

Исүс бидэнд хэрхэн түүний тухай мэдэж, түүнд итгэж болохыг хэлж өгсөн юм. Тэр бидэнд судруудыг уншиж, зарлагуудын түүний тухай юу гэж бичсэнийг судлахыг тушаасан юм. Мөн өнөөдөр амьдарч буй зарлагын юу хэлэхийг сонсохыг хүсчээ. Эдгээрийг биелүүлснээр бид Исүсийн тухай улам ихийг мэдэх болно.

Бид Исүсийн тухай судалж байхдаа залбирах хэрэгтэй. Исүсийн тухай уншиж, сонсож буй зүйлээ ойлгоход маань туслахыг Тэнгэр дэх Эцгээсээ хүсэх хэрэгтэй юм. Тэнгэр дэх Эцэг маань бидэнд судлан буй зүйлээ ойлгоход маань туслахаар Ариун Сүнснийг илгээх болно. Ариун Сүнс бидэнд Исүс бол Тэнгэр дэх Эцгийн маань Хүү, бидний Аврагч бөгөөд түүний сургаалууд үнэн юм гэдгийг хэлж өгөх болно.

Алма хэмээх нэгэн зарлага хэрэв бид аливаа зүйлийн үнэн эсэхийг мэдэхийг хүсвэл түүнээ шалгаж үзэх хэрэгтэй гэжээ. Тэр үүнийг үр суулгахтай зүйрлэсэн байна. Хэрэв бид сайн үр суулгаад арчилж тордвол тэр маань ургаж, бид түүнийг сайн үр байжээ гэж мэднэ. Хэрэв үр маань ургахгүй бол бид муу үр байсныг нь мэдэх болно. Үүний нэгэн адилаар бид хэрэв Исүсийн сургаалын үнэн эсэхийг мэдэхийг хүсвэл түүнийг судалж, даган мөрдөх хэрэгтэй.

Исүст итгэнэ гэдэг бол зөвхөн түүнд итгэдэг гэж хэлэхээс хавьгүй илүү зүйл билээ. Энэ нь бид түүнд маш ихээр итгэн найдаж, биднийг юу хийхийг тушаасан ч түүнийг дагах хүсэлтэй байна гэсэн үг юм. Үнэнчээр Исүсийг дагадаг тэр л хүмүүс түүнд итгэлтэй байдаг. Бид түүнийг дуулгавартайгаар дагах тусам бидний итгэл улам бүр хүчтэй болдог. Бид түүний сургаалууд нь жирийн хүнийх биш, харин Тэнгэр дэх Эцгийнх маань гэдгийг мэдэх болно.

Хэрэв бид Исүсийг дуулгавартай дагахгүй бол бидний итгэл сулардаг. Бидэнд хийхийг тушаасан зүйлсийг нь хийснээр итгэл маань хүчирхэгжинэ. Итгэл маань батжисаар бид түүнийг харсан юм шигээр түүний амьдран буйд огтхон ч үл эргэлзэх мэдлэгт хүргэнэ.

Ярилцлага

- Бид Исүсийг хараагүй байж хэрхэн түүнд итгэж чадах вэ?
- Исүст итгэлтэй байхын тулд бид яагаад түүнийг дуулгавартай дагах ёстой вэ?

Исүст Итгэснээр Бид Асар Их Мэдлэг, Хүчин Чадлыг Хүлээн Авах Болно

Бидний судраас уншиж мэддэг тэр зарлагуудын Исүст итгэх итгэл нь маш хүчтэй байсан. Энэ итгэл нь тэдэнд хүн арддаа туслах хүчийг өгдөг байжээ. Тэд Исүст итгэдэг байсан учир өөрийн биеэр хийж чадахааргүй зүйлсийг хийх гийм хүчин чадалтай байв.

Исүсийг мэндлэхээс өмнө Тэнгэр дэх Эцэг маань түүнийг Ной хэмээх зарлага дээр очиж, хөлөг онгоц барихыг тушаахыг даалгажээ. Учир нь Нойгийн үед амьдарч байсан муу явдалт хүмүүс нүглээ наманчлан гэмшихгүй бол Тэнгэр дэх Эцэг маань их усан галав юүлүүлэх гэж шийдсэн байлаа. Хүмүүс нүглээ гэмшин наманчилсангүй. Ной Исүст итгэн хөлөг онгоц босгов. Галав юүлэхэд нүглээ наманчлаагүй бүх хүмүүс үрэгдэж, Ной болон түүний гэр бүлийнхэн Исүст итгэж, түүний хий гэснийг хийсэн учраас хөлөг онгоцондоо суун аврагджээ.

Моүзес бол өөрийн ард түмнийг боолчлолоос гарган авсан зарлага байлаа. Моүзес Исүст итгэж, түүний тушаалыг биелүүлдэг байсан тул Тэнгэр дэх Эцэг маань түүнд туслуулахаар Исүсийг илгээсэн юм.

Исүсийг газар дэлхий дээр амьдарч байхад нэгэн эмэгтэй түүнд маш ихээр итгэдэг байв. Тэр удаан хугацаагаар өвчтэй байсан бөгөөд зөвхөн Исүсийн хувцсанд л хүрч чадвал өвчнөөсөө салах болно хэмээн итгэдэг байжээ. Исүс хуран цугласан олны дунд явж байлаа. Нөгөөх эмэгтэй хүмүүсийг түлхэлсээр түүн дээр очиж, түүний хувцсанд гараа хүргэн тэр даруйдаа эдгэрчээ. Исүс түүнд өөрийн тань итгэл таныг эдгээлээ хэмээн хэлсэн байна.

Зарлага Жозеф Смит Исүст итгэдэг байлаа. Тэр Библиэс хэрэв бид Тэнгэр дэх Эцэг маань бидний асуултад хариулна гэж итгэвэл тэр хариултыг өгөх болно гэж бичсэнийг уншжээ. Жозеф Тэнгэр дэх Эцэгтээ хандан залбирав. Тэнгэр дэх Эцэг маань Исүсийн хамтаар түүнд харагджээ. Тэнгэр дэх Эцэг маань Жозефт Исүсийн үгийг сонсоод түүний тушаасныг биелүүл гэлээ. Жозеф Исүсийг дуулгавартай дагасны тул тэрээр Мормоны Номыг хүлээн авч, Исүс Христийн Сүмийг дахин сэргээсэн юм.

Хэрэв бид түүнд итгэвэл Исүс бидэнд ч мөн туслах болно. Бидний урам зориг мохсон үед тэр бидэнд тусална. Тэр бидэнд нүглийг даван туулахад тусална. Бид өөрсдийн гэр бүл, бусад хүмүүст туслах боломжтой болно.

Бид Исүст итгэвэл Тэнгэр дэх Эцгийнхээ төлөвлөгөөг дагаж эхэлдэг. Бид Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиход маань туслах тийм л зүйлсийг хийх зорилготой ажиллаж, амьдрах болно. Ийнхүү тууштай байваас бид хэзээ нэгэн цагт түүнтэй мөнхөд хамт амьдрах боломжтой болно.

Ярилцлага

- Бид Исүст итгэлтэй байснаар ямар мэдлэг, хүчин чадлыг хүртэж болох вэ?

Лавламж

Бид Исүс Христэд Итгэл Найдвараа Өгч Чадна

- Жон 14:6 (Зөвхөн Исүс л бидэнд Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очих замыг зааж өгч чадна.)
- Үйл явдал 4:12; 2 Нифай 2:9, 9:23; Мосайя 3:12 (Исүст итгэдэг хүмүүс л гэм нүглээс аврагдаж чадна.)

- Еврейчүүд 11:1; Алма 32:21 (Итгэлтэй байна гэдэг нь харж үл чадах зүйлд үнэмшихийг хэлнэ.)
- Еврейчүүд 11:6 (Итгэлгүйгээр бид Тэнгэр дэх Эцэгтээ үйлчилж чадахгүй.)
- Мосайяа 4:10-11 (Бид Исүст итгэх хэрэгтэй.)

*Исүс Бидэнд Түүнд Итгэх Итгэлийг Гүнзгийрүүлэх Арга
Замыг Өгчээ*

- Жон 5:39 (Сударт Исүсийн талаар гэрчилдэг тул бид түүнийг судлах ёстой.)
- Жон 7:16-17 (Бид Исүсийн тушаасныг биелүүлбэл түүний сургаал үнэн гэдгийг мэдэх болно.)
- 1 Коринфынхан 12:3 (Исүст итгэхэд маань Ариун Сүнс тусалдаг.)
- Жеймс 2:17 (Исүсийн тушаасан зүйлсийг биелүүлснээр бид түүнд итгэдгээ харуулж чадна.)
- Алма 32:27-39 (Хэрэв бид Исүсийг дагахаар хичээх юм бол түүний сургаалууд сайн болохыг мэднэ.)

*Исүст Итгэснээр Бид Асар Их Мэдлэг, Хүчин Чадлыг Хүлээн
Авах Болно*

- Лук 8:43-48 (Исүс өөрт нь итгэлтэй нэгэн эмэгтэйг эдгээжээ.)
- Еврейчүүд 11 (Исүс итгэл бишрэлтэй олон хүмүүст тусалжээ.)

НАМАНЧЛАЛ

14-р бүлэг

Буруу үйл хийх нь биднийг уйтгар гунигтай болгодог. Яавал бид ямар нэгэн буруу зүйл хийснийхээ дараагаар дахин баяр баясгалантай болж чадах вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Нүглийг Даван Туулах Замыг Бэлтгэж Өгсөн Юм

Тэнгэр дэх Эцэг маань бид бүгдийг газар дэлхий дээр байхдаа буруу зүйл хийнэ гэдгийг мэдэж байв. Бидний хийдэг тэдгээр буруу үйлийг нүгэл гэнэ. Бурхны хориглосон зүйлийг хийх нь нүгэл үйлдэж байна гэсэн үг юм. Бурхны хүссэн зүйлийг хийхгүй бол мөн нүгэлд тооцогдоно.

Тэнгэр дэх Эцэг маань нүгэл үйлддэггүй бөгөөд өөртэйгөө хамт амьдрах хүмүүсийг ч нүгэл үйлдэхийг үл зөвшөөрнө. Түүнтэй хамт амьдрахын тулд бид нүглээ наманчлах ёстой. Наманчилна гэдэг нь гэм нүгэлдээ гэмшин, түүнийг дахин үйлдэхгүй байхыг хэлнэ.

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хайртай. Тэр биднийг түүн дээр эргэн очиход маань бидний гэм нүгэл саад болохыг үл хүсдэг. Ингээд тэр бидэнд туслахаар нэгэн замыг төлөвлөсөн юм.

Биднийг нүглээ наманчлахад маань туслахаар Тэнгэр дэх Эцэг маань Исүсийг илгээжээ. Нүглээс зайлсхийхийн тулд бид юу хийвэл зохих вэ гэдгийг Исүс бидэнд заадаг. Мөн бидэнд тэдгээр зүйлсийг хийх хүч тэнхээг хайрладаг. Хэрэв бид түүнд итгэн дагах юм бол тэр бидний зүрх сэтгэлийг шинэчлэх бөгөөд ингэснээр бид нүгэл хийхийг тэвчин, гагцхүү сайн үйл хийх эрмэлзэлтэй болдог.

Бид Исүст итгэж, нүглээ наманчлах аваас түүний эдэлсэн зовлон бидний нүглийг цагаатгаж, бид ариусах болно. Ийнхүү бид нэгэнт ариуссан учраас Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очих боломжийг олно.

Ярилцлага

- Наманчлах гэж юуг хэлэх вэ?
- Яагаад Тэнгэр дэх Эцэг маань биднийг нүглээ наманчлахыг хүсдэг вэ?
- Яагаад Исүст үнэхээр итгэсэн хүмүүс нүглээ наманчилдаг юм бэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Нүглээ Наманчлахын Тулд Юу Хийх Хэрэгтэйг Хэлж Өгсөн

Наманчлахын тулд бид Исүст болон түүний сургасан зүйлст итгэх ёстой. Бид түүнийг бидний гэм нүглийн төлөө зовсон гэдэгт итгэх ёстой. Зөвхөн тэр л бидний нүглийг цагаатгаж чадна гэдэгт бид итгэх ёстой. Тэр биднийг нүглээ даван туулаасай гэж хүсч байгаад мөн үүнийг хийхэд маань тусална гэдэгт итгэх ёстой юм. Бид түүний тушаасан зүйлсийг хийхийн тулд хичээнгүйлэн хөдөлмөрлөх ёстой.

Бид нүглээ наманчлахдаа Исүст биднийг өөрийн хүслээр өөрчлөхийг зөвшөөрдөг. Бид муу үйл хийхээ больж, сайн үйлийг хийж эхэлнэ. Хэрэв бид худал ярьж байсан бол түүнээ больж, зөвхөн үнэнийг л ярих болно. Ямар нэгэн зүйлийг хулгайлсан бол түүнээ эзэнд нь буцаан өгч дахин хэзээ ч хулгай хийхгүй болно. Хэрэв бид бусдад хатуу ширүүн ханддаг байсан бол тэдэнтэй эелдэг зөөлөн харьцах болно.

Бид нүглээ наманчлахдаа доорх зүйлсийг хийдэг:

Бид нүглэл үйлдсэнээ хүлээн зөвшөөрнө. Тэнгэр дэх Эцгээ дагахгүй байгаа бол бид гэм хийж буйгаа мэднэ. Нүглээ наманчлахдаа бид буруу зүйл хийж байгаагаа цагаатгах хэрэг биш харин буруу зүйл хийснээ зөвшөөрч өөрчлөгдөхийг хүсдэг.

Бид буруу зүйл хийсэндээ харамсан гэмшидэг. Бид гэм нүглээ наманчлан байхдаа гэм хийсэндээ үнэн сэтгэлээсээ харамсдаг. Бид гэм нүгэлтэйдээ гэмшиж байна гэж зөвхөн хэлэх биш харин үнэхээр гутарч, тэдгээрийг хийхгүй байх нь яав даа хэмээн хүсдэг юм. Мөн Тэнгэр дэх Эцгийнхээ тушаасан зүйлийг хийхийг хүсдэг.

Бид буруу зүйлийг хийхээ болино. Бид зөвхөн гэм нүгэл хийснээ хүлээн зөвшөөрч, харамсаж байна гэж хэлснээрээ нүглээ үнэхээр наманчилж буй хэрэг биш ээ. Үнэхээр наманчлахын тулд бид муу үйл хийхээ эцэс болгоно гэсэн үг юм. Зарим үед муу үйлийг тэвчих нь амаргүй боловч Исүс бидэнд тэр тусламжийг хүргэхээр газар дэлхийд ирсэн билээ. Энэ нь бидний төгс төгөлдөр болох, Бурхантай хамт амьдрахаар эргэн очих цорын ганц зам учраас Тэнгэр дэх Эцэг маань биднийг Исүсийн тусламжийг хүлээн авахыг хүсдэг юм.

Бид хийсэн гэм нүглээ илчилдэг. Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хувьд гэмээ илчилнэ гэдэг нь Тэнгэр дэх Эцэгтээ болон Сүмийн удирдагчдаа ямар муу үйл хийснээ хэлнэ гэсэн үг юм. Зарим гэм нүгэл маань зөвхөн бидэнд өөрсдөд маань нөлөөлдөг. Тэнгэр дэх Эцэгтээ хандан залбирахдаа бид эдгээр гэм нүглээ дурьдаж, түүнээс биднийг өршөөхийг, мөн тэдгээрийг гэтлэн давахад туслахыг хүсэх хэрэгтэй. Хэрэв гэм нүгэл маань өөр хэн нэгэнд нөлөөлсөн бол бид түүнийгээ Бурханд болон тэр хүнд хүлээх хэрэгтэй. Садар самуун явдал гэх мэт муу нүглийг бид Сүмийн удирдагч болох *бишоп, *салбарын ерөнхийлөгч нартаа илчлэн хүлээх хэрэгтэй.

Бид хийсэн буруу зүйлээ засч залруулахын тулд чадах бүхнээ хийдэг. Бид нүглээ гэмшин наманчилж байхдаа хийсэн буруу зүйлээ засч залруулдаг. Жишээлбэл: Хэрэв бид хөршийнхөөсөө хулгай хийсэн бол авсан зүйлээ буцааж өгдөг. Бидний авсан тэр зүйл маань байхгүй болчихсон бол өөр зүйлээр орлуулах юм уу эсвэл төлж болно.

Бид бусдын гэмийг уучилдаг. Тэнгэр дэх Эцэг маань бидэнд бусдыг уучлан өршөөхийг тушаажээ. Хэрэв бид түүнийг биднийг өршөөхийг хүсч байгаа бол бид өөрсдөө бусдын гэмийг уучлах ёстой. Хүмүүсийг хийсэн гэмийнх нь төлөө үзэн ядаж, үл уучлах юм бол Тэнгэр дэх Эцэг маань биднийг гэм нүглийг ч нэгэн адил үл уучлах болно.

Бид Исүсийн бүх хууль зарлигийг насан туршидаа дуулгавартай дагахыг үнэн сэтгэлээсээ хичээдэг. Бид дан ганц сайн үйл бүтээх болтлоо муу

зүйл хийхээ засч залруулсаар байдаг. Тэдгээрийг засч залруулахын тулд юу чадах бүхнээ өдөр бүр хийсээр байх болно.

Бид ямар нэг муу үйл хийх бүртээ гэмшиж байх ёстой. Яг тэр үед наманчлал хийх нь хэцүү, хожим амархан мэт санагдаж болох боловч тийм биш юм. Хийлгүй хүлээсээр байх тусам наманчлал улам хэцүү болно. Хэрэв бид нүглээ наманчлахгүй бол Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиход бэлтгэх, мөн түүний талаар ихийг сурч мэдэхэд маань Исүс тусалж чадахгүй учраас ийнхүү хүлээх нь бидний оюун санааны хөгжилд саад тотгор болох юм. Бид буруу зүйл хийж буйгаа ухаарах бүртээ гэмшин наманчилж байх хэрэгтэй.

Ярилцлага

- Гэмээ наманчлахын тулд бид юу хийх хэрэгтэй вэ?

Хүн Бүр Нүглээ Наманчилж Чадна

Хүн бүр нүглээ наманчилж чадна. Зарим үед наманчлал маш хэцүү санагдаж болох бөгөөд бидэнд өөрсдийн сул талыг хэзээ ч засах боломжгүй мэт санагддаг. Сатан ч биднийг үүнд итгүүлэхийг хүсдэг бөгөөд ингэснээр бид муу үйлийг хийсээр л байх болно. Бид нүглээ гэмшин наманчилж чадна гэдгээ үргэлж санах ёстой. Бид үүнийг өөрсдөө хийж чадахгүй. Бидэнд тусламж хэрэгтэй. Хүн болгон Тэнгэр дэх Эцгийн маань хүүхэд бөгөөд тэр бидэнд туслахаар Исүсийг илгээсэн юм. Исүсийн тусламжтайгаар бид Тэнгэр дэх Эцгийнхээ бидэнд хийхийг тушаасан бүгдийг хийж чадна.

Хэрэв бид Тэнгэр дэх Эцэгтээ хандан Исүсийн тусламжийг хүсч залбирах юм бол Исүс гэмээ наманчлахад маань туслах болно. Тэр болон Тэнгэр дэх Эцэг маань биднийг зөв зүйл хийхийг хүсч байдаг юм. Биднийг буруу зүйл хийхэд тэд үл таалдаг. Гэвч биднийг буруу зүйл хийсэн ч тэд бидэнд хайртай хэвээр байна. Тэд биднийг нүглээ наманчлахыг хүсдэг бөгөөд ингэснээр Тэнгэр дэх Эцэг маань биднийг өршөөж, бид баяр баясгалантай байх болно.

Ярилцлага

- Яагаад бид хэдий хэцүү байлаа ч гэм нүглээ наманчлах ёстой вэ?
- Нүглээ наманчлахад маань хэн бидэнд туслах вэ?

Нүглээ Наманчилбал Тэнгэр дэх Эцэг Маань Биднийг Энэрэн Соёрхох Болно

Хэрэв бид итгэл бишрэлээ Исүст зориулж, гэм нүглээ наманчилбал Тэнгэр дэх Эцэг маань бидний бүх гэм нүглийг уучлан өршөөх болно. Бид тэдгээрийнхээ төлөө шийтгэл хүлээнэ гэж санаа зовох хэрэггүй. Тэр биднийг зөвхөн өршөөгөөд зогсохгүй, биднийг дахин нүгэл хийх хүсэлгүй болж үргэлж сайн үйл хийхэд маань туслах болно. Исүс энэ тусламжийг бидэнд өгдөг юм.

Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ гэв гэнэтхэн адил болчихгүй гэдгийг үргэлж санаж байх хэрэгтэй. Харин бид Исүст итгэлтэй хэвээр байж, гэм нүглээ наманчлан, Исүсийг дуулгавартай дагавал Тэнгэр дэх Эцэг маань бидний гэмийг уучилсаар байх болно. Исүс ч бидэнд тусалсаар байна. Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ улам бүр адил төстэй болдог. Улмаар бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт амьдрахаар эргэн очиж чадна.

Бид нүглээ наманчилснаар баяр баясгалантай болдог. Исүсийн тусламжтайгаар өөрсдийн сул талыг ялан дийлсэн учраас бид баяр баясгалантай байж урьд нь муу үйл хийсэндээ сэтгэлээр үл унах болно. Тийнхүү бид уруу таталтыг эсэргүүцэж, сайн үйл бүтээх хүчин чадалтай гэдгээ мэддэг юм.

Ярилцлага

• Гэм нүглээ наманчилснаар бид ямар энэрэл соёрхлыг хүртдэг вэ?

Лавламж

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Нүглийг Даван Туулах Замыг Бэлтгэж Өгсөн Юм

- Жеймс 4:17 (Нүгэл үйлдэх гэдэг нь Бурхны хориглосон зүйлийг хийнэ гэсэн үг юм.)
- 1 Жон 1:8 (Хэрэв бид нүгэл үйлдээгүй гэвэл худал хэлсэн хэрэг болно.)
- 1 Жон 5:17 (Аливаа шударга бус үйлийг хийх нь нүгэл үйлдсэн хэрэг мөн.)

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Нүглээ Наманчлахын Тулд Юу Хийх Хэрэгтэйг Хэлж Өгсөн

- Матвей 6:14-15; 3 Нифай 13:14-15 (Бид бусдыг уучлах ёстой.)
- Алма 32:13-16 (Албадуулж хүлцэнгүй байснаас өөрсдөө төлөв даруу болох нь бидэнд дээр)
- Алма 34:32-36 (Нүглээ наманчлах цаг чинь одоо юм.)

Хүн Бүр Нүглээ Наманчилж Чадна

- 1 Нифай 3:7 (Тэнгэр дэх Эцэг маань хэзээ ч бидний хийх боломжгүй зүйлийг хийлгэхийг хүсэхгүй.)
- Алма 42:29-30 (Бид гэм нүглээ зөвтгөх ёсгүй.)

Нүглээ Наманчилбал Тэнгэр дэх Эцэг Маань Биднийг Энэрэн Соёрхох Болно

- Мосайя 5:5-9 (Исүс нүглээ наманчлан түүнийг дагасан хэнд ч тусална.)
- Моронай 8:24-26 (Нүглээ наманчилсан хүмүүс усаар батлуулж болно.)

УСАН БАТАЛГАА

15-р бүлэг


Усаар батлуулна гэдэг нь таны энэ газар дэлхий дээр байхдаа хийж чадах хамгийн чухал зүйлсийн нэг юм. Яагаад усан баталгаа тийм чухал байдаг вэ? Усан баталгаа хийлгэх зөв арга зам юу вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Усан Баталгаа Хийлгэхийг Тушаасан

Усан баталгаа хийлгэнэ гэдэг нь усан баталгааг хийх эрх бүхий хүнээр усанд хэсэг хоромд бүрэн дүрүүлээд дахин өргүүлж босохыг хэлнэ. Усан баталгаа нь Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөөний нэг хэсэг юм. Тэр биднийг Исүс Христэд итгэлтэй байгаагаа, түүнийг хайрлаж, дагахыг хүсдэгээ болон гэм нүглээ наманчилснаа харуулахын тулд усаар батлуулахыг тушаажээ.

Тэнгэр дэх Эцэг маань өөрийн бүх хүүхдүүдэд усаар батлуулахыг тушаасныг Исүс мэдэж байлаа. Исүс газар дэлхий дээр байхдаа усан баталгаа хийлгэжээ. Тэрээр Тэнгэр дэх Эцгээ дагахыг хүссэний учир үүнийг хийсэн юм. Түүнчлэн тэр бидэнд Тэнгэр дэх Эцгээ дуулгавартай дагаж, усаар батлуулах ёстой гэдгийг харуулахыг хүссэн байна.

Найман нас хүрч зөв бурууг ялгадаг болсон, мөн Исүст итгэж нүглээ наманчилсан хүн бүр усаар батлуулах ёстой. Найман нас хүрээгүй хүүхдүүд усан баталгаа хийлгэх шаардлагагүй. Тэнгэр дэх Эцэг маань тэднийг хийсэн үйлээр нь шүүдэггүй юм. Түүнчлэн зөв буруу гэж юу болохыг ялган салгах оюун ухааны чадваргүй хүмүүс усан баталгаа хийлгэх хэрэггүй. Бусад бүх хүмүүс хэрэв Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт амьдрахаар эргэн очихыг хүсч байгаа бол усаар батлуулах ёстой.



Алма Мормоны Усанд усан баталгаа хийв.

Исүс бидэнд хэзээ усан баталгаа хийлгэвэл зохихыг хэлж өгсөн. Тэр өөрийн дагалдагчдад хүмүүсийг өөрийнх нь тухай сурч мэдээд түүнд итгэж, нүглээ наманчилсных нь дараагаар усаар батлахыг даалгажээ. Тэрээр өөрийн Сүмийн зарим эрчүүдэд хүмүүсийг усаар батлах эрх мэдлийг олгосон юм.

Ярилцлага

- Яагаад Тэнгэр дэх Эцэг маань биднийг усаар батлуулахыг хүсдэг вэ?
- Исүс яагаад усан баталгаа хийлгэсэн бэ?

Усаар Батлуулах нь Бидний Хийж Чадах Хамгийн Чухал Зүйлсийн Нэг Мөн


Усан баталгаа хийлгэснээр бид Тэнгэр дэх Эцэгтээ түүний төлөвлөгөөг дагахыг хүсч буйгаа харуулдаг юм. Бид Исүсийг өөрсдийн удирдагчаар хүлээн зөвшөөрч, түүний хэлсэн бүгдийг дуулгавартай дагахаа амладаг. Бид түүнийг болон түүний бидний төлөө хийсэн бүх зүйлсийг үргэлж дурсан санахаа амладаг билээ.

Биднийг Исүст итгэж, гэм нүглээ наманчлан, усаар батлуулахад Тэнгэр дэх Эцэг маань бидний нүглийг өршөөдөг юм. Тэр биднийг түүнтэй хамт амьдрахаар эргэн очиж чадна гэдгийг бидэнд амладаг. Тэр биднийг Исүс Христийн Сүмийн гишүүдээр хүлээн зөвшөөрдөг. Биднийг өөрийнх нь тухай улам ихийг сурч мэдэх болон сайн үйл хийхэд маань туслахаар тэр Ариун Сүнснийг илгээнэ. Бид усаар батлуулахдаа хийнэ гэж амласан зүйлсээ биелүүлсээр байвал эдгээр адис ивээлийг хүлээн авах болно.

Эдгээр адис ивээлийг бид зөвхөн усаар батлуулсан нөхцөлд л хүртэж чадна. Энэ бол бидний Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж хамт амьдрах, Исүс Христийн Сүмийн гишүүд болох цорын ганц зам юм. Энэ нь амьдралдаа Ариун Сүнсний тусламжийг хүртэх эрхийг буюу Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах ганцхан зам юм. Энэ бэлгийг бид усан баталгаа хийлгэснийхээ дараа хүртдэг. Эдгээр нь биднийг Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж хамт амьдрахад маань зайлшгүй шаардлагатай зүйлс юм.

Ярилцлага

- Бид усан баталгаа хийлгэхдээ Тэнгэр дэх Эцэгтээ ямар амлалт өгдөг вэ?



Бид нүглээс ангижрахын тулд бүх биеэрээ булхан усаар батлуулах хэрэгтэй.

- Биднийг усан баталгаа хийлгэхэд Тэнгэр дэх Эцэг маань бидэнд ямар амлалт өгдөг вэ?
- Яагаад усан баталгаа тийм чухал байдаг юм бэ?

Усан Баталгаа Хийлгэхэд Бид Өөрсдийгөө Бэлтгэх Ёстой

Усаар батлуулахын өмнө бид тодорхой зүйлийг хийсэн байх ёстой. Бид Исүс Христийн тухай судалж, түүнд итгэж нүглээ наманчлан, түүний тушаасан зүйлсийг хийдэг байх ёстой.

Ярилцлага

- Усан баталгаа хийлгэхэд бэлтгэж бид юу хийх ёстой вэ?

Усан Баталгаа Бидэнд Шинэ Эхлэлийг Өгдөг

Усан баталгаа нь биднийг гэм нүглээс маань цэвэрлэж, шинэ амьдралд оруулдаг. Исүс үүнийг дахин төрөхтэй адил гэж хэлсэн юм. Тэрээр хэрэв хүн оюун санаагаараа дахин төрөөгүй бол Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж хамт амьдарч чадахгүй гэжээ.

Исүсийн дагалдагчдын нэг Паул бид усаар батлуулсныхаа дараа шинэ амьдрал эхлэх ёстой гэж хэлсэн байдаг. Тэрээр усан баталгаа хийлгэх үед бид бүх биеэрээ усанд орж булхаж байгаа нь нүгэл хилэнцээ булшилж байгаатай адил, уснаас гарч ирэх нь бид ариусч, шинэ хүн болж, шинэ амьдрал эхлэхэд бэлэн боллоо гэсэнтэй адил юм гэжээ. Усан баталгаа нь бидний Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очих замыг нээж байгаа хэрэг юм.

Лавламж

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Усан Баталгаа Хийлгэхийг Тушаасан

- 2 Нифай 31:4-7 (Усан баталгаа хийлгэх хэрэгтэйг Исүс бидэнд харуулсан юм.)
- 3 Нифай 11:21-27 (Усаар хэрхэн батлуулахыг Исүс заасан билээ.)
- Моронай 8:9-22 (Бага насны хүүхдүүд усан баталгаа хийлгэх шаардлагагүй.)

Усаар Батлуулах нь Бидний Хийж Чадах Хамгийн Чухал Зүйлсийн Нэг Мөн

- Ромынхан 6:3-7 (Усан баталгаа хийлгэснээр бид ариусдаг.)
- 3 Нифай 27:16 (Тэнгэр дэх Эцэг маань усан баталгаа хийлгэсэн хүмүүст ивээлээ хайрладаг.)

АРИУН СҮНСНИЙ БЭЛЭГ

16-р бүлэг

Ариун Сүнс бидэнд үнэнийг ухаарч ойлгоход тусалдаг. Бид Ариун Сүнсний бэлгийг хэрхэн хүлээн авч чадах вэ?

Ариун Сүнс Биднийг Үнэний Замд Дагуулж Чадна

Ариун Сүнс хүнд усан баталгаа хийлгэхээс нь өмнө ч тусалж чадна. Тэрээр хүнд Исүсийн сургаал үнэн болохыг хэлж өгнө. Зарим үед хаана Исүс Христийн үнэн Сүмийг олж болохыг хэлж өгдөг. Гэвч Ариун Сүнс нь биднийг усаар батлуулан Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах хүртэл бидэнтэй хамт үлдэхгүй.

Шинэ Гэрээнд бид Корнелиус хэмээх нэгэн хүний тухай уншдаг билээ. Тэр усан баталгаа хийлгээгүй хүн байв. Ариун Сүнс түүнд Исүсийн сургаал үнэн гэдгийг хэлжээ. Корнелиус хожим нь усаар батлуулж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсан юм.

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Ариун Сүнсний Бэлгийг Хүлээн Авах Замыг Өгсөн Юм

Бид Тэнгэр дэх Эцгийнхээ төлөвлөгөөг мэдэхийн сацуу гэм нүглээ наманчлан Исүсийн бидэнд тушаасан бүгдийг дагах хүсэлтэй болдог юм. Гэвч бид үүнийг ямар нэг туслалцаагүйгээр хийж үл чадна. Ариун Сүнсний бэлэг гэдэг нь цаг ямагт Ариун Сүнсний туслалцааг авч байх эрх гэсэн үг юм. Усан баталгаа хийлгэснийхээ дараа бид энэ бэлгийг хүлээн авдаг.

Ариун Сүнсний бэлгийг хүлээн авахын тулд бид бэлтгэх хэрэгтэй. Бид Исүст итгэж, түүний тушаалыг биелүүлэхийг хичээх ёстой. Бид гэм нүглээ наманчлан усаар батлуулах ёстой.



Бид Ариун Сүнсний бэлгийг толгой дээр гар тавьснаар хүлээн авах ёстой.

Усаар батлуулсны дараа Тэнгэр дэх Эцгээс маань бидний толгой дээр гараа тавих эрхийг авсан хүмүүс бидэнд Ариун Сүнсний бэлгийг өгч, биднийг Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн албан ёсны гишүүд болгодог. Тэд мөн биднийг адислан ерөөнө.

Ярилцлага

- Бид Ариун Сүнсний бэлгийг хэрхэн хүлээж авдаг вэ?

Ариун Сүнс бидэнд тусалж болох олон арга зам байдаг. Тэр бидэнд Исүсийн илгээмж айлдварыг авчирч болно. Тэр бидэнд Исүс болон Тэнгэр дэх Эцгийн маань талаар олон зүйлийг зааж өгч чадна.

Ариун Сүнс бидэнд төвөгтэй асуудлуудаа хэрхэн шийдвэрлэхэд маань тусалж, биднийг тайтгаруулж, гэм нүглийг тэвчих, сайн үйл хийхэд маань тусалж чадна.

Ариун Сүнс бидэнд бусдыг ойлгож, хайрлахад тусалж чадна. Тэдэнд хэрхэн туслахыг мэдэхэд маань тэр тусална. Тэрээр Исүсийн сургаалыг ойлгоход бидэнд тусалж чадна. Бусад хүмүүст Тэнгэр дэх Эцгийнхээ болон Исүсийн тухай заахдаа юу гэж хэлбэл зохихыг мэдэхэд маань тэр туслах болно.

Ярилцлага

- Ариун Сүнс бидний амьдралд нөлөөлж болох ямар арга замууд байна вэ?

Энэ Бэлгийг Авахын Тулд Бид Нүглээ Наманчлах Ёстой

Ариун Сүнсний бэлгийн ачаар бид илүү сайн хүмүүс болж, сайн үйл хийж чадна. Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ улам илүү адил болно. Гэхдээ бид үргэлж сайн үйл хийхийг хичээх ёстой, эс тэгвээс Ариун Сүнс биднийг орхих болно. Бид үргэлж сайн сайхан зүйлсийн талаар бодохыг хичээх ёстой. Бид Исүсийн сургаалыг дагахыг хичээж, ямар нэг буруу зүйл хийвэл гэмшин наманчлах ёстой. Энэ бүгдийг хийхийг хичээх юм бол Ариун Сүнс бидэнд туслах болно.

Заримдаа Ариун Сүнс бидний сэтгэл зүрхэнд тайван, дулаан мэдрэмжийг төрүүлэх замаар биднийг удирдан залдаг. Бид ямар нэг буруу зүйл хийсэн тохиолдолд энэ сайхан мэдрэмж биднийг орхин замхарна. Зарим үед бид бодол санаандаа бидэнд хандан юу хийж болох, юу хийж болохгүйг хэлж буй ямар нэгэн дуу хоолойг

сонсч болох юм. Бид Ариун Сүнсний хэлэхийг сонсч түүнийг даган биелүүлэхэд үргэлж бэлэн байх ёстой. Учир нь Ариун Сүнс үргэлж Исүсийн биднийг хийхийг хүссэн зүйлсийг хэлж өгдөг бөгөөд ийнхүү Исүсийг дагаснаар бид Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж чадна.

Хэрэв бид Ариун Сүнсийг дагахгүйгээр буруу зүйлсийг хийж эхэлбэл Ариун Сүнс биднийг орхих болно. Бид зөв зүйлс хийхгүй л бол тэр бидэнтэй үлдэж бидэнд туслахгүй байх болно. Харин түүний зааврыг үргэлж сонсч байвал тэр бидэнтэй байнга хамт байна. Тэр бидэнд сайн хүмүүс болоход маань тусалж, Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт амьдрахад маань бэлтгэдэг юм.

Ярилцлага

• Ариун Сүнсний тус дэмийг авахын тулд бид юу хийх ёстой вэ?

Ариун Сүнсээр Дамжуулан Бид Бусад Онцгой Адис Ивээлийг Хүртдэг

Ариун Сүнсээр дамжуулан хүлээн авдаг зарим онцгой адис ерөөлүүдийг оюун санааны бэлгүүд гэж нэрлэдэг. Исүс тэдгээрийг өөрийн Сүм нь энэ газар дэлхий дээр байгаа цагт өөрийн жинхэнэ Сүмийн гишүүдэд өгсөөр байдаг юм. Тэр эдгээр бэлгийг бидэнд Ариун Сүнсээр дамжуулан өгдөг. Тэдгээрийг ухаалгаар ашиглахын тулд бид сайтар ойлгох хэрэгтэй.

Олон Хэлээр Ярих Бэлэг


Энэ бэлэг нь хүмүүсийг өөр хэлээр ярихад нь тусалдаг. Хүмүүст олон хэлийн ард түмэнд Евангелийн сургаалыг заахад туслах нь Исүсийн энэ бэлгийг хүмүүст өгсний нэг шалтгаан байлаа.

Өөр Хэлийг Хөрвүүлэх Бэлэг

Энэхүү бэлэг нь Евангелийг сургаалыг хүлээн авч буй хүмүүст тусалдаг юм. Өөр хэлийг хөрвүүлэх энэ бэлэг нь тэдэнд тэдний мэдэхгүй хэлээр яригдсан Исүсийн айлдварыг ойлгоход нь тусална.

Исүс бол Тэнгэр дэх Эцгийн Маань Хүү Мөн Гэдгийг Мэдэх Бэлэг

Энэ бэлэг хүмүүст Исүсийг Тэнгэр дэх Эцгийн маань Хүү гэдгийг мэдэхэд нь тусалдаг. Гагцхүү Ариун Сүнсний тусламжтайгаар Исүс бол бидний Аврагч мөн гэдгийг мэдэж чадна хэмээн сударт



Жозеф Смит Мормоны Номыг Ариун Сүнсний хүчээр орчуулжээ.

өгүүлдэг. Тэгвэл энэхүү бэлэг нь Исүс үнэхээр Тэнгэр дэх Эцгийн маань Хүү, дэлхий ертөнцийн Аврагч мөн гэдгийг гэрчилж буй Ариун Сүнсний гэрчлэл юм.

Бусдын Гэрчлэлд Итгэх Бэлэг

Бусдын гэрчлэлд итгэх энэ бэлэг нь хүмүүст хэн нэгний Исүсийн талаар ярьж буй зүйл үнэн эсэхийг мэдэхэд тусална. Ариун Сүнс бидэнд үнэн гэрчлэлийг таньж, түүнд итгэхэд маань тусалж байдаг.

Итгэлийн Бэлэг

Энэхүү итгэлийн бэлэг нь бидэнд Исүсийн хууль зарлигийг дагахад маань тусалдаг. Итгэлгүйгээр бид ямар ч оюун санааны бэлгийг хүлээн авч чадахгүй. Итгэлгүйгээр бил Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж үл чадна. Олон хүмүүс Исүст маш их гүн итгэлтэй байдаг. Мормоны Номын нэгэн зарлага Исүст ийм итгэлтэй байсан учир түүнд Исүс үзэгджээ. Зарлага Жозеф Смитийн Исүс Христэд итгэх итгэл маш хүчтэй байсны учир түүнд Тэнгэр дэх Эцэг маань Исүсийн хамтаар үзэгдсэн юм.

Хөрвүүлэх бэлэг

Хөрвүүлгийн бэлэг нь хүмүүст Тэнгэр дэх Эцгийн маань болон Исүс, түүний дагалдагчдын бичигдэн үлдсэн үгсийг нэг хэлнээс нөгөө хэл рүү орчуулахад тусална. Зарлага Жозеф Смит Мормоны номыг орчуулж байхдаа ийм чадвартай байжээ. Энэ бэлэг нь орчуулагчид илгээмж, айлдварын үнэн зөв утгыг ойлгож, түүнийгээ зөвөөр орчуулахад нь тусалдаг юм.

Танин Мэдэхүйн Бэлэг

Танин мэдэхүйн бэлэг нь хүмүүст Тэнгэр дэх Эцгийн маань болон Исүсийн ажил хэргийг ойлгоход нь тусална. Хэрэв бид түүнээс биднийг хийхийг хүсч буй зүйлсийг ойлгож мэдэхгүй бол түүнд эргэн очиж чадахгүй гэж Тэнгэр дэх Эцэг маань хэлсэн байдаг. Бид Тэнгэр дэх Эцгийнхээ бидэнд өгсөн төлөвлөгөөг мэдсэнээр түүнд эргэн очиж чадна.

Энэ амьдралдаа олж авсан мэдлэг маань үхлийн дараах сүнсний ертөнцөд бидэнд хэрэг болно гэж Исүс хэлжээ. Тэрээр биднийг түүний сургаал, зарлигууд, тэнгэр газрын тухай, юу болж өнгөрсөн



Иаредын ах маш их итгэл бишрэлтэй байсан учраас Исүсийг газар дэлхийд мэндлэхээс өмнө тэрээр Исүсийн хурууг тэнгэрт олж харжээ.

болон өөрсдийн төдийгүй өөр бусад улс оронд болж буй үйл явдлын талаар мэдэж байхыг хүсдэг юм. Бид энэ мэдлэгээ ухаалгаар ашиглах ёстой гэж тэр хэлжээ. Бид аливаа мэдлэгийн эрэлд Ариун Сүнсний тусламжийг хүсч байх хэрэгтэй.

Мэргэн Ухааны Бэлэг

Энэ бэлэг нь хүмүүст Тэнгэр дэх Эцгээсээ авсан мэдлэгийг ухаалгаар хэрэглэхэд тусалдаг. Бид энэхүү бэлгийг амьдралаа дээшлүүлж, бусдад зааж сурган, ухаалаг зөвлөлгөө өгөхөд ашиглах хэрэгтэй.

Багшлах Бэлэг

Багшлах бэлэг нь Евангелийг бусдад ойлгомжтой байдлаар заахад тусалдаг. Бид энэ бэлгийг зөвхөн Исүст итгэлтэй байснаар хичээл зүтгэл, залбирлаар дамжуулан олж болно.

Зөгнөн Хэлэх Бэлэг

Зөгнөн хэлэх бэлэг нь хүмүүст урьд өмнө болж өнгөрсөн, одоо болж буй, мөн ирээдүйд болох зүйлсийг ойлгож мэдэхэд тусалдаг. Зарлагуудад энэ увдис чадвар заяадаг ч бид амьдралыг маань удирдан жолоодох энэ бэлгийг нэгэн адил хүртэж чадна.

**Үзэгдлийн Бэлэг*

Ариун Сүнс хүмүүст тус болох зүйлийг нээн өгч байдаг. Бидний хэн маань ч гэсэн өөрт тус болох үзэгдлийг хүлээн авч чадна. Гэвч бүхэл бүтэн Сүмийн ач холбогдолтой үзэгдлүүдийг зөвхөн зарлага л хүлээн авна. Бид Сүмийн удирдагчийн өмнөөс үзэгдлийг хүлээн авч чадахгүй. Ариун Сүнсний бидэнд нээж өгч буй бүх зүйл Тэнгэр дэх Эцгийн маань болон Исүсийн хууль зарлигуудтай тохирч байдаг юм.

Анагаах Бэлэг

Анагаах бэлэг нь өвчтэй хүмүүст эдгэрэхэд нь тусална. Зарим нь эмчлүүлэх итгэлтэй, зарим нь бусдыг эмчлэх итгэлтэй байдаг.

Гайхамшигийг Бүтээх Бэлэг

Гайхамшигийг бүтээх бэлэг нь хүмүүст туслах зорилготой юм.

Гайхамшиг гэдэг нь Тэнгэр дэх Эцгийн маань бидний төлөө хийж буй, бид өөрсдийн хүчээр хийж үл чадах тийм зүйл юм. Шинэ Гэрээнд болон Мормоны Номд Исүсийн түүнд итгэсэн хүмүүсийн дунд байх болно гэж хэлсэн нь бий.

Сатан Эдгээр Оюуны Хүчин Чадлыг Дуурайж Чадна

Сатан жинхэнэ оюун санааны бэлгүүдийг хуулбарласан зүйлсийг бий болгож чадна. Тэр өөрөө Бурхны элчийн дүрээр ч харагдаж чадна. Тэр муу зүйлсийг зөв шударга, сайн сайхан мэтээр үзүүлж ч чадна. Тэр худал зарлагыг жинхэнэ зарлага мэтээр харуулж чаддаг. Тэр хүмүүсийг хуурахын тулд гайхамшигийг ч үзүүлж чадна. Ид шидтэн, сүнс дуудагчид, үзмэрч зэрэг хүмүүс тэр хүчин чадлаа Сатанаас хүлээж авдаг бөгөөд тэд Исүсийн дагалдагчид биш юм. Бид тэднээс хол байвал зохино.

Сатан аливаа юмсыг маш үнэмшилтэй харуулж чаддаг тул тэдгээрийг худал болохыг нотлохын тулд бид Тэнгэр дэх Эцгээсээ асуух хэрэгтэй. Сатан болон түүний дагалдагчид оюун санааны бэлгүүдийг хуулбарлахад бидэнд тайван бус, эргэлзсэн сэтгэгдэл төрнө. Тэдгээр оюуны бэлгийг хэзээ жинхэнэ байна, хэзээ Сатан хуулбарлаж байна вэ гэдгийг мэддэг тэр чадварыг зөн билэг гэж нэрлэдэг юм.

Ярилцлага

- Оюун санааны бэлгүүд гэж юу вэ?
- Жинхэнэ оюуны бэлгүүд болон Сатаны хуулбарлалтыг бид хэрхэн ялгаж чадах вэ?

Бидэнд Буй Бэлгүүдийг Ашиглаж, Хөгжүүлэхийн Тулд Бид Хөдөлмөрлөх Хэрэгтэй

Бид суралцаж, мацаг барьж, залбирснаар бидэнд ямар бэлэг байгааг мэдэж чадна. Бид өөрсдийн бэлгийг зөвхөн Исүсийн зарлигийг дагасан үед л ашиглаж чадах юм. Тэгвэл бид тэдгээрийг бусдад туслах, мөн Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн босголцоход ашиглахыг хүсээх болно. Хэрэв бид өөрсдийн бэлгийг хөгжүүлж, ашиглахгүй бол тэдгээрийг алдах болно.

Исүс биднийг өөрт байгаа адис ерөөлөөр хүртсэн бэлгээр бардамнаж болохгүй гэдгийг хэлжээ. Тэдгээрийг ариун гэж үл

бодогч хүмүүст энэ тухайгаа ярих хэрэггүй. Эдгээр бэлгийг бид өөрсдийн тусын тулд мөн бусад хүмүүсийг адислан ивээхийн тулд хүртсэн билээ. Тэдгээрийг ариун нандин гэдгийг бид санаж явах ёстой. Исүс эдгээр бэлгийг бидэнд Ариун Сүнсээр дамжуулан өгдөг юм. Тэр биднээс зөвхөн түүнд талархалтай байж, тэдгээрийг түүний хүссэнээр ашиглахыг хүсдэг билээ.

Ариун Сүнсний Бэлэг Бидэнд Маш Үнэ Цэнэтэй Юм

Бид үргэлж сайн зүйл хийж, Исүсийг дагахыг эрмэлзэх хэрэгтэй бөгөөд эс тэгвээс Ариун Сүнсний нөлөө бидэнтэй хамт үлдэхгүй байх болно. Бид үргэлж сайн сайхан юм бодохыг хичээх ёстой. Ямар нэг буруу зүйл хийчихээд түүндээ гэмших хэрэгтэй. Бид Ариун Сүнсний хэлж буй зүйлсийг ойлгохыг хичээх ёстой. Бид түүний өгсөн заавар зөвлөмжийг дагах ёстой.

Хэрэв бид үнэн сэтгэлээсээ Исүсийг дагахыг хүсэх юм бол Ариун Сүнсний бэлэг бидний амьдралыг ивээх болно. Энэ нь бидэнд аз жаргалтай амьдарч, Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт амьдрахад бэлтгэхэд туслах юм.

Ярилцлага

- Ариун Сүнсний тус дэмийг хүртэхийн тулд бид юу хийх ёстой вэ?

Лавламж

Ариун Сүнс Биднийг Үнэний Замд Дагуулж Чадна

- 2 Нифай 32:5; Моронай 10:5-7 (Аливаа зүйлийн үнэн эсэхийг Ариун Сүнс бидэнд хэлж өгдөг.)

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Ариун Сүнсний Бэлгийг Хүлээн Авах Замыг Өгсөн Юм

- Үйл явдал 10:44-48; 2 Нифай 31:17-18 (Ариун Сүнсний бэлгийг усан баталгааны дараа өгдөг.)
- Моронай 8:25-26 (Бид Ариун Сүнсийг хүлээн авч чадна.)

Энэ Бэлгийг Авахын Тулд Бид Нүглээ Наманчлах Ёстой

- Мосайя 2:36 (Бид Тэнгэр дэх Эцгийнхээ зарлигийг үл дагаваас Ариун Сүнсний бэлгийг алдах болно.)
- Моронай 8:28 (Биднийг нүглээ наманчлахгүй бол Ариун Сүнс туслахаа болино.)

Ариун Сүнсээр Дамжуулан Бид Бусад Онцгой Адис Ивээлийг Хүртдэг

- 1 Коринфынхан 12:1-11; Моронай 10:8-19; Сургаал ба Гэрээ 46:10-33 (Ариун Сүнс бидэнд оюуны бэлгүүдийг өгөх болно.)
- Марк 16:17-18; Мормон 9:7-24 (Оюун санааны бэлгүүд нь Исүс Христийн Евангелийн нэг хэсэг юм.)

Бидэнд Буй Бэлгүүдийг Ашиглаж, Хөгжүүлэхийн Тулд Бид Хөдөлмөрлөх Хэрэгтэй

- Матвей 25:14-30 (Тэнгэр дэх Эцэг маань бидэнд өөрийнх нь ажилд ашиглахын тулд бэлгүүдийг өгдөг бөгөөд хэрэв бид тэдгээрийг ашиглахгүй байвал алдах болно.)


Ариун Сүнсний Бэлэг Бидэнд Маш Үнэ Цэнэтэй Юм

- Алма 34:37-38 (Бид Ариун Сүнсний хэлсэн зүйлсийг биелүүлэхийг хичээх хэрэгтэй.)

ИСҮС ХРИСТИЙН СҮМ

Зургадугаар хэсэг





Абрахам Из Эзэнтэй гэрээ байгуулсан нь

ИСҮС ХРИСТИЙН ДАГАЛДАГЧИД

17-р бүлэг


Исүс Христийн дагалдагчид бусад хүмүүстэй адилгүй. Дагалдагчид гэж хэн бэ? Тэд юугаараа ялгаатай вэ?

Исүс Христийн Дагалдагчид Тэнгэр дэх Эцэгт Маань Хайртай

Исүсийн дагалдагчид гэдэг бол түүнд итгэж, түүнийг дагадаг хүмүүс юм. Тэд Исүсийн тэдэнд заасан Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөөг мэдэж, түүнийг дагаж мөрдөхийг хүсдэг. Тэд Тэнгэр дэх Эцэгт маань хайртай байж, түүнийг тэдэнд аль болох сайн сайхан амьдралыг хүсдэг гэдэгт итгэцгээдэг. Тэд Исүсийг Тэнгэр дэх Эцгийн маань Хүү гэж итгэнэ. Исүс тэдний Аврагч мөн гэдэгт тэд итгэдэг. Исүс тэдэнд Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очих боломжийг өгсөн гэдэгт тэд итгэнэ. Тэд зөвхөн Исүсийг дагаж, түүний хууль зарлигийг сахиснаар нүгэл хилэнц маань өршөөгдөж, Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж чадна гэдэгт итгэдэг.

Исүсийг дагалдагч тэдгээр хүмүүс Бурхан болон Исүст тэдний тусын тулд хийж бүтээсэн бүх зүйлийнх нь төлөө талархаж байдаг. Тэд Исүсийг дуулгавартай дагахыг хүсдэг. Тэд гэм нүглээ наманчлан, усаар батлуулж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авдаг. Тэд бүх хүмүүс Бурханд чухал юм гэдгийг ойлгодог. Тэд бусад хүмүүст бүхий л боломжоороо туслахыг хичээж байдаг юм.

Исүсийн үнэн дагалдагчид ариун нандин амлалт өгдөг байна. Тэд Исүс Христийн нэрээр дуудагдахаа Тэнгэр дэх Эцэгтээ амладаг. Энэ нь түүний Сүмийн гишүүн байж, түүний бүх сургаалыг хүлээн зөвшөөрч, түүнийг үргэлж дурсан санана гэсэн үг юм. Түүнчлэн тэд бусдыг хайрлаж, тэдэнд тусалж явахаа амладаг.



Моүзес Аароны толгой дээр гар тавин зэрэгтний хүчийг олгожээ.

Тэнгэр дэх Эцэг маань Исүсийн дагалдагчдад мөн ариун нандин амлалтуудыг өгдөг. Тэдгээрийн заримаас дурдвал, тэрээр:

1. Тэднийг Исүс Христийн Сүмийн гишүүдээр хүлээн зөвшөөрөх болно.
2. Тэдэнд Ариун Сүнсний бэлгийг хүртээнэ.
3. Тэдэнд хэрэгтэй байгаа зүйлсээ олж авахад нь тусална.
4. Тэдэнд өөрийн ажлыг хийж гүйцэтгэх хүчин чадлыг хайрлана.
5. Тэдэнд асар их адис ивээлийг одоо ч, ирээдүйд ч хайрлах болно.
6. Исүсийг дагасаар байвал тэдэнд өөртэй нь хамт амьдрахаар эргэн очихыг зөвшөөрнө.

Ярилцлага

- Исүсийн дагалдагчид бусад хүмүүсээс ямар ялгаатай вэ?
- Исүсийн дагалдагчид юу хийхээр амладаг вэ?
- Исүсийн дагалдагчдад Тэнгэр дэх Эцэг маань болон Исүс юуг амладаг вэ?

Исүс Өөрийн Дагалдагчдад Тэнгэр дэх Эцгийн Маань Хүчин Чадлыг Өгдөг

Исүс дагалдагчдадаа өөрийн ажлыг хийхэд туслах эрх мэдлийг өгдөг. Энэ эрхийг зэрэгтний хүч гэнэ. Үүнийг Тэнгэр дэх Эцэг маань Исүст өгсөн юм.

Зэрэгтний хүчтэй байх нь аугаа их адис ерөөл юм. Түүнийг зөвхөн Исүсийн үнэн дагалдагчид бөгөөд түүний зарлигийг мөрдөхийг үнэхээр хичээж буй хүмүүс хүртдэг.

Хэрэв хүн зэрэгтний хүчийг хүртсэн бол Исүсийн түүгээр хийлгэхийг хүсч буй тодорхой зүйлсийг гүйцэтгэж чадна. Тэрээр бусдад Тэнгэр дэх Эцгийнхээ тухай зааж, тэднийг усаар баталж, Ариун Сүнсний бэлгийг өгч чадна. Зэрэгтний хүч бүхий эр хүн өөрийн гэр бүлийнхнийг өвчин зовлонтой, эсвэл ямар нэгэн хүнд хэцүү үед нь адислаж чадна. Хүмүүс Исүст итгэж, түүний зарлигийг дагасаар байсан үед Исүс тэдэнд зэрэгтний хүч болон бусад ивээлийг хүртээсээр байсан билээ.

Ярилцлага

- Зэрэгтний хүч гэж юу вэ?
- Яагаад Исүс зэрэгтний хүчийг өөрийн дагалдагчдад өгдөг вэ?

Исүсийг Газар Дэлхийд Ирэхээс Өмнө Олон Хүн Түүнд Итгэж, Түүний Зарлигийг Дагаж Байлаа

Түүнийг Газар Дэлхийд Ирэхээс Өмнө Адам Ева Хоёр Болон Тэдний Зарим Үр Хүүхэд Исүст Итгэж, Түүний Зарлигийг Дагаж Байжээ.

Тэнгэр дэх Эцэг маань Адам Ева хоёрт Исүст Христэд итгэж, түүний зарлигийг дагахыг тушаажээ. Хэзээ нэгэн өдөр түүнийг газар дэлхийд ирнэ гэж тэдэнд хэлсэн байлаа. Адам Ева хоёр дуулгавартай дагахаа амлажээ. Тэд амлалтаа биелүүлсэн юм. Тэд усаар батлуулж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсан юм.

Исүс энэ дэлхийд ирэхээсээ өмнө зэрэгтний хүчийг Адамд өгчээ. Тэрээр Адамд Исүсийг дуулгавартай дагадаг өөрийн хөвгүүдэд зэрэгтний хүчийг хүртээхийг зөвшөөрсөн байна. Адам өөрийн дуулгавартай хүү бүрийн толгой дээр гараа тавин зэрэгтний хүчийг олгож байв. Хожим нь Адамын хөвгүүд зэрэгтний хүчийг мөн өөрсдийн хөвгүүдэд нэгэн адилаар хүртээж байлаа.

Ярилцлага

- Исүсийн дагалдагчид болохын тулд Адам Ева хоёр юу хийсэн бэ?
- Исүсийн дагалдагчид зэрэгтний хүчийг хэрхэн хүлээн авсан бэ?

Абрахам Исүсийг Ерөөж, Түүний Зарлигийг Дагасан нь

Абрахам болон түүний гэр бүлийнхэн Исүст итгэдэг байлаа. Тэд түүнийг хэзээ нэгэн өдөр энэ дэлхийд ирнэ гэдэгт итгэж байв. Абрахам Тэнгэр дэх Эцэгт маань Исүсийг дагаж, түүний ажлыг хийх болно гэдгээ амлажээ. Тэнгэр дэх Эцэг маань хэрэв түүнийг дуулгавартай байвал түүнийг болон удам угсааг нь ивээх болно гэж Абрахамд амласан юм. Тэнгэр дэх Эцгийн маань амласан зүйлсийн заримаас дурьдвал:

1. Тэр Абрахам болон түүний үр удамд зэрэгтний хүчийг өгөх болно.
2. Тэр Абрахам болон түүний үр удамд амьдран суух нутаг өгнө.
3. Тэр Абрахамын үр садыг өнөр өтгөн болгоно.
4. Абрахамын удмын олон хүн Исүсийн дагалдагчид байх болно.
5. Абрахамын удмын олон хүн Исүсийн ажлыг хийхээр сонгож, бусад хүмүүст Тэнгэр дэх Эцгийн маань болон Исүсийн тухай заах болно.

Абрахам өөрийн хүүхдүүдэд Исүст итгэж, түүний зарлигийг дагахыг сургадаг байлаа. Абрахам өөрийн хүү Исаакт зэрэгтний хүчийг өгчээ. Исаак зэрэгтний хүчийг хүү Иаковт өгөв. Хожим нь Тэнгэр дэх Эцэг маань Иаковын нэрийг Израиль хэмээн өөрчилсөн юм. Израиль арван хоёр хүүтэй байлаа. Тэрээр тэдэнд Исүст итгэж, зарлигийг нь дагахыг сургадаг байв. Тэд бүгд зэрэгтний хүчтэй байлаа. Израилийн хөвгүүдийн үр удмыг Израилийн арван хоёр омог хэмээн нэрлэжээ.

Ярилцлага

- Абрахамд Тэнгэр дэх Эцэг маань юу гэж амласан бэ?
- Израиль гэж хэн байсан бэ?

Израилийн Ард Түмэн Исүст Итгэж, Түүний Зарлигийг Дагадаг Байлаа

Тэдний төрсөн нутагт нь хоол унд хомсхон байснаас Израиль хөвгүүдийнхээ хамтаар Египет хэмээх газарт амьдрахаар явжээ. Египетэд амьдарч байсан хүмүүс тэднийг хүнд хүчир хөдөлмөрт зардаг байв. Тэднийг хүчээр Египетэд үлдээн өөрсдийн зарцаа болгож, Исүсийн тэдэнд өгөхөөр амласан нутаг руу явахыг үл зөвшөөрчээ.

Олон жилийн дараа Тэнгэр дэх Эцэг маань Израилийн үр садыг Египетээс удирдан гаргахаар Моүзес гэдэг хүнийг сонгосон байна. Моүзес зэрэгтний хүчний тусламжтайгаар тэднийг Египетийн хүмүүсээс зугтаалгаж чаджээ. Тэрээр тэднийг Исүсийн тэдэнд өгөхөөр амласан газар нутагт дагуулан очив. Уг газрыг Канаан гэж нэрлэдэг байсан нь одоо Израиль болон өөрчлөгджээ.

Ярилцлага

- Моүзес Исүсийн ард олонд Египетээс зугтахад нь ямар хүчийг ашиглан тусалсан бэ?

Израилийн Хүн Ард Исүст Итгэхээ Больсон нь

Израилийн ард түмэн Канаан нутагт олон жилээр амьдарсны дараагаар Исүст итгэн түүний зарлигийг дагаахаа больжээ. Исүс тэднийг нүглээ наманчлан түүний хууль зарлигийг дагахыг хэлүүлэхээр зарлагуудаа илгээсээр байв. Исүсийн илгээсэн зарлагуудын дунд Исай, Элайжа, Иеремия нар байсан юм. Мөн өөр олон зарлагууд байлаа.

Гэвч Израилийн ард түмэн гэмшин наманчилсангүй. Тиймд Тэнгэр дэх Эцэг маань бусад ард түмнүүд тэдний газар нутгийг эзлэн авч захиран олон хүмүүсийг нь өөр нутаг оронд тараан бутаргахыг зөвшөөрчээ. Энэ нь тэднийг дахин даруу хүлцэнгүй болгож, Исүсийг дурсан санаж, дагахад хүргэв. Гэвч Исүсийг Бэтлэхэмд төрөхөөс хэдэн жилийн өмнөөс хүмүүс дахин шударга бус болцгоож, Тэнгэр дэх Эцгийн маань хүслээр Израилийн хүн ардыг Ромчууд эзлэн авч, газар нутаг болон ариун нандин барилга байгууламжийг нь эрх мэдэлдээ авчээ.

Ярилцлага

- Хүмүүс Тэнгэр дэх Эцэгтээ өгсөн амлалтыг мартаж, Исүсийг дагахаа болиход тэдэнд юу тохиолдсон бэ?

Исүс Газар Дэлхийд Ирж Өөрийн Дагалдагчдыг Зохион Байгуулсан нь

Исүс газар дэлхийд ирээд хүмүүст өөрийгөө Бурхны Хүү гэдгийг заажээ. Тэрээр хэрэв тэд түүний сургаалыг дагавал өөрсдийн гэм нүглийн төлөө мөнхөд зовохгүй байж болно хэмээн заав. Тэр тэдэнд өөрт нь итгэж, нүглээ наманчлан усан баталгаа хийлгэх ёстой гэдгийг хэлсэн. Тэдэнд туслахаар Ариун Сүнснийг илгээнэ гэж мөн амлав. Тэрээр хүмүүст Бурхныг хайрлаж, түүнийг дагахыг заажээ. Тэрээр бусдыг мөн хайрлаж, туслахыг сургасан юм.

Исүст итгэж, түүнийг дагасан хүмүүс дагалдагчид нь болжээ. Тэр өөрийн хүмүүсийг Исүс Христийн Сүм гэгдэх нэгэн бүлэгт нэгтгэн зохион байгуулсан юм. Сүмийнхээ удирдагчид болон багш нарт тэрээр зэрэгтний хүчийг олгожээ.

Ярилцлага

- Исүс хүмүүст өөрийг нь дагахад хэрхэн тусалсан бэ?
- Хүмүүс Исүсийн дагалдагчид болохын тулд юу хийх хэрэгтэй вэ?

Исүсийн Дагалдагчдын Нэг Байх нь Аугаа Их Нэр Төрийн Хэрэг Билээ

Исүсийг дагадаг хүмүүс аз жаргалтай байдаг. Тэд өөрсдөд нь зориулсан Тэнгэр дэх Эцгийнхээ төлөвлөгөөг мэддэг. Тэд Тэнгэр дэх Эцэг тэдэнд хайртайг мэднэ. Тэд түүнийг өөрсдийг нь Исүсийг дагахыг хүсч буйг мэддэг, учир нь ингэснээр түүнд эргэн очиход Исүс туслах болно. Тэд аз жаргалтай байхын тулд юу хийвэл

зохихыг мэднэ. Тэднийг тайтгаруулан, тэдэнд туслах Ариун Сүнсний бэлэг тэдэнд бий. Хүнд хэцүү үед нь Исүс тусална гэдгийг тэд мэддэг. Исүсийг дагах итгэлтэй байгаад нь Бурхан тэднийг адислана гэдгийг тэд бас мэднэ.

Исүсийг дагагч тэдгээр хүмүүс Тэнгэр дэх Эцгээсээ хүртсэн олон адис ерөөлдөө тун талархалтай байдаг. Тэд залбирахдаа тэдгээр адис ивээлийнхээ төлөө Тэнгэр дэх Эцэгтээ талархаж буйгаа илэрхийлдэг юм.

Исүсийг үл дагагч хүмүүс ч түүний дагалдагчид болж болно. Тэд түүний талаар судраас уншиж, Сүмийн удирдагчдаас сонсч мэдэж болно. Тэд түүнд итгэн, нүглээ наманчилж, усан баталгаа хийлгэж болно. Хэрэв тэд Исүсийг дагавал Тэнгэр дэх Эцгийн маань Исүсийн дагалдагчдад үргэлж амладаг тэдгээр зүйлсийг хүлээн авах болно.

Ярилцлага

- Яагаад Исүсийн дагалдагчдын нэг байх нь аугаа их нэр төрийн хэрэг байдаг вэ?

Лавламж

Исүс Христийн Дагалдагчид Тэнгэр дэх Эцэгт Маань Хайртай

- Жон 8:12 (Исүс биднийг түүнийг дагахыг хүсч байна.)
- 2 Нифай 31:12 (Биднийг Исүс Христийг дагаж, түүний хийснийг хий гэж тушаасан билээ.)
- Мосайя 2:41 (Исүсийн зарлигийг дагадаг тэр хүмүүс бүхий л талаар ивээл хүртдэг.)
- 3 Нифай 18:37 (Исүс өөрийн дагалдагчдад Ариун Сүнсний бэлгийг бусдад өгөх хүчийг өгсөн.)

Исүс Өөрийн Дагалдагчдад Тэнгэр дэх Эцгийн Маань Хүчин

Чадлыг Өгдөг

- Дүрвэлт 3 (Моүзес Тэнгэр дэх Эцгээс маань эрх мэдлийг хүлээн авчээ.)
- Тоолол 27:18-23 (Моүзес Жошуагийн толгой дээр гараа тавьж, түүнд Тэнгэр дэх Эцгийн маань эрх мэдлийг олгожээ.)

Исүсийг Газар Дэлхийд Ирэхээс Өмнө Олон Хүн Түүнд Итгэж, Түүний Зарлигийг Дагаж Байлаа

- Үүсэл гарал 12:1-2; 17:1-8 (Исүсийн дагалдагч Абрахамд амлалтуудыг өгчээ.)
- Дэлгэрэнгүй хууль 28:9-10 (Бурхан Израилийн хүн ардад амлалт өгсөн нь)
- Иеремия 23:3-4 (Исүс Израилийн хүн ардыг нүглээ наманчилсных нь эцэст нэгтгэн хураах болно.)
- Изекиль 20:33-36 (Израилийн ард түмэн хуран цуглах болно.)
- Лук 6:13 (Исүс өөрийн Арван Хоёр Төлөөлөгчийг сонгов.)
- Жон 15:16 (Исүс өөрийн Төлөөлөгчдөд эрх мэдэл, хүчин чадал олгов.)
- 3 Нифай 21:26-29 (Исүсийн дагалдагчид бүх үндэстний дотроос хуран цуглах болно.)

Исүсийн Дагалдагчдын Нэг Байх нь Аугаа Их Нэр Төрийн Хэрэг Билээ

- 2 Нифай 31:13 (Исүсийг дагаж, түүний заасныг хийсэн хүмүүсийг онцгой адис ерөөлүүд хүлээж байна.)
- Алма 5:57 (Исүсийг дагасан хүмүүс үнэнч шударгад тооцогдох болно.)
- Моронай 7:48 (Исүсийн дагалдагчид Бурхантай адил болно.)

ИСҮСИЙН СҮМ БАЙГУУЛАГДСАН НЬ

18-р бүлэг

Исүс газар дэлхий дээр байхдаа сүмээ байгуулжээ. Үүнийг юу гэж нэрлэдэг байсан бэ? Түүний Сүмийг хэн удирдаж байв?

Исүс Байгуулсан Сүмийнхээ Тэргүүн нь Байлаа

Исүс газар дэлхийд байх хугацаандаа нэгэн сүмийг байгуулжээ. Үүнийг Исүс Христийн Сүм гэж нэрлэдэг байлаа. Исүсийн Сүмийн гишүүдийг Гэгээнтнүүд гэдэг байв. Исүс өөрөө тэр сүмийн тэргүүн нь байсан юм. Тэр түүнийг удирдаж байв. Тэрээр сүмийг удирдахад нь туслуулахаар 12 хүнийг сонгон авчээ. Тэднийг Төлөөлөгчид гэдэг байлаа. Эдгээр Төлөөлөгчид нь мөн зарлагууд байсан юм. Исүс тэдний толгой дээр гараа тавьж тус бүрт нь зэрэгтний хүчийг өгсөн байна. Тэрээр тэднийг өөрийн ажлын хийлгэхээр томилов. Эдгээр Төлөөлөгчид, зарлагууд бол Исүс Христийн Сүмийн удирдагчид байсан юм.


Исүс Христийн Сүмд зэрэгтний хүчийг хүлээн авсан эрчүүд гараа бусад сайн хүмүүсийн толгой дээр тавьж, тэдэнд зэрэгтний хүчийг хүртээдэг байв. Энэ нь зэрэгтний хүч нэгээс нөгөөд дамжих цорын ганц зам билээ. Зэрэгтний хүчийг худалдан авч үл чадна.

Ярилцлага

- Исүс Христийн Сүмийн тэргүүн хэн байсан бэ?
- Исүсийн туслагчдыг юу гэж нэрлэдэг байсан бэ?

Исүсийг Тэнгэрт Буцсаны Дараа Исүс Христийн Сүм Үйл Ажиллагаагаа Үргэлжлүүлсэн нь

Исүсийг тэнгэрт буцсаны дараа түүний сүм газар дэлхий дээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байв. Түүнийг 12 Төлөөлөгчид удирдаж



Исус Христ Төлөөлөгчдийг томилон баталсан нь.

байлаа. Төлөөлөгчдийн хэн нэг нас барвал түүнийг орлох хүнийг Исүс сонгодог байв. Ариун Сүнсээр дамжуулан Исүс бусад Төлөөлөгчдөд хэн шинэ Төлөөлөгч болохыг мэдүүлдэг байлаа. 12 Төлөөлөгчид бусад сайн хүмүүсийг сонгон тэдэнд зэрэгтний хүчийг олгож, Исүсийн Сүмийн ажилд туслуулдаг байв. Тэдгээр хүмүүсийг далтан, дээд зэрэгтэн, ахлагч, бишоп, зэрэгтэн, багш, туслах хэмээн нэрлэдэг байжээ. Тэдгээрийн албан үүргийг 20 дугаар бүлэгт тайлбарласан болно.

Исүс Сүмийг Үзэгдлээр Дамжуулан Удирддаг Байв

Ариун Сүнсээр дамжуулан өгч буй Исүсийн илгээмж, айлдварыг үзэгдэл гэдэг юм. Исүс өөрийн Сүмийг зарлага болон бусад удирдагч нарт юу хийвэл зохихыг нь үзүүлэх замаар удирддаг.

Исүс тэнгэрт буцахынхаа өмнө өөрийн Төлөөлөгчдөд тэдэнтэй үргэлж хамт байх болно гэдгээ хэлжээ. Үүгээрээ Исүс тэрээр Ариун Сүнсээр дамжуулан тэднийг удирдсаар байх болно гэдгээ илэрхийлсэн юм.

Ярилцлага

- Тэнгэрт буцсанахаа дараа Исүс өөрийн Сүмийг хэрхэн удирдаж байсан бэ?

Исүс Христийн Сүм Түүний Үнэн Сургаалыг Агуулдаг Байлаа

Исүс Христийн Сүмийн удирдагчид Ариун Сүнсээр дамжуулан Исүсээс үзэгдлийг хүлээн авч байв. Тухайлбал, Исүс Төлөөлөгч Питерт Евангелийн сургаалыг зөвхөн Израилийн ард түмэнд ч биш нийт хүн ардад хүргэх хэрэгтэй гэж хэлжээ. Исүс Төлөөлөгч Паулд түүний хүн ардад заах ёстой олон зүйлсийг хэлж өгсөн юм. Исүс ирээдүйн талаар олон зүйлсийг Төлөөлөгч Жонд хэлжээ.

Газар дэлхий дээр амьдарч байхдаа Исүс хүмүүст түүнд итгэж, нүглээ наманчлан усан баталгаа хийлгэхийг номлож байв. Тэр тэдэнд Ариун Сүнсний бэлгийг өгчээ. Тэрээр хүмүүст Тэнгэр дэх Эцгээ хайрлаж, түүнийг дуулгавартай дагахыг зааж байсан юм. Тэр бусдыг хайрлаж, тэдэнд туслахыг сургажээ.

Исүсийг тэнгэрт буцсаны дараа Төлөөлөгчид нь түүний зааж байсны нэгэн адил зүйлсийг номлодог байлаа. Исүс Христийн

Сүмийн гишүүд болохыг хүссэн бүх хүн Исүс Христэд итгэж, нүглээ наманчлан, усаар батлуулах ёстой байв. Тэд Ариун Сүнсний бэлгийг хүлээн авч байв. Тэд Тэнгэр дэх Эцгээ хайрлаж, түүнийг дагахыг болон бусдыг хайрлан тэдэнд үйлчлэхийг сурч байсан юм.

Ярилцлага

- Хүмүүс Исүс Христийн Сүмд элсэхийн тулд юу хийх ёстой байсан бэ?

Исүс Христийн Сүмд Харьяалагдсан Хүмүүс Оюун Санааны Бэлгүүдийг Хүлээн Авч Байлаа

Исүс Христийн Сүмд харьяалагдсан хүмүүс оюун санааны бэлгүүдийг хүлээн авч байлаа. Тэдгээр бэлэгнүүдийн зарим нь өвчтэй хүнийг анагаах итгэл, ирээдүйд болох үйл явдлыг зөгнөн хэлэх чадвар, үзэгдэл харах чадал зэрэг байсан юм.

Ярилцлага

- Оюун санааны бэлэгний зарим нь юу вэ?

Исүсийн Сүм Газар Дэлхий Дээр Оршин Тогтнохоо Больсон нь Исүсийг тэнгэрт буцсаны дараа түүний Төлөөлөгчид Сүмийг удирдаж байв. Олон хүн Сүмийн гишүүд боллоо. Гэвч зарим гишүүд Исүс болон Төлөөлөгчдийн номлож байсан зүйлсийн оронд худал сургаал заах болов. Тухайлбал, зарим хүмүүс Тэнгэр дэх Эцэг маань яс, махан биегүй хэмээн сургаж байлаа.

Муу санаат хүмүүс Сүмийн удирдагчид, бусад гишүүдийг хавчин мөрдөх болов. Хорон санаатнууд Төлөөлөгчдийг болон зэрэгтний хүч бүхий бусад удирдагчдын амийг бүрэлгэв. Түүнчлэн тэд Исүс Христийн Сүмийн олон гишүүдийн амь насыг хөнөөсөн юм.

Худал хуурмаг зүйлсийг улам их заах болсноор Исүсийн үнэн сургаалыг итгэж дагадаг хүн ганц ч үлдсэнгүй. Зэрэгтний хүч хүртсэн нэг ч хүн үлдээгүй тул газар дэлхий дээр Исүсийн ажлыг хийж чадах, Тэнгэр дэх Эцгийнхээ бүх хүүхдийн төлөө Исүсийн айлдварыг хүлээж авах тийм хүн байсангүй. Исүсийн сургаалд итгэдэг бөгөөд түүний эрх мэдлийг хүртсэн хүн ганц ч байгаагүй энэхүү үеийг тэрслэлт гэж нэрлэдэг.

Тэрслэлтийн үед хүмүүс Исүсийн байгуулснаас өөр сүмүүдийг зохион байгуулж байв. Тэд Исүсийн заагаагүй зүйлийг заадаг

байлаа. Тэдэнд зэрэгтний хүч гэж байсангүй. Тэд Исүсийн сүмд гүйцэтгэж байсан ёслолуудаас ялгаатай ёслол үйлддэг байв. Тэд Исүсээс ямар ч үзэгдлийг хүлээн авдаггүй байсан юм. Исүс, түүний Төлөөлөгчдийн тэдэнд зааж байсан шигээр Евангелийн бүх сургаалыг тэд заадаггүй байлаа. Энэ бүхэн тохиолдох болно гэдгийг зарлагууд хэлж байсан юм.

Ярилцлага

- Тэрслэлт хэрхэн тохиолдсон бэ?

Исүс Өөрийн Сүмийг Газар Дэлхий Дээр Дахин Сэргээнэ Гэж Амласан Юм

Исүс хүмүүсийг түүний хүчин чадал, сургаал номлолыг алдах болно гэж мэдэж байжээ. Ингээд тэрээр үнэн сүмийг газар дэлхий дээр дахин байгуулагдах замыг бэлтгэсэн юм.

Төлөөлөгч Жон Евангелийн сургаал газар дэлхийд дахин сэргэнэ гэдгийг үзэгдлээр харжээ. Тэрээр Исүс хүмүүст Тэнгэр дэх Эцгийн маань тухай үнэнийг заалгахаар бурхны элч нарыг илгээх болно гэдгийг харав. Исүс Тэнгэр дэх Эцгийн маань бүх хүүхдүүдэд евангели, зэрэгтний хүч, адис ерөөлүүд, Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиход зайлшгүй хэрэгтэй өөр бусад зүйлүүдийг хүргэх болно.

Ярилцлага

- Яагаад Исүс өөрийн Сүмийг газар дэлхий дээр дахин байгуулах замыг бэлтгэсэн бэ?

Лавламж

Исүс Байгуулсан Сүмийнхээ Тэргүүн нь Байлаа

- Лук 9:1 (Исүс өөрийн Төлөөлөгчдөд хүчин чадал хайрлав.)
- 3 Нифай 27:8 (Исүс Христийн Сүм түүний нэрээр нэрлэгддэг.)

Исүсийг Тэнгэрт Буцсаны Дараа Исүс Христийн Сүм Үйл Ажиллагаагаа Үргэлжлүүлсэн нь

- Матвей 16:16-18 (Исүсийн үхлийн дараа Питер Сүмийг тэргүүлэхээр сонгогдов.)
- Матвей 28:20 (Исүс Төлөөлөгчидтэйгөө үргэлж хамт байхаа амладаг.)
- Марк 3:14 (Исүс арван хоёр хүнийг Төлөөлөгчдөөр сонгожээ.)

- Марк 16:17-18; 1 Коринфынхан 12:4-11 (Исүсийн дагалдагчид оюуны бэлгийг хүртэх болно.)
- Лук 10:1 (Исүс Евангели номлох далан хүнийг сонголоо.)
- Жон 14:26 (Исүс Ариун Сүнсээр дамжуулан Төлөөлөгчидтэй үргэлж хамт байх болно.)
- Үйл явдал 1:23-26 (Нас барсан нэгнийх нь оронд шинэ Төлөөлөгч сонгогддог.)
- Үйл явдал 8:18-20 (Зэрэгтний хүчийг худалдан авч чадахгүй гэдгийг Питер нэгэн хүнд хэлсэн нь.)
- Үйл явдал 10 (Евангели нь хүн бүрт зориулагдсан юм гэдгийг Питер үзэгдлээр дамжуулан мэджээ.)
- Үйл явдал 14:23 (Ахлагчдыг цуглаан дээр *томилон баталдаг.)
- Ефесчүүд 2:19-20 (Исүс бол Сүмийн гол тулгын чулуу бөгөөд Төлөөлөгч, зарлага нарынхаа тусыг авч байдаг.)
- Ефесчүүд 4:11-13 (Хүмүүст Исүсийн томилсон албан үүргийн нэрсийг жагсаажээ.)
- Жеймс 5:14-15 (Өвчтэй хүмүүс зэрэгтний хүч бүхий хүнээс адислал авч болно.)

Исүсийн Сүм Газар Дэлхий Дээр Оршин Тогтнохоо Больсон нь

- Амос 8:11-12 (Хүмүүс хаана олохоо үл мэдэн үнэнийг эрэх болно.)
- Матвей 24:9-12 (Төлөөлөгчид амь үрэгдэх болно.)
- 2 Тессалончууд 2:3-4 (Тэрслэлтийг зөгнөн хэлжээ.)
- 2 Питер 2:1 (Хуурамч зарлагууд худал номлож байв.)

Исүс Өөрийн Сүмийг Газар Дэлхий Дээр Дахин Байгуулна Гэж Амласан Юм

- Үйл явдал 3:20-21 (Өөрийн Евангелийг сэргээхээр Исүс газар дэлхийд буцан ирэх болно.)
- Үзэгдэл 14:6 (Евангелийг сэргээхэд бурхны элч туслах болно.)
- Даниел 2:44-45 (Тэнгэр дэх Эцгийн маань хаант улс хожмын өдрүүдэд байгуулагдана.)

ИСҮС ХРИСТИЙН СҮМ ӨНӨӨДӨР

19-р бүлэг

Бид өнөөдөр Исүс Христийн үнэн Евангелийн сургаалыг хаана олж болох вэ?


Олон Жилээр Исүс Христийн Сүм Газар Дэлхий Дээр Байсангүй Исүс газар дэлхий дээр байхдаа өөрийн Сүмийг байгуулжээ. Түүнийг тэнгэр буцсаны дараа түүний Сүм хэсэг хугацаанд дэлхий дээр оршин тогтнож байв. Хүмүүс түүний үнэн сургаалд итгэн дагах, зааж сургахаа больмогц Исүс өөрийн Сүмийг зэрэгтний хүчийн хамтаар газар дэлхийгээс татан авсан юм.

Олон жилээр хүмүүс үнэн Евангели болон Исүс Христийн Сүмгүйгээр амьдарчээ. Хүмүүс Библийн зарим сургаал болон өөрсдийн санал бодол дээр үндэслэсэн олон сүмийг байгуулав. Гэвч тэдгээр сүмүүдэд Тэнгэр дэх Эцгийн маань зэрэгтний хүч байхгүй байлаа. Тэдэнд Исүсийн бүх сургаал номлол, түүнээс хүлээн авах байнгын үзэгдэл, оюун санааны бэлэг чадварууд гэж байсангүй.

Хүмүүс Тэнгэр дэх Эцгийнхээ тухай үнэнийг мэдэхийг хүсч эхлэв. Тэд Тэнгэр дэх Эцгийн маань болон түүний сургаалын талаар үнэнийг эрэлхийлэх боллоо. Тэдний зарим нь Евангелийн үнэн сургаал, Исүс Христийн Сүм газар дэлхий дээр алга байгааг ухаарчээ. Ийнхүү Тэнгэр дэх Эцэг маань газар дэлхийд Евангелийн үнэн сургаал, Исүс Христийн Сүмийг сэргээх цаг ирснийг мэдлээ.

Ярилцлага

- Исүс яагаад зэрэгтний хүчийг газар дэлхийгээс татан авсан бэ?
- Яагаад хүмүүсийн байгуулсан сүмүүд Исүс Христийн Сүм байсангүй бэ?



Тэнгэр дэх Эцэг маань Исүсийн хамтаар Жозеф Смит дээр залран ирсэн нь

Тэнгэр дэх Эцэг Маань Үнэн Сүмийг Буцаан Авчрах Амлалтаа Биелүүлсэн нь

Тэнгэр дэх Эцэг маань өөрийн бүх хүүхдэд хайртай билээ. Тэднийг үхэж, дахин амилсныхаа дараа өөртэй нь хамт амьдрахын тулд юу хийх ёстойгоо мэдээсэй гэж тэр хүсдэг юм. Исүс Христ өөрийн Сүмийг газар дэлхийгээс татан авахын өмнө энэ явдал зайлшгүй тохиолдоно гэдгийг өөрийн зарлага, Төлөөлөгчдөд хэлж байсан юм. Тэр мөн хэзээ нэгэн цагт газар дэлхий дээр Сүмээ дахин сэргээхийг амлажээ. Үүнийг тэрээр Евангелийн үнэн сургаалыг хүлээн авахад бэлэн хүмүүс дахин мэндлэх үед хийх байв.

Исүс Өөрийн Сүмийг Газар Дэлхийд Сэргээн Байгуулав

Исүс Сүмээ өөрийн энэ дэлхийд амьдран байх үедээ байгуулсан тэр Сүмийн нэгэн адил эрх мэдэл, адис ерөөлийн хамтаар дахин сэргээсэн юм. Түүний сургаал зарлигийг дагахыг хүсч буй хүн бүхэн түүний Сүмийн гишүүн болж чадна.

Тэнгэр дэх Эцэг Маань Жозеф Смитийг Сүмийг Дахин Сэргээхэд Туслуулахаар Сонгов

1820 онд Исүс евангелийн үнэн сургаал болон Сүмийг газар дэлхийд сэргээж эхлэв. Жозеф Смит хэмээх нэгэн залуу хөвгүүн Исүс Христийн Сүм аль нь болохыг мэдэхийг хүсч байлаа. Тэрээр Библиэс хэрэв хүн ямар нэгэн зүйлийг мэдэхийг хүсвэл Тэнгэр дэх Эцгээсээ асуух хэрэгтэй гэснийг олж уншжээ. Аль сүмд элсэхээ Тэнгэр дэх Эцгээсээ асуухаар тэр шийдлээ. Тэрээр гэрийнхээ ойролцоох нэгэн ойд очиж, Тэнгэр дэх Эцгээс маань аль сүмд элсвэл зохихыг асуужээ. Тэнгэр дэх Эцэг маань Исүсийн хамтаар Жозеф Смитэд үзэгдэв. Тэнгэр дэх Эцэг маань Жозефт Исүсийн үгийг сонсч, түүнийг дагахыг тушаав. Тийнхүү Исүс Жозеф Смитэд аль ч сүмд элсэх хэрэггүй гэж айлдсан байна. Тэрээр газар дэлхийд үнэн Сүм байхгүй хэмээн хэлжээ.

Евангелийн үнэн сургаал, Исүс Христийн Сүмийг газар дэлхийгээс татан авснаас хойш Тэнгэр дэх Эцгээс маань ийм үзэгдэл анх удаа ирсэн нь энэ байлаа. Үүнээс хойш өөр олон үзэгдлүүд ирсэн юм. Тэнгэр дэх Эцэг маань өөрийгөө газар дэлхий дээр төлөөлүүлэхээр Жозеф Смитийг сонгожээ. Түүгээр дамжуулан Исүс үнэн евангели болон Исүс Христийн Сүмийг дахин сэргээсэн юм.

Ярилцлага

- Жозеф Смит яагаад үзэгдэл харсан бэ?

Зэрэгтний Хүчийг Дахин Сэргээлээ

Зэрэгтний хүчийг газар дэлхийд 1829 онд дахин сэргээжээ. Жон Баптист тэнгэрээс ирж, Жозеф Смитийн толгой дээр гараа тавин түүнд зэрэгтний хүчийн зарим эрх мэдлийг олгосон байна. Энэхүү зэрэгтний хүчийн эрх мэдлийг Аарон Зэрэгтний Хүч гэдэг. Энэ зэрэгтний эрх мэдлийг сэргээсэн Жон Баптист нь Исүсийг усаар баталсан хүн мөн билээ. Исүсийн анхны Төлөөлөгчид болох Питер, Жеймс, Жон нар залран ирж, Жозеф Смитэд зэрэгтний илүү эрх мэдлийг хүртээжээ. Энэ эрх мэдлийг Мелкизедек Зэрэгтний Хүч гэдэг.

Моүзес, Элайжа нарын бусад зарлагууд ч мөн адил ирцгээж, Жозеф Смитэд өөр бусад ариун ажил үүргийг гүйцэтгэх эрхийг олгожээ. Ийнхүү евангелийг заах, ариун нандин ажил үүргийг гүйцэтгэх, Сүмийг удирдах Тэнгэр дэх Эцгийн маань эрх мэдэл газар дэлхий дээр дахин орших боллоо.

Ярилцлага

- Жозеф Смит зэрэгтний хүчийг анх хэрхэн хүлээж авсан бэ?

Исүс Өөрийн Сүмийг Дахин Байгуулсан нь

Исүс үзэгдлээр дамжуулан Жозеф Смитэд өөрийн Сүмийг 1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд байгуулахыг тушаажээ. Исүс дэлхийд амьдарч байхдаа Сүмийн тэргүүн нь байсан билээ. Тэр одоо ч өөрийн Сүмийн тэргүүн байна. Түүний Сүмийн гишүүдийг ч мөн Гэгээнтнүүд гэж нэрлэдэг.

Исүс эдүгээ өөрийн Сүмийг Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хэмээн нэрлэжээ. *Хожмын Үеийн* гэдэг үгс нь энэ бол дэлхий дээр хожим байгуулагдсан Исүс Христийн Сүм гэдгийг илэрхийлж байгаа юм. Исүс тус Сүм бол дэлхий дээрх цорын ганц үнэн Сүм бөгөөд тэрээр үүнд тун сэтгэл ханамжтай байна гэдгээ хэлсэн юм.

Исүс Сүмийг газар дэлхий дээр удирдах зарлагыг сонгодог. Тэр зарлагыг Исүс зааварчилна. Тэрээр зарлагад Сүмийг удирдах эрх

мэдлийг олгодог. Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн анхны зарлага нь Жозеф Смит байлаа. Сүмийн зарлагыг мөн Сүмийн Ерөнхийлөгч ч гэж нэрлэдэг. Ерөнхийлөгч түүнд туслах хүмүүстэй байна. Тэднийг зөвлөхүүд гэж нэрлэнэ. Зарлагыг нас бармагц, Исүс түүнийг орлох шинэ зарлагыг сонгодог юм.

Түүнчлэн Исүс Сүмийг удирдахад туслах арван хоёр Төлөөлөгчийг сонгодог. Бусад сайн эрэгтэйчүүд, хөвгүүд мөн зэрэгтний хүчийг хүлээн авна. Тэд зарлага болон Төлөөлөгч нарт тусалдаг. Тэднийг дээд зэрэгтэн, далтан, ахлагч, бишоп, зэрэгтэн, багш, туслах зэргээр Исүс Христийн анхны Сүмд нэрлэж байсантай адилаар нэрлэдэг юм.

Исүс Жозеф Смитэд өөрийн Сүмийг ямар зохион байгуулалттай байвал зохихыг хэлж өгчээ. Сүм тодорхой нэг бүс нутагт бүрэн байгуулагдсаны дараа тус бүс нутгийг *тойрог гэж нэрлэнэ. Тойргийг ерөнхийлөгч удирдах бөгөөд тэрээр түүнд туслах хоёр зөвлөхтэй байна.

Тойрог нь хоёр жижиг бүсэд хуваагдах ба тэдгээрийг *хэсэг гэж нэрлэнэ. Хэсгийг бишоп гэгдэх зэрэгтэн удирддаг. Тэрээр мөн хоёр зөвлөхтэй байна.

Тойргууд хараахан зохион байгуулагдаж амжаагүй бүс нутагт хэд хэдэн салбараас тогтсон *дүүргүүд байж болох юм. Салбарууд нь ерөнхийлөгч ба хоёр зөвлөхийн удирдлага дор байна. Олон тооны номлогчид евангелийг зааж буй бүс нутгийг *номлолын бүс гэж нэрлэнэ.

Зэрэгтний Хүч Бүхий Эрэгтэйчүүд Чуулгад Зохион Байгуулагдана

Зэрэгтний хүч бүхий эрэгтэйчүүд чуулга хэмээх бүлгүүдэд зохион байгуулагдан орцгооно. Зэрэгтний чуулга гэдэг нь зэрэгтний хүчний нэгэн ижил алба үүрэг бүхий бүлэг хүмүүсийг хэлнэ. Тэд харилцан бие биедээ Болон бусад хүмүүст туслахын тулд нэгдэцгээдэг.

Ярилцлага

- Өнөөдрийн Исүс Христийн Сүмийн тэргүүн хэн бэ?

- Сүмийг удирдахад тусалдаг хүмүүсийг юу гэж нэрлэдэг вэ?

Өнөөгийн Сүм нь Исүсийн Газар Дэлхийд Байхдаа Байгуулсан Сүмтэй Нэгэн Адилаар Зохион Байгуулагджээ

Исүс Одоо ч Өөрийн Сүмийг Үзэгдлээр Дамжуулан Удирдсаар Байна

Исүс Ариун Сүнсээр дамжуулан Сүмийг хэрхэн удирдахыг зарлагад хэлж өгдөг. Тэрээр мөн Төлөөлөгчид, бусад удирдагчдад тэднийг юу хийхийг хүсч буйгаа үзэгдлээр нээж өгдөг юм. Үзэгдлээр дамжуулан Исүс өөрийн сүмийн гишүүдийг ямагт удирдан залсаар байна.

Хэн ч Сүмийн Гишүүн Болж Чадна

Эдүгээ хэн ч гэсэн Исүсийг газар дэлхий дээр байх үед хүмүүс түүний Сүмд хэрхэн элсч байсантай адилаар Исүс Христийн Сүмийн гишүүн болж болно. Гагцхүү тэр Исүст итгэж, нүглээ наманчлан, усан баталгаа хийлгэх ёстой. Усаар батлуулсны дараа тэрээр Ариун Сүнсний бэлгийг хүлээн авна.

Ярилцлага

- Исүс Христийн Сүмийн гишүүн болохын тулд бид одоо юу хийх ёстой вэ?

Өнөөдрийн Сүмийн Гишүүд Оюун Ухааны Бэлгүүдийг Хүлээн Авдаг

Исүс өөрийн Сүмийн гишүүдэд оюуны бэлэг чадваруудыг үргэлж хайрладаг. Эдгээр бүх бэлгүүд өнөөдрийн Сүмд ч бий.

Ярилцлага

- Оюун ухааны ямар бэлгүүд байдаг вэ? (16-р бүлгийг үзнэ үү)

Исүс Үнэн Сургаалаа Сэргээв

Исүс өөрөө болон түүний Төлөөлөгчдийн номлож байсан үнэн сургаалаа сэргээв. Энэ сургаалын гол үндэс нь Исүс Христэд итгэх итгэл, гэм нүглийн наманчлал, усан баталгаа, Ариун Сүнсний бэлэг эдгээр болно. Исүсийн өөрийн Сүмд өгсөн зарим үнэнийг дурьдвал:

1. Тэнгэр дэх Эцэг маань яс, махан бие цогцостой.

2. Бид Тэнгэр дэх Эцгийнхээ сүнсэн хүүхдүүд юм. Бид энэ дэлхийд мэндлэхээсээ өмнө сүнсний байдлаар түүнтэй хамт амьдарч байжээ.
3. Бид Адамын хийсэн зүйлийн өмнөөс биш зөвхөн өөрсдийн гэм нүглийн төлөө шийтгэл хүлээх болно. Олонхи хүмүүс Адам Ева хоёр хориотой жимсийг идсэнээс болж тэдний үр хүүхэд болох бид нүгэл хилэнцтэй төрдөг гэж итгэдэг билээ. Энэ нь худал юм. Хүүхдүүд анх мэндлэхдээ нүгэл хилэнцгүй байдаг. Тэдэнд гэм буруу байхгүй. Тийм учраас тэд найман нас хүртлээ усан баталгаа хийлгэх шаардлагагүй байдаг юм.
4. Исүс Христийн Сүмийн *ёслолуудыг (21-р бүлгийг үзнэ үү) гүйцэтгэхийн тулд эрэгтэй хүн зэрэгтний хүчтэй байх ёстой.

Ярилцлага

- Исүсийн хүмүүст дахин өгсөн сургаалын заримыг дурьдана уу.

Дахин Хэзээ ч Исүс Христийн Сүмийг Газар Дэлхийгээс Татан Авахгүй

Эдүгээ Исүс Христийн үнэн Сүм, зэрэгтний эрх мэдэл, евангели газар дэлхийд сэргээгдсэн бөгөөд дахин тэднийг татан авахгүй байх болно. Тэнгэр дэх Эцэг маань хэзээ ч үл мөхөх хаант улсыг байгуулна хэмээн айлджээ. Тэрхүү хаант улс нь Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм юм. Тэрээр мөнхөд оршин тогтнох болно.

Олон хүн Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд Элсчээ. Дэлхийн олон улс оронд тус Сүмийн гишүүд бий. Улам олон хүмүүс Сүмд элссээр байх бөгөөд Тэнгэр дэх Эцгийн маань бүх хүүхэд евангелийг сонсч, түүнийг хүлээн авах боломжийг олох болно.

Ярилцлага

- Та бүхэн бусдад Исүс Христийн евангелийн тухай сонсч, тэгснээр түүний Сүмд элсэхэд нь хэрхэн тусалж чадах вэ?

Лавламж

Олон Жилээр Исүс Христийн Сүм Газар Дэлхий Дээр Байсангүй

- Исаяя 24:5 (Хүмүүс үнэн сургаал номлолыг өөрчлөх болно.)

- Амос 8:11-12 (Хүмүүс Тэнгэр дэх Эцгийнхээ үнэн үгийг хэрхэн олохоо үл мэдэх болно гэж энэ зарлага хэлжээ.)
- 4 Нифай 1:26-29 (Хүмүүс өөрсдийн сүмийг байгуулцгаав.)

Тэнгэр дэх Эцэг Маань Үнэн Сүмийг Буцаан Авчрах Амлалтаа Биелүүлсэн нь


- Исайяа 2:2-4 (Тэнгэр дэх Эцэг маань өөрийн хаант улсыг хожмын өдрүүдэд байгуулах болно.)
- 2 Нифай 3:6-15 (Газар дэлхийд үнэнийг сэргээхэд Жозеф хэмээх нэгэн зарлага туслах болно.)

Өнөөгийн Сүм нь Исүсийн Газар Дэлхийд Байхдаа Байгуулсан Сүмтэй Нэгэн Адилаар Зохион Байгуулагджээ

- Үйл явдал 3:20-21 (Бүх зүйлс дахин сэргэх болно гэж зарлагууд айлджээ.)
- 2 Нифай 29:9 (Исүс эрт, эдүгээ, ирээдүйд ч хэвээр байх болно.)
- Моронай 10:7 (Исүс оюун ухааны бэлгүүдийг эрт, эдүгээ, ирээдүйд ч өгсөөр байна.)

Дахин Хэзээ ч Исүс Христийн Сүмийг Газар Дэлхийгээс Татан Авахгүй

- Даниел 2:44-45; Матвей 21:43 (Тэнгэр дэх Эцэг маань хэзээ ч үл мөхөх хаант улсыг байгуулахаар амлажээ.)



*Исүс Христийн Сүмийг Исүс гол тулгын чулуу нь байж, Төлөөлөгчид,
зарлагууд суурь нь болсон барилгатай зүйрлэж болно.*

ЗЭРЭГТНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

20-р бүлэг

Тэнгэр дэх Эцгийн маань ажлыг хийж гүйцэтгэх эрх мэдлийг хэрхэн олж авдаг вэ?

Зэрэгтний Хүчийг Хүртсэн Хүн Тэнгэр дэх Эцгийн Маань Ажлыг Гүйцэтгэж Чадна

Тэнгэр дэх Эцгийн маань зөв шударга эрэгтэйчүүд, хөвгүүдэд олгодог газар дэлхий дээр түүний ажлыг гүйцэтгэх эрх мэдлийг зэрэгтний хүч гэдэг. Тэр энэ эрх мэдлийг Исүст өгсөн юм. Түүнийг Исүс энэ дэлхийн эрэгтэйчүүдэд өгчээ. Зэрэгтний хүч бүхий эрэгтэйчүүд, хөвгүүд Тэнгэр дэх Эцэг болон Исүсийг төлөөлдөг. Тэд бусад хүмүүсийн хийж үл чадах зүйлсийг хийж гүйцэтгэдэг. Тэд номлогч болж, Исүс Христийн үнэн евангелийг зааж чадна. Тэд өвчтэй хүмүүсийг адислаж чадна. Тэд Сүмийн ариун ажил үйлсийг гүйцэтгэж чадна.

Хүн бусад эрчүүд, хөвгүүдэд зэрэгтний хүчийг хэрхэн хүртээхийг Исүс бидэнд хэлж өгсөн билээ. Зэрэгтний хүч бүхий хүн гараа тухайн хүн буюу хөвгүүний толгой дээр тавина. Тэрээр ийнхүү түүнд зэрэгтний хүчийг Исүс Христийн нэрээр, өөрийн зэрэгтний хүчийн эрх мэдлээр дамжуулан олгодог.

Исүсийн зарлигийг дагаж мөрддөг эрчүүд, хөвгүүд л зэрэгтний хүчийг хүртэж чадна. Исүс эрчүүд, хөвгүүдэд өөрийн ажлыг хийх эрх мэдлийг зөвхөн тэднийг түүний зарлигийг дагасан тохиолдолд л өгдөг.

Зэрэгтний хүчийг зүй ёсоор нь ашиглаж буй эрчүүд, хөвгүүдээс илүү хүчирхэг хүн энэ дэлхийд байхгүй билээ.

Ярилцлага

- Зэрэгтний хүч гэж юу вэ?
- Хэн зэрэгтний хүчийг хүлээн авч чадах вэ?

Зэрэгтний Хүчийг Хоёр Хуваана

Зэрэгтний хүчийг Аароны ба Мелкизедек зэрэгтний хүч гэж хоёр хуваадаг. Аароны зэрэгтний хүчийг заримдаа доод зэрэг гэх нь бий. Мөн Мелкизедек зэрэгтний хүчийг дээд зэрэг гэнэ.

Аароны Зэрэгтний Хүч

Аароны зэрэгтний хүчийг Моүзес зарлагын ах Аароны нэрээр нэрлэжээ. Аарон нь Моүзесийн үед удирдагч байлаа.

Арван хоёроос дээш насны эр хүн Аароны зэрэгтний хүчийг хүртэж болно. Аароны зэрэгтний хүч бүхий эрчүүд, хөвгүүд хүмүүст зааж болно. Тэдний зарим нь усан баталгаа хийх эрхтэй. Тэд хүмүүст Исүсийг дурсан санахад нь тусална. Тэд хүмүүст олон замаар тус дэм хүргэж чадна.

Мелкизедек Зэрэгтний Хүч

Мелкизедек зэрэгтний хүч нь Мелкизедек хэмээх нэгэн хүний нэрээр нэрлэгджээ. Мелкизедек нь зэрэгтний хүч бүхий маш үнэнч шударга нэгэн байлаа. Тэрээр Абрахамын үед амьдарч байсан юм. Тэр дээд зэрэгтэн байлаа. Тус зэрэгтний хүчийг түүний нэрээр нэрлэхээс өмнө Бурхны Хүүгийн Айлдвараар Ариун зэрэгтний хүч гэдэг байлаа. Гэвч хүмүүсийг Тэнгэр дэх Эцгийн маань нэр алдрыг хэт их ашиглахаас сэргийлэн Мелкизедек болгон өөрчилсөн юм.

Мелкизедек зэрэгтний хүчийг хүртэхийн тулд эр хүн арван найман нас хүрсэн байх ёстой. Мелкизедек зэрэгтний хүч бүхий эрчүүд Сүмийн гишүүдэд адислал хүртээх хүчин чадалтай байдаг. Исүс тэдэнд адислал хүртээхэд мэдэх ёстой зүйлсийг болон юу хэлэхийг нь үзэгдлээр нээж өгдөг.

Ярилцлага

- Сүмийн хоёр зэрэгтний хүчийг нэрлэнэ үү.

Зэрэгтний Хүч Тус Бүрийн Эрх Мэдэл ба Албан Үүрэг

Аароны зэрэгтний хүчийг хүртэж, тухайн зэрэгт хамаарах албан тушаалд томилогдсон эрчүүд, хөвгүүд дараах зүйлсийг хийх хүчин чадалтай юм.

1. Евангелийг заах
2. Усан баталгаа хийх
3. *Ариун ёслолыг бэлтгэж, адислаж, түгээх
4. Мелкизедек зэрэгтний хүч бүхий хүмүүст Сүмийн гишүүдэд айлчлан тусламж үзүүлэхэд нь туслах
5. Бусдад Аароны зэрэгтний хүчийг олгох

Мелкизедек зэрэгтний хүч бүхий эрчүүд дараах зүйлсийг хийх эрх мэдэлтэй байна.

1. Сүмийг удирдах
2. Евангелийг заах
3. Ариун Сүнсний бэлгийг хүртээх
4. Онцгой адислалуудыг хүртээх
5. Нялх хүүхдүүдэд нэр өгч, адислан ерөөх
6. Өвчтөнийг анагаах
7. Зэрэгтний хүчийг бусдад олгох
8. Аароны зэрэгтний хүч бүхий эрчүүд, хөвгүүдийн хийдэг бүх ажил үүргийг гүйцэтгэх

Хүн зэрэгтний хүчийг хүртсэнийхээ дараа тухайн зэрэгт хамаарах албанд томилогддог. Аароны болон Мелкизедек зэрэгтний хүч аль аль нь хэд хэдэн албатай байдаг.

Ярилцлага

- Мелкизедек зэрэгтний хүч бүхий хүмүүс юу хийх эрхтэй вэ?
- Аароны зэрэгтний хүч бүхий хүмүүс юу хийх эрхтэй вэ?

Аароны Зэргийн Албан Тушаалууд, Тэдгээрийн Үүрэг

Аароны зэргийн албан тушаалууд нь туслагч, багш, зэрэгтэн, бишоп болно.

Туслагч

Арван хоёр нас хүрсэн Сүмийн эрэгтэй гишүүн тус зэрэгтний хүчийг хүртэж, туслагчийн албанд томилогдож болно. Тэрээр Исүсийн зарлиг, Сүмийн дүрэм журмыг сахин мөрдөх ёстой.

Туслагчийн үүрэг:

1. Ариун ёслолыг түгээх
2. Удирдагчдадаа туслах
3. Аароны зэрэгтэн багш нарт үүргээ гүйцэтгэхэд нь туслах
4. Туслагч бусад хүмүүст зэрэгтний хүчийг хүртээж чадахгүй. Тэрээр усан баталгаа хийж, ариун ёслолыг адислаж чадахгүй.

Багш

Арван дөрвөн нас хүрсэн Сүмийн эрэгтэй гишүүн тус зэрэгтний хүчийг хүлээн авч багшийн албанд томилогдож болно. Тэрээр Исүсийн зарлиг, Сүмийн дүрэм журмыг сахин мөрдөх ёстой.

Багшийн үүрэг:

1. Сүмийн гишүүдэд анхаарал тавьж, тэдний биеийн болон оюуны хэрэгцээг хангахад туслах
2. Гишүүдэд Исүсийн хууль зарлигийг дагахад нь туслах
3. Мелкизедек зэрэгтний хүч бүхий хүмүүст айл өрхүүдээр айлчилж, тэдэнд Исүсийн зарлигийг дагахыг заахад нь туслах
4. Ариун ёслолыг бэлтгэх
5. Шаардлагатай үед туслагчийн үүргийг гүйцэтгэх

Багш зэрэгтний хүчийг бусдад хүртээж чадахгүй. Түүнчлэн усан баталгаа хийж, ариун ёслолыг адислаж чадахгүй.

Зэрэгтэн

Арван зургаан нас хүрсэн Сүмийн эрэгтэй гишүүн тус зэрэгтний хүчийг хүлээн авч, зэрэгтний албанд томилогдож болно. Тэрээр Исүсийн зарлиг, Сүмийн дүрэм журмыг сахин мөрдөх ёстой.

Зэрэгтний үүрэг:

1. Евангелийг заах
2. Гишүүдэд Исүсийн хууль зарлигийг дагахыг урамшуулах
3. Усан баталгаа хийх
4. Ариун ёслолыг адислах
5. Бусад туслагч, багш, зэрэгтэн нарыг томилон батлах
6. Цугларалт дээр Мелкизедек зэрэгтний хүч бүхий хүн байхгүй тохиолдолд цуглааныг удирдах

Зэрэгтэн нь багш, туслагч нарын хийдэг бүх үүргийг гүйцэтгэж болно. Тэрээр хэн нэгнийг бишоп болон Мелкизедек зэргийн ямар нэгэн албанд томилох эрхгүй.

Бишоп

Бишоп нь хэсгийн удирдагч юм.

Бишопын үүрэг:

1. Өөрийн хэсэг дэх Аароны зэрэгтнүүдийг удирдах
2. Өөрийн хэсгийн зэрэгтнүүдийн чуулгыг удирдах
3. Сүмийн гишүүдэд онцгой тохиолдолд хоол хүнс, хувцас хунар, бусад зүйлсийг олоход нь туслах
4. Сүмийн гишүүдийн тодорхой эрх тушаал, адис ерөөлийг авахад тохирох эсэхийг нь шүүн тогтоох
5. Хүмүүсийн Сүмд хандивласан мөнгө болон бусад зүйлсийг хүлээн авч, хадгалан хамгаалах
6. Хэсгийнхээ гишүүдийг сэтгэл санааны дэмжлэг хүссэн үед нь эсвэл өөрөө шаардлагатай гэж үзсэн үедээ тэдэнд зөвлөлгөө өгөх

Сүмийн Ерөнхийлөгч тойргийн ерөнхийлөгчдөд хэнийг бишопоор томилох талаар удирдамж өгдөг.

Ярилцлага

- Туслагч, багш, зэрэгтэн, бишоп нарын үүрэг юу вэ?

Мелкизедек Зэргийн Албан Тушаалууд, Тэдгээрийн Үүрэг

Мелкизедек зэргийн албан тушаалууд нь ахлагч, дээд зэрэгтэн, тэргүүн хамба, Далтан, Төлөөлөгч эдгээр болно. Алба бүр онцгой үүрэгтэй байна.

Ахлагч

1. Усан баталгаа хийх
2. Ариун Сүнсний бэлэг хүртээх
3. Цугларалтыг удирдах
4. Дээд зэрэгтэн байхгүй үед цугларалтыг тэргүүлэх
5. Евангелийг заах
6. Өвчтөнийг анагаах
7. Нялх хүүхдүүдийг адислах

8. Бусдад зэрэгтний хүчийг олгож, тэднийг ахлагч, зэрэгтэн, багш, туслагчийн албанд томилох

9. Шаардлагатай үед зэрэгтэн, багш, туслагчийн үүргийг гүйцэтгэх

Дээд Зэрэгтэн

Дээд зэрэгтний гол үүрэг бол Сүмийн нийт хүмүүсийг удирдаж, оюун санааны аливаа үйлийг хариуцах юм. Дээд зэрэгтэн нь мөн ахлагч, зэрэгтэн, багш, туслагчийн аль ч үүргийг шаардлагатай үед гүйцэтгэж болно.

Тэргүүн Хамба

Тэргүүн хамба гэдэг нь Сүмийн гишүүдэд онцгой адислалыг хүртээдэг дээд зэрэгтэн юм. Тэдгээр адислалуудыг

тэргүүн хамбын адислал гэдэг. Тэргүүн хамбын адислал нь гишүүдэд Исүсийн тэднийг хийхийг хүсч буй зүйлсийг ойлгоход нь тусална.

Далтан

Далтны гол үүрэг нь Сүмийн гишүүн бус хүмүүст евангелийн сургаалыг номлох юм. Далтнууд нь мөн Төлөөлөгчдөд Сүмийг удирдахад нь тусалдаг.

Төлөөлөгч

Төлөөлөгч нь дэлхий дахинаа Исүс Христийг гэрчлэх онцгой гэрч юм. Төлөөлөгчид Сүмийн үйл ажиллагааг дэлхий нийтийн хэмжээнд удирддаг. Төлөөлөгч бүрт зэрэгтний хүчийн бүх эрх мэдэл байдаг. Гэвч зөвхөн Сүмийн Ерөнхийлөгч буюу Төлөөлөгч тэр бүх эрхийг ашиглаж болно. Бусад Төлөөлөгчид тэдгээр эрх мэдлийг гагцхүү Сүмийн Ерөнхийлөгчийн удирдамжаар ашиглана.

Зэрэгтний Хүчийн Түлхүүрүүд

Зэрэгтний хүч гэдэг нь Исүсийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, биднийг Тэнгэр дэх Эцэгт маань буцаан аваачих эрх мэдэл юм. Зэрэгтний хүчийн түлхүүр гэдэг нь тэрхүү эрх мэдлийг ашиглахыг зөвшөөрдөг эрх мэдэл болно. Энэ нь хэдий олон хүн зэрэгтний хүчийг эзэмшиж болох боловч тэдэнд зэрэгтний хүчээ ашиглах зөвшөөрлийг олгох эрх мэдэл хэн нэгэн хүнд байх ёстой

гэсэн үг юм. Тухайлбал, зэрэгтэн хүн усан баталгаа хийх эрхтэй. Гэвч тэрээр бишопын зөвшөөрөлгүйгээр хэнийг ч усаар баталж үл чадна. Бишоп өөрийн хэсгийн Аароны зэрэгтний хүчийн түлхүүрийг барьж байдаг. Өөр нэгэн жишээ дурьдвал: зэрэгтний хүч бүхий хүн уг хүчийг зөвхөн тухайн газрынхаа зэрэгтний хүчийн түлхүүрийг барьж байдаг хүний зөвшөөрөлтэйгөөр бусдад олгож болно. Тэр хүн нь түүний бишоп, тойргийн ерөнхийлөгч эсвэл номлолын бүсийн ерөнхийлөгч байж болох юм.

Ярилцлага

• Зэрэгтний хүчийн түлхүүр гэж юу вэ?

Зэрэгтний Хүч Бүхий Эрчүүд Хөвгүүдийн Бүлгүүд

Зэрэгтний хүчийн ижил албанд буй эрчүүд, хөвгүүд бүлэг болон хуваагддаг. Эдгээр бүлгүүдийг чуулга гэж нэрлэнэ. Мелкизедек зэрэгт ахлагч нарын ба дээд зэрэгтний чуулга байдаг.

Аароны зэрэгт туслагч, багш, зэрэгтэн нарын чуулгууд байна.

Эрчүүд, хөвгүүд зэрэгтний хүчийн аль нэг албанд томилогдохдоо тэдэнтэй ижил алба үүрэг бүхий хүмүүсийг хамрах чуулгын гишүүд болж, өөр албанд томилогдох хүртлээ тухайн чуулгад харьяалагдана. Чуулгын удирдагчид чуулгынхаа гишүүдэд зааж, тусалдаг.

Мелкизедек Зэргийн Чуулгууд

Ахлагч нарын Чуулга

Ахлагч нарын чуулга нь тухайн хэсэгт амьдардаг бүх ахлагч нарыг хамрах бөгөөд гишүүдийн тоо 96 хүртэл байж болно. Гишүүдийн тоо 96-аас давсан тохиолдолд өөр чуулга байгуулагдана. Мелкизедек зэргийг хүртэж амжаагүй байгаа эрчүүд ахлагч нартай уулзаж, хамтран сурч боловсорч, олон нийтийн ажиллагаанд оролцож, үүрэг даалгавар биелүүлж болно.

Ерөнхийлөгч хоёр зөвлөхийн хамтаар ахлагч нарын чуулгыг удирдана.

Дээд Зэрэгтнүүдийн Чуулга

Дээд зэрэгтнүүдийн чуулга нь тухайн тойрог дахь бүх дээд зэрэгтнүүдийг хамардаг. Тойргийн ерөнхийлөгч өөрийн хоёр зөвлөхийн хамтаар дээд зэрэгтнүүдийн чуулгыг удирдана.

Аароны Зэргийн Чуулгууд

Туслагчдын Чуулга

Туслагчдын чуулга нь 12 хүртэл туслагчдыг хамарч болно. Хэрэв тухайн хэсэгт 12-оос дээш тооны туслагч байвал өөр чуулга байгуулагдана. Туслагчдын чуулга нь ерөнхийлөгч, хоёр зөвлөхтэй байна.

Багш нарын Чуулга

Багш нарын чуулга 24 хүртэл багштай байж болно. Хэрэв тухайн хэсэгт 24-өөс дээш тооны багш нар байвал өөр чуулга байгуулагдана. Багш нарын чуулга нь ерөнхийлөгч, хоёр зөвлөхтэй байна.

Зэрэгтнүүдийн Чуулга

Зэрэгтнүүдийн чуулга нь 48 хүртэл зэрэгтнүүдээс тогтоно. Хэрэв тухайн хэсэгт 48-аас дээш тооны зэрэгтнүүд байвал өөр чуулгыг зохион байгуулдаг. Зэрэгтнүүдийн чуулгын ерөнхийлөгч нь бишоп эсвэл салбарын ерөнхийлөгч байна. Тэр чуулгаас хоёр зэрэгтнийг өөрийн туслахаар сонгоно.

Ярилцлага

- Чуулга гэж юу вэ?
- Ахлагч, дээд зэрэгтэн, туслагч, багш, зэрэгтэн нарын чуулгууд хэдэн гишүүдтэй байж болох вэ?
- Чуулгын гишүүд хэрхэн бие биедээ тусалж болох вэ?

Лавламж

- Еврейчүүд 7; Сургаал ба Гэрээ 84:6-30 (Энд Аароны болон Мелкизедек зэрэгтний хүчийг тайлбарлажээ.)
- Сургаал ба Гэрээ 20:38-60; Сургаал ба Гэрээ 107 (Зэрэгтний хүчийн албан тушаалууд, тэдгээрийн үүргийг тодорхойлжээ.)

ЗАН ҮЙЛҮҮД

21-р бүлэг

Зэрэгтний хүч бүхий эрчүүд, хөвгүүд юу хийж чадах вэ?

Зэрэгтний Хүчийг Хүртсэнээр Хүмүүс Зан Үйлүүдийг Хийж Гүйцэтгэх Исүсийн Нэгэн Адил Эрх Мэдэлтэй Болдог

Зан үйлүүд гэдэг нь зэрэгтний хүчийн эрх мэдлийг хүртсэн хүмүүсийн хийж гүйцэтгэдэг ариун ёслолуудыг хэлнэ. Усан баталгаа, Ариун Сүнсний баталгаа, өвчтэй хүмүүсийн толгой дээр гараа тавин адислан анагаах, талх усыг адислан түгээх зэрэг нь зан үйлийн жишээ юм.

Исүс газар дэлхийд байхдаа хүмүүст туслахын тулд зан үйлийг гүйцэтгэдэг байжээ. Тэрээр өвчтөнийг анагааж, сохор хүнд хараа оруулж байв. Тэр дүлий хүнийг сонсголтой болгож, түүгээр ч зогсохгүй үхсэн хүнийг дахин амьдруулдаг байлаа. Тэр өөрийн дагалдагчдад ариун ёслолын талх усыг хүртээсэн юм.

Исүс зэрэгтний хүч бүхий эрчүүдэд зан үйлүүдийг гүйцэтгэх эрх мэдэл, хүчин чадлыг өгсөн юм. Зэрэгтний хүчийг хүртсэн цэгц шударга эрчүүд, хөвгүүд зан үйлийг гүйцэтгэж болно. Тэд эдгээр зан үйлийг биднийг адислан ерөөж, бидэнд Тэнгэр дэх Эцэгтэйгээ улам илүү адил болоход маань туслахын тулд хийж гүйцэтгэдэг юм.

Исүс зэрэгтний хүчийг газар дэлхийд эдүгээ амьдран буй хүмүүст өгсөн учраас бид амьдралдаа маш их адис ерөөлийг хүртэж чадна. Бид усаар батлуулж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авч, гэр бүлээрээ мөнхөд амьдарч чадах юм.



*Исүс өөрийн Төлөөлөгчдийн хамт барьсан сүүлчийн
зоол дээрээ талх, усыг түгээжээ.*

*Карл Блок. Фредериксбург Шилэтгээний Дуган дахь эх зураг, Дани.
Фредериксбург музейн зөвшөөрлөөр нийтлэв.*

Чуулгын ерөнхийлөгчид чуулгынхаа гишүүдэд зан үйлийг хэрхэн гүйцэтгэхийг заах хэрэгтэй. Хэрэв аливаа зан үйлийг хийж гүйцэтгэхээр томилогдсон зэрэгтний хүч бүхий хүн уг үйлийг яаж хийхээ мэдэхгүй бол чуулгынхаа ерөнхийлөгчөөс асууж, заалгах хэрэгтэй.

Ярилцлага

- Ямар учраас зан үйлийг хийж гүйцэтгэдэг вэ?

Бидний Тусын Тулд Гүйцэтгэдэг Зан Үйлүүд

Усан баталгаа

Усан баталгаа нь Исүс Христийн евангелийн анхдагч зан үйл юм. Хүн усаар батлуулахынхаа өмнө Исүст итгэн нүглээ наманчилж, Исүсийн заасан зүйлсийг хийх эрмэлзэлтэй байх хэрэгтэй.

Гагцхүү зэрэгтний хүч бүхий хүн л бусдыг усаар баталж чадна. Хэн нэгнийг усаар батлахын тулд тэрээр өөрийн бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө зөвшөөрөл авсан байх ёстой. Усан баталгаа хийх гэж буй хүн усаар батлуулах хүнийхээ хамтаар усан дотор орж зогсох бөгөөд баталгааг хийж буй хүн усаар батлуулж буй хүний нэрийг хэлж богинохон залбирал уншина. Дараа нь тэрээр батлуулж буй уг хүнийг бүхлээр нь усан доор оруулж, дахин уснаас гаргаж ирдэг.


Тус залбирлын үг нь: “Исүс Христийн итгэмжилснээр би таныг Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр усаар баталж байна. Амен.”

Ярилцлага

- Исүс Христийн евангелийн анхдагч зан үйл юу вэ?

Ариун Сүнсний Бэлгийг Хүртээх нь

Хүнийг усан баталгаа хийлгэсний дараа Мелкизедек зэрэгтний хүч бүхий хүмүүс толгой дээр нь гараа тавьж, тэдний нэг нь онцгой залбирал хэлдэг. Уг залбиралд тухайн хүнийг Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр батлаад түүнд хандан “Ариун Сүнсийг хүлээн авна уу” гэж хэлнэ. Энэ нь тэр хүн Исүсийн зарлигийг дагахыг үнэн сэтгэлээр хичээсэн цагт Ариун Сүнсний удирдамжийг үргэлж хүлээн авах эрхтэй боллоо гэсэн үг



*Бид Исус Христ, түүний цагаатгалыг дурсан санахын
тулд ариун ёслолоос хүртдэг.*

юм. Энэхүү Ариун Сүнсний бэлгийг хүртээх ёслол нь Исүс Христийн евангелийн хоёрдогч зан үйл юм. Үүний дараагаар зан үйлийг гүйцэтгэгч, тэр хүнд Ариун Сүнсний илгээсэн адис ерөөлийг дэвшүүлнэ. Хэн нэгэнд Ариун Сүнсний бэлгийг хүртээхийн тулд тэд бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө зөвшөөрөл авсан байх ёстой.

Ярилцлага

• Хэн Ариун Сүнсний бэлгийг хүртээж чадах вэ?

Зэрэгтний Хүчийг Хүртээх нь

Хүнд зэрэгтний хүчийг хүртээх нь зан үйлийн нэг юм. Үүнийг бусад зэрэгтний хүч бүхий эрчүүд гүйцэтгэх ёстой. Тэд Аароны зэргийг хүртээхийн тулд бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөс, Мелкизедек зэргийг хүртээхийн тулд тойргийн ерөнхийлөгчөөс зөвшөөрөл авдаг. Эрчүүд, хөвгүүдийн хувьд зэрэгтний хүчийг хүлээн авах нь асар их нэр төрийн хэрэг юм. Зэрэгтний хүчийг хүлээн авахдаа хийсэн амлалтаа биелүүлж чадсан хэн боловч тэрхүү зэрэгтний хүчийг үүрд хадгалж чадна.

Ярилцлага

• Хэн бусдад зэрэгтний хүчийг олгож чадах вэ?

Ариун ёслол

Зэрэгтний хүч бүхий хүн хэсэг талх, усыг адислан залбирал хэлнэ. Үүний дараагаар тэр өөрөө эсвэл зэрэгтний хүч бүхий өөр нэгэн хүн тэрхүү хэсэглэсэн талх болон усыг Сүмийн гишүүдэд түгээдэг. Үүнийг ариун ёслол гэнэ. Ариун ёслол нь мөн зан үйлийн нэг юм.

Талх, ус нь Исүсийн мах, цусны бэлэг тэмдэг юм. Тэдгээр нь бидэнд Исүс бидний төлөө амь насаа *золиосолсныг сануулж байдаг. Бид түүний бидэнд ямар хайртай байсныг дурсан санах ёстой. Бидэнд гэм нүглээ өршөөлгөн, Тэнгэр дэх Эцэгтэйгээ дахин хамт амьдрах боломжийг олгосонд нь бид түүнд талархаж явах хэрэгтэй.

Ариун ёслолоос хүртэх бүрдээ бид усаар батлуулахдаа Тэнгэр дэх Эцэгтээ өгсөн амлалтаа дахин сэргээж байдаг. Бид Исүсийг үргэлж дурсан санаж, хууль зарлигийг нь дуулгавартай даган, түүний нэрээр дуудагдахад бэлэн байхаа дахин амладаг билээ. Ариун ёслолоос хүртэхийнхээ өмнө бид хийсэн буруу үйлээ гэмшин наманчилж, амлалтуудаа сэргээн санах хэрэгтэй.

Тэнгэр дэх Эцэг маань хэрэв биднийг амласан зүйлсээ биелүүлбэл бидэнд Ариун Сүнсийг үргэлж хамт байлгахаар илгээнэ гэдгээ амладаг.

Талхны адислал

Исүс бидэнд ариун ёслолын тусгай залбирлуудыг өгсөн юм. Дараах залбирлыг талх адислахдаа хэлнэ.

“Бурхан минь, *Мөнхийн Эцэг минь, энэ талхнаас хүртсэн хэн бүхэн таны Хүүгийн биеийг төлөөлөн дурсч байхын тулд, таны Хүүгийн нэрийг хүлээн авч, түүнийг ямагт дурсан санаж, мөн тэдэнд хайрласан сургаалыг нь дагахаа Бурхан, Мөнхийн Эцэг таны өмнө гэрчлэхийн тулд, түүний Сүнсийг тэдэнтэй мөнхөд хамт байлгахын тулд энэ талхыг та аравнайлж өгөхийг таны Хүү, Исүс Христийн нэрийн өмнөөс бид залбирч байна. Амен.”

Усны адислал

Дараах залбирлыг усыг адислахад хэлнэ.

“Бурхан минь, Мөнхийн Эцэг минь, энэ уснаас хүртсэн хэн бүхэн өөрсдийнх нь төлөө асгаруулсан таны Хүүгийн цусыг төлөөлөн дурсахын тулд, мөн түүнийг ямагт дурсан санаж байгаагаа Бурхан, Мөнхийн Эцэг таны өмнө гэрчлэхийн тулд, түүний Сүнсийг тэдэнтэй хамт байлгахын тулд энэ усыг та аравнайлж өгөхийг таны Хүү, Исүс Христийн нэрийн өмнөөс бид залбирч байна. Амен.”

Ярилцлага

- Ариун ёслол гэж юу вэ?
- Зэрэгтний хүч бүхий хүмүүс ариун ёслолыг адислан түгээж байхад бид юуны тухай бодох хэрэгтэй вэ?
- Ариун ёслолоос хүртэхдээ бид ямар амлалтууд хийдэг вэ?

Хүүхдүүдийг Адислах нь

Зэрэгтний хүч бүхий хүмүүс нялх хүүхдүүдийг төрснөөс нь хэдэн долоо хоногийн дараа адислан ерөөж болно. Үүнийг хийхийн тулд тэд бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчийн зөвшөөрлийг авсан байх хэрэгтэй. Нялх хүүхдийн эцэг нь Мелкизедек зэрэгтэй бол өөрөө адислаж болно. Хэрэв тэрээр Мелкизедек зэрэггүй бол хүүхдээ адислах буюу түүнийг адислаж буй хүмүүсийн хүрээнд орж зогсох эрхгүй. Тэр Мелкизедек зэрэг бүхий өөр хэн нэгэн хүнээс хүүхдийг нь адислахыг хүсч болно. Мелкизедек зэрэг бүхий эцэг нь эсвэл адислаж буй Мелкизедек зэрэгтэн бусад Мелкизедек зэрэгтнүүдийн тусламжтайгаар хүүхдийг гартаа тэвэрч, залбирал хэлдэг. Тэрээр залбиралдаа Тэнгэр дэх Эцэгтээ хандан өөрөө уг зан үйлийг Мелкизедек зэргийн тусламжтайгаар гүйцэтгэж, хүүхдэд эцэг эхийнх нь сонгосон нэрийг хайрлаж буйгаа хэлнэ. Дараа нь тэрээр Ариун Сүнсний нөлөөн дор хүүхдийг адислан ерөөнө.

Ярилцлага

- Нялх хүүхдийг адислахдаа Мелкизедек зэрэгтэн хүн юу хийдэг вэ?

Өвчтэй Хүмүүсийг Адислах нь

Хүн өвдвөл Мелкизедек зэрэгтний хүч бүхий хүмүүсээс өөрийг нь адислаж өгөхийг хүсч болно. Эхний хүн нь түүнийг ариусгана. Тэгэхдээ эхлээд өвчтөний толгой дээр бага хэмжээний аравнайлан тосыг тавиад гараа мөн дээр нь тавин тусгай залбирал уншдаг. Түүний дараа бусад нь өвчтөний толгой дээр гараа тавьж, нэг нь ариусгалыг батлан, уг хүнийг Ариун Сүнсний нөлөөн дор адислана. Энэхүү зэрэгтний хүчийн адислалыг хүртээд олон хүн сайжрах буюу өвчнөөсөө салж байжээ. Өвчтэй хүмүүсийг адислах нь зан үйл билээ.

Өвчтэй хүмүүсийг ариусгахад хэрэглэдэг тэрхүү тосыг энэ зорилгоор мөн өөр зан үйлийн дагуу аравнайлдаг байна. Тосыг аравнайлахын тулд Мелкизедек зэрэг бүхий хүн бага хэмжээний тосыг задгай саванд хийж бариад тусгай залбирал хэлдэг.

Эдгээр зан үйлүүдийг гүйцэтгэхэд Мелкизедек зэрэгтэн бишоп, салбарын болон тойргийн ерөнхийлөгчөөсөө зөвшөөрөл авах шаардлагагүй байдаг байна.

Ярилцлага

- Өвчтэй хүмүүсийг хэн адислаж чадах вэ?

Эцэг Хүн Гэр Бүлийнхээ Гишүүдийг Адислаж Чадна

Мелкизедек зэрэг бүхий эцэг хүн өөрийн гэр бүлийн гишүүдийг адислаж чадна. Тэрээр үүнийг хэн нэг нь өвчтэй эсвэл онцгой тусламж хэрэгтэй үед хийж болно. Үүнийг хийхэд түүнд бишоп, салбарын болон тойргийн ерөнхийлөгчийн зөвшөөрөл хэрэггүй. Эцэг нь тухайн хүнийхээ толгой дээр гараа тавьж, залбирал хэлнэ. Тэрээр залбирахдаа Ариун Сүнс түүний ой ухаанд юу гэж хэлсний дагуу адис ерөөлийг өгнө. Гэр бүлийнхэндээ адис ерөөл хайрлах нь зан үйлүүдийн нэг юм.

Ярилцлага

- Эцэг нь ямар үед гэр бүлийн гишүүддээ адис ерөөл хайрлаж болох вэ?

Зарим Зан Үйлүүд Маш Чухал Учраас Хүн Бүр Тэдгээрийг Хүлээн Авах Ёстой Байдаг

Зэрэгтний хүчийн зарим зан үйлүүд хүнд Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж хамт амьдрахад нь зайлшгүй хэрэгтэй байдаг. Тэдгээрийн хоёр нь усан баталгаа, Ариун Сүнсний бэлэг юм. Түүнчлэн эрчүүд, хөвгүүд зэрэгтний хүчийг заавал хүлээн авах ёстой. Эцгийн гэр бүлийнхнээ адислах мэтийн бусад зан үйлүүдийг бидэнд тусламж, тайтгарал хэрэг болсон үед л гүйцэтгэдэг юм.

Ярилцлага

- Зарим зан үйлийг нэрлэнэ үү.
- Тэдгээрийн авчрах адис ерөөлийг хэлнэ үү.

Лавламж

Зэрэгтний Хүчийг Хүртсэнээр Хүмүүс Зан Үйлүүдийг Хийж Гүйцэтгэх Исүсийн Нэгэн Адил Эрх Мэдэлтэй Болдог


- Матвей 16:19; Марк 3:14 (Исүс өөрийн дагалдагчдад зэрэгтний хүчийг өгчээ.)
- Марк 1:34 (Исүс өвчтэй хүмүүсийг эдгээж, муу ёрын сүнснүүдийг зайлуулж байлаа.)
- Үйл явдал 9:1-6 (Исүсийн Төлөөлөгчид зан үйлүүдийг гүйцэтгэдэг байв.)

Бидний Тусын Тулд Гүйцэтгэдэг Зан Үйлүүд

- Матвей 19:14-15 (Исүс бяцхан хүүхдүүдийг адислаж байв.)
- Матвей 26:26-28 (Исүс талх, усыг адислан дагалдагчдааа хүртээв.)
- Үйл явдал 8:17 (Исүсийн Төлөөлөгчид Ариун Сүнсийг өглөө.)
- Жеймс 5:14 (Ахлагч нар өвчтэй хүний толгой дээр бага хэмжээний тос тавьж түүнийг адислах ёстой.)
- 3 Нифай 11:23-28 (Усан баталгааг хэрхэн гүйцэтгэх загвар өгөгджээ.)
- Моронай 4, 5 (Олон жилийн өмнө амьдарч байсан хүмүүст Исүс ариун ёслолын адислалын залбирлыг өгчээ.)
- Моронай 6:1-3 (Усаар батлуулах хүмүүст тавигдах шаардлагууд өгөгдөв.)

ҮЗҮҮЛЭН ТАНИУЛАХ ТУСЛАЛЦАА

Туслах Материалууд



1-16-Р ЗУРГИЙН ТАЙЛБАРУУД

1. Хуучин Гэрээний зарлагуудын нэг болох Исаяя, Исүс Христийн ирэхийг зөгнөн хэлжээ.
2. Жон Баптист Исүсийг Иордан голд усаар баталсан нь.
3. Исүс, Питер болон бусад хүмүүсийг хойноосоо дагуулсан нь.
4. Исүс арван хоёр Төлөөлөгчийг томилсон нь.
5. Исүс хүүхдүүдийг хайрлаж, адислан ерөөдөг байлаа.
6. Исүс хүмүүст евангелийн сургаалыг номлосон нь. (Карл Блок, *Уулан Дээрх Номлол*, Фредериксбург Шилтгээний Дуган дахь эх зураг, Дани. Фредериксбург музейн зөвшөөрлөөр нийтлэв.)
7. Гэтсиманы Цэцэрлэгт Исүс бүх хүн төрөлхтний нүглийн өмнөөс зовон шаналжээ.
8. Исүс бүх хүн төрөлхтний нүгэл хилэнцийн өмнөөс загалмай дээр нас эцэслэсэн билээ.
9. Гурав дахь өдрөө Исүс булшнаасаа босч иржээ.
10. Дахин амилсан Исүс өөрийн шарх сорвийг Төлөөлөгчдөдөө үзүүлсэн нь.
11. Дахин амилсан Исүс Америк дахь өөрийн хүн ард дээр заларсан нь.
12. Жозеф Смит Жеймс 1:5-6-ыг уншаад Бурхнаас аль нь Исүс Христийн үнэн Сүм болохыг асуух санаа төржээ.
13. Түүний залбирлын хариуд Тэнгэр дэх Эцэг, Исүс Христийн хамтаар Жозеф Смит дээр залран ирсэн юм.
14. Бурхны элч Моронай Жозеф Смитэд Мормоны Номыг багтаасан алтан хуудсуудыг гардуулав.
15. Жон Баптист, Жозеф Смит, Оливер Каудери нар дээр ирж, тэдэнд Аароны зэрэгтний хүчийг хүртээсэн нь.
16. Питер, Жеймс, Жон нар Мелкизедек зэрэгтний хүчийг Жозеф Смит, Оливер Каудери нарт хүртээлээ.

































ИСҮС ХРИСТИЙГ ДАГАХ НЬ

Долдугаар хэсэг





Исус усаар батлуулснаараа Эцэгтээ дуулгавартай буйгаа харуулсан юм.

ДУУЛГАВАРТАЙ БАЙХ НЬ

22-р бүлэг

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд аз жаргалтай байх, түүнд эргэн очиж хамт амьдрахын тулд юу хийх ёстойг хэлж өгсөн билээ. Бид тэдгээр зүйлсийг хэрхэн сурч, мэдэж авах вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Хайртай Учраас Хууль Тогтоож Өгсөн Юм

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хайртай учраас биднийг газар дэлхий дээр аз жаргалтай байгаасай гэж хүсдэг юм. Тэрээр мөн биднийг түүнд эргэн очиж түүн шигээр баяр баясгалантай байхыг хүсдэг. Үүнийг бид зөвхөн түүний бидэнд хайрласан өөртэй нь адил болох чадварыг ашигласан тохиолдолд л хийж чадах болно.

Тэнгэр дэх Эцэг маань биднийг түүнтэй адил болохын тулд юу хийх ёстойг мэднэ. Тэрээр бидэнд юу хийвэл сайн болохыг заасан хууль зарлигийг тогтоож өгчээ. Түүнчлэн юу хийвэл бидэнд муу болохыг ч хэлж өгсөн юм.

Тэнгэр дэх Эцгийн маань буулгасан зарлиг бүр бидний сайн сайхны төлөө үйлчилж байдаг. Эдгээр зарлигууд нь бидний амьдралыг удирдан залдаг бөгөөд хэрэв бид тэдгээрийг даган мөрдөж чадвал аз жаргалтай байх болно.

Бид бүгдээр Тэнгэр дэх Эцгийнхээ зарлигийг зөрчсөн билээ. Нэгэнт Тэнгэр дэх Эцгийнхээ зарлигийг зөрчсөн учраас бид нүгэл үйлдсэн гэсэн үг. Бид нүгэл үйлдсэний учир Тэнгэр дэх Эцгээсээ тусгаарлагджээ. Тэнгэр дэх Эцгээсээ мөнхөд тусгаарлагдах нь бидний нүгэл хилэнцэд оногдох цорын ганц шийтгэл юм.

Хэдий тийм боловч Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хайртай. Тэрээр бидний нүглийн шийтгэлийг хэлтрүүлэх арга замыг нээж, өөрийн Хүү, Исүс Христийг илгээсэн юм. Исүс биднийг тэрхүү шийтгэлээс хэлтрүүлсэн бөгөөд бид Исүст итгэснээр Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж чадах болов. Исүст итгэлтэй байх гэдэг нь түүнд итгэн найдаж, түүний дуулгавартай дагалдагчид болохыг хэлнэ. Исүст итгэдэг хүмүүс түүний зарлигийг дуулгавартай дагадаг. Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очихын анхны алхам бол Исүст итгэж, түүнийг дагахыг үнэн сэтгэлээсээ хичээх явдал юм. Тийнхүү биднийг Исүст итгэх итгэлээ хадгалсаар байвал тэр бидэнд Тэнгэр дэх Эцгийнхээ бүх хууль зарлигт дуулгавартай байхад маань тусалж, ингэснээр Тэнгэр дэх Эцэг маань бидний нүгэл хилэнцийг уучлан өршөөх болно.

Исүсийн зарим хууль зарлигууд Сүмийн бүх гишүүдэд зориулагдсан байдаг. Тэдгээр нь судраар болон зарлагуудаар дамжин бидний хүртээл болдог. Тэрээр зарим зарлигуудыг хувь хүмүүст Ариун Сүнсээр дамжуулан өгдөг. Тухайлбал, судар болон зарлагууд бидэнд Сүмийн бүх гишүүд евангелийг бусдад заах ёстойг хэлдэг бол Ариун Сүнс хувь хүмүүс хэрхэн гэр бүлийнхээ гишүүд, найз нөхөд, хөршүүддээ евангелийг зааж болохыг хэлж өгнө. Хэрэв бид судруудыг уншин судалж, зарлагуудын үгийг сонсон, Ариун Сүнсний шивнээг дагавал бид хийх ёстой зүйлсээ цаг ямагт мэдэж байх болно.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцгийн маань болон Исүсийн хууль зарлигт тэдний хайр хэрхэн илэрдэг вэ?
- Тэнгэр дэх Эцгийнхээ болон Исүсийн айлдсан зүйлсийг бид хэрхэн мэдэж болох вэ?

Тэнгэр дэх Эцгийн Маань Зарлиг Бүр Чухал

Бид Исүсийн тушаасан болгоныг биелүүлэхэд бэлэн байх ёстой. Түүний хууль зарлигууд чухал бөгөөд биднийг Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиход маань тусалж байдаг. Библид Нааман хэмээх нэгэн хүний тухай өгүүлэл бий. Тэрээр хүнд өвчтэй байсан бөгөөд Элиша хэмээх зарлагаар өөрийгөө эмчлүүлэхийг хүсчээ. Тэр орон гэрээ орхин Элишагийн амьдарч байсан нутаг руу явжээ. Элиша Нааманд элч илгээж, хэрэв тэрээр Иордан голын усанд долоон удаа орвоос өвчнөөсөө салах болно хэмээн хэлүүлэв.

Нааман үүнийг сонсоод ихэд уурлав. Тэрээр өөрийнх нь нутагт олон том голууд байсаар байтал яагаад заавал Иордан голын усанд орох ёстой болсныг гайхаж байлаа. Тэр хэдийгээр уурласан боловч зарлагын үгийг дагахаар шийджээ. Ийнхүү тэр дуулгавартай дагасан учраас эдгэрсэн байна. Хэрэв тэр үл дагасан бол эдгэрэхгүй байх байсан билээ.

Зарим хүмүүс Исүсийн зарлигийг дагах хэцүү гэж боддог. Эрт үед Нифай хэмээх нэгэн залуу хөвгүүн ах нарынхаа хамтаар хэцүү даалгавар биелүүлэх болжээ. Исүс түүнд Иерусалим хотноо буцаж, чухал судрыг олж ирэхийг даалгасан байна. Түүний ах нар нь хийж чадахгүй гэлээ. Энэ нь маш хэцүү даалгавар байсан юм. Гэвч Нифай Исүсийн хэлснийг гүйцэтгэх болно гэж хэлэв. Тэрээр Исүс тушаал буулгахдаа тэр нь ямар ч хүнд хэцүү байсан бидэнд түүнийг биелүүлэхэд тусалдаг гэж хэлсэн юм.

Исүс бидэнд түүнтэй болон Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болохын тулд хөдөлмөрлөх ёстой хэмээн айлджээ. Бид үүнийг хийж чадна гэдгийг тэр мэдээгүй бол бидэнд хийхийг үл тушаахсан билээ.

Исүс нэг ч нүгэл хилэнц үйлдээгүй учраас Тэнгэр дэх Эцэгтэй маань адил билээ. Бид бүгд нүгэл хилэнц үйлдсэн хэдий ч Исүст итгэн нүглээ наманчилснаар Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болж чадна.

Зарим үед бид Исүсийн зарлиг тушаалуудын учир шалтгааныг ойлгохгүй байж болох юм. Гэвч бид Исүсийг хайрлаж, түүнд итгэвэл түүний бидэнд хэлсэн бүгдийг хийх болно. Хэдийгээр ямар учраас тийнхүү тушааж буйг нь ойлгохгүй ч бид дуулгавартай дагах болно. Адам Ева хоёр мөн ингэж байсан юм. Исүс, Адам Ева хоёрт Тэнгэр дэх Эцэгтээ *тахил өргөхийг тушаажээ. Нэгэн өдөр бурхны элч Адам дээр ирж, түүнээс юуны учир тахил өргөж байгааг асуув. Адам түүнд учрыг нь мэдэхгүй гэвч Исүс даалгасан юм гэжээ. Тэгэхэд нь бурхны элч Адамд тэрхүү хуулийн учрыг хэлж өгч, евангелийг номлосон байна. Хуулийн учир шалтгааныг мэдэхээсээ өмнө түүнийг дуулгавартай дагасанд нь Исүс Адамд ихэд сэтгэл ханамжтай байлаа.

Бид түүнд хайртай, түүнийг дагахыг хүсдэг учраас Исүсийн зарлиг тушаалуудыг биелүүлэх ёстой. Исүсийн зарлигийг дагахыг хүсдэг хүмүүст сэтгэл ханамжтай байдгаа Тэнгэр дэх Эцэг маань айлдсан билээ. Харин тэднийг хүчлэх ямар нэгэн зүйл тохиолдох хүртэл

түүний хүүхдүүд Исүсийн зарлигийг үл дагавал Тэнгэр дэх Эцэг маань харамсах болно. Тэнгэр дэх Эцэг маань өөрийн хүүхдүүдийг Исүсийг хайрлаж, түүнийг дуулгавартай дагаж сурахыг хүсдэг. Учир нь энэ бол тэдний түүнд эргэн очих цорын ганц зам юм.

Ярилцлага

- Яагаад биелүүлэхэд хэцүү байлаа ч Исүсийн зарлигийг дагах нь чухал байдаг вэ?
- Бид яагаад хэдий ойлгомжгүй байлаа ч зарлигийг дагах ёстой вэ?
- Яагаад бид өөрсдийн хүслээр дуулгавартай дагах нь чухал байдаг вэ?

Бид Тэнгэр дэх Эцэгтээ Хайртай Бол Исүсийг Дагахыг Хүснэ

Исүс Тэнгэр дэх Эцгийнхээ тушаасан болгоныг биелүүлж байжээ. Исүс Тэнгэр дэх Эцэгт маань хайртай учраас түүний үгийг дуулгавартай дагадаг байлаа. Сатан Исүсийг Тэнгэр дэх Эцгээ үл дагахыг ятгасан боловч Исүс Сатаны ятгалгад ороогүй юм.

Хамгийн Анхдагч, Хамгийн Чухал Зарлиг бол Тэнгэр дэх Эцгээ Хайрлах Юм

Бид Тэнгэр дэх Эцэгтээ хайртай бол Исүсийн адилаар түүнийг дуулгавартай дагахыг хүснэ. Түүний тухай илүү ихээр мэдэх тутам бид Тэнгэр дэх Эцгээ улам илүүтэйгээр хайрлаж чадна. Бид түүний тухай болон тэр бидний төлөө юу хийдгийг нь мэдэх хэрэгтэй. Бид үүнийг судруудыг уншиж, Исүс Христийн Сүмийн удирдагчдыг сонссоноор мэдэж авч чадна. Бид Тэнгэр дэх Эцгээ хайрласнаар Исүсийг биднийг Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиход хэрхэн тусалсных нь төлөө мөн хайрлах болно. Бид Исүсийн тушаасан зүйлсийг хийж гүйцэтгэснээр түүнийг хайрлаж сурна. Тэнгэр дэх Эцгээ болон Исүсийг хайрлах хайр маань гүнзгийрэх тутам тэдний зарлигийг дагах амархан болно.

Хоёрдогч Чухал Зарлиг Бол Бүх Хүмүүсийг Хайрлах Юм

Исүс бидэнд бусдыг хайрлаж, тэдэнд туслахыг сургажээ. Хүмүүсийг бидэнтэй яаж харьцахыг хүсдэг шигээ тэдэнтэй харьцахыг тэр сургасан юм. Бид тэднийг муучлахгүй байж, тэдний алдааг уучилж, бусдад чадах бүхнээрээ тусалж байх ёстой.

Бид Тэнгэр дэх Эцэг, Исүст хайртай байсан цагтаа бусдыг хайрлан тэдэнд тусалж байдаг. Исүсийг болон бусад хүмүүсийг хайрлах

тутам Тэнгэр дэх Эцгийн маань болон Исүсийн зарлигуудыг дагах амархан болно.

Ярилцлага

- Хоёр чухал зарлигийг хэлнэ үү.
- Тэнгэр дэх Эцгийнхээ зарлигийг дагахад Исүсийн үлгэр дууриал бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Бид хэрхэн Тэнгэр дэх Эцгээ болон Исүсийг хайрлаж, тэдний зарлигийг дагаж сурах вэ?

Бидний Хүлээн Авдаг Адис Ерөөл Бүр Дуулгавартай Байсны Маань Хариуд Ирдэг Юм

Түүний зарлигийг дуулгавартай дагавал Тэнгэр дэх Эцэг маань биднийг адислаж байдаг. Тэрээр бидний дагадаг хууль зарлиг бүрт адис ерөөл хайрлахаа амлажээ. Аливаа зарлигийг нь дагах бүртээ бид түүнийг дагасныхаа хариуд адис ерөөл хүртэж байдаг. Хэрэв бид хууль зарлигийг нь үл дагасан бол амласан адис ерөөлийг хүлээх учиргүй юм.

Тэнгэр дэх Эцгийн маань хууль зарлигуудыг дагаснаар бидэнд ирдэг адис ерөөлүүдэд аз жаргал, айх аюулгүй байдал, сайн эрүүл мэнд, эрдэм мэдлэг, авьяас чадвар багтана. Тэнгэр дэх Эцгийн маань бидэнд амладаг хамгийн чухал адис ерөөл бол түүнтэй адил болж, мөнхөд түүнтэй хамт амьдрах юм. Түүний бүх зарлигуудыг дагаснаар бид энэхүү адис ерөөлийг хүртэж чадна.

Тэнгэр дэх Эцгийнхээ зарлигуудыг дагахыг үнэн сэтгэлээсээ хүсвэл бид тэдгээрийг зөвхөн Исүсийн тусламжтайгаар даган мөрдөж чадна гэдгийг үргэлж санаж байх ёстой. Хэрэв бид Исүст итгэлтэй байж, гэм нүглээ наманчилбал биднийг дуулгавартай дагаагүй тохиолдолд Тэнгэр дэх Эцэг маань уучлан өршөөх болно. Нэгэнт бид бүгд нүгэл үйлдсэн учраас Исүсийн цагаатгалд талархалтай байх хэрэгтэй. Түүний цагаатгалын ачаар Тэнгэр дэх Эцэг маань биднийг өршөөж, адислаж, дуулгавартай болоход маань тусалж чаддаг билээ. Бид дан ганц өөрсдийн хүчээр Тэнгэр дэх Эцгийнхээ адис ерөөлийг хүртэж үл чадах байлаа.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцгийнхээ зарлигийг дагаснаар та нар ямар адис ерөөлүүдийг хүртэх вэ?

- Тэдгээрийг хүртэхэд Исүс бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Тэнгэр дэх Эцгийнхээ хамгийн чухал бэлгийг бид хэрхэн хүртэж болох вэ?

Лавламж

*Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Хайртай Учраас Хууль Тогтоож
Өгсөн Юм*

- Жон 15:10-14 (Хэрэв бид Тэнгэр дэх Эцгийнхээ зарлигийг дагасаар байвал түүний бидэнд хайртайг мэдсээр байх болно.)

Тэнгэр дэх Эцгийн Маань Зарлиг Бүр Чухал

- 2 Хаад 5:1-14 (Элиша хэмээх зарлага Нааманд эрүүл болохын тулд юу хийх хэрэгтэйг хэлж өгсөн нь)
- 1 Нифай 3:1-7 (Хууль зарлигийг нь дагах арга замыг Исүс бидэнд бэлтгэж өгдөг.)
- 3 Нифай 12:48 (Исүс бидэнд төгс төгөлдөр болохыг тушаав.)

Бид Тэнгэр дэх Эцэгтээ Хайртай Бол Исүсийг Дагахыг Хүснэ

- Матвей 22:37-40 (Исүс хоёр их зарлиг буулгасан нь)
- Жон 8:29 (Исүс ямагт Эцгийнхээ таашаалд нийцэх зүйлсийг хийж байв.)
- Жон 14:15, 21-24 (Бид Тэнгэр дэх Эцгээ болон Исүсийг хайрладаг бол тэдний зарлигийг дуулгавартай дагана.)
- 1 Коринфынхан 2:9 (Тэнгэр дэх Эцэг маань өөрийг нь хайрладаг хүмүүст асар их адис ерөөлийг бэлтгэжээ.)

*Бидний Хүлээн Авдаг Адис Ерөөл Бүр Дуулгавартай Байсны Маань
Хариуд Ирдэг Юм*

- Зүйр үгс 3:1-4; Иеремия 7:23 (Тэнгэр дэх Эцэг маань хүмүүс өөрийг нь дуулгавартай дагавал адислана хэмээн амлажээ.)
- 2 Нифай 2:3-9; Алма 22:14; Моронай 6:4 (Аврагч маань л бидэнд туслахгүй бол бид дан ганц өөрсдийн хүчээр Тэнгэр дэх Эцгийнхээ адис ерөөлийг хүртэж чадахгүй.)
- Мосайя 2:24 (Тэнгэр дэх Эцэг маань бидэнд өөрийг нь дуулгавартай дагавал адис ерөөлөө хайрладаг.)
- Мосайя 2:41 (Хууль зарлигийг нь дагасан хүмүүс олон адис ерөөлийг хүртэж, аз жаргалтай байдаг.)

ЗОЛИОСЛОЛ

23-р бүлэг

Хэн нэгэн хүнд тусалж ямар нэгэн зүйлийг өгөх нь биднийг өөртэй нь адил болоход туслах Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөөний нэг хэсэг юм. Та нар урьд өмнө нь хэн нэгэн хүнд тус болох ямар нэгэн зүйл өгснөөр баяр хөөртэй, байж үзсэн үү?

Исүс Бидний Төлөө Амиа Золиосолсон Юм

Бид Тэнгэр дэх Эцгээ дагахын тулд үргэлж золиослох хэрэгтэй болдог. Золиослох гэдэг нь хэн нэгэн хүнд тус болох зүйлийг өгөх гэсэн үг юм. Исүс хамгийн аугаа их золиослолыг хийсэн билээ. Тэр бидний нүгэл хилэнцийн өмнөөс шаналан зовж, дараа нь бидний төлөө амиа өгчээ.

Исүс бидний төлөө амиа өгсөн учраас хүн болгон үхлийн дараа дахин амьдрах болно. Бид бүгдээрээ дахин хэзээ ч үл үхэх төгс төгөлдөр бие махбодыг олж авна. Үүнийг дахин амилах гэдэг. Түүнчлэн Исүсийн хийсэн зүйлийн ачаар Исүст итгэдэг хүмүүс гэм нүглээ наманчилснаар өршөөлийг үзэж, Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж, хамт амьдрах болно.

Адамын үеэс Исүсийн үеийг хүртэл хүмүүс ан амьтдаар Тэнгэр дэх Эцэгтээ өргөл барьдаг байв. Хүмүүс сүргийн дотроос хамгийн сайныг нь шилж авдаг байлаа. Тэр нь ямагт сүргийн ууган, эр хүйсийн амьтан байдаг байв. Тохирох амьтдыг шилж сонгосныхоо дараа тэднийг алаад, галд өргөн Тэнгэр дэх Эцэгтээ тахил өргөдөг байлаа.

Хүмүүс Тэнгэр дэх Эцгийнхээ хуулийг дагахын тулд тэдгээр амьтдаар өргөл барьдаг байв. Ийнхүү тэд өөрсдөд нь чухал



*Чинээлэг, залуу захирагчид эд хөрөнгөө өргөлд барьж,
Исүсийг дагах итгэл дутжээ.*

хэрэгцээтэй байсан зүйлээрээ өргөл барьц барин Тэнгэр дэх Эцгийг маань дуулгавартай дагахад бэлэн буйгаа илэрхийлдэг байсан юм. Тэнгэр дэх Эцэг маань өөрийн Хүүг тэдний төлөө золиослох болно гэдгээ тэдэнд сануулж байхын тулд ан амьтдаар өргөл барихыг хүмүүст тушаасан байна. Тэнгэр дэх Эцгийн маань ууган Хүү, Исүс газар дэлхийд ирж, бүхий л талаар төгс төгөлдөр байх болно. Тэрээр бидний нүгэл хилэнцийн өмнөөс өөрийгөө золиослохыг зөвшөөрнө.

Исүс амиа золиосолсны дараа тэрээр амьтдаар өргөл барихгүй байхыг хүмүүст тушаав. Тэр бидний төлөө хийсэн аугаа их золиослолыг бидэнд сануулахын тулд ариун ёслолыг хайрлалаа. Ариун ёслолын талх, ус нь Исүсийн бидний төлөө золиосолсон бие, урсгасан цусыг төлөөлж байдаг юм.

Ярилцлага

- Эрт цагт ан амьтдаар тахил өргөх нь юуг бэлэгддэг байсан бэ?

Золиослол Бол Тэнгэр дэх Эцгийн Маань Төлөвлөгөөний Нэг Хэсэг Юм

Эдүгээ Тэнгэр дэх Эцэг маань биднээс өөр арга замаар өргөл барихыг шаардаж байна. Тэрээр биднийг шимширсэн зүрх, гэмшсэн сэтгэлээр өргөл барихыг тушааж байна. Энэ нь бид өөрсдийн нүгэл хилэнц, бардам зангаас татгалзах ёстой гэсэн үг юм. Бид Исүсийг дурсан санаж, ямар ч үнээр хамаагүй түүний зарлигийг даган биелүүлэхэд ямагт бэлэн байх ёстой. Энэ нь юу гэвэл:

1. Бид Исүст итгэж, гэм нүглээ наманчлан, усаар батлуулж, Исүсийн зарлигийг биелүүлнэ.
2. Бид Исүст итгэх итгэл бишрэлийнхээ талаар бусад хүмүүст ярьж өгснөөр тэд түүний дагалдагчид болж, түүний Сүмд элсэн орж болох юм.
3. Бид Исүсийн Сүмд түүний биднээр хийлгэхийг хүссэн ямар ч ажил үүргийг гүйцэтгэхэд бэлэн байна.
4. Эрчүүд зэрэгтний хүчийг хүлээн авч, гэр бүлдээ болон бусдад дараагийн амьдралдаа Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиход бэлтгэгдэх тийм замаар амьдрахад нь туслахад бэлэн байна.

Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очихын тулд бид Исүсийн хүссэн болгоныг сэтгэл харамгүй өгөхөд бэлэн байх ёстой. Төлөөлөгч Паул бид газар дэлхий дээрх цаг хугацаагаа Исүсийн ажилд тус болох бүхнийг хийхэд зориулах ёстой гэж хэлсэн юм.



Абрахам маш их итгэлтэй байсан бөгөөд Их Эзний тушааснаар өөрийн хүү Исаакийг тахилд өргөхөөр бэлдсэн байлаа.

Ярилцлага

- Та нар эдүгээ Исүсийн золиослолыг дурсан санаж буйгаа хэрхэн илэрхийлж чадах вэ?

Нэгэн баян хүн Исүсээс Тэнгэр дэх Эцэгтэйгээ мөнхөд хамт амьдрахын тулд юу хийвэл зохихыг асуужээ. Исүс түүнд Тэнгэр дэх Эцгийнхээ бүх хууль зарлигийг дагах хэрэгтэй гэж хэлэв. Баян хүн хариуд нь бага залуугаасаа эхлэн тэдгээр зарлигийг дагаж ирснээ хэлжээ. Исүс түүнд дахин нэг зүйл хийх ёстой гэлээ. Тэрээр өөрт буй бүх зүйлээ зараад мөнгийг нь ядуу хүмүүст тараан өгч, өөрөө Исүсийг дагах ёстой байлаа. Баян хүн үүнийг сонсоод гунигт автав. Тэрээр өөрт буй бүгдийг тараан өгч, Исүсийг дагахыг хүссэнгүй.

Тэр баян сайн хүн байлаа. Тэрээр үнэн сэтгэлээсээ түүний зарлигийг биелүүлэхийг хичээдэг байв. Гэвч Исүсийг түүнээс бүх эд хөрөнгөө тараан өгөөд өөрийг нь дагахыг хүсэхэд тэрээр биелүүлж чадсангүй.

Исүсийн хоёр Төлөөлөгч Питер, Андрей нар тэдэнд байсан бүх зүйлээ орхиод түүнийг дагахад бэлэн байсан юм. Тэд Исүсийн хүссэнээр хийж байсан ажлаа орхиод түүнийг дагасан билээ.

Түүнчлэн Абрахам өөрт байгаа бүхнээ Тэнгэр дэх Эцэгт маань зориулахад бэлэн байлаа. Абрахам Исүсийг мэндлэхээс өмнө амьдарч байсан бөгөөд тэр үед Тэнгэр дэх Эцэг маань амьтдаар тахил өргөхийг хүмүүсээс шаарддаг байв. Тэрээр Абрахамын дагах эсэхийг туршихаар түүнд хүүгээрээ тахил өргөхийг тушаажээ. Абрахам биелүүлэхэд бэлэн байлаа. Тэрээр тахилын тавцан босгож, дээр нь хүүгээ хэвтүүлэв. Абрахамын хүүгээ алахыг завдсан тэр мөчид бурхны элч түүнийг зогсоожээ. Бурхны элч Абрахамд хүүгээ золиослох хэрэггүй гэдгийг хэлэв. Тэнгэр дэх Эцэг маань Абрахам түүний тушаасан болгоныг өгөх, тэр ч байтугай өөрийн хүүгээ ч өгөхөд бэлэн буйг мэдлээ. Абрахам Тэнгэр дэх Эцэгт маань маш их хайртай байсан учраас түүний тушаасан бүгдийг биелүүлэхэд бэлэн байсан юм. Өөрийнх нь төлөө юугаа ч золиослохоос буцахгүй байсан учраас Тэнгэр дэх Эцэг маань Абрахамд адис ерөөлөө хайрласан юм.

Ярилцлага

- Түүнд тушаасан бүгдийг Исүст өгөхөд бэлэн биш байсан хүний жишээг хэлнэ үү.
- Түүнд тушаасан бүгдийг Тэнгэр дэх Эцэгт маань өгөхөд бэлэн байсан хүний жишээг хэлнэ үү.
- Дээр өгүүлсэн хоёр нөхцөлд та нар юу хийх байсан бэ?

Исүсийн Үйл Хэргийн Төлөө Золиослол Хийх Үе Бидэнд Тулгарч Болно

Гэр бүлийнхэн маань бидний Исүсийг дагах явдлыг зөвшөөрөхгүй байж болно. Түүний зарлиг тушаалуудыг даган мөрдөхөд маань бусад хүмүүс биднийг шоолон инээлдэж, бидний сэтгэлийг эмзэглүүлэхийг хичээж оролдох болно. Исүс Христийн Сүмд элсэн орсноороо бид ажил төрлөө ч алдаж болох юм.

Бидэнд өөрсдийн цаг, мөнгийг Исүсийн тухай бусад хүмүүст очиж заахад зарцуулах шаардлага тулгарч болно. Түүний үйл хэргийг гүйцэлдүүлэхэд нь Сүмийнхээ удирдагчдад туслах хэрэг гарна. Мөн Тэнгэр дэх Эцэг маань биднийг Исүсийн гэрчлэгчид байхаасаа татгалзсанаас амь насаа алдсан нь дээр гэж үзэхийг хүсч болох юм.

Ярилцлага

- Хэрэв танаас нандигнан хайрладаг эд юмсаа өргөхийг хүсвэл танд ямар санагдах вэ?
- Та Исүсийн үйл хэргийн төлөө хэр ихийг золиослоход бэлэн байна вэ?

Өргөл Барьснаар Өөр Аргаар Олохгүй Тийм Адис Ерөөлийг Хүртэнэ

Өргөл барих нь биднийг амиа хичээх явдлаас сэргийлнэ. Бид Тэнгэр дэх Эцэгтээ болон бусад хүмүүст хэрхэн үйлчлэхэд суралцана. Бусдын төлөө ямар нэгэн зүйл хийснээр бид баяр баясгалантай болдгийг мэдэх болно. Исүсийн тушаасан зүйлийг хийх нь энэ газар дэлхий дээр буй ямарваа материаллаг эд юмсыг эзэмшихээс хавьгүй чухал болохыг бид ойлгоно. Бусдад үйлчилж, туслах нь дан ганц өөрсдийгөө бодсоноос илүү юм гэдгийг бид ухаарах болно. Бид харамгүй сэтгэлээр өргөл баривал, барьсан зүйлээсээ хавьгүй илүү адис ерөөлийг Тэнгэр дэх Эцгээсээ хүртэнэ гэдгийг олж мэднэ.

Бусдад өргөл барих нь Исүс бидний төлөө юу хийснийг илүүтэй ойлгоход маань тусалдаг. Тэрээр бидэнд бидний төлөө амь амьдралаа зориулж чадахуйц тийм их хайртай байжээ. Бид Тэнгэр дэх Эцэгтээ болон бусад хүмүүст өргөл барихын хэрээр тэднийг улам илүү хайрлах болно. Ингэснээр бид өгөөмөр сэтгэлтэй болж, Тэнгэр дэх Эцэг болон Исүстэй илүү адил болох юм.

Эд хөрөнгө ихтэй байх нь муу хэрэг биш ээ. Заримдаа тэр бүхнийг Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хайрладаг бөгөөд тэгснээр бид бусдад тусалж чадна. Гэвч хөрөнгө, мөнгөө хайрлахгүй байна гэдэг хэцүү юм. Түүнийг хуримтлуулахад бид нөр их хөдөлмөр зарцуулдаг. Тэдгээрийн зарим нь бидний амьжиргаанд зайлшгүй хэрэгцээтэй зүйлс байдаг. Хэдий тийм боловч, Тэнгэр дэх Эцгийнхээ бусад хүүхдүүдэд хэрэгцээтэй зүйлээр туслах сэтгэлийн тэнхээгүй болтлоо эд хөрөнгөний хойноос хэт улайрч болохгүй.

Исүс Христийн Сүмийн бүх гишүүд Тэнгэр дэх Эцэгтээ болон Исүст үйлчилж байх хэрэгтэй бөгөөд энэ нь тэдний амьдралын хамгийн чухал зүйл юм. Исүс Христийн Сүмийн удирдагчдын биднээс хүссэн зүйлсийг биелүүлснээр бид Тэнгэр дэх Эцгээ болон Исүсийг өөрсдийн эд хөрөнгөнөөс илүү их хайрладаг гэдгээ харуулж байгаа хэрэг юм. Тэднийг бусад хүмүүст зааж, үйлчлэхэд нь туслахын тулд бид өөрсдийн цаг завьг зориулах хэрэгтэй. Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт амьдрахын тулд бид өөрт байгаа бүгдийг Исүсийн үйл хэрэгт зориулахад бэлэн байх ёстой.

Исүс өөрийг нь дагаж, түүнд үйлчилсэн хүмүүст маш их адис ерөөлийг амлажээ. Хэрэв бид одоо түүний үйл хэргийн төлөө аливааг золиослох юм бол хожим нь одоо төсөөлөхийн аргагүй гайхамшигтай зүйлсийг хүлээж авах болно гэж тэр хэлжээ.

Лавламж

Исүс Бидний Төлөө Амиа Золиосолсон Юм

- Лук 9:57-62 (Исүсийг дагах нь бидний амьдралд юунаас ч илүү чухал юм.)
- Жон 15:12-13 (Исүс бидний төлөө амьдралаа өгснөөр бидэнд асар их хайртайгаа харуулсан юм.)

Золиослол Бол Тэнгэр дэх Эцгийн Маань Төлөвлөгөөний Нэг Хэсэг Юм

- Үүсэл гарал 22:1-14 (Абрахамд өөрийн хүү Исаакаар тахил өргөхийг тушаав.)
- Матвей 4:18-20 (Исүс Питер, Андрей нарыг өөрийн дагалдагчдаар дуудав.)
- Ромчууд 12:1 (Бид өөрсдийн цаг завьг Тэнгэр дэх Эцгээ үйлчлэхэд зарцуулах хэрэгтэй.)

Исүсийн Үйл Хэргийн Төлөө Золиослол Хийх Үе Бидэнд Тулгарч Болно

- Сургаал ба Гэрээ 64:23 (Энэ бол өргөл барих цаг үе.)
- Сургаал ба Гэрээ 97:8 (Тэнгэр дэх Эцэг маань өөрийнх нь төлөө золиос хийхэд бэлэн байгаа хүмүүсийг хүлээн авдаг.)

Өргөл Барьснаар Өөр Аргаар Олохгүй Тийм Адис Ерөөлийг Хүртэнэ

- Матвей 19:29 (Евангелийн сургаалын төлөө аливааг зориулсан хүмүүст Исүс асар их адис ерөөлийг амлажээ.)
- Лук 12:16-34 (Бид газар дэлхийн эд юмсаас өмнө Тэнгэр дэх Эцгийнхээ хаант улсыг хайх хэрэгтэй.)

ХҮНДЭТГЭЛИЙН ӨДӨР

24-р бүлэг

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд долоо хоног бүрийн нэг өдрийг түүнийг хүндэтгэх өдөр байлгахыг зарлиг болгожээ. Тэрхүү өдрийг ариун байлгаснаар бид маш их адис ивээлийг хүртэх болно.


Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Туслахын Тулд Хүндэтгэлийн Өдрийг Өгчээ

Бидэнд олон бэрхшээлтэй асуудлууд буйг Тэнгэр дэх Эцэг маань мэднэ. Бид өдөр бүр олон зүйл хийх хэрэгтэй байдаг. Бид хоол хүнс, хувцас хунараа олохын тулд хөдөлмөрлөх ёстой. Бид хоол хүнсээ бэлтгэх болон бусад ажил төрлийг өдөр тутамд хийх хэрэгтэй байдаг.

Бидэнд энэ бүх ажлын хажуугаар Тэнгэр дэх Эцгийнхээ тухай мартаход хялбар байдаг. Түүний биднээр хийлгэхийг хүсч буй зүйлсийг мөн амархан мартана. Бид Тэнгэр дэх Эцгээсээ илүү өдөр тутмынхаа хэрэгцээний талаар бодох болно.

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд түүний талаар бодох цаг хэрэгтэйг мэднэ. Түүний биднээр хийлгэхийг хүсч буй зүйлсийн талаар мэдэхэд бидэнд мөн цаг хугацаа хэрэгтэй. Ийм учраас тэрээр бидэнд долоо хоногийн нэг өдрийг ажлаасаа амарч, түүний тухай сурч мэдэхэд зориулахыг тушаасан юм.

Тэнгэр дэх Эцэг маань газар дэлхийг цаг хугацааны зургаан мөчлөгт бүтээсэн билээ. Тэрээр эдгээр мөчлөгийг өдөр буюу хоног хэмээн нэрлэжээ. Долоо дахь өдөр нь тэрээр газар дэлхийг бүтээх ажлаа орхин амарсан байна. Тэрээр бидэнд долоо хоног бүрийн нэг өдөрт нь өдөр тутмын ажлаа орхин амрах хэрэгтэй гэж айлджээ.



Ням гариг бол хүндэтгэлийн өдөр юм.

Аль Өдөр нь Хүндэтгэлийн Өдөр Болохыг Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Хэлж Өгчээ

Эрт үеийн хүмүүст Тэнгэр дэх Эцэг маань долоо хоногийн долоо дахь өдрийг хүндэтгэлийн өдөр болгохыг айлджээ. Энэ өдөр нь хүмүүст түүнийг газар дэлхийг бүтээснийхээ дараа долоо дахь өдөрт нь амарсан юм гэдгийг сануулах учиртай байлаа.

Исүс нас барсныхаа дараа долоо хоногийн эхний өдөр дахин амилсан байна. Исүсийн дагалдагчид долоо хоногийн эхний өдрийг хүмүүст Исүсийн дахин амилсан тэр өдрийг дурсан санаж, хүндэтгэхэд нь туслах зорилгоор хүндэтгэл мөргөлийн өдөр болгожээ. Энэ өдрийг бид Их Эзний өдөр гэдэг. (Зарим үед Исүсийг Их Эзэн гэж нэрлэдэг.) Түүнчлэн *амралтын өдөр ч гэж нэрлэнэ. Хэдийгээр энэ нь эрт үед мөргөл хийж байсан тэр өдрөөс өөр гариг боловч мөн л долоо хоногийн нэг өдөр билээ. Бид одоо хүртэл ердийн ажил үүргээ долоо хоногийн зургаан өдөрт хийгээд долоо дахь өдөр нь Тэнгэр дэх Эцгээ хүндэтгэдэг юм.

Одоо үед ихэнх хүмүүс долоо хоногийн эхний өдөр буюу Ням гаригийг хүндэтгэлийн өдөр болгодог. Зарим тохиолдолд Тэнгэр дэх Эцэг маань өөрийн зарлагад зарим орны хүмүүс долоо хоногийн өөр гаригийг хүндэтгэлийн өдөр болгож болно хэмээн айлдсан нь бий.

Бид Их Эзний Өдрийг Ариун Байлгаж Чадна

Их Эзний өдрөөр бидэнд хийж гүйцэтгэвэл зохих олон зүйл бий. Хамгийн чухал нь бид өдрийн турш Тэнгэр дэх Эцгийнхээ болон Исүсийн тухай бодох явдал юм. Бид тэдний биднийг мэдээсэй, хийгээсэй гэж хүсч буй зүйлсийн талаар бодох хэрэгтэй. Хүндэтгэлийн өдрөөр Тэнгэр дэх Эцгээ дурсан санах, түүний тухай сурч мэдэхэд дөхөм болох зүйлсийг дурьдвал:

1. Тэнгэр дэх Эцэг болон Исүсийн тухай заадаг судруудыг унших.
2. Сүмийн тухай мэдэхэд нь бусад хүмүүст туслах.
3. Гэр бүлийнхэндээ Тэнгэр дэх Эцэг болон Исүсийн тухай, мөн тэдний биднээр хийлгэхийг хүсч буй зүйлсийн тухай зааж сургах.
4. Евангелийн сургаалыг хамтран судлах, мэдэх бололцоо олгодог Сүмийн цуглаан, хичээл сургалтад оролцох. Бид Исүс болон евангелийн бусад сургаалын тухай түүхүүдийг сурч мэдэж, Тэнгэр дэх Эцэг болон Исүсийн бидний төлөө хийсэн зүйлийн талаар харилцан ярилцаж болно.

5. Долоо хоногийн бусад өдөр хийдэг ажлаа орхин амрах.
6. Залбирал үйлдэх.
7. Өвчтэй хүмүүсийг эргэн тойрч, тэдэнд туслах.
8. Гэр бүлдээ тохиолдсон зүйлийг бичиж тэмдэглэх. Ингэснээр хожим нь бид тэдгээрийг санах болно.

Хүндэтгэлийн өдөр Исүс Христийн Сүмийн гишүүд ариун ёслолоос хүртэх ёстой. Түүнийг хүртэхийн тулд тэд Исүсийн тухай, түүний бидний төлөө хийж гүйцэтгэсэн зүйлсийн тухай бодож бэлтгэлтэй байна. Тэд Исүсийг дурсан санахад нь туслахыг Тэнгэр дэх Эцгээсээ гуйж болно. Ариун ёслолоос хүртэх мөчдөө тэд хийсэн амлалтуудаа эргэн санах ёстой. Хэрэв тэд Исүсийг дуулгавартай дагавал Тэнгэр дэх Эцгийн маань өгөхөөр амласан зүйлсийн талаар бодох хэрэгтэй.

Хүндэтгэлийн өдөр бидний хийхгүй байвал зохих олон зүйлс байдаг. Бид ажиллах ёсгүй. Бид гэр бүлийнхнээрээ, үйлчлэгч албат нараар болон адгуусан амьтдаар ажил хийлгэх ёсгүй. Тэнгэр дэх Эцэг болон Исүсийн тухай бодлоос маань биднийг холдуулах зүйлсийг уншиж, телевизийн нэвтрүүлгийг үзэж, дуу хөгжим сонсч болохгүй. Бид спортын арга хэмжээнд оролцож, худалдаа наймаа хийхээс татгалзах нь зүйтэй. Эдгээр зүйлс чухал мэт санагдаж болох боловч энэхүү ариун өдөр Тэнгэр дэх Эцэг болон Исүсийн тухай бодоход маань тус дөхөм болж чадахгүй билээ.

Хүндэтгэлийн өдрөөр ажил хийх тохиолдлууд гарч болох хэдий ч аль болох зайлсхийх хэрэгтэй. Хэрэв ажил хийх шаардлага тулгарвал бид ажиллах явцдаа Тэнгэр дэх Эцэг болон Исүсийн тухай бодохыг хичээх хэрэгтэй юм.

Ярилцлага

- Их Эзний өдөр бид юу хийвэл зохих вэ?
- Хүндэтгэлийн өдөр бид юуг үл хийвэл зохих вэ?

Их Эзний Өдрийг Ариун Байлгаснаар Бид Тэнгэр дэх Эцгийнхээ Ивээлийг Хүртдэг

Хүндэтгэлийн өдрийн зорилго ямагт нэгэн ижил билээ. Энэ нь бид өдөр тутмын ажлаа орхин амрах өдөр юм. Энэ нь Тэнгэр дэх Эцгийнхээ тухай мэдэж, түүнтэй хамт амьдрахад бэлтгэх, Тэнгэр дэх Эцгийнхээ биднээр хийлгэхийг хүсч буй зүйлсийн талаар илүү ихийг мэдэж авснаар амьдрал ахуйгаа дээшлүүлэх өдөр юм.

Энэ өдөр нь Тэнгэр дэх Эцгээ дурсан санах, мөн бидний энэ дэлхийд амьдарч буй утга учрыг ойлгоход чухал үүрэгтэй юм. Их Эзний өдрөөр Тэнгэр дэх Эцгийнхээ хүссэн зүйлийг хийх юм бол бид адис ерөөл хүртэх болно. Гэр бүлийнхэн маань илүү аз жаргалтай байна. Бидний бие сэтгэл сэргэнэ. Бид Тэнгэр дэх Эцэг, түүний сургаалыг улам сайн мэдэж, дараах долоо хоногийн турш Ариун Сүнсний нөлөөг илүү хүчтэй мэдрэх болно. Хэрэв бид дуулгавартай байвал Тэнгэр дэх Эцэг маань бидэнд өөрсдийн хоол хүнс, хувцас хунар, хэрэгцээний бусад зүйлийг хангах, өөрийнх нь тухай илүү мэдэх, аз жаргалтай байхад маань туслах болно.

Ярилцлага

- Хүндэтгэлийн өдрийг ариун байлгах ямар шалтгаан байна вэ?

Лавламж

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Туслахын Тулд Хүндэтгэлийн Өдрийг Өгчээ

- Үүсэл гарал 2:2-3 (Тэнгэр дэх Эцэг маань долоо дахь өдөр ажлаасаа амарчээ.)
- Дүрвэлт 20:8 (Хүндэтгэлийн өдрийг ариун байлгахыг Тэнгэр дэх Эцэг маань бидэнд тушааж байна.)
- Дүрвэлт 35:1-3 (Бид хүндэтгэлийн өдрөөр амрах хэрэгтэй.)
- Марк 2:27 (Тэнгэр дэх Эцэг маань хүндэтгэлийн өдрийг бидэнд туслахаар өгсөн юм.)
- Мосайя 18:23 (Бид амралтын өдрийг ариун байлгах хэрэгтэй.)

Аль Өдөр нь Хүндэтгэлийн Өдөр Болохыг Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Хэлж Өгчээ

- Үйл явдал 20:7 (Төлөөлөгчид долоо хоногийн эхний өдөр ариун ёслолыг хүртжээ.)
- 1 Коринфынхан 16:2 (Хүмүүс долоо хоногийн эхний өдөр мөргөлд бэлтгэж байлаа.)

Бид их Эзний Өдрийг Ариун Байлгаж Чадна

- Дүрвэлт 20:9-10 (Тэнгэр дэх Эцэг маань бидэнд долоо дахь өдөр ажил хийх хэрэггүй хэмээн айлдаж байна.)

Их Эзний Өдрийг Ариун Байлгаснаар Бид Тэнгэр дэх Эцгийнхээ Ивээлийг Хүртдэг

- Исайя 58:13-14 (Хүндэтгэлийн өдрийг ариун байлгавал Тэнгэр дэх Эцэг маань биднийг адислан ивээх болно.)

АРИУН ЯВДЛЫН ХУУЛЬ

25-р бүлэг

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд үр хүүхэдтэй болох ариун нандин чадавхи хайрлажээ. Тэрхүү чадавхийг хэрхэн ашиглахыг тэр бидэнд хэлж өгсөн юм. Хэрэв бид түүнийг зөвөөр ашиглавал маш их аз жаргалтай байх болно.

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Үр Хүүхэдтэй Болж, Ариун Явдлын Хуулийг Мөрдөхийг Зарлиг Болгожээ

Адам, Ева хоёрыг гэрлэмэгц Тэнгэр дэх Эцэг маань тэдэнд үр хүүхэдтэй болохыг тушаажээ. Тэрээр Адам, түүний эхнэр Евад үр хүүхэдтэй болохыг зарлиг буулгаснаар тэнгэрт буй сүнснүүд газарт ирж, яс махан бие цогцсыг хүлээн авч чадах байлаа. Яс махан бие цогцос бол Тэнгэр дэх Эцгийн маань бидэнд өгсөн аугаа их бэлгүүдийн нэг билээ. Тэнгэр дэх Эцэг маань яс махан бие цогцостой бөгөөд өөрийн хүүхдүүдийг мөн түүнтэй адил болохыг хүсдэг юм.

Үр хүүхэдтэй болох чадвар нь маш ариун нандин юм. Энэхүү чадварыг хэрхэн ашиглах тухай хуулийг Тэнгэр дэх Эцэг маань бидэнд өгчээ. Түүнийг ариун явдлын хууль гэдэг. Тэрхүү хуулинд бид зөвхөн хууль ёсоор гэр бүл болсон хүнтэйгээ бэлгийн харьцаатай байх ёстой гэж заадаг. Энэ нь бид гэрлэхийнхээ өмнө бэлгийн харьцаанд орох ёсгүй бөгөөд гэрлэснийхээ дараа зөвхөн өөрийн нөхөр буюу эхнэртэй бэлгийн харьцаанд байвал зохино гэсэн үг юм.

Үр хөндөх, хүүхдийг хүчээр зулбуулж гаргах, эхийн хэвлий дэх хүүхдийг хордуулах зэрэг нь буруу бөгөөд зөвхөн зарим онцгой

тохиолдолд бишоп, салбарын ерөнхийлөгчийн туслалцаа болон залбирлаар дамжуулан эдгээр асуудалд хянуур болгоомжтой хандах хэрэгтэй. Бид үр хөндөлтийн асуудлыг дэмжихгүй байвал зохино.

Эцэг эхчүүд үр хүүхдэдээ ариун явдлын хуулийг зааж сургах ёстой. Эцэг эх нь тэдэнд бидний бие махбод бол маш ариун нандин зүйл бөгөөд хэн нэгнийг биеийн тодорхой хэсгүүдэд хүрэхийг үл зөвшөөрөх хэрэгтэй гэдгийг зааж өгөх ёстой. Хүүхдүүдийн өрөөл бусдаас сурсан гаж буруу үгс, ойлголтыг эцэг эхчүүд засч залруулдаг байх хэрэгтэй юм.

Хүүхдүүд өсч том болохын хэрээр Тэнгэр дэх Эцэг маань бидэнд үр хүүхэдтэй болох чадварыг хайрласан бөгөөд түүнийг бид гэрлэснийхээ дараа ашиглах нь зүйтэй юм гэдгийг заалгаж байвал зохино. Тэднийг 12-13 настай байхад нь бид тэдэнд аль хэдийн хүүхэд хэрхэн бүрэлдэж бий болдгийг хэлж таниулсан байх учиртай. Хүүхдийг янз бүрийн худал хуурмаг ойлголт, хортой зуршлаас сэргийлэхийн тулд бид эртнээс тэдэнд тохиромжтой арга хэлбэрээр зааж сургах хэрэгтэй.

Ярилцлага

- Яагаад Тэнгэр дэх Эцэг маань бидэнд үр хүүхэдтэй болох чадварыг хайрласан бэ?
- Ариун явдлын хууль гэж юу вэ?
- Бид үр хүүхдэдээ тэдний бие махбодын талаар юу зааж сургах ёстой вэ?

Сатан Биднийг Ариун Явдлын Хуулийг Зөрчихийг Хүсдэг

Сатан Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиход маань саад хийхийг хүсч байдаг. Сатан биднийг ариун явдлын хуулийг зөрчихийг хүсдэг. Тэрээр үр хүүхэдтэй болох чадвар маань ариун биш гэж бидэнд итгүүлэхийг хүсдэг. Тэрээр ариун явдлын хуулийг зөрчих нь нүгэл биш гэдэгт биднийг итгүүлэхийг хүсч байна.

Сатан энэ хуулийг зөрчихийг бидэнд ятгахдаа олон янзын ухаалаг аргуудыг хэрэглэдэг. Бусдаар илж таалуулах, бие хаагаа гайхуулах нь тийм муу зүйл биш гэж бидэнд ойлгуулахыг тэр хичээнэ. Бидэнд элдвийн муу муухай бодол төрүүлэхийг Сатан хүсч байдаг. Тэрээр биднийг бузар булайд уруу татах зураг, кино, бүжиг үзэх,

тэдгээр бүжигт оролцох, мөн явган яриа, хөгжим сонсохыг ятгадаг. Хэрэв тэгвэл бидний бие бузарлагдаж, үр хүүхэд төрүүлэх чадвараа зүй бусаар хэрэглэхэд хүрэх учраас Сатан энэ бүх зүйлсийг биднээр хийлгэхийг хүсч байдаг юм.

Зарим үед Сатан бидний сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмжийг ашиглан ятгахыг оролддог. Сатан биднийг хэзээ ганцаардмал, эргэлзэн тээнэгэлзсэн, уйтгар гунигтай байгааг мэддэг бөгөөд тэрхүү эгзэгтэй цаг мөчийг сонгон авч, ариун явдлын хуулийг зөрчих хүслийг бидэнд төрүүлэхэд ашигладаг юм. Тэрээр бидэнд ариун явдлын хуулийг зөрчсөнөөр ямар ч муу юм тохиолдохгүй гэсэн бодол төрүүлэхийг хичээдэг байна.

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд Сатаны ятгалга, уруу таталтыг эсэргүүцэх хүч чадлыг өгч чадна. Тэр биднийг муу муухай зүйлийг харж, муу бодол санаа өвөрлөн явахыг үл хүсдэг билээ. Тэрээр Сатаны ятгалгыг бидний эсэргүүцлээс хавьгүй илүү гаргахгүй гэж бидэнд амласан юм. Уруу таталт, ятгалгыг даван гарах замыг тэр бидэнд бэлтгэж өгчээ.

Бид Сатаныг эсэргүүцэхэд туслахыг Тэнгэр дэх Эцгээсээ хүсэн залбирч болно. Биднийг тийн залбирахад Тэнгэр дэх Эцэг маань бидэнд туслахаар Ариун Сүнсийг илгээх болно. Ариун Сүнс бидэнд бидний бие махбод болон үр хүүхэд төрүүлэх чадвар маань ариун нандин юм гэдгийг санахад тусална. Тэрхүү чадварыг зүй бусаар ашиглахгүй байхад маань Ариун Сүнс тусална. Тэрээр үзэж харах, унших, бодоход сайн зүйлсийг сонгоход бидэнд туслах болно. Ариун явдлын хуулийг мөрдвөл бид аз жаргалтай байж, зөрчвөл уйтгар гунигт автах болно гэдгийг тэр бидэнд сануулна.

Ярилцлага

- Яагаад Сатан биднийг ариун явдлын хуулийг зөрчихийг хүсдэг вэ?
- Бид Сатаны ятгалгыг эсэргүүцэхийн тулд юу хийж чадах вэ?
- Ариун явдлын хуулийг сахихад Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

Ариун Явдлын Хуулийг Зөрчих нь Ноцтой Нүгэл Юм

Бие биеэ хайрлаж, хүндэтгэдэг эхнэр нөхрийн хоорондох бэлгийн харьцаа нь цэвэр ариун, сайн сайхан зүйл юм. Энэ нь Тэнгэр дэх

Эцгийн маань бидэнд хайрласан үр хүүхэдтэй болох зам билээ. Энэ нь түүнчлэн эхнэр нөхрийн харилцан бие биедээ хайр сэтгэлээ илэрхийлэх, бие сэтгэлээрээ улам ойртож, дотносох зам юм. Харин гэр бүлээс гадуур бэлгийн харьцаатай байх нь нэн ноцтой нүгэл байдаг.

Ариун явдлын хуулийг зөрчих нь биднийг аз жаргалтай бус болгодог. Бид Тэнгэр дэх Эцгээ дагаагүй болохоо ухаармагц буруугаа ойлгож, ичгүүртэй санагдах болно. Бид түүний бидэнд өгсөн ариун чадварыг зүй бусаар ашиглаж, бусдыг мөн адил уйтгар гунигт унагаснаа ухаардаг. Ариун явдлын хуулийг зөрчих нь нялх хүүхдийг зүй ёсны гэр бүлгүй төрүүлэхэд хүргэж ч болно.

Гагцхүү хоёр нүгэл л ариун явдлын хуулийг зөрчихөөс илүү ноцтой байдаг. Тэдгээр нь Ариун Сүнсийг үгүйсгэх болон хүний амийг хороох юм. Ариун явдлын хуулийг зөрчсөн хүмүүс уучлал өршөөл хүртэж болно. Тэнгэр дэх Эцэг маань тэднийг Исүст итгэж, гэм нүглээ наманчилбал өршөөнө гэдгээ хэлжээ. Ариун явдлын хуулийг зөрчсөн бөгөөд нүглээ үл наманчилсан хүмүүс Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт амьдрах боломжгүй болно.

Бусдаар хүчиндүүлж, доромжлуулсан хүмүүсийг ариун явдлын хуулийг зөрчсөн гэж үзэхгүй.

Зөвхөн Исүст итгэж, нүглээ наманчилснаар өршөөл үзэж болно. Бид үнэхээр гэм нүгэл хийснээ ухаарч, буруу зүйл хийсэндээ үнэн сэтгэлээсээ харамсах ёстой. Бид буруу зүйл хийхээ зогсоож, гомдоосон байж мэдэх хүмүүстээ болон тохирох зэрэгтний хүчийн эрх мэдэлтэнд (бишоп, салбарын ерөнхийлөгч, тойргийн ерөнхийлөгч, номлолын албаны ерөнхийлөгч нарт) гэм нүглээ тоочин буруугаа хүлээх хэрэгтэй. Тэнгэр дэх Эцэг маань Исүст итгэж, Тэнгэр дэх Эцгийн болон зохих Сүмийн удирдагчийн өмнө гэм нүглээ илчлэн хүлээсэн, үнэн сэтгэлээсээ гэмшиж буй хүнийг өршөөх болно гэдгээ хэлсэн байдаг. Эдгээрийг хийгээгүй хүн бол үнэхээр гэмшээгүй байна гэсэн үг бөгөөд үл өршөөгдөх болно.

Ярилцлага

- Яагаад ариун явдлын хуулийг зөрчих нь ноцтой нүгэл байдаг вэ?
- Ариун явдлын хуулийг зөрчсөнөөр бидэнд юу тохиолдож болох вэ?

- Бид яагаад ариун явдлын хуулийг сахин мөрдөх ёстой вэ?
- Ариун явдлын хуулийг зөрчсөн нүглээ наманчлахын тулд бид юу хийх ёстой вэ?

Ариун Явдлын Хуулийг Мөрдсөнөөр Бид Аз Жаргалтай Байдаг
Бид ариун явдлын хуулийг мөрдсөнөөр үр хүүхдэдээ сайн үлгэр дуурайл үзүүлдэг. Тэнгэр дэх Эцгээ дуулгавартай дагаснаар тэр бидэнд сэтгэл ханамжтай байх болно. Тэрхүү хуулийг дагахад гэр бүлийнхэн маань бидний хайрыг мэдэрч, бидэнд буруутай, ичгүүртэй санагдах ямар ч шалтгаан үгүй болно. Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ илүү адил болдог. Ариун явдлын хуулийг сахиснаар Тэнгэр дэх Эцэг маань биднийг болон үр хүүхдийг ивээн адислах болно.

Тэнгэр дэх Эцгийнхээ бидний бие махбодод хайрласан чадварыг гэр бүлийнхээ хүрээнд хэрэглэх нь бидэнд аз жаргал авчрах болно. Гэрлэсэн хосуудын хувьд бэлгийн харьцаа аз жаргал бэлэглэнэ. Энэ нь тэднийг хайр дурлалын хүчит мэдрэхүйгээр улам ойртуулж чадна. Тэдэнд заяах үр хүүхэд нь Тэнгэр дэх Эцгийн маань адис ерөөл юм. Зарим үед хүүхдүүд эцэг эхийнхээ сэтгэлийг зовоож, түгшүүлэх авч тэдэнд асар их баяр баясгаланг авчирдаг. Хүүхдүүд маань өсөн торниж, сурч боловсрох, гэр бүл, үр хүүхэдтэй болцгоох нь бидний амьдралын хамгийн аз жаргалтай мөчүүдийн нэг билээ.

Ярилцлага

- Ариун явдлын хуулийг сахиснаар бид ямар адис ерөөлийг хүртдэг вэ?
- Яагаад ариун явдлын хуулийг сахих нь үл сахихаасаа илүүтэйгээр биднийг аз жаргалтай болгодог вэ?

Лавламж

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Үр Хүүхэдтэй Болж, Ариун Явдлын Хуулийг Мөрдөхийг Зарлиг Болгожээ

- Үүсэл гарал 1:28 (Тэнгэр дэх Эцэг маань Адам, Ева хоёрт үр хүүхэдтэй болохыг тушаажээ.)
- Дүрвэлт 20:14 (Тэнгэр дэх Эцэг маань бидэнд садар самуун явдлыг хоригложээ.)

- Левитикус 20:10-23 (Тэнгэр дэх Эцэг маань ариун явдлын хуулийг зөрчсөн хүмүүсийг шийтгэж, даган мөрдсөнийг нь ивээж байдаг.)
- 1 Коринфынхан 6:19 (Бидний бие махбод ариун нандин билээ.)
- Моронай 9:9 (Ариун явдал бүхнээс эрхэм юм.)

Сатан Биднийг Ариун Явдлын Хуулийг Зөрчихийг Хүсдэг

- Матвей 5:27-28 (Бид буруу зүйлс хийх талаар бодох ч ёсгүй.)
- 1 Коринфынхан 10:13 (Тэнгэр дэх Эцэг маань бидэнд ятгалгыг эсэргүүцэх хүч чадлыг хайрлах болно.)
- Алма 12:14 (Бид сайн зүйлсийг бодож, ярих хэрэгтэй.)

Ариун Явдлын Хуулийг Зөрчих нь Нэн Ноцтой Нүгэл Юм

- Зүйр үгс 6:25-32 (Ариун явдлын хуулийг зөрчих нь биднийг гунигтай болгоно.)
- Исаяя 1:16-18 (Тэнгэр дэх Эцэг маань нүглээ наманчилсан хүмүүсийг өршөөх болно.)
- 1 Коринфынхан 6:9 (Садар самуунд оролцсон хүмүүс Тэнгэр дэх Эцгийн маань хаант улсад орж үл чадна.)
- Алма 39:5 (Гагцхүү хоёр нүгэл л ариун явдлын хуулийг зөрчихөөс илүү ноцтой.)

Ариун Явдлын Хуулийг Мөрдсөнөөр Бид Аз Жаргалтай Байдаг

- Галатынхан 5:16-24 (Тэнгэр дэх Эцэг маань ариун явдлын хуулийг сахидаг хүмүүсийг ивээх болно.)
- Титус 2 (Зөв шударгаар амьдрах нь биднийг аз жаргалтай болгодог.)

ШУДАРГА ЁС

26-р бүлэг

Тэнгэр дэх Эцэг маань хийж буй бүгдэдээ үнэнч шударга байдал. Тэрээр биднийг мөн шударга байхыг хүсдэг үү?

Тэнгэр дэх Эцэг Маань Биднийг Хийсэн Бүгдэдээ Шударга Байхыг Хүсч Байна

Шударга байна гэдэг нь үнэнийг хэлж, худал хэлэхгүй, хулгай хийхгүй байна гэсэн үг юм. Үнэн бус зүйл ярих, үнэний өчүүхэн хэсгийг ч нуун дарагдуулбал бид худал хэлсэнд тооцогдоно. Хэрэв бид хүмүүсийг ямар нэгэн худал хуурмаг зүйлд итгэхэд хөтөлж буй бол бид шударга биш байна гэсэн үг юм.

Хулгай хийх гэдэг нь хэн нэгэн хүний өмчийг эзнийх нь зөвшөөрөлгүйгээр авахыг хэлнэ. Үнийг нь төлөлгүйгээр дэлгүүрээс бараа авбал тэр нь хулгай болно. Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хулгай хийхийг хориглосон байна.

Шударга хүн бол цалинг нь авч буй бүх цагийн турш шургуу хөдөлмөрлөдөг. Хөлсийг төлж буй шударга эзэн хүн бол ажилчдынхаа хийсний хэрээр цалинг олгоно. Шударга хүн үйлдвэрлэл үйлчилгээ болон худалдаж буй эд бараагаа үнэн зөвөөр үнэлдэг. Хэрэв бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт амьдрахыг хүсдэг бол үнэнч шударга байх хэрэгтэй.

Сатан биднийг шударга бус байхыг ятгахыг хичээж байдаг билээ. Бид ямар нэг байдлаар шударга бус байгаа бол бид Сатаныг дагаж байна гэсэн үг юм. Сатан худал хэлэх дуртай. Сатан шударга бус байх нь ухаалаг хэрэг гэж бодохыг биднээс хүсдэг. Тэрээр хэрэв

шударга бус байвал аз жаргалтай байх болно гэж бидэнд ойлгуулахыг оролддог юм. Шударга бус байх нь гэм нүгэл биш гэсэн бодол бидэнд төрүүлэхийг тэр хүсч байдаг. Сатан биднийг шударга бус байлгаж, тэгснээр зол жаргалгүй болгохыг хүснэ.

Тэнгэр дэх Эцэг маань цаг ямагт үнэнч шударга байхыг бидэнд номлосон билээ. Тэрээр бидний худал хуурмаг явдалд харамсаж, худал хэлэх нь нүгэл болно гэдгийг бидэнд мэдүүлэхийг хүсдэг. Шударга бус байх нь буруу бөгөөд биднийг зол жаргалгүй болгодог.

Зарим хүмүүс аливаа эд зүйлийг эзэмших эрхтэй хэмээн бодсоноос хулгай хийх нь бий. Зарим сурагчид сургуульдаа сайн дүн авахын тулд эсвэл бусад нь мөн адил тэгдэг учраас хууран мэхэлдэг. Зарим хүмүүс бусдад аятай сэтгэгдэл төрүүлэхийн тулд худал ярьдаг. Эдгээр учир шалтгааны аль нь ч худал ярих, хулгай хийхийг зөвтгөж чадахгүй билээ. Худал ярьснаа зөвтгөх гэж оролдох нь шударга бус хэрэг юм.

Ярилцлага

- Шударга зан гэж юуг хэлэх вэ?
- Бид шударга байвал хэнийг дагаж байна гэсэн үг вэ?

Бид Бүх Талаар Шударга Байж Чадна

Хэдий хэцүү байсан ч үнэнийг хэлэх зүрх зоригтой байснаар бид шударга байж чадна. Хэрэв биднийг хүсвэл Тэнгэр дэх Эцэг маань бидэнд үнэнч шударга байхад тусална. Тэрээр шударга замыг сонгоход маань туслуулахаар Ариун Сүнсийг илгээх болно. Шударга байх нь зөв зүйтэй хэрэг мөн гэдгийг ухаарахад маань Ариун Сүнс бидэнд туслах болно.

Исүсийн сургаал номлолыг ойлгосон цагтаа бид үнэнч шударга байхыг эрмэлзэх болно. Бид бүхэн Тэнгэр дэх Эцгийнхээ хүүхдүүд бөгөөд өөр хоорондоо ахан дүүс юм гэдгийг Исүс бидэнд заажээ. Бид зөвхөн шударга байснаар л үнэнхүү аз жаргалтай байж чадна гэж тэр сургасан байна. Хэрэв гэр оронд маань өөр хүний эд зүйлс байх юм бол бид сэтгэл тайван сууж үл чадах билээ. Тэрээр хэрэв бид түүнд итгэж, гэм нүглээ наманчлан, үнэнч шударга байх юм бол Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт амьдрахаар эргэн очиж чадах бөгөөд үүрд аз жаргалтай байна гэдгийг бидэнд сургажээ.

Энэ бүх зүйлийг ойлгох аваас бид шударга байхыг эрмэлзэх болно. Бид бусад хүмүүст худал ярихыг үл хүсэх бөгөөд Тэнгэр дэх Эцгээ баярлуулахыг хүсэх болно. Ингэснээр бид түүнд эргэн очиж, хамт амьдарч чадна. Бид алдаагаа хүлээн зөвшөөрч, тэдгээрийг зассанаар Тэнгэр дэх Эцгийнхээ өршөөлийг хүртэх болно.

Ярилцлага

- Яагаад бид их бага гэлгүйгээр худал ярьсан гэмээ наманчилж байх ёстой вэ?
- Бид хэрхэн бүх талаар шударга байж чадах вэ?
- Тэнгэр дэх Эцэг маань биднийг шударга байхад хэрхэн тусалж чадах вэ?

Шударга Байх нь Биднийг Аз Жаргалтай Болгодог

Шударга байвал бидний сэтгэл санаа таатай байдаг. Тэнгэр дэх Эцэг маань ч бидний адил баяртай байна. Бидэнд буруутай юм шиг санагдах нь үгүй. Бидэнд бусдаас нуун дарагдуулах зүйл огт үгүй гэдгээ мэдсэнээр бидний сэтгэл амар тайван байдаг. Хэн нэгэн хүн худлаа хэлснийг минь мэдчих болов уу гэж түгших ч хэрэггүй болно.

Бид шударга байснаараа Тэнгэр дэх Эцэгтэйгээ улам илүү адил болдог. Түүнд эргэн очиж, хамт амьдрахад бэлтгэн буйгаа бид мэднэ. Биднийг үнэнч шударга байвал бусад хүмүүс бидэнд итгэл найдвар хүлээлгэдэг. Шударга байснаар бид зөв үйл хэрэгтээ Тэнгэр дэх Эцгийнхээ тус дэмийг хүртэх болно.

Ярилцлага

- Шударга байснаар бидэнд ямар мэдрэмж төрдөг вэ?
- Хэрэв хүн бүр үнэнч шударга байсан бол дэлхий ертөнц ямар байх байсан бол?

Лавламж

- Дүрвэлт 20:15-16; Матвей 19:18 (Тэнгэр дэх Эцэг маань бидэнд худал хэлж, хулгай хийхийг хориглосон билээ.)
- Зүйр үгс 19:5 (Худал ярьдаг хэн боловч шийтгэлээс мултарч чадахгүй.)

- Жон 8:44; 2 Нифай 2:18 (Сатан бүх худал хуурмагийн эцэг нь юм. Тэр биднийг уйтгар гунигтай байхыг хүсдэг.)
- Үйл явдал 5:1-10 (Тэнгэр дэх Эцэг маань худал ярьдаг хүмүүсийг шийтгэх болно.)
- Филиппчүүд 4:8 (Бид үнэн шударга бүхнийг хийхийг хичээх хэрэгтэй.)
- Еврейчүүд 6:18 (Тэнгэр дэх Эцэг маань худал хэлдэггүй.)

МЭРГЭН ҮГ

27-р бүлэг

Тэнгэр дэх Эцгийн маань бидэнд хайрласан аугаа их адис ерөөлүүдийн нэг нь бидний яс, махан бие цогцос билээ. Тэрээр бидэнд биеэ эрүүл саруул авч явахад маань зориулж эрүүл мэндийн нэгэн хуулийг өгчээ. Эрүүл мэндийн энэхүү хуулийн талаар та юу мэдэх вэ?

Бидний Бие Махбод Ариун Нандин Юм

Газар дэлхийд ирэхийн нэг гол шалтгаан бол яс, махан бие цогцсыг хүлээн авах явдал билээ. Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болоход маань бидэнд бие махбод хэрэгтэй. Гагцхүү бие махбодтой байснаараа бид түүнтэй адил болоход хэрэгтэй зүйлсийг мэдэж чадах болно. Бид үр хүүхэдтэй болно. Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж, хамт амьдрахад маань зайлшгүй хэрэгцээтэй зан үйл, ёслолуудыг бид хүлээн авч чадна. Бие махбодгүйгээр бид эдгээр зүйлсийг хийж үл чадах билээ.

Бидний сүнс биед оршдог учраас бие цогцос маань ариун нандин байдаг юм. Хэрэв бид Исүс Христэд итгэж, түүнийг дагахыг хичээвэл Тэнгэр дэх Эцэг маань Ариун Сүнсийг бидэнтэй хамт байлгахаар илгээдэг. Биднийг дуулгаваргүй байж, бие махбоддоо анхаарал халамж үл тавибаас Ариун Сүнс бидэнтэй хамт үлдэж чадахгүй.

Биднийг үхэхэд сүнс маань биеэ орхин оддог. Исүсийг нас барахад түүний сүнс биеийг нь орхин одсон билээ. Гурван өдрийн дараа түүний сүнс биедээ эргэн ирж, тэрээр дахин амилсан юм. Исүст амьдралд дахин эргэн ирэх хүч чадал байсан бөгөөд түүний бидний төлөө хийсэн золиослолын ачаар бид ч нэгэн адил үхлийн дараа дахин амилах болно. Бидний сүнс, бие махбод дахин нэгдэнэ.

Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болж, түүнтэй үүрд хамт амьдрахад маань яс, махан бие цогцос хэрэг болно гэдгийг Исүс мэдэж байжээ.

Тэнгэр дэх Эцэг маань биднийг биеэ сайтар арчлан тордохыг хүсч байдаг. Хэрэв бид биедээ сайтар анхаарал халамж тавих аваас эрүүл чийрэг, хүч тэнхээтэй байж, түүний биднээр хийлгэхийг хүсч буй зүйлсийг хийж чадах болно. Бид бүгдээр бие махбодоо сайтар арчлан тордох уу, эсвэл биедээ хор хөнөөлтэй зүйлийг хийх үү гэдгээ шийдэх ёстой. Бид бие цогцос маань энэ болоод дараагийн амьдралд маш чухал гэдгийг мэднэ. Бид биеэ сайтар арчлан тордохыг хүсэх учиртай. Эс тэгвээс Тэнгэр дэх Эцэг маань аз жаргалтай байж үл чадна.

Хүүхдүүдэд тэдний бие махбод бол Тэнгэр дэх Эцгийн маань ариун нандин бэлэг бөгөөд ямар учраас тэрхүү бие махбод чухал ач холбогдолтой байдгийг хэлж тайлбарлаж өгөх хүмүүс бол тэдний эцэг эхчүүд юм. Хүүхдүүд биеэ сайтар арчлан тордохын чухлыг ойлговол Сатаны ятгалга, уруу таталтад автахгүй байх болно.

Ярилцлага

- Яагаад бид яс, махан бие цогцостой байдаг вэ?
- Ямар учраас бие махбод маань ариун нандин байдаг вэ?
- Биеэ сайтар арчлан тордохын чухлыг хүүхдүүддээ зааж өгөх нь ямар ач холбогдолтой вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Эрүүл Мэндийн Хуулийг Хайрлажээ

Тэнгэр дэх Эцэг маань бидний биед сайн болон хор хөнөөлтэй зүйлсийг бидэнд хэлж өгчээ. Энэ нь судар номд бичээстэй буй бөгөөд түүнийг Мэргэн Үг гэж нэрлэдэг.

Тэнгэр дэх Эцэг маань Мэргэн Үгийг Зарлага Жозеф Смитэд нээн мэдүүлжээ. Энэ нь хууль юм. Бид эрүүл чийрэг бие махбод, саруул ухаантай байхын тулд энэхүү хуулийг дагаж мөрдөх ёстой.

Мэргэн Үг нь бидний биед юу сайн болохыг зааж өгдөг. Бид гагцхүү биедээ сайн зүйлсийг л ууж идвэл зохино. Бид үр тариа, жимс, хүнсний ногоог өргөнөөр хэрэглэж, хэт ихээр биш тохируулан хооллож байх нь зүйтэй. Махыг бага хэрэглэвэл зохино.

Ярилцлага

- Ямар хоол хүнс бидний биед сайн бэ?
- Амралт, дасгал сургуулилалт Тэнгэр дэх Эцгийн маань Мэргэн Үгтэй ямар холбоотой вэ?
- Бид бие махбодоо хэрхэн цэвэр байлгаж чадах вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидний Бие Махбодод Юу Хортой Болохыг Хэлж Өгчээ

Сатан биднийг эрүүл мэндээ хордуулахыг ятгана гэдгийг Тэнгэр дэх Эцэг маань мэдэж байлаа. Тэнгэр дэх Эцэг маань бидний бие, эрүүл мэндэд хортой зарим зүйлсийг хэлж өгчээ. Согтууруулах ундаа хэрэглэх нь бидний эрүүл мэндэд муу. Тэнгэр дэх Эцэг маань бидэнд архи, пиво болон бусад согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон бөгөөд тэдгээр нь гэр оронд өвчин эмгэг, зовлон зүдгүүр авчирдаг юм. Тэдгээрийг хэрэглэсэн хүн эрүүл ухаанаа алдана. Эдгээр ундааны зүйлс нь муу муухайд тэмүүлэх, худал ярих, хөрөнгө мөнгөө үрэн таран хийх, ариун явдлын хуулийг зөрчихөд хүргэдэг. Хэрэв жирэмсэн эмэгтэй согтууруулах ундаа хэрэглэвэл хэвлий дэх хүүхдэдээ хор хөнөөл хүргэх болно. Согтууруулах ундаа хэрэглэдэг хүмүүс өөр олон ноцтой асуудалд орооцолддог.

Мөн тамхи бидний бие, эрүүл мэндэд хортой болохыг Тэнгэр дэх Эцэг маань хэлж өгчээ. Бид тамхийг татах буюу зажлахгүй байх нь зүйтэй. Тамхи нь өвчин эмгэгийн эх үүсвэр бөгөөд эхийн хэвлий дэх ургийг хордуулж чадна гэдгийг эрдэмтэд баталсан байна.

Тэнгэр дэх Эцэг маань мөн цай, кофег хэрэглэхийг хоригложээ. Тэдгээр нь хортой бодисуудыг агуулдаг учраас бид цай, кофег хэрэглэхгүй байвал зохино. Түүнчлэн эм тариаг эмчийн заавар, зөвшөөрөлгүй хэрэглэхээс зайлсхийх нь зүйтэй.

Тэнгэр дэх Эцэг маань хэрэв бид архи, тамхи, эм танг хэрхэн зөв зохистой хэрэглэхийг мэддэг бол тэдгээр нь бидэнд тус болно гэж хэлжээ. Архийг зөвхөн бидний биеийг угааж ариутгахад, тамхийг өвчин эмгэгтэй малын шарх сорвийг эмчлэхэд хэрэглэж болно. Бид өвчин эмгэгээ эм тангаар эмчилдэг. Гэвч хэрэглэхээсээ өмнө бид тэдгээрийн зориулалт, хэрэглэх зааврыг учир мэдэх хүмүүсээс

асууж лавлах нь зүйтэй. Хэрэв тэдгээрийг буруу хэрэглэвэл хор болно.

Бид бие махбод, эрүүл мэнддээ харшлах зүйлийг хэрэглэж болохгүй. Мэргэн Үг нь зарим хор хөнөөлтэй зүйлийг бидэнд хэлж өгдөг. Энэ нь маш чухал хууль юм.

Мэргэн Үг нь бидний үл хэрэглэвэл зохих бүх зүйлийг тоочдоггүй. Хэдий Мэргэн Үгэнд дурьдагдаагүй ч гэсэн бидний бие махбод, оюун санаанд хор хөнөөлтэй зүйлсийг хэрэглэхгүй байвал зохихыг бид ойлгох ёстой. Түүнчлэн бид бусад замаар, тухайлбал, биеэ цэвэр байлгахын тулд үргэлж угаах, биеийн тамирын дасгал хийх, сайн амрах зэргээр бие, эрүүл мэнддээ анхаарал халамж тавих хэрэгтэй.

Ярилцлага

- Зарим зүйлс бие махбодод маань хор болохыг бид хэрхэн мэдэж болох вэ?
- Хэрэглэхгүй байвал зохих ямар зүйлс байдаг вэ?

Мэргэн Үгийг Дагаснаар Бид Асар Их Адис Ерөөлийг Хүртэх Болно

Хэрэв бид Мэргэн Үгийг дагавал Тэнгэр дэх Эцэг маань бидний бие махбодыг энэхүү тушаалыг үл дагаснаас илүү хүчтэй болгож адислана. Бид түүний үйл хэргийг газар дэлхий дээр хийж гүйцэтгэх илүү чадвартай болно. Тэрээр хэрэв бид энэ хуулийг мөрдөх юм бол эцэж цуцахгүй алхаж, унаж тусахгүй гүйдэг болно гэжээ. Энэ нь үнэхээр аугаа их адис ерөөл юм.

Мөн Тэнгэр дэх Эцэг маань биднийг Мэргэн Үгийг дагавал аугаа их эрдэм мэдлэг, мэргэн ухаан хайрлахаа амласан билээ. Өөр арга замаар мэдэж авахын аргагүй олон чухал зүйлсийг Ариун Сүнс бидэнд нээж өгөх болно. Сатан биднийг эрхшээлдээ оруулж чадахгүй бөгөөд бид Мэргэн Үгийг дагаснаар илүү эрүүл чийрэг байж, Тэнгэр дэх Эцэгтэйгээ амьдрах *мөнхийн амьдралд бэлтгэгдэх болно.

Ярилцлага

- Мэргэн Үгийг дагаснаар бидэнд ямар адис ерөөлүүд ирдэг вэ?

Лавламж

Бидний Бие Махбод Ариун Нандин Юм

- 1 Коринфынхан 3:16-17 (Ариун Сүнс бидэнтэй хамт байж чадна.)

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Эрүүл Мэндийн Хуулийг Хайрлажээ

- Шүүгчид 13:13-14 (Самсоны эхэд тодорхой зарим зүйлсийг уух, идэхийг хориглосон бөгөөд ингэснээр Самсон эрүүл чийрэг хүүхэд болох байлаа.)
- Исайяа 5:11-12 ба Зүйр үгс 20:1 (Дарс болон бусад согтууруулах ундааны зүйлс бидний эрүүл мэндэд хортой.)
- Сургаал ба Гэрээ 89:5-17 (Бидний бие махбодод тохирох, үл тохирох хоол хүнс гэж бий.)

Мэргэн Үгийг Дагаснаар Бид Асар Их Адис Ерөөлийг Хүртэх Болно

- Даниель 1:8-17 (Даниель өөрийн нөхдийн хамтаар бие, эрүүл мэндэд нь тустай хоол хүнсийг хэрэглэснээр муу хоол идсэн бусдаасаа илүү ухаалаг, эрүүл чийрэг болцгоожээ.)
- Сургаал ба Гэрээ 89:1-4, 18-21 (Мэргэн Үгийг дагаснаар хүлээн авах адис ерөөлийг жагсаав.)

ӨГЛӨГ БАРЬЦ БА АРАВТЫН ТАТВАР

28-р бүлэг

Өглөг барьц, аравтын татвар гэж юуг хэлэх вэ? Тэдгээрийг үнэн сэтгэлээсээ өгснөөр Тэнгэр дэх Эцгийнхээ ямар адис ерөөлийг хүртэх вэ?

Аравтын Татвараа Төлж Байхыг Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Тушаажээ

Аравтын татвар гэдэг нь бидний нийт орлогын аравны нэг юм. Эрт дээр үеэс Тэнгэр дэх Эцэг маань бидэнд аравтын татвар төлөхийг тушаажээ. Абрахам, Жейкоб болон бусад олон хүмүүс энэ тушаалыг биелүүлж байлаа.

Хэрэв бид хөдөлмөрлөн цалин хөлс авч байгаа бол түүнийхээ аравны нэгийг аравтын татварт төлөх ёстой. Бид мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг бол мөн л аравтын татвар төлж болно. Нийт ургацынхаа болон тухайн жилд өсгөсөн малынхаа аравны нэгийг өгч болно. Хэрэв боломжтой бол мал, үр тариагаа Сүмд хандивлахын оронд тэдгээрийг зарж борлуулаад мөнгийг нь тушаах хэрэгтэй. Бид аравтын татвараа бишоп, салбарын ерөнхийлөгчдөө өгдөг. Хэрэв хэдий хэмжээний татвар төлөхөө мэдэхгүй байвал аравтын татварын хуулийг ойлгоход маань туслалгыг бишоп болон салбарын ерөнхийлөгчөөсөө хүсч болно.

Аравтын татвараа төлснөөр бид евангелийг дэлхий дахинаа түгээн дэлгэрүүлэхэд тусалж байгаа юм. Аравтын татварыг сүмийн барилга байгууламж барих, ном сэтгүүл хэвлэх болон Исүсийн үнэний Сүмд хэрэгцээтэй бусад зүйлд зарцуулдаг.

Хүүхдүүд ч мөн аравтын татвар төлөх ёстой. Тэд эцэг эхийнхээ хэрхэн аравтын татвараа төлж буйг харж түүнд суралцах ёстой.



Мацаг барьж, залбирал үйлдэх нь адис ерөөл авчрах болно.

Хэрэв тэд багаасаа аравтын татварыг төлж сурвал том болж, өөрийн гэр бүлтэй болсон үедээ ч түүнийг нэгэн адил төлөхийг хүсэх болно.

Ярилцлага

- Аравтын татварт бид хэдий хэмжээний мөнгө төлөх ёстой вэ?
- Аравтын татвар төлөхийг бид хүүхдүүддээ хэрхэн зааж өгөх вэ?

Аравтын Татвар Төлснөөр Бид Тэнгэр дэх Эцэгтээ Хайртайгаа Харуулдаг

Бид аравтын татварыг үнэн сэтгэлээсээ төлөх учиртай. Тэгснээр түүнийг Тэнгэр дэх Эцэг маань хүлээн авч, биднийг ивээх болно. Аравтын татварыг бид өөрсдийн хүслээр төлөх ёстой.

Хэрэв бидэнд аравтын татвараа төлөх хүсэл төрөхгүй байвал Тэнгэр дэх Эцгийнхээ бидэнд өгсөн бүх л адис ерөөлийг санах хэрэгтэй. Аравтын татварыг үнэн сэтгэлээсээ төлснөөр бид Тэнгэр дэх Эцэгтээ болон бусад хүмүүст хайртайгаа харуулж чадна.

Ярилцлага

- 2 Коринфынхан 9:6-7-г уншина уу.
- Яагаад сэтгэл харамгүй өгөх нь чухал байдаг вэ?

Аравтын Татварыг Төлбөл Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Адис Ерөөл Хайрлахаа Амлажээ

Биднийг аравтын татвараа төлөхөд Тэнгэр дэх Эцэг маань баяртай байдаг. Хэрэв түүнийг төлбөл бидэнд адис ерөөл хайрлахаа тэрээр амласан юм. Тэрээр бид тэдгээрийг нь яах учраа олохыг больтол тоо томшгүй их адис ерөөл өгнө гэж хэлжээ. Тэрээр мөн хэрэв бид аравтын татвараа сэтгэл харамгүй төлбөл муу муухай зүйлстэй хамт устгагдахгүй байх болно гэжээ.

Тэнгэр дэх Эцэг маань биднийг адислан ивээснээр бид түүнийг улам илүүтэй мэдэх болно. Тэрээр бидэнд евангелийг илүү сайн ойлгуулахын тулд ивээлээ хайрлах болно. Евангелийн сургаалыг өдөр тутамд мөрдөж, энэ талаар гэр бүлийнхэндээ туслахад маань тэр бидэнд илүү их хүч чадал хайрлана. Ийнхүү биднийг бусдад евангелийн тухай сурч мэдэхэд нь туслахад тэр баяртай байдаг юм.

Аравтын татвараа төлснөөр бид мөнгөө зөв зарцуулах, амин хувиа хичээхгүй байхад суралцдаг. Юуны өмнө бид орлогынхоо аравны

татварт өгөх хэсгийг салган авах хэрэгтэй. Ингэснээр бид үлдсэн хэсгийг өөрсдийн хэрэгцээг хангахын тулд ухаалгаар зарцуулахад маань Тэнгэр дэх Эцэг маань ивээлээ хайрладгийг мэдэх болно.

Ярилцлага

• Аравтын татвараа төлснөөр бид ямар гурван ивээлийг хүртдэг вэ?

Мацгийн Өргөлөө Өгснөөр Бид Бусад Хүмүүст Тусалдаг

Сүмийн гишүүд сар бүр нэг удаа мацаг барьдаг. Энэ нь бид хоёр удаагийн хоолноосоо татгалзана гэсэн үг юм. Бид 24 цагаар юу ч идэж, уулгүй явах ёстой. Мацаг барих нь биднийг сэтгэл санааны хувьд хүчтэй байхад маань тусалдаг гэдэгт бид итгэдэг.

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд мацгийн өргөл хэмээх өргөл барихыг тушаажээ. Энэхүү өргөл нь мацаг барихдаа бидний татгалзсан хоёр хоолны өртөг байх ёстой. Хэрэв чадвал бид түүнээс илүү хэмжээний мөнгө өгөх хэрэгтэй. Ингэвэл Тэнгэр дэх Эцэг маань биднийг адислан ивээх болно. Энэхүү өргөл нь ядуу зүдүү хүмүүсийг хоол хүнс, хувцас хунар, орон байраар хангахад зориулагддаг. Мацгийн өргөлийг өгснөөр бид ахан дүүсээ хэрхэн хайрладаг болохоо харуулдаг юм.

Бид мацгийн өргөлийг бишоп, салбарын ерөнхийлөгчдөө өгөх бөгөөд тэрээр уг мөнгийг ядуу зүдүү хүмүүст болон онцгой тусламж хэрэгтэй хүмүүст туслахад зарцуулна. Ядууст тусалбал биднийг адислан ивээнэ гэж Тэнгэр дэх Эцэг маань айлджээ. Тэрээр бидний залбирлыг хариулж, тусламж хэрэгтэй үед маань бидэнд туслах болно. Тэрээр евангелийг илүү сайн ойлгоход маань тусалж, үргэлж биднийг удирдан чиглүүлэх болно.

Сүм аравтын татвар болон мацгийн өргөлийг

1. Бусад евангелийг заахад
2. Ариун сүм, цугларалтын байр, Сүмийн бусад барилга байгууламжийг барих, засварлахад
3. Евангелийг судлах, Тэнгэр дэх Эцгийн маань үйл хэргийг гүйцэтгэхэд Сүмийн хүмүүст шаардлагатай хичээлийн ном болон бусад зүйлсийг хэвлэхэд
4. Өөрсдийгөө тэжээх чадваргүй хүмүүст туслахад

Ярилцлага

- Бидэнд өгсөн хайр ивээлийнх нь хариуд бид талархлаа Тэнгэр дэх Эцэгтээ хэрхэн үзүүлдэг вэ?
- Яагаад мацгийн өргөлийг төлөх нь биднийг баяр баясгалантай болгодог вэ?

Лавламж

Аравтын Татвараа Төлж Байхыг Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Тушаажээ

- Үүсэл гарал 14:20; Еврейчүүд 7:1-10 (Абрахам аравтын татвараа Мелкизедект төлжээ.)
- Үүсэл гарал 28:20-22 (Тэнгэр дэх Эцгийнхээ түүнд өгсөн бүх зүйлийн аравны нэгийг эргүүлэн өгөхөө Жейкоб амлажээ.)
- 2 Хрониклс 31:5-6; Неемия 10:37-39 (Израилийн хүүхдүүд аравтын татвар, мацгийн өргөлөө төлж байлаа.)

Аравтын Татвар Төлснөөр Бид Тэнгэр дэх Эцэгтээ Хайртайгаа Харуулдаг

- Малакай 3:8-10 (Аравтын татвар, мацгийн өргөлөө төлөхгүй байх нь Тэнгэр дэх Эцгээ луйвардсан хэрэг юм.)
- 2 Коринфынхан 9:6-7 (Тэнгэр дэх Эцгийнхээ таашаалд нийцүүлэхийн тулд бид бэлгээ сэтгэл харамгүй өгөх ёстой.)

Аравтын Татварыг Төлбөл Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Адис Ерөөл Хайрлахаа Амлажээ


- Үүсэл гарал 14:19-20 (Аравтын татвараа төлснөөр Абрахам Тэнгэр дэх Эцгийнхээ ивээлийг хүртжээ.)
- Малакай 3:10 (Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хэрэгцээнээс маань давсан их ивээлийг хайрлах болно.)


Мацгийн Өргөлөө Өгснөөр Бид Бусад Хүмүүст Тусалдаг

- Исаяя 58:6-11 (Бусдад хэрэгцээнийх нь зүйлийг өгч туслан сайн үйл хийхийг Тэнгэр дэх Эцэг маань биднээс хүсчээ.)

ГЭР БҮЛЭЭ ХАДГАЛАХ НЬ

Наймдугаар хэсэг





Гэр бүл үүрд хамтдаа байх болно.

ГЭР БҮЛ БОЛ ЧУХАЛ

29-р бүлэг

Яагаад Тэнгэр дэх Эцэг маань биднийг энэ газар дэлхий дээр гэр бүлээрээ амьдрахаар төлөвлөсөн бэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Биднийг Гэр Бүлээр Амьдрахаар Төлөвлөжээ

Газар дэлхий дээр байгаа бидний гэр бүл бол тэнгэрлэг гэр бүлтэй маань адил загвартай юм. Бид энэ газар дэлхийд ирэхийнхээ өмнө тэнгэрлэг гэр бүлийн хэсэг байжээ. Бид Бурхны буюу Тэнгэр дэх Эцгийнхээ сүнсэн хүүхдүүд байсан юм. Тэр бидэнд хайртай, бидэнд анхаарал халамж тавьж байдаг. Тэр бидний төлөө сайн сайхан зүйлсийг хүсч, биднийг нэгэн өдөр түүнд эргэн очиж хамт амьдрахыг хүсч байдаг юм.

Тэнгэр дэх Эцэг маань Адам Ева хоёрыг гэрлүүлснээр анхны гэр бүлийг бий болгожээ. Тэрээр тэдэнд үр хүүхэдтэй болохыг тушаав. Ингэснээр Тэнгэр дэх Эцгийн маань сүнсэн хүүхдүүд яс, махан бие цогцсыг олж авч чадах байлаа. Үр хүүхдэдээ хэрэгцээтэй байгаа зүйлсийг нь өгч байхыг тэрээр тэдэнд тушаажээ. Мөн үр хүүхдэдээ евангелийг заан сургаж, евангелийн зан үйлийг хүлээн авахад нь туслахыг тэрээр даалгасан байна.

Тэнгэр дэх Эцэг маань хэд хэдэн шалтгаанаар гэр бүлийг бий болгосон байна.

Нэгдүгээрт, бид эцэг эхээсээ яс, махан бие цогцсыг хүлээж авах болно. Хийх ёстой зүйлсээ сурч мэдэхэд маань бидэнд бие махбод хэрэгтэй бөгөөд тэгснээр бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ үүрд хамт амьдрах болно.

Хоёрдугаарт, бидэнд газар дэлхий дээр хэрэг болох зүйлсийг гэрг бүл маань хангах болно. Эцэг эх нь үр хүүхдээ хоол хүнс, хувцас хунар, орон байр, хайр энэрэл болон бусад хэрэгцээт зүйлсээр хангадаг. Хожим нь эцэг эхээ нас өндөр болоход үр хүүхдүүд нь асран халамжилдаг.

Гуравдугаарт, эцэг эхчүүд үр хүүхдэдээ Исүс Христийн евангелийг заан сургаж чадна. Тэнгэр дэх Эцгийнхээ зарлиг тушаалыг дуулгавартай дагахыг тэдэнд сургаж, Исүсийн биднийг хүртэх ёстой гэж айлдсан зан үйлүүдийг хүүхдүүд нь хүлээн авч буй эсэхийг тэд магадална.

Ярилцлага

- Яагаад Тэнгэр дэх Эцэг маань биднийг газар дэлхийд гэр бүлээрээ ирэхээр зохион байгуулсан бэ?
- Газар дэлхийд ирсэн анхны гэр бүл хэн байсан бэ?
- Тэнгэр дэх Эцэг маань гэр бүлийг бидний төлөө юу хийлгэхээр төлөвлөсөн бэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Гэр Бүлийн Гишүүдийг Бие Биенээ Хайрлахыг Хүсдэг

Энэ газар дэлхий дээр байгаа бидний гэр бүл тэнгэрлэг гэр бүлийн маань адил байж чадна. Гэр бүл нь хайр энэрлийг мэдэрч чадах бөгөөд тэрхүү хайрын үндсэн дээр тэд бие биедээ тус дэм болох, сайхан харилцах хүсэлтэй болдог.

Эхнэр нөхөр хоёр бие биеэ хайрлах ёстой. Тэд эелдэг дөлгөөн байж, харилцан бие биедээ туслан, нэгнийхээ сэтгэлийг сэвтээх зүйлийг хэлэх юмуу хийх ёсгүй.

Эцэг эхчүүд үр хүүхдэдээ хайртай байх ёстой бөгөөд тэдэнд бие биенээ хэрхэн хайрлахыг зааж сургах хэрэгтэй. Мөн бие биедээ анхаарал халамж тавьж, харилцан туслахыг сургах нь зүйтэй.

Хүүхдүүд эцэг эхээ хайрладаг байх ёстой. Тэд эцэг эхээ хайрлаж, үгийг нь дуулгавартай дагаж, тусалдаг байх ёстой.

Ярилцлага

- Ефесчүүд 4:29-32-ыг уншина уу.
- Гэр бүлийн гишүүдэд бие биенээ хайрлахад нь бид хэрхэн тусалж чадах вэ?

- Яагаад Тэнгэр дэх Эцэг маань гэр бүлийн гишүүдийг бие биенээ хайрлахыг хүсдэг вэ?

Аз Жаргалтай, Үнэнч Шударга Гэр Бүлийг Бий Болгох нь Бидний Хийж Чадах Хамгийн Чухал Зүйл Юм

Үнэнч шударга гэр бүлийг бий болгох нь бидний хийж чадах хамгийн чухал зүйл билээ. Бусад талаар хэчнээн их амжилт оллоо ч, гэр бүлийнхэндээ Тэнгэр дэх Эцгийг хайрлах, түүнийг дуулгавартай дагахыг зааж сургаагүй бол бид хамгийн чухал үүргээ умартлаа гэсэн үг юм. Зарим үед бидний үр хүүхэд Тэнгэр дэх Эцгийг маань хайрлах, дагах замыг сонгохгүй байж болох хэдий ч бид түүний тухай зааж сургахад бүгдийг зориулах ёстой. Хэрэв эцэг эхчүүд үр хүүхдээ заан сургахад бүх хүчин чармайлтаа зориулсан бол Тэнгэр дэх Эцэг маань хүүхдүүдийнх нь буруу үйлийн хариуцлагыг тэдэнд үл хүлээлгэх болно. Эцэг эхчүүд зөвхөн сайн эцэг эх байхыг хичээхээ больсон цагтаа л буруутай болно.

Амьдралын маань хамгийн аугаа их аз жаргалыг бидний гэр бүл өгч чадна. Бид үр хүүхдээ Сүмийн сайн гишүүд, улс орныхоо сайн иргэд болгон хүмүүжүүлэхийн төлөө зүтгэвэл маш их сайн үйлийг хийж байна гэсэн үг юм.

Гэр бүл бол Сүмийн хамгийн чухал хэсэг юм. Тэнгэр дэх Эцэг маань өөрийн Сүмийг гэр бүлүүдэд түүнд эргэн очиход нь бүх талаар тусалж чадахаар зохион байгуулжээ. Сүм бүх гэр бүлд үүрд хамт байхад нь туслахыг хүсдэг.

Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөөнд гэр бүл хэчнээн чухал байр суурь эзэлддэг болохыг Сатан мэднэ. Тэрээр гэр бүлийг маань сарнин бутаргах зүйлсийг биднээр хийлгэхийг оролдож байдаг.

Ярилцлага

- Таны хувьд гэр бүл тань хэр чухал вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Хэрхэн Сайн Гэр Бүлтэй Байхыг Хэлж Өгчээ

Хүн болгон сайн сайхан, аз жаргалтай гэр бүлтэй байхыг хүсдэг. Гэр бүлд тус болох зарим зүйлсийг дор дурьдав. Үүнд:

1. Гэр бүлээрээ өглөө, оройд хамтдаа залбирал хийх хэрэгтэй.
2. Эцэг эхчүүд өдөр бүр хамтдаа залбирал хийх хэрэгтэй.
3. Эцэг эхчүүд евангелийг үр хүүхдэдээ заан сургах хэрэгтэй.
4. Гэр бүлээрээ өдөр бүр судраас унших хэрэгтэй.
5. Ням гариг бүр Сүмийн цуглаанд гэр бүлээрээ очих хэрэгтэй.
6. Хүүхдүүд мацаг барьж чадах, түүний зорилгыг ойлгох насанд хүрмэгц гэр бүлээрээ сард нэг удаа мацаг барих хэрэгтэй.
7. *Гэр бүлийн үдшийн цуглаан гэж нэрлэдэг уулзалтыг долоо хоног бүр хийж, гэр бүлээрээ хамтдаа цуглан хийсэн сайн үйлийнхээ талаар ярилцаж байх хэрэгтэй. Түүнчлэн хүн бүрт тулгарсан хүнд бэрх асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцах нь зүйтэй. Энэ цуглаан дээр тэд дуу дуулж, хичээл зааж, судрын зарим хэсгийг судалж, тоглоом тоглож, бяцхан зоог барьж болно.
8. Гэр бүлээрээ хамтран сурч хөдөлмөрлөх хэрэгтэй.
9. Гэр бүлийн гишүүд бие биедээ найрсаг, тэвчээртэй хандах хэрэгтэй.
10. Гэр бүлийн гишүүд хийж байгаа зүйлсийнхээ талаар бичсэн түүхийг хадгалах хэрэгтэй.

Хэрэв бид ганцаараа болон гэр бүлийнхээ хамтаар залбирал үйлдэхийг үл мартвал Тэнгэр дэх Эцэг маань бидэнд улам ойр дотно байна. Тэрээр бидний залбирлыг сонсч, бидэнд сайн байх тэр л замаар хариултыг өгөх болно.

Ярилцлага

- Сайн гэр бүлтэй байхын тулд юу хийж болох вэ?

Лавламж

Тэнгэр дэх Эцэг Маань Биднийг Гэр Бүлээр Амьдрахаар Төлөвлөжээ

- Матвей 19:3-8 (Тэнгэр дэх Эцэг маань эхнэр нөхөр хоёрыг үүрд амьдруулахаар төлөвлөжээ.)

Тэнгэр дэх Эцэг Маань Гэр Бүлийн Гишүүдийг Бие Биенээ Хайрлахыг Хүсдэг

- Үүсэл гарал 2:21-24 (Тэнгэр дэх Эцэг маань Адам Ева хоёрыг бүтээж, тэднийг эхнэр нөхөр болгожээ.)

Аз Жаргалтай, Үнэнч Шударга Гэр Бүлийг Бий Болгох нь Бидний Хийж Чадах Хамгийн Чухал Зүйл Юм

- Ефесчүүд 5:25 (Нөхөр нь эхнэрээ хайрлах ёстой хэмээн тушаажээ.)
- Ефесчүүд 6:1 (Хүүхдүүд эцэг эхийнхээ үгийг дуулгавартай дагах ёстой хэмээн тушаажээ.)
- Титус 2:4 (Эхнэр нь нөхрөө хайрлах ёстой хэмээн тушаажээ.)
- Мосайяа 4:14-15 (Эцэг эхчүүд үр хүүхдийнхээ хэрэгцээг хангаж, тэдэнд үнэнч шударга байхыг сургах ёстой.)

Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Хэрхэн Сайн Гэр Бүлтэй Байхыг Хэлж Өгчээ

- 1 Коринфынхан 13:1-7 (Бидэнд хайрын ач холбогдлыг хэлж өгсөн нь.)
- Ефесчүүд 6:4 (Хүүхдүүдээ уцаарлуулах зүйл үл хийхийг аав нарт тушаасан нь.)

ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДДЭЭ ТҮСЛАХ НЬ БИДНИЙ ҮҮРЭГ МӨН

30-р бүлэг

Гэр бүлээ аз жаргалтай байлгахад хүн бүр юу хийж чадах вэ?

Гэр Бүлийн Гишүүн Бүр Чухал

Аз жаргалтай, хайр халамжтай гэр бүлтэй болоход их ажил хийгдэнэ. Гэр бүлд буй хүн болгонд Тэнгэр дэх Эцэг маань үүрэг хариуцлага хүлээлгэдэг юм. Гэр бүлийн гишүүн бүр тусархаг, найрсаг, урам зоригтой байх хэрэгтэй. Хамтдаа залбирал хийж, ажиллаж, дуулж, тоглож наадахад гэр бүлийнхэн маань баяр баясгалантай байдаг.

Гэр бүлийн бусад гишүүдээ хайрласнаар Тэнгэр дэх Эцгийнхээ биднийг хийхийг хүсч буй зүйлсийг хийхэд илүү хялбар болдог. Бид гэр бүлээ хайрласнаар тэдэнд туслахын тулд чадах бүхнээ хийхийг хүсдэг. Хэрэв хайрын сэтгэлээр хийх юм бол хүнд хэцүү зүйл ч амархан мэт санагдана. Гэр бүлийн сайн гишүүн байх нь цаг, хөдөлмөр шаарддаг.

Ярилцлага

- Гэр орноо аз жаргалтай байлгахад хүн бүр хэрхэн тусалж чадах вэ?
- Яагаад гэр бүлийн гишүүн болгон чухал байдаг вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Эцэг Эхчүүдэд Онцгой Үүрэг Хариуцлага Хүлээлгэжээ

Үр хүүхдийнхээ хэрэгцээг хангаж, тэднийг асран халамжлахад аав, ээжүүд хамтран ажиллах ёстой. Тэд мөн хүүхдүүддээ евангелийг заан сургаж, залбирал хийх, Тэнгэр дэх Эцгийнхээ хууль зарлигуудыг даган биелүүлэхийг заах хэрэгтэй.



Хамтран ажилласнаар гэр бүл бат бэх болдог.

Аав, ээжүүд тэдний үр хүүхэд зарим үед зөв зүйл заалгасан хэдий ч буруу замыг сонгож авч болох юм гэдгийг ойлгох хэрэгтэй.

Хүүхдүүдийг ямар нэг буруу зүйл хийхэд эцэг эхчүүд тэдэнд туслахаа зогсоож болохгүй. Эцэг эхчүүд үр хүүхдээ урьдын адилаар хайрлаж, заан сургах хэрэгтэй. Тэдэнд сайн үлгэр дуурайл үзүүлж, тэдний төлөө мацаг барин залбирах хэрэгтэй.

Эцэг эхчүүд гэр бүлдээ тодорхой зүйлсийг хийж гүйцэтгэх учиртай.

1. Тэд үр хүүхдээ хайрлаж, тэднийг бусдыг хайрлахад сургах ёстой.
2. Тэд хүүхдүүддээ евангелийг заах хэрэгтэй.
3. Гэр бүлийн гишүүддээ хэрхэн залбирахыг заах хэрэгтэй.
4. Тэд өөрсдийн үлгэр жишээгээр үр хүүхдэдээ аравтын татвар, өргөлүүдийг төлөхийг зааж сургах ёстой.
5. Тэд хэрхэн ажил хөдөлмөр хийхийг хүүхдүүддээ заах хэрэгтэй.
6. Тэд хүүхдүүдийг хоол хүнс, хувцас хунар, цэвэр гэр орноор хангах ёстой.
7. Үр хүүхдэдээ сургуулийн болон гэрийн сургалтаар дамжуулан унших, бичих, математикийн үндсэн үйлдлүүдийг зааж сургах хэрэгтэй.
8. Үр хүүхдэдээ боловсрол, мэргэжил эзэмшүүлэх, хэрэгцээнийхээ мөнгийг олоход нь бэлтгэхийн тулд тэд чадах бүхнээ хийх ёстой.
9. Тэд мөнгийг ухаалгаар зарцуулж, ирээдүйн хэрэгцээнд хуримтлуулах талаар хүүхдүүддээ дуурайл үзүүлэх хэрэгтэй.
10. Авьяас чадвараа хөгжүүлэхэд нь үр хүүхдэдээ туслах. Энэ нь багшлах, хөгжим тоглох, дуулах, засвар хийх болон бусдыг ойлгох зэрэг чадварууд байж болно.

Эцэг эх нь үр хүүхдэдээ туслахын тулд ямар ч бэрхшээлийг даван туулахад бэлэн байх хэрэгтэй. Эцэг эх нь үр хүүхдээ нэг нэгэндээ элэгсэг дотно хандаж байгаа болон хоол хүнс, хувцас хунараар дутагдахгүй байхад анхаарах ёстой гэж Тэнгэр дэх Эцэг маань айлдсан билээ.

Эцэг эхчүүд эдгээр зүйлсээр хангахын тулд урьдчилан төлөвлөсөн байх хэрэгтэй. Учир нь тэдэнд өвчин эмгэг тусах, ажил төрлөө алдах болон бусад асуудлууд тулгарч мэднэ. Үүний тулд тэд мөнгө хуримтлуулж, хоол хүнс, түлш нөөцлөх зэргээр арга хэмжээ авч болно.

Ярилцлага

- Гэр бүлийнхээ хэрэгцээг хангахын тулд эцэг эхчүүд юу хийж чадах вэ?
- Аливаа асуудал тулгарахад бэлтгэлтэй байхын тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ?

Эцэг Хүн Онцгой Үүрэг Хариуцлагатай

Эцэг хүн бол гэр бүлийн зэрэгтний хүчийн удирдагч юм. Эцэг хүн гэр бүлдээ хайр халамж тавьдаг тэргүүн нь байх ёстой. Тэрээр Тэнгэр дэх Эцгийнхээ хууль зарлигуудыг хэрхэн дагаж биелүүлэхийг гэр бүлдээ өөрийн жишээгээр харуулах учиртай. Тэр гэр бүлийнхэндээ евангелийг зааж, өглөө, оройд гэр бүлийн залбиралд бусдыгаа уриалах ёстой бөгөөд эдгээрийг хийхэд эхнэр нь туслах хэрэгтэй.

Эцэг хүн гэр бүлийнхнийгээ адислан ерөөхийн тулд зэрэгтний хүчээ ашиглах ёстой. Тэрээр нялх хүүхдүүддээ нэр өгч, ивээл хайрлан, найман нас хүрэхэд нь усаар баталж болно. Өөрийн хөвгүүдэд зэрэгтний хүчийг хүртээн баталж, хэрэгцээтэй үед нь хүүхдүүддээ онцгой адис ивээлийг хүртээнэ. Тэднийг өвчтэй байхад нь адислал хайрлаж болно.

Эцэг хүн хүүхэд бүртэйгээ цаг гаргаж ажиллах хэрэгтэй. Тэдэнтэй ярилцаж, бодол санаа, эрэлт хэрэгцээг нь ойлгодог байх нь чухал. Тэрээр тэднийг урамшуулж, тэдэнд хайртай болон ямар нэгэн асуудал тулгарвал үргэлж түүнээс тусламж хүсч болно гэдгийг хэлэх хэрэгтэй.

Ярилцлага

- Эцэг хүний үүрэг хариуцлага юу вэ?
- Тэр өөрийн зэрэгтний хүчийг гэр бүлийнхэндээ туслахын тулд хэрхэн ашиглаж болох вэ?

Эх Хүн Онцгой Үүрэг Хариуцлагатай

Эх хүний хамгийн чухал үүрэг хариуцлага бол үр хүүхэд төрүүлж, өсгөн, тэдэнд зааж сургах явдал юм. Тэнгэр дэх Эцгийнхээ сүнсэн хүүхдүүдэд яс, махан бие цогцсыг олгоно гэдэг нь ариун үүрэг юм. Эх хүн үүнийг хийснээр Тэнгэр дэх Эцгийн маань хамтран зүтгэгч болдог. Хүүхэд төрүүлнэ гэдэг бол бүх адис ерөөлөөс хамгийн аугаа нь билээ.

Эх хүн энэрэнгүй нинжин сэтгэлтэй байж, хүүхэд бүртээ евангелийг заан сургаж, хүүхэд нэг бүртэй ажиллаж, тусалж байх ёстой. Мөн хүүхэд бүрийг өөрийгөө зөв үнэлж, орчин тойрныхоо зүйлсийг ойлгодог болгохын тулд нөхөртэйгөө хамтран зүтгэх ёстой.

Мормоны Номд эхийнхээ сургаалыг дуулгавартай дагасан хэсэг залуу хөвгүүдийн тухай өгүүлдэг. Тэдгээр залуусын ээжүүд тэднийг үнэнч шударга, эрэлхэг зоригтой байхыг сургажээ. Түүнчлэн хэрэв Исүст итгэвэл Тэнгэр дэх Эцэг маань тэднийг авран хамгаалах болно гэжээ. Тэдгээр залуус эх нутгаа хамгаалахаар цэрэгт мордох болов. Тэд эхийнхээ сургаалыг дагаж, итгэлтэй байсан учраас их аюултай нүүр тулгарахдаа зориг зүрхтэй байж үүргээ биелүүлсэн юм. Эх хүн үр хүүхдийнхээ амьдралд маш их нөлөөтэй байдаг.

Ярилцлага

- Эх хүний үүрэг хариуцлага юу вэ?
- Яагаад эх хүн Тэнгэр дэх Эцгийн маань хамтран зүтгэгч гэгддэг вэ?

Эцэг Эхийн Үүргийг Ганцаар Гүйцэтгэх нь

Зарим тохиолдолд эцэг юм уу эх нь ганцаар гэр бүлээ өсгөн хүмүүжүүлж, эцэг эхийн хоёул хийх ёстой ажлыг нуруун дээрээ үүрэх болдог. Тэнгэр дэх Эцэг маань энэ ямар хэцүү болохыг мэднэ. Хэрэв ганц бие эцэг эх Тэнгэр дэх Эцгээсээ тусламж хүсвэл, Тэнгэр дэх Эцэг маань гэр бүлээ авч явахад нь түүнд туслах болно.

Ганц бие эцэг эхчүүд мөн *гэрийн багш нарын туслалцааг авдаг. Гэрийн багш нар гэдэг нь Сүмийн гишүүд бөгөөд бусад гишүүдэд тусламж дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий хүмүүс юм.

Ярилцлага

- Ганц бие эцэг эхчүүдэд хэн тусалж чадах вэ?

Хүүхдүүд ч Мөн Онцгой Үүрэг Хариуцлага Хүлээдэг Болох нь

Хүүхдүүд гэр бүлээ аз жаргалтай байлгахад нь эцэг эхдээ туслах ёстой. Хүүхдүүд эцэг эхдээ байр сууц, орчин тойрноо цэвэрлэх, хоол хийх, сав суулга, хувцас хунараа угаах болон дүү нараа асран халамжлах зэргээр тусалж болно.

Хүүхдүүд эцэг эхийнхээ заасан зүйлийг сурахын тулд сайн хөдөлмөрлөх хэрэгтэй. Тэд шургуу хөдөлмөрлөж, ажил үүргээ сайн гүйцэтгэж, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж сурах ёстой.

Хүүхдүүд Исүсийн зарлигийг дуулгавартай дагаж, гэр бүлийнхэндээ тусалж байх хэрэгтэй. Хүүхдүүдийг хоорондоо хэрэлдэж маргахыг Тэнгэр дэх Эцэг маань үл таашаана. Эцэг эхийнхээ үгийг дуулгавартай дагаж, тэдэнд хүндэтгэл үзүүлж байхыг Тэнгэр дэх Эцэг маань хүүхдүүдэд зарлиг болгосон юм.

Хүүхдүүд эцэг эхээ хайрлаж, үгийг нь дагаж, хүндэтгэх ёстой. Мөн тэднийг өвчтэй, өөрсдийгөө арчлан тордож чадахааргүй өндөр настай болсон үед нь асран халамжлах үүрэгтэй юм.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэг маань хүүхдүүдээс юу хийхийг хүсэн хүлээдэг вэ?
- Эцэг эхээ өндөр настай болсон үед үр хүүхэд нь юу хийх үүрэгтэй вэ?
- Хүүхдүүд нь эцэг эхийнхээ үгийг дагадаг, тэдэнд хүндэтгэл үзүүлдэг болохоо харуулахын тулд юу хийх ёстой вэ?

Гэр Бүлийг Бэхжүүлэх Шаардлага

Өнөөдөр дэлхий дээр буруу үзэлтэй олон хүмүүс гэр бүлийн талаарх бидний үзэл бодлыг өөрчлөх гэж эрмэлзэж байна. Телевиз, кино, сонин сэтгүүлээр эрэгтэй, эмэгтэй хүмүүс, тэдний хоорондын харилцааны тухай этгээд, гаж буруу үзэл бодлыг дэлгэрүүлж байна. Гаж буруу үзлийг янз бүрийн сувгаар нэвтрүүлж, тэдгээр нь зугаа цэнгээний байдлаар илэрдэг. Садар самуун явдлыг тааламжтай, хүсүүштэй зүйл мэтээр үзүүлдэг. Хүүхдүүд нь эцэг эхээ үл хүндлэн буйг харуулж, сайн гэр бүлийг тоглоом тохуу болгож байна. Зарим үед бидний үр хүүхэд амьдрал дээр сайн гэр бүл ямар байдгийг кино, телевизээр тэр болгон хардаггүй билээ.

Эцэг эхчүүд хүүхдүүдийг энэ мэтийн зүйлийг кино, телевизээр үзэхээс урьдчилан сэргийлж, муу программ, киног үзэхгүй байхын учир холбогдлыг тэдэнд таниулах ёстой. Эцэг эхчүүд гэр орондоо тогтмол сайн үлгэр дуурайл үзүүлж байх нь маш чухал юм. Хэрэв хүүхдүүд гэртээ өдөр бүр сайн үлгэр дуурайл авч байвал тэд сайн хүмүүжлийг олж, хожим нь сайн эцэг эх болно. Тэд эцэг эхийнхээ

харилцан бие биенээ хэрхэн хайрлаж буйг харж, мэдэрснээр өөрсдөө тийм эцэг эхчүүд болохыг хүсэх болно.

Ярилцлага

• Яагаад бид хүүхдүүдийнхээ үзэх кино, телевизийн программуудад сайтар сонголт хийх ёстой вэ?

Харилцан Бие Биедээ Тусалж Байхыг Тэнгэр дэх Эцэг Маань Биднээс Хүсдэг

Гэр бүлийн гишүүн бүр харилцан бие биенээ хайрлаж, тусалж байх ёстой. Юуны өмнө бид эцэг эх, ах дүү нартаа тусалж байж бусдад хэрхэн туслахыг сурдаг. Түүнчлэн бид хамаатан садандаа хэрэгцээтэй үед нь тусалдаг байх хэрэгтэй. Бид өөрсдийгөө хангах чадвартай байгаа үедээ бусдаас тусламж гуйх хэрэггүй. Эс тэгвээс Тэнгэр дэх Эцэг маань үл таашаах болно.

Исүс хүн бүрт хайртай байсан бөгөөд бидэнд туслахаар газар дэлхийд ирсэн билээ. Тэрээр бидэнд хүн бүрийг хайрлаж, тэдэнд туслахыг зааж сургасан. Хэрэв бид Исүсийн нэгэн адилаар бусдыг хайрлах юм бол тэдэнд туслахын тулд чадах бүхнээ хийдэг болно.

Бидний зарим маань Тэнгэр дэх Эцгээсээ тусламж хэрэгтэй байгаа хүмүүст туслахыг гуйчихаад өөрсдөө тэдэнд тус болохыг боддоггүй билээ. Энэ нь буруу юм. Тэнгэр дэх Эцэг маань биднээр дамжуулан бусдад тусалж байдгийг бид санах ёстой. Бид эхлээд тусламж хэрэгтэй байгаа тэр хүмүүсийн төлөө залбираад дараа нь тэдэнд бүхий л талаар туслалцаа үзүүлэх ёстой.

Бүх хүнд бусдын туслалцаа хэрэгтэй байдаг. Биднийг хүүхэд байхад эцэг эх маань биднийг тэжээж, хувцаслаж, хайрлан халамжилдаг. Том болох тусам бусад хүмүүс бидэнд сурч мэдэх, хийх ёстой зүйлсийг маань зааж өгдөг. Олонх хүмүүс өвчтэй байхдаа бусдын тусламжийг шаардана.

Бусад хүмүүст тусалснаар бид адис ерөөлийг хүлээн авдаг. Ингэснээр бид хүнийг улам ихээр хайрлах болж, амин хувиа хичээх, өөрийн тулгамдсан асуудлыг бусдынхаас дээгүүр тавихаа болино. Тэнгэр дэх Эцэг маань өөртэй нь хамт амьдрахыг хүссэн хэн бүхэн түүний бүх хүүхдийг хайрлаж, тэдэнд туслах ёстой гэж айлдсан билээ.

Ярилцлага

- Яагаад Тэнгэр дэх Эцэг маань биднээс бусдад туслахыг хүсч, шаарддаг вэ?
- Бидний тусламж хэнд тус болох вэ?

Лавламж

Гэр Бүлийн Гишүүн Бүр Чухал

- Дүрвэлт 20:12; Ефесчүүд 6:1 (Эцэг эхээ хүндэтгэхийг бидэнд зарлиг болгосон нь.)
- 2 Нифай 1:14-32; Алма 36-42 (Мормоны Номын зарлагууд үр хүүхдэдээ зөв зүйтэй сургаал айлдсан нь.)
- Мосайя 4:14; Сургаал ба Гэрээ 68:25-28 (Эцэг эхчүүд үр хүүдийнхээ амьдралын хэрэгцээг хангаж, тэдэнд үнэнч шударга байхыг заан сургах үүрэгтэй.)

Гэр Бүлийг Бэхжүүлэх Шаардлага

- 2 Тимофей 3:1-4 (Хожмын өдрүүдэд маш их муу үйл тохиолдох бөгөөд бид бэлтгэлтэй байх ёстой.)

Харилцан Бие Биедээ Тусалж Байхыг Тэнгэр дэх Эцэг Маань Биднээс Хүсдэг

- Лук 22:27; Матвей 20:26-27; Жон 13:15-16 (Исүс үнэн сэтгэлээсээ хүмүүст үйлчлэхийн жишээг үзүүлсэн нь.)
- Колосс 3:18-20 (Гэр бүлийн гишүүд харилцан бие биенээ халамжлах үүрэг хүлээнэ.)
- Мосайя 2; Колосс 3:23-24; Матвей 25:32-46 (Бусдад үйлчилнэ гэдэг нь Тэнгэр дэх Эцэгтээ үйлчилж байгаа хэрэг юм.)

ЕВАНГЕЛИЙГ ЗААЖ ТҮГЭЭХ НЬ БИДНИЙ ҮҮРЭГ МӨН

31-р бүлэг


Тэнгэр дэх Эцгийнхээ бүх хүүхдэд евангелийг түгээхэд бид хэрхэн тусалж чадах вэ?

Тэнгэр дэх Эцэг Маань Бүх Хүүхдээ Евангелийг Мэдсэн Байхыг Хүсдэг

Тэнгэр дэх Эцэг маань өөрийн бүх хүүхдийг хайрладаг. Хүн бүр түүний хувьд чухал бөгөөд түүнтэй адил төстэй болж чадна. Тэрээр биднийг түүнд эргэн очиж хамт амьдран түүний адил аз жаргалтай, алдар суутай болохыг хүсдэг.

Тэнгэр дэх Эцэгт маань хүн бүрт түүн дээр эргэн очиж хамт амьдрахад нь туслах төлөвлөгөө бий. Энэхүү төлөвлөгөөг Исүс Христийн евангели гэж нэрлэдэг. Евангелийг судалснаар бид өөрсдийн үнэ цэнийг ойлгоод зогсохгүй, ямар учраас энэ газар дэлхий дээр амьдарч буй, мөн үхлийн дараа бид хаана очихоо болон Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очихын тулд юу хийх ёстойгоо мэдэж авна.

Исүс Христ бол бидний сүнслэг ах бөгөөд Тэнгэр дэх Эцгийн маань сүнслэг ууган хүү билээ. Тэрээр газар дэлхийд Тэнгэр дэх Эцгийн маань Цорын Ганц Аравнайлан Хүү болон бие махбодод хувилан ирсэн билээ. Тэр бидэнд маш их хайртай тул бидний төлөө зовж шаналан нас нөгчсөн юм. Тэрээр Тэнгэр дэх Эцэг маань биднээр юу мэдэж, хийлгэхийг хүсч буйг бидэнд заав. Бидэнд туслахын тулд тэрээр Сүмээ зохион байгуулж, газар дэлхий дээр буй хүмүүст зэрэгтний хүчийг олгосноор тэд түүний үйл хэргийг гүйцэтгэж чадах болсон юм.



*Исус өөрийн Төлөөлөгчдөд бүх дэлхий даяар евангелийг
заан түгээхийг тушаажээ.*

Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь Тэнгэр дэх Эцгийн маань зэрэгтний хүч болон үнэн төлөвлөгөө бүхий цорын ганц сүм билээ. Тэнгэр дэх Эцэг маань бүх хүмүүсийг түүний төлөвлөгөөг сурч мэдэж, хүлээн зөвшөөрөхийг хүсч байдаг. Үнэний Сүмийн зан үйлүүд нь Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж хамт амьдрахад маань зайлшгүй хэрэгтэй юм.

Тэнгэр дэх Эцэг маань өөрийн Сүмийн гишүүн бүрт бусдад евангелийн сургаалыг түгээхийг тушаадаг билээ. Адамын үеэс эхлэн бүх зарлагууд өөрсдийн ихэнх цагийг бусдад евангелийн сургаалыг заахад зориулдаг байлаа. Сүмийн гишүүн нэг бүр номлогч байх хэрэгтэй гэж тэд айлджээ. Энэ нь бидний усаар батлуулахдаа хийсэн амлалтуудын нэг юм. Бид аль боломжтой үедээ хүмүүст Исүсийн тухай ярьж байна гэж амласан билээ.

Ярилцлага

- Яагаад бүх хүн евангелийн сургаалыг сонсох хэрэгтэй вэ?
- Хүмүүст евангелийн сургаалыг зааж номлох нь хэний үүрэг хариуцлага вэ?

Сүмийн гэр бүл болгон евангелийг заахын ач холбогдлыг сайтар ойлгох шаардлагатай. Бид евангелийн төлөвлөгөө ямар чухал болохыг мэднэ. Бид бусдын төлөө санаа тавьж, Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөөг ойлгоход нь тэдэнд туслахын тулд хэрэгцээтэй бүхнийг хийх ёстой.

Евангелийг сурч мэдэхэд нь бусдад туслахын тулд гэр бүлийн гишүүд олон зүйлийг хийж чадна. Тухайлбал:

1. Бусдын төлөө сайн зүйл хийх.
2. Евангелийн сургаалыг дагаснаар аз жаргалтай байгаагаа бусдадтай ярьж, хуваалцах.
3. Найз нөхөд, хөршүүддээ евангелийг тайлбарлах. Тэднийг Сүмийн цугларалтад хамт явахыг урих.
4. Хүмүүсийг гэр бүлийн үдшийн цуглаандаа урих буюу номлогч нараар хичээл заалгах.
5. Евангелийн талаар сонсох, мэдэх сонирхолтой найз нөхөд, төрөл төрөгсдийнхөө нэр, хаягийг номлогч нарт өгөх.

6. Номлогчийн албаны ач холбогдлыг үр хүүхэддээ тайлбарлан таниулах. Номлогчийн албанд явахаар мөнгө хуримтлуулахад нь тэдэнд туслах.
7. Аравтын татвараа төлөх.
8. Номлогчийн албын санд мөнгө хандивлах.

Ярилцлага

- Сүмийн гишүүн бус хүнд евангелийн тухай хэрхэн ярьж болох арга замыг бодно уу.
- Бусад хүмүүст евангелийн талаар сурч мэдэхэд нь туслахын тулд танай гэр бүл юу хийж чадах вэ?

Танай Гэр Бүл Сүмийн Номлолын Албаны Нэгэн Чухал Хэсэг Байж Чадна

Манай Сүм хэдэн мянган номлогчдыг евангели заалгахаар олон оронд илгээсээр байдаг билээ. Тэдний олонх хувийг 19-25 насны залуучууд эзэлдэг юм. Настай хүмүүс ч мөн номлогчийн албанд зүтгэдэг. Эдгээр хүмүүс бол Тэнгэр дэх Эцэгтээ үйлчлэх чин хүсэл бүхий, Сүмийн дуулгавартай, итгэлтэй гишүүд юм.

Дахин олон номлогч хэрэгтэй байгаа бөгөөд танай гэр бүл гэр бүлийн гишүүдээ номлогчийн албанд бэлтгэх замаар энэхүү чухал үйл хэрэгт оролцож болно. Эцэг эхчүүд хүүхдүүддээ евангелийн гэрчлэлийг хэрхэн хүлээж авах болон бусдад евангелийг хэрхэн тайлбарлах талаар суралцахад нь тусалж болно. Тэд үр хүүхдэдээ өөр үндэстэн ястны хүмүүсийг хайрлах сэтгэлийг төлөвшүүлж, мөн хүүхдүүдээ нас биед хүрсний дараа номлогчийн албанд явахад өөрсдийгөө бэлтгэх хэрэгтэй.

Олон хүмүүст евангелийн сургаал хүрч амжаагүй байгаа билээ. Тэдний зарим нь номлогчдын очих боломжгүй улс оронд амьдарч байна. Эдгээр хүмүүс евангелийг сонсч, хүлээн авах боломжийг хүртэх ёстой юм. Үүнийг гүйцэтгэх арга замыг Тэнгэр дэх Эцэг маань бэлтгэн өгөх нь гарцаагүй. Тэдгээр улс орнуудын удирдагч нар сургаал номлогчдыг нэвтрүүлж, хүмүүст заахыг зөвшөөрөхийг бид Тэнгэр дэх Эцэгтээ хандан залбирч хүсэх хэрэгтэй.

Ярилцлага

- Евангелийг заан түгээх үүргээ Сүмийн гэр бүлүүд хэрхэн биелүүлсээр ирсэн бэ?
- Яагаад өнөөдөр ч гэсэн олон номлогчид хэрэгтэй байна вэ?

Бусадтай Евангелийг Хуваалцсан Хүнд Асар Их Адис Ерөөл Ирэх Болно

Хэрэв бид бусдын төлөө санаа тавьж, тэдэнд евангелийн тухай ярьж өгвөл Тэнгэр дэх Эцэг маань биднийг ивээх болно. Тэрээр биднийг зарлигийг дагаж, евангелийг хүлээн авсан тэр хүмүүст авчирсан аз жаргалын маань төлөө адислан ерөөх болно. Хэрэв бид түүний ганцхан хүүхдэд ч гэсэн евангелийг мэдэж, түүнд эргэн очиход нь тусалж чадах юм бол бид аз жаргалтай байна гэж тэр хэлжээ. Түүнээс ч олон хүүхдэд нь түүн дээр эргэн очиход нь тусалж чадваас бидний баяр баясгалан улам их байх болно.

Ярилцлага

- Евангелийг бусдад түгээснээр ямар адислалыг хүртдэг вэ?
- Та эдгээр адислалуудаас хүртэж байсан уу?

Лавламж

Тэнгэр дэх Эцэг Маань Бүх Хүүхдээ Евангелийг Мэдсэн Байхыг Хүсдэг

- Матвей 24:14 (Евангелийн сургаал бүх улс, үндэстэнд хүрэх учиртай.)
- Марк 16:15-16 (Исүс хүн бүрт евангелийг номлохыг Төлөөлөгчдөдөө тушаажээ.)
- Үйл явдал 5:42 (Эртний Төлөөлөгчид чадлынхаа хэрээр хүн бүрт евангелийг номлож байлаа.)

Танай Гэр Бүл Сүмийн Номлолын Албаны Нэгэн Чухал Хэсэг Байж Чадна

- 1 Тимофей 4:12 (Залуу хүмүүс бусдыг үлгэрлэж чадна.)
- Мосайяа 4:15 (Бие биенээ хайрлахыг үр хүүхдэдээ сурга.)

Бусадтай Евангелийг Хуваалцсан Хүнд Асар Их Адис Ерөөл Ирэх Болно

- Сургаал ба Гэрээ 18:15-16 (Евангелийг хүлээн авахад бусдад тусалснаар бид асар их баяр хөөрийг амсах болно.)

ГЭР БҮЛЭЭРЭЭ ҮҮРД ХАМТ АМЬДРАХ НЬ

32-р бүлэг

Энэ дэлхий дээрх амьдралын дараа ч гэсэн хэрхэн гэр бүлээрээ үүрд хамт байж чадах вэ?

Бурхан Гэр Бүлүүдийг Үүрд Хамт Байлгахаар Төлөвлөжээ

Газар дэлхий дээр байгаа хүмүүсийн хамгийн чухал хэсэг бүлэг бол гэр бүл юм. Бидний газар дэлхийн гэр бүл тэнгэрлэг гэр бүлийн маань адил загвартай байдаг. Бид тэнгэрт бүгд ахан дүүс байлаа. Бид Бурхны хүүхдүүд байсан бөгөөд тэнгэр дэх гэр бүлийн маань тэргүүн нь Бурхан байв. Бид Тэнгэрлэг Эцэг Эхээсээ хайр энэрэл, удирдамжийг хүлээн авдаг байлаа.

Бурхан хүн бүрийг энэ газар дэлхийн гэр бүлд илгээсэн юм. Тэрээр эцэг эхчүүдэд түүний үр хүүхдүүдийг газар дэлхий дээр байх хугацаанд нь халамжлан хайрлах үүрэг хариуцлагыг оноожээ. Эцэг эхчүүд үр хүүхдээ энэрэн хайрлаж, тэднийг хоол хүнс, хувцас хунар, орон гэрээр хангах үүрэгтэй. Тэд хүүхдүүддээ Бурхны тухай болон хэрхэн түүнтэй адил болж болох талаар зааж сургах ёстой.

Бурхан гэр бүлүүдийг үүрд хамтдаа байх боломжтой болгожээ. Тэрээр гэр бүлийг үүрд холбож өгөх эрх мэдлийг өөрийн Сүмийн удирдагчдад олгосон байна. Ийнхүү үүрд холбохыг баталгаа гэж нэрлэдэг. Энэхүү батлах ёслолыг зөвхөн ариун сүмд л хийдэг бөгөөд ариун сүм гэдэг нь гагцхүү Сүмийн итгэлтэй гишүүд л орох эрхтэй ариун нандин барилга байгууламж юм. Ариун сүмд зэрэгтний хүч бүхий, баталгааг хийх онцгой хүчин чадалтай хүнээр батлуулсан гэрлэлт бол эхнэр нөхөр хоёрыг нас барсны дараа ч хүчин төгөлдөр байх болно. Хэрэв тэд ариун сүмд хийсэн амлалтаа баримталж



АНУ-ын Орегон мужийн Портланд дахь ариун сүм.

чадвал тэдний гэрлэлт үүрд хүчин төгөлдөр байна. Үүнийг мөнхийн гэрлэлт гэж нэрлэдэг.

Хэрэв хүмүүс ариун сүмд батлуулаагүй бол эхнэр нөхөр хоёрын аль нэг нь нас барсан тохиолдолд тэдний гэрлэлт цуцлагдана. Тийм гэр бүлүүд энэ амьдралын дараа мөнхөд хамт байж чадахгүй. Бид ариун сүмд гэрлэлтээ батлуулж, амьдралынхаа эцсийг хүртэл Исүс Христийг итгэлтэйгээр дагаж чадваас бидний гэр бүл мөнхөд хамтдаа байх болно.

Хэрэв гэрлэсэн хосууд Исүсийн итгэлтэй дагалдагчид мөн бол ариун сүмд очиж гэрлэлтээ батлуулж болно. Батлах онцгой эрх мэдэлтэй, зэрэгтний хүч бүхий хүн тэднийг хооронд нь батлах ёслолыг үйлдэнэ. Тэрээр тэдний хүүхдүүдийг ч мөн адилаар баталж өгч чадна. Ийнхүү харилцан бие биедээ батлуулсны дараа тэд анхнаасаа ариун сүмд гэрлэсэн мэтээр мөнхөд хамт байж чадах юм.

Бурхан өөрийн бүх хүүхдүүдийг ариун сүмд гэрлэн батлуулж, дуулгавартай гэр бүлийг бий болгохыг хүсдэг. Хүүхдүүдийг нас биед хүрч гэрлэхэд ариун сүмд очих бэлтгэлтэй байлгахын тулд эцэг эх нь эртнээс зааварчилж байх ёстой. Хэрэв эхнэр нөхөр хоёр ариун сүмд гэрлэлтээ батлуулсан бол энэхүү гэрлэлтээс төрсөн хүүхдүүд нь шууд тэдэнтэй батлагдах болно.

Ярилцлага

- Бурхан гэр бүлүүдэд мөнхөд хамтдаа байх боломжийг хэрхэн олгосон бэ?
- Яагаад ариун сүмд гэрлэлтээ батлуулах нь чухал вэ?

Зөвхөн Сүмийн Итгэлтэй Гишүүд л Ариун Сүмд Орж Болно

Ариун сүм бол ариун нандин газар юм. Гагцхүү Исүс Христийн хууль зарлигийг дуулгавартай дагаж, Исүс Христэд итгэх итгэлээ үзүүлж чадсан Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд л тэнд орох зөвшөөрөлтэй байдаг. Энэ хүмүүс бол ариун сүмд орох шаардлагыг хангасан хүмүүс юм. Ариун сүмд орохын тулд доод тал нь нэг жил сүмийн гишүүн байсан буюу эрэгтэйчүүд Мелкизедек Зэрэгтний Хүчтэй байх ёстой.

Эрэгтэй эмэгтэй гишүүд ариун сүмд орохыг хүссэн үедээ бишоп, салбарын ерөнхийлөгчтэйгөө ярилцаж, шаардлагыг хангах эсэхээ

шалгуулна. Бишоп болон салбарын ерөнхийлөгч нь тухайн хүнийг шаардлага хангасан гэж үзвэл түүнд ариун сүмийн зөвшөөрөл гэж нэрлэгдэх гарын үсэг бүхий цаасыг өгнө. Үүний дараагаар тойргийн ерөнхий зөвлөлийн гишүүн, эсвэл номлолын албаны ерөнхийлөгч тухайн хүнтэй дахин ярилцлага хийх ёстой. Ингээд түүнийг шаардлага хангаж байна гэж үзвэл ариун сүмийн зөвшөөрлийн хуудас дээр гарын үсгээ зурна. Тухайн хүн ариун сүмд орохын тулд зөвшөөрлийн хуудсыг авч очих хэрэгтэй.

Сүмийн гишүүн хүн ариун сүмд орох шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлохдоо бишоп болон салбарын ерөнхийлөгч нар дараахтай төстэй асуултаудыг тавьдаг.

1. Та Бурхан, түүний Хүү, Исүс Христ болон Ариун Сүнсэнд итгэдэг үү?
2. Танд ямар нэгэн ноцтой нүгэл үйлдээд түүнийгээ тохирох зэрэгтний хүчийн удирдагч нарт илчлэн хүлээгээгүй тохиолдол бий юу?
3. Та Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгчийг зарлага, үзэгдлийг харагч хэмээн хүлээн зөвшөөрч байна уу? Түүнийг бүх зэрэгтний хүчийн түлхүүрийг ашиглах эрх мэдэл бүхий энэ газар дэлхий дээрх цорын ганц хүн гэж та хүлээн зөвшөөрөх үү?
4. Та орлогынхоо аравны нэгийг Сүмд хандивладаг уу?
5. Та Мэргэн Үгсийг дагаж биелүүлдэг үү?
6. Та бусадтай харилцахдаа үнэнч шударга байхыг хичээдэг үү?
7. Та хууль зарлигийг даган мөрдөж, цугларалтад оролцох зэргээр Сүмд хүлээх үүргээ биелүүлэхийг үнэхээр эрмэлздэг үү?
8. Та ариун явдлын хуулийг сахидаг уу?

Ариун сүмд орох гэдэг нь маш ариун нэр төр юм. Бид шаардлагыг хангахуйц байж, ариун сүмд Бурхны өмнө хийх ариун нандин амлалт бүрээ сахин биелүүлэхэд бэлэн байх ёстой. Түүнчлэн бид ариун сүмд хийгдсэн гэрлэлтийн мөнхийн баталгаа нь нандин зүйл гэдгийг санах ёстой. Энэ нь гэр бүлээрээ мөнхөд хамт байж, Бурхны бидэнд хайрлах бүх адислалыг хүлээн авах цорын ганц зам юм. Ариун сүмд батлуулахыг хичээх нь бидний мөнхийн аз жаргалд маш чухал билээ.

Ярилцлага

- Хэн ариун сүмд орж болох вэ?
- Ариун сүмд орох шаардлагыг хангасан байхын тулд хүн юу хийх ёстой вэ?
- Ариун сүмд очиж, батлуулах нь ямар ач холбогдолтой вэ?

Мөнхийн Хамтын Амьдралд Гэр Бүлээ Бэлтгэх нь

Ариун сүмд гэрлэлтээ батлуулах нь гэр бүлээрээ мөнхөд хамт амьдрах боломжийг өгдөг ч гэлээ энэхүү аугаа их адислалыг хүртэхийн тулд бид бусад зүйлийг хийх ёстой байдаг. Бид Исүсийг итгэлтэйгээр дагахаа үргэлжлүүлэх хэрэгтэй. Ариун сүмд хийсэн амлалтаа биелүүлж, гэр бүлийн гишүүд харилцан бие биенээ хайрлаж, үйлчилдэг байх ёстой. Бид аливаа үйл хэрэгт зөв шийдвэр гаргахдаа Ариун Сүнсний тусламжийг авахын тулд Бурханд хандан залбирч, мөн Бурхантай хамт амьдрахад бэлтгэхэд нь гэр бүлийнхэндээ туслахыг үргэлж хичээх хэрэгтэй.

Ярилцлага

- Гэр бүлээрээ мөнхөд хамт амьдрахын тулд ариун сүмд батлуулахаас гадна өөр юу хийх ёстой вэ?

Өвөг Дээдсээ Аврах Боломжийг Бурхан Бидэнд Өгсөн нь

Бурхны хэдэн сая хүүхэд евангелийг сонсч амжилгүй энэ хорвоогоос халин одсон билээ. Тэд гэм нүглээсээ өршөөгдөж, Бурхантай дахин хамт амьдрахад зайлшгүй хэрэгтэй зан үйлүүдийг хүлээн авч чадсангүй. Бурхан өөрийн бүх хүүхдэд хайртай учраас тэднийг цөмөөрөө түүнд эргэн очихыг хүсдэг. Иймд тэрээр евангелийн зан үйлийг тэдний төлөө гүйцэтгэх замыг нээж өгчээ. Энэхүү ёслолыг ариун сүмд хийдэг.

Ариун сүмд нас барагсдын өмнөөс хийгддэг зан үйлд усан баталгаа, Ариун Сүнсний бэлэг өгөх, гэр бүлийн мөнхийн баталгаа зэрэг ёслолууд багтана. Эдгээр зан үйлийн ёслолууд нь Бурхантай хамт амьдрахыг хүссэн хэн бүхэнд зайлшгүй хэрэгтэй учраас бид эдгээрийг өөрсдийн өвөг дээдсийн төлөө хийж болно.

Ярилцлага

- Евангелийг сонсолгүйгээр нас барсан тэр хүмүүс Бурханд эргэн очиход хэрэгтэй зан үйлийг хэрхэн хүлээн авч чадах вэ?

- Хэн нас барагчдын төлөө зохих зан үйлүүдийг хийх хариуцлагыг хүлээдэг вэ?

Амьд нь Үхсэнийхээ Төлөө Зан Үйлүүдийг Хийж Гүйцэтгэнэ

Нас барсан төрөл төрөгсдийнхөө төлөө зан үйлүүдийг гүйцэтгэхийн тулд бид зарим нэг зүйлсийг хийх хэрэгтэй. Бид тэдний нэр, төрсөн болон нас барсан газар, он сарыг тодорхойлох хэрэгтэй бөгөөд хэрэв энэхүү мэдээллийг олж чадахгүй бол мэдэхийнхээ хэрээр садан төрлийн холбоог (эцэг, эх, тэдний үр хүүхэд) нь тодорхойлж болно.

Нас барсан төрөл төрөгсдийнхөө нэр болон тэдний талаарх бусад мэдээллийг цуглуулах энэ ажлыг угсаа зүй буюу гэр бүлийн намтар гэж нэрлэнэ.

Эдгээр мэдээллийг бичих гэр бүлийн хүснэгт, гэр бүлийн баримт гэж нэрлэгдэх хоёр хүснэгт байдаг. Та тэдгээрийг өөрийн зэрэгтний хүчийн удирдагчаас авч болно. Тэрээр мэдээллийг бичихэд тань туслах хэн нэгнийг гаргаж өгнө. Уг баримтаа та тэдгээр зан үйлүүдийг гүйцэтгэдэг ариун сүмд хүргэж өгөх буюу илгээж болно.

Хэрэв төрөл төрөгсдийн маань хэн нь ч бидэнд хэрэгтэй баримт мэдээллийг мэдэхгүй байвал бид тэдгээрийг засгийн газрын болон тэдний харьяалагдаж байсан сүмийн баримт бичиг, оршуулгын газар болон ер нь тэрхүү мэдээллийг цуглуулж болохуйц газруудаас хайх хэрэгтэй.

Хэрэв бид шаардлагыг хангахуйц байж чадвал ариун сүмд очиж, төрөл төрөгсдийнхөө өмнөөс өөрсдийн биеэр зан үйлийг гүйцэтгэж болно. Хэрэв бид ариун сүмд орох боломжгүй бол бусад хүмүүс тэдний төлөө зан үйлийг гүйцэтгэх болно. Бид нас барагсдын төлөө зан үйлийг гүйцэтгэхийн тулд ариун сүмд тогтмол очиж байх хэрэгтэй.

Ярилцлага

- Нас барсан өвөг дээдсийнхээ төлөө ариун сүмд зан үйлийг гүйцэтгэхийн өмнө бид юу хийсэн байх ёстой вэ?
- Тэдгээр зан үйлийг гүйцэтгэхэд ямар мэдээлэл хэрэгтэй болдог вэ?
- Нас барсан өвөг дээдсийн маань төлөө хэн зан үйлийг гүйцэтгэж чадах вэ?

Хувийн Намтар Чухал Ач Холбогдолтой

Гэр бүлийнхээ нэг гишүүний өөрийн тухай бичсэн зүйлийг уншаад бид түүнийг улам ихээр хайрладаг билээ. Нас барсан төрөл төрөгсдийнхөө талаар мэдэж, тэдний төлөө зан үйлийг гүйцэтгэхээс гадна бид өөрсдийн амьдралын талаар баримт хөтлөх хэрэгтэй юм. Бид эцэг эхийнхээ болон өөрсдийн хэрхэн мэндэлсэн, бидний амьдралд юу тохиолдсон талаар бичиж үлдээх хэрэгтэй. Бид өөрсдийн юу бодож санаж явааг мөн бичих хэрэгтэй бөгөөд ингэснээр бидний үр хүүхэд, ач зээ нар маань бидний талаар ихийг мэдээд зогсохгүй, бидний нэгэн адилаар сайн үйл бүтээхийг хүсч болох юм.

Бурхан Адамд үр хүүхэддээ өөрийн тухай бичиж үлдээхийг зарлиг болгожээ. Зарлагууд ч үүний нэгэн адилаар бичиж байсан бөгөөд бид ч мөн тэгэх хэрэгтэй. Адам болон бусад зарлагуудын бичсэн баримт бичгүүдийг уншсанаар бид тэдний Бурхнаас хүлээн авсан хууль зарлиг, адис ерөөлүүдийг мэдэж авдаг. Энэ нь бидэнд сайн үйл хийхэд маань тусалдаг юм. Бид өөрсдийн амьдралыг бичиж үлдээн үр хүүхэддээ туслах ёстой.

Ярилцлага

- Яагаад Бурхан хүмүүст амьдрал, намтраа бичиж үлдээхийг тушаасан бэ?
- Таны хувийн намтар үр хүүхэд, ач зээ нарт тань ямар адислалыг авчирч чадах вэ?

Лавламж

Бурхан Гэр Бүлүүдийг Үүрд Хамт Байллагаар Төлөвлөжээ

- Матвей 18:18 (Зохих эрх мэдэлтнээр газар дэлхий дээр батлагдсан гэрлэлт тэнгэрт ч хүчин төгөлдөр байна.)
- Матвей 19:4-6 (Бурхны нэгтгэсэн зүйл салж хагацах учиргүй билээ.)

Зөвхөн Сүмийн Итгэлтэй Гишүүд л Ариун Сүмд Орж Болно

- Сургаал ба Гэрээ 88:19-21 (Ариун сүмд орохын тулд бид гэмээ наманчлах ёстой.)

Мөнхийн Хамтын Амьдралд Гэр Бүлээ Бэлтгэх нь

- 1 Питер 3:1-9 (Эхнэр нөхөр хоёр сайн сайхнаар хамтран амьдрах ёстой.)

Өвөг Дээдсээ Аврах Боломжийг Бурхан Бидэнд Өгсөн нь

- Малакай 4:6 (Хүмүүс өвөг дээдсийнхээ төлөө хойч үеийнхээ нэгэн адилаар санаа тавих болно.)
- Еврейчүүд 11:40 (Биднээс түрүүн нас барсан тэр хүмүүсгүйгээр бид төгс төгөлдөр болж чадахгүй байхсан билээ.)

Амьд нь Үхсэнийхээ Төлөө Зан Үйлүүдийг Хийж Гүйцэтгэнэ


- 1 Коринфынхан 15:29 (Эртний Төлөөлөгчдийн үед хүмүүс нас барагсдын өмнөөс усан баталгаа хийлгэдэг байв.)

Хувийн Намтар Чухал Ач Холбогдолтой

- Малакай 3:16 (Бурханд хайртай байсан хүмүүсийн нэрсийн жагсаалт бүхий ном хадгалагдан үлджээ.)

ИСҮС ХРИСТИЙН ХОЁР ДАХЬ ИРЭЛТ

Есдүгээр хэсэг





*Исус Христийн хоёр дахь ирэлт ойртлоо гэдгийг
нотлох олон шинж тэмдгүүд байна.*

ИСҮС ХРИСТИЙН ХОЁР ДАХЬ ИРЭЛТ

33-р бүлэг

Исүс Христ газар дэлхийд дахин ирнэ. Түүний ирэлтийн шинж тэмдэг ямар байх болон дахин ирэхэд нь түүнтэй уулзахын тулд бид хэрхэн бэлтгэх вэ?

Исүс Газар Дэлхийд Дахин Ирэхээ Амласан нь

Исүс дахин амилаад дөч хоносны дараа тэрээр өөрийн Төлөөлөгчидтэй Чидун Жимст Уул хэмээх нэгэн уулан дээр уулзжээ. Тэнгэр дэх Эцгийнхээ түүнийг илгээсэн хэрэг зоригийг бүтээсэн тул Исүсийн тэнгэрт буцах цаг нь болсон байлаа. Төлөөлөгчид нь Исүсийг тэнгэр өөд эргэн одохыг харан зогсч байтал бурхны хоёр элч тэдэн дээр ирж, Исүс дахин газар дэлхийд ирэх болно хэмээн хэлжээ. Тэр цагаас хойш одоог хүртэл Исүст итгэдэг хүмүүс түүний эргэн ирэхийг хүлээсээр байгаа билээ. Түүний энэ ирэлтийг Христийн хоёр дахь ирэлт гэж нэрлэдэг.

Хоёр дахь ирэлтээрээ Исүс тэнгэрээс аугаа их хүчин чадалтай бууж ирэх бөгөөд газар дэлхийг муу муухай бүхнээс ариутган цэвэрлэж, тэгснээр Сатан хүмүүсийг эзэмдэн захирах хүчээ алдана. Өөрт нь үнэнч байсан хүмүүсийг Исүс мянган жилээр удирдан суух болно.

Ярилцлага

- Исүс газар дэлхийд дахин ирнэ гэдгийг бид яаж мэддэг вэ?

Түүнийг Ирэхээс Өмнө Юу Тохиолдохыг Исүс Бидэнд Айлдсан нь

Исүс түүнийг дахин ирэхээс өмнө болох олон зүйлийн талаар өгүүлжээ. Тэдгээрийг түүний хоёр дахь ирэлтийн шинж тэмдгүүд

гэж нэрлэдэг. Тэрээр бидэнд эдгээр шинж тэмдгүүдийг ажиглаж, түүнийг ирэхэд бэлэн байхыг захисан юм. Тэдгээр зүйлсийг тохиолдон буйг хараад түүний ирэх ойртож байна гэдгийг бид мэдэх болно гэж тэр хэлжээ. Гэвч бид түүний ирэх тодорхой цаг хугацааг үл мэдэх болно.

Хэрэв бид судар уншиж, Исүст итгэлтэй байвал Исүсийн ирэлтийн шинж тэмдгүүд юу байхыг мэдэж чадна. Исүсийг газар дэлхийд дахин ирэхээс өмнө олон зүйл тохиолдох болно. Тэдгээрийн зарим нь болж өнгөрсөн, зарим нь одоо болж буй бөгөөд үлдсэн нь ирээдүйд тохиолдох болно.

Исүсийн хоёр дахь ирэлтээс өмнө евангели бүх улс үндэстэнд хүрсэн байх болно. Энэ нь олон хүнийг баярлуулж, тэдэнд адис ерөөл авчирна. Өөр бусад тохиолдох зүйлс нь бидний итгэлийн шалгуур болох юм. Асар их гамшиг зовлон, газар хөдлөлтүүд болон янз бүрийн сүйрэл тохиолдох болно.

Газар Дэлхийд Цөвийн Цаг Ирнэ

Бид газар дэлхий дээр асар их гай гамшиг, дайн тулаан, зовлон зүдгүүр тохиолдоход түүний ирэх ойргжээ гэдгийг мэднэ гэж Исүс хэлжээ. Тэр нь маш цөвийн цаг байх бөгөөд газар хөдлөн, хүчтэй салхи шуурга тавьж, өвчин эмгэг, тахал зовлон нүүрлэж, мөндрийн дуслууд газар дээрх үр тариаг сүйтгэх болно.

Олон хүмүүс Тэнгэр дэх Эцгийг маань хайрлахаа больж Сатанд хандах бөгөөд тэд мөн бусдыг хайрлаж, үйлчлэхээ болин тэдэнд хор учруулж эхлэх болно. Дэлхий дээр олон тооны дайн тулаан гарна. Улс үндэстнүүд бие биенийхээ эсрэг дайтаж, тэдгээр тулаанууд нь газар дэлхий дээр урьд хожид гараагүй хамгийн том, хөнөөлтэй, эцсийн дайн болтлоо үргэлжлэх болно. Тэр цагт Исүс хүрч ирнэ.

Евангели Дахин Сэргэлээ

Исүсийг дахин ирэхээс өмнө дэлхий дээр евангели дахин сэргэнэ гэж зарлагууд айлджээ. Зарлага Жозеф Смитээр дамжуулан евангели дахин сэргэсэн юм. Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очихын тулд бидний мэдвэл зохих евангелийн бүх сургаал газар дэлхий дээр дахин сэргэсэн билээ.

Мормоны Ном хэвлэгдэж, дэлхий дахинд хүртээл болохын цагт бид түүний ирэх цаг ойртлоо хэмээн мэднэ гэж Исүс бидэнд хэлсэн юм. Олон жилийн тэртээ зарлага Исаяя, Изекиль нар Мормоны Номын тухай өгүүлсэн байдаг. Зарлага Жозеф Смит Мормоны Номыг англи хэлнээ хөрвүүлжээ. Түүнээс хойш уг ном олон хэл дээр орчуулагдсан юм. Исүсийг ирэхээс өмнө Мормоны Ном бүх улс үндэстний хүртээл болох болно.

Израилийн Гэр Бүл Дахин Нэгдсэн Байх Ёстой

Израилийн гэр бүлийн* үр удам евангелийг сонсч, хүлээн зөвшөөрч, Исүсийг дахин ирэхэд нь түүнтэй уулзахад өөрсдийгөө бэлдсэн байх ёстой гэж Тэнгэр дэх Эцэг маань айлджээ. Евангелийг хүлээн авсан хүмүүс түүнийг бусдад зааж, ариун сүм босгож, нас барагсдын төлөө зан үйлүүдийг гүйцэтгэдэг байх ёстой.

Израилийн гэр бүлтэй ураг төрлийн холбоотой олон хүмүүс Исүс Христийн евангелийг хүлээн авч, Сүмд нэгдэн орцгоож байна. Абрахамын үр удмын олонх нь цугларах Ариун Нутаг адислалыг хүртсэн билээ. Абрахамын үр удамд араб, еврей болон өөр бусад улс үндэстнүүд багтана. Мормоны Номд гардаг Америк тив дахь хүмүүсийн удам угсаа буюу мөн Абрахамын үр удмынхан евангелийг хүлээн авч, хүчирхэг, үнэнч шударга хүмүүс болцгоож байна.

Евангели Дэлхий Дахинаа Хүртээл Болно

Түүний дагалдагчид бүх дэлхий даяар евангелийг номлосон тэр цагт түүний ирэх ойртож буйг бид мэднэ гэж Исүс айлджээ. Сүм дахин сэргэсэн цагаас хойш евангелийг заахаар янз бүрийн улс үндэстнүүдэд номлогчдыг илгээсээр байгаа билээ. Одоо дэлхийн бараг бүх өнцөг буланд олон тооны номлогчид евангелийг заан сургаж байна. Сүмийн гишүүн бүр төрөл төрөгсөд, найз нөхдөдөө евангелийн талаар ярьж таниулах үүрэгтэй бөгөөд тэдний олонх нь евангелийг номлохоор бусад оронд очдог. Ингэснээр бүх хүн евангелийн сургаалыг сонсох боломжийг олж авах юм.

Элайжа Иржээ

Библийн зарлага Малакай Исүсийг ирэхийн өмнө зарлага Элайжа газар дэлхийд ирэх болно хэмээн айлджээ. Тэрээр гэр бүлийг

мөнхөд хамтад нь батлах эрх мэдлийг буцаан авчирч, хүмүүсийн сэтгэл зүрхэнд өвөг дээдэс, үр удмынхаа тухай мэдэж, тэднийг аврагдахад нь туслах гэсэн хүслийг төрүүлэх учиртай байв. 1836 оны дөрвөн сард Элайжа тэрхүү эрх мэдлийг Жозеф Смитэд хүлээлгэн өгсөн юм. Элайжа ирсний ачаар өнөөдөр дэлхий дээрх хүмүүсийн гэр бүлүүд ариун сүмд хамтдаа батлуулж чадах болсон юм.

Шинэ Иерусалим Хот Барилдах Болно

Түүний Сүм Иерусалим хэмээх нэгэн шинэ хотыг барихад түүний ирэх ойртлоо гэдгийг мэднэ гэж Иүсү бидэнд айлджээ. Иүсү тэрхүү хотыг захирч, тэнд зөвхөн шударга хүмүүс амьдрах болно гэж тэр хэлсэн юм. Тэрээр бидэнд энэ хотыг барих газрыг зааж өгсөн бөгөөд тэр нь Америкийн Нэгдсэн Улсын Миссури муж юм.

Эдгээр нь Иүсүийн ирэх ойртсоныг дохиолох шинж тэмдгийн зөвхөн хэд нь юм. Судрууд бидэнд бусад шинжүүдийг хэлж өгөх болно. Хэдийгээр олон шинж тэмдгүүд мэдэгдээд байгаа ч гэсэн бид Иүсүийн дахин ирэх тодорхой цаг үеийг мэдэж чадаагүй байна.

Ярилцлага

- Иүсүийн хоёр дахь ирэлт ойртож буйг бид хэрхэн мэдэх вэ?
- Иүсүийн хоёр дахь ирэлтийн шинж тэмдгүүд юу вэ?

Гай Гамшиг, Зовлон Зүдгүүр Нүүрлэлээ ч Бид Амгалан Тайван, Итгэл Найдвартай Байж Чадна

Бид Иүсүийн хоёр дахь ирэлтэд бэлтгэлтэй байх ёстой. Түүнийг ирэхэд бэлтгэх хамгийн зөв зам бол түүний сургаалыг үргэлж даган биелүүлэх явдал юм. Түүнчлэн бид өнөөдөр түүний Сүмийн Ерөнхийлөгчид өгч буй тушаал заавруудыг биелүүлэх хэрэгтэй. Бидний бодол санаа, үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг Ариун Сүнснийг бид үргэлж өөрсөдтэйгөө хамт байлгах хэрэгтэй. Хэрэв бид түүнийг ирэхэд бэлэн бол бидэнд айх зүйл байхгүй гэж Иүсү хэлсэн билээ. Бид баяр баясгалантай байж, түүнтэй хамт байхыг хүсэх болно. Түүнийг ирэхэд сайн хүмүүс үл хөнөөгдөх болно. Тэд газар дэлхий дээр амьдарч, тэдний үр хүүхэд нүгэл хилэнцгүйгээр өсөн торнино. Иүсү тэдэнтэй хамт байж, тэднийг ивээн адислаж, удирдан залах болно.

Исүсийг тэнгэрээс дахин заларч ирэхэд муу хүмүүс хөнөөгдөх болно. Нас барсан сайн хүмүүс булшнаасаа босон ирж, түүнийг тэнгэрээс ирэхэд нь тосон уулзах болно. Муу хүмүүс мянган жил өнгөрөхөөс нааш булшнаасаа босч ирэхгүй. Тэрхүү цаг хугацааг *Мянган жил гэж нэрлэдэг.

Исүсийг газар дэлхий дээр амьдарч байх тэр үед цөөн хэдэн хүмүүс даян дэлхийн Аврагч хүрч ирлээ гэдгийг мэдэж байв. Исүсийг дахин ирэх үед хүн бүр түүнийг Исүс Христ, Бурхны Хүү, дэлхийн Аврагч гэж мэдэх болно.

Ярилцлага

- Хоёр дахь Ирэлтийн шинж тэмдгүүдийг мэдэх нь бидэнд ямар тус болох вэ?
- Исүсийг буцаж ирэхэд дэлхий дээр буй сайн хүмүүст юу тохиолдох вэ?
- Тэр үед дэлхий дээр амьдарч байх муу хүмүүст юу тохиолдох вэ?

Лавламж

Исүс Газар Дэлхийд Дахин Ирэхээ Амласан нь

- Матвей 24:36, 42-44 (Бид Исүсийн буцаж ирэх өдөр, цагийг мэдэхгүй.)
- Матвей 26:64 (Исүс хурмаст тэнгэрийн үүлэн дундаас залран ирнэ.)
- Жон 14:2-3 (Исүс буцан ирэхээ амлаж байна.)
- Үйл явдал 1:11 (Исүс дахин ирнэ гэдгийг бурхны элчүүд Төлөөлөгчдөд хэлжээ.)

Түүнийг Ирэхээс Өмнө Юу Тохиолдохыг Исүс Бидэнд Айлдсан нь

- Матвей 24 (Исүсийн хоёр дахь ирэлтийн өмнө тохиолдох шинж тэмдгүүдийг тайлбарласан нь.)

Гай Гамшиг, Зовлон Зүдгүүр Нүүрлэлээ ч Бид Амгалан Тайван, Итгэл Найдвартай Байж Чадна

- Матвей 13:40-43 (Муу хүмүүс хөнөөгдөж, шударга сайн хүмүүс аврагдах болно.)
- Зекарайя 14:9 (Исүс буцан ирж, дэлхийг захирах болно.)

МЯНГАН ЖИЛ

34-р бүлэг

Мянган жил гэж юу вэ? Мянган жилийн хугацаанд дэлхий дээрх амьдрал ямар байх вэ?

Мянган Жилийн Хугацаанд Газар Дэлхий Дээр Үнэнч Шударга Хүмүүс Амьдрах Болно

Исүс дахин эргэж ирэхдээ газар дэлхийг нэг мянган жилийн турш захирах болно. Энэ цаг хугацааг Мянган Жил хэмээн нэрлэх болно.

Мянган жил нь энх амгалан, үнэн шударгын үе байх болно. Мянган жилийг эхлэхээс өмнө Исүс газар дэлхийг нүгэл хилэнцээс ариутган цэвэрлэх бөгөөд муу хүмүүс бүгд хөнөөгдөнө. Тэр үед зөвхөн шударга сайн хүмүүс л газар дэлхий дээр аврагдан үлдэх болно. Мянган жилийг дуустал Сатан хүмүүсийг эзэмдэн захирах хүчин чадлаа алдах юм.

Мянган жилийн туршид тэнгэрээс хүмүүс үргэлж газар дэлхийд айлчлан ирж байх болно гэж зарлага Жозеф Смит хэлжээ. Тэд ариун сүмийн болон номлолын албаны ажил хэрэгт туслах болно.

Ярилцлага

- Мянган жил гэж юу вэ?
- Мянган жилийн үед ямар хүмүүс дэлхий дээр амьдрах вэ?
- Муу муухай зүйл огтхон ч байхгүй газар амьдрах ямар болохыг төсөөлнө үү.

Мянган Жилийн Хугацаанд Хоёр Их Үйл Хэрэг Биелэлээ Олно

Анхдугаар аугаа үйл хэрэг бол ариун сүмд амьд болон нас барсан хүмүүсийн төлөө хийгдэх зан үйлүүд юм. Дахин амилсан хүмүүс нас

барсан төрөл төрөгсдийнхөө нэрийг хайн олж, баримт бичгүүдийг нь алдаа мадаггүй болгоход нь дэлхий дээр амьдран буй хүмүүст туслах болно.

Гэр бүлийг батлах зан үйлийн ёслол ариун сүмд хийгдэнэ. Гэр бүлүүд Адамын үеийг хүртэл үе үеэрээ харилцан холбогдох болно.

Дараачийн нэг том үйл хэрэг бол евангелийг номлох юм. Хүн бүр евангелийг сонсч, түүнийг хүлээн авах боломжтой болно. Мянган жил эхлэхэд Исүсийн сүмийн гишүүд биш ч гэлээ сайн хүмүүс дэлхий дээр амьдарч байх юм. Хэдий тийм боловч улмаар бүх хүмүүс Исүсийг даян дэлхийн Аврагч гэдгийг мэдэж, гэрчлэх болно.

Ярилцлага

- Мянган жилийн хугацаанд ямар хоёр их үйлс бүтээгдэх вэ?

Мянган Жилийн Хугацаанд Амьдрал Ямар Байх нь

Мянган жилийн үед газар дэлхий Адам Ева хоёрыг Эдений Цэцэрлэгт амьдарч байсан үетэй адил байх болно. Дайн дажин үл гарах бөгөөд Исүс Сүм, засаг төрийг хослон захирна. Бүх хууль тогтоолууд үнэн шударга зарчим дээр үндэслэсэн байна. Тэр үед хоёр нийслэл хот байх бөгөөд нэг нь Иерусалим, нөгөө нь Америкийн Нэгдсэн Улс дахь Шинэ Иерусалим болно.

Хүн ард хамтдаа энх амгалан, энэрэл хайрын дунд амьдарна. Өнөөдөр хоорондоо дайсан байгаа ан амьтад ч эв найрамдалтай аж төрөх болно. Тэд дахин хоорондоо тулалдахгүй.

Тэр үед өвчин эмгэг, үхэл хагацал үгүй болно. Хүмүүс хөгшрөвч үл үхэх бөгөөд хормын зуур одоо байгаа байдлаасаа үхэшгүй мөнхийн хэлбэрт шилжих болно.

Мянган жилийн үед амьдрах нь маш их нэр төрийн хэрэг юм. Одоо бидэнд ойлгомжгүй байгаа юмс тэр үед тодорхой болно. Амьдрал хэдийгээр одоотой адил байх боловч бүх зүйл эв найрамдал, энэрэл хайрын үрээр хийгдэнэ. Хүмүүс үр хүүхэдтэй болж, тэднийгээ өсгөн бойжуулж, үр тариа тарьж, ургацаа хураан, байшин барилга барин амьдарсан хэвээр байна.

Ярилцлага

- Мянган жилийн хугацаанд газар дэлхий ямар байдалтай байх вэ?

Мянган Жилийн Төгсгөлд Нэгэн Эцсийн Бэрхшээл Тулгарах Болно

Мянган жил дуусахын алдад Сатан газар дэлхий дээр дахин хүчирхэгжих болно. Зарим хүмүүс түүнд итгэж, Сатан болон түүний дагалдагчид Исүсийн дагалдагчидтай тулалдах болно. Энэхүү дайнд Сатан, өөрийн дагалдагчдын хамтаар мөнхийн ялагдлыг хүлээх юм. Дайны дараагаар хүн бүр шүүгдэж, өөртөө бэлдсэн тохирох хаант улсдаа очих болно.

Ярилцлага

- Мянган жилийн эцэст юу тохиолдох вэ?

Лавламж

Мянган Жилийн Хугацаанд Газар Дэлхий Дээр Үнэнч Шударга Хүмүүс Амьдрах Болно

- 2 Нифай 30:10 (Муу хүмүүс хөнөөгдөнө.)
- Моүзес 7:64 (Газар дэлхий муу муухайгаас ангижирна.)

Мянган Жилийн Хугацаанд Хоёр Их Үйл Хэрэг Биелэлээ Олно

- Иеремиа 31:34 (Тэд бүгдээр Исүсийн тухай мэдэх учраас хүмүүс бие биедээ түүний тухай заах хэрэггүй болно.)

Мянган Жилийн Хугацаанд Амьдрал Ямар Байх нь

- Исайяа 2:3-4 (Дэлхийд хоёр нийслэл хот байх бөгөөд дэлхий дахинаа энх амгалан тогтоно.)
- Исайяа 11:6-9 (Ан амьтад хоорондоо эв найртай аж төрнө.)
- Үзэгдэл 20:1-3 (Сатан хүлэгдэх болно.)

Мянган Жилийн Төгсгөлд Нэгэн Эцсийн Бэрхшээл Тулгарах Болно

- Үзэгдэл 20:7-10 (Эцсийн дайнд Сатан болон түүний дагалдагчид ялагдал хүлээнэ.)

ҮХЛИЙН ДАРААХ АМЬДРАЛ

Аравдугаар хэсэг





*Үхлийн дараа бид өөрсдийн гэр бүл, хайртай хүмүүстэйгээ сүнсний
ертөнцөд дахин нэгдэх болно.*

ҮХЛИЙН ДАРААХ АМЬДРАЛ

35-р бүлэг

Бид дараагийн амьдралдаа хэрхэн бэлтгэж чадах вэ?

Биднийг Үхсэний Дараа Сүнс Маань Амьдарна

Бид Тэнгэр дэх Эцгийнхээ сүнсэн хүүхдүүд юм. Түүний хамтаар тэнгэрт амьдарч байхад бидэнд бие махбод байсангүй. Бид газар дэлхий дээр мэндэлж, сүнснүүд маань яс, махан бие цогцсыг хүлээн авдаг нь түүний төлөвлөгөөний нэг хэсэг юм. Сүнс гэдэг бол биднийг газар дэлхий дээр байх хугацаанд бие махбодыг маань амьдруулж байдаг зүйл юм.

Төрөх гэдэг нь Тэнгэр дэх Эцгийн маань төлөвлөгөөний нэг хэсэг байдгийн адилаар үхэх ч мөн түүний нөгөө хэсэг юм. Хүнийг үхэхэд түүний сүнс биеийг нь орхин одно. Сүнсгүй болсон бие махбод амьдралаа алдаж, булшлагдана.

Биднийг төрөхөөс өмнө сүнс маань амьдарч байсан, мөн үхсэний дараа ч амьдарсаар байх болно. Бие махбод маань булшиндаа үлдэхэд, сүнс дахин амилахыг хүлээхээр сүнсний ертөнцөд очдог юм.

Сүнсний ертөнцөд очсон сүнс биднийг газар дэлхий дээр яс, махан бие цогцстой амьдарч байсантай нэгэн адил хэлбэрийг олно. Бид одооных шигээ харагдах бөгөөд энд байсантайгаа адилаар бодож сэтгэж, нэгэн ижил зүйлд итгэн бишрэх болно. Энэ амьдралдаа шударга сайн байсан хүмүүс мөн хэвээр үлдэнэ. Шударга бус байсан хүмүүс ч тэр хэвээр байна. Газар дэлхийд байх үеийн маань хүсэл мөрөөдөл бидэнд хадгалагдан үлдэх болно.

Ярилцлага

- Бидний сүнс хаанаас гаралтай вэ?
- Биднийг үхэхэд сүнс маань яах вэ?
- Сүнслэг бие цогцос ямар байдаг вэ?

Сүнсний Ертөнц Бол Сурч Хөдөлмөрлөх, Хүлээх Газар Юм

Тэнгэр дэх Эцгийн маань зарлагууд бидэнд сүнсний ертөнцийн талаар олон зүйлийг хэлж өгсөн. Тус ертөнцөд диваажин хэмээх газар бий. Евангелийг хүлээн авч, Исүсийн итгэлтэй дагалдагч байсан хүн үхэхэд түүний сүнс диваажинд очно. Тэнд хүмүүс гай гамшиг, өвчин зовлонгүй, аз жаргалтай, амар тайван байдаг газар юм. Тэд бусдад евангелийг заах болон өөрсдөө түүний талаар улам ихийг мэдэж авах зэргээр олон үр нөлөөтэй ажлыг хийж болно.

Сүнсний шорон хэмээн нэрлэгдэх нэгэн газар бас бий. Энэ амьдралдаа муу муухай явсан хүмүүс, сайн сайхнаар амьдарсан боловч евангелийг хүлээж аваагүй хүмүүс, евангелийг сонсох завшаан олдоогүй гэсэн гурван янзын хүмүүс тэнд байх болно.

Сүнсний ертөнцөд буй шударга сайн хүмүүсийн дундаас номлогчдыг илгээж, нас барсан хүмүүсийн бүх сүнсэнд евангелийг заах болно гэдгийг Тэнгэр дэх Эцгийн маань зарлагууд айлдсан билээ. Тэдний олонх нь евангелийг хүлээн авч, нүглээ наманчлах болно. Шаардлагатай авралын зан үйлүүдийг амьд буй хүмүүс Тэнгэр дэх Эцгийн маань ариун сүмд тэдний төлөө хийх болно. Тэдгээр зан үйлийг тэдний төрөл төрөгсөд болон Сүмийн гишүүд хийж гүйцэтгэдэг. Ийнхүү тэд сүнсний шоронгоос гарах боломжтой болно. Ийм замаар Тэнгэр дэх Эцэг маань аль цаг үед газар дэлхий дээр амьдарч байв гэдгийг нь үл харгалзан өөрийн бүх үр хүүхдэд евангелийн адис ерөөлийг хүлээн авах боломжийг олгодог юм.

Улмаар сүнсний ертөнцөд байгаа бүх сүнснүүд дахин амилах болно. Дахин амилахад бие махбод, сүнстэйгээ дахин нэгдэнэ. Хэдийгээр булшинд үлдсэн бие цогцос замхран арилж, тоос болсон ч гэсэн тэрээр үхэшгүй мөнхийн, төгс төгөлдөр бие болох болно. “Бие махбодын эд эс бүхэн дахин сэргэж, толгой дээрх үсний нэг ширхэг ч гэсэн үл гээгдэх бөгөөд тэдгээр нь төгс төгөлдөр хэлбэрт шилжих болно.” гэж зарлага Алма хэлсэн байдаг.

Дахин амилснаар бие махбод, сүнстэйгээ дахин нэгдэж, хэзээ ч үл хагацах болно. Дахин амилах энэхүү гайхамшигтай бэлгийг Исүс өөрийн хайр, аугаа их цагаатгалын золиослолоор дамжуулан энэ газар дэлхий дээр амьдрах хүн бүрт өгсөн юм.

Ярилцлага

- Сүнсний ертөнц ямар хоёр хэсэгт хуваагддаг вэ?
- Хэн диваажинд очих вэ? Диваажинд буй сүнснүүд юу хийдэг вэ?
- Хэн сүнсний шоронд очих вэ? Тэнд юу тохиолддог вэ?

Бид Бүгдээрээ Эцсийн Шүүлтээр Шүүгдэх Болно

Бид мөнхийн амьдралынхаа явцад олон удаа шүүлт шалгуурыг давдаг. Тэнгэр дэх Эцгийнхээ хамтаар амьдарч байхдаа ч гэсэн бид энэ газар дэлхийд ирж, бие махбодыг хүлээн авахад тэнцэх эсэхээ шүүлгэсэн билээ. Бид энд байхдаа усан баталгаа хийлгэхэд тохирох эсэхээ ч мөн шалгуулж, эрэгтэйчүүд зэрэгтний хүчийг хүлээн авч чадах эсэхээ шүүлгэдэг юм. Түүнчлэн ариун сүмд орж онцгой адис ерөөлийг хүртэхэд тэнцэх эсэхийг маань ч шүүдэг. Үхлийн дараа бид дахин шүүгдэж, газар дэлхий дээр хэрхэн амьдарч байснаасаа шалтгаалан тохирох шагналыг хүлээн авах болно.

Бид дахин амилсныхаа дараа эцсийн удаа шүүгдэхээр Тэнгэр дэх Эцгийнхээ өмнө хүргэгдэх болно. Түүнийг эцсийн шүүлт гэж нэрлэдэг. Тэрхүү эцсийн шүүлт биднийг мөнхөд амьдрахаар хаашаа одохыг маань тодорхойлж өгнө. Энэ удаа биднийг энэ амьдралдаа хэлж ярьж байсан үгс, бодож байсан бодол санаа, хийсэн ажил үйлс, түүнчлэн Исүсийн сургаалыг хэрхэн дагаж байснаар маань тэнгэрт болон газар дэлхийд хуримтлагдсан баримтын дагуу шүүх болно. Биднийг шүүлгэхээр Тэнгэр дэх Эцэг маань Исүсийг томилж болно.

Исүс бидэнд маш их хайртай ч гэлээ, тэрээр шударга шүүгч тул биднийг амьдарсан амьдралаар маань дэнслэн шүүх юм. Бидний бодож санаж, хэлж ярьж, хийж байсан бүх зүйлс бидний оюун ухаанд болон бусад баримт бичигт хадгалагдан үлдсэн бөгөөд Исүс бидний талаар бүгдийг мэднэ. Бид ч мөн түүний өмнө зогсож байхдаа тэр бүхнээ эргэн санах болно.

Ярилцлага

- Биднийг шалгаж сорьдог цаг үеүдээс нэрлэнэ үү.
- Биднийг юугаар маань шүүн дэнслэх вэ?

Үхлийн Дараа Бидэнд Юу Тохиолдохыг Бид Өдөр Тутмын Үйл Ажиллагаагаараа Шийдэж Байдаг

Хэрэв бид амьдралынхаа туршид зөв зүйлийг хийх юм бол өөрсдийгөө Тэнгэр дэх Эцэгтэйгээ болон энэ газар дэлхийн сайн хүмүүстэй хамт мөнхөд амьдрахад бэлтгэж байна гэсэн үг юм. Хэрэв бид Тэнгэр дэх Эцгийнхээ зарлиг тушаалыг дагаагүй бол Исүсийн өмнө шүүгдэхээр зогсоход бидэнд тун хэцүү байх болно.

“Бидний үгс биднийг шийтгэнэ, тийм ээ, бүх үйл хэрэг маань биднийг шийтгэнэ; бид өчүүхэн ч толбогүй цэвэр ариун үл байж, бидний бодол санаа биднийг шийтгэх болно.” хэмээн зарлагууд өгүүлжээ. Тэд, муу хүмүүс Исүсийн өмнө “ичгүүртэйгээр, гэм буруугаа ухамсарлан” зогсож, уул толгод, хад асга тэдний дээрээс нуран унаж, тэднийг Исүсийн бараа сүрнээс далдлан нуугаасай хэмээн хүсэх болно гэж хэлжээ.

Энэ газар дэлхий дээр амьдарч байсан хэн хүний хувьд эцсийн шүүлтийн тэрхүү өдөр нэг бол тун гайхамшигтай, нэг бол маш их уйтгар гунигтай өдөр байх болно. Бидний хувьд баяр баясгалантай өдөр байлгахын тулд бид тэрхүү ирээдүйн цаг мөчид өөрсдийгөө бэлтгэх хэрэгтэй. Бид Тэнгэр дэх Эцгийнхээ өмнө ямар ч ичгүүргүйгээр зогсож, түүний амьдралынхаа туршид хийж байсан зүйлсийг маань сайшаан өгүүлэхийг сонсохыг хүсч байна.

Бид энэхүү эцсийн шүүлтийн тухай бодох хэрэгтэй. Түүнд бэлэн байхын тулд бид амьдралынхаа эцсийг хүртэл Исүс Христэд итгэж, бүх гэм нүглээ наманчилж байх хэрэгтэй. Энэ нь тэрхүү цаг мөчийг ирэхэд бид гэм нүгэлгүй байж чадах цорын ганц зам юм. Хэрэв бид Исүс Христэд итгэж, бүх нүглээ наманчлах юм бол Тэнгэр дэх Эцэг маань бидний нүгэл хилэнцийг уучлан өршөөж, ямар ч гэм нүгэлгүй болоход маань туслах болно. Исүс Христэд итгэлтэй байснаар бид амьдралдаа зөвхөн сайн үйлсийг бүтээж, сайн сайхан бодол санаа агуулж, сайн үгсийг өгүүлэх болно. Бидэнд муу бодол төрүүлэх болон ямар нэгэн замаар биднийг шударга бус байлгах тийм газар, ном хэвлэл, хүмүүсээс бид аль болох зайлсхийдэг болно.

Тэнгэр дэх Эцэг маань бид бүгдэд хайртай бөгөөд хүн бүрийг түүний дэргэд очиход тэнцэхүйцээр амьдраасай гэж хүсдэг. Хэрэв бид түүнтэй болон өөрсдийн хайртай сайн хүмүүстэй хамт амьдрахыг хүсч байгаа бол Исүс Христэд итгэж, түүний тушаасныг хийж гүйцэтгэх хэрэгтэй. Түүнчлэн өөрсдийн гэр бүлийнхэнд сайн сайхан амьдрахад нь туслах хэрэгтэй. Тэнгэр дэх Эцэг маань бидэнд тусална. Тэрээр бидэнд замыг маань зааж өгөх евангелийн сургаалыг хайрласан бөгөөд түүнээс тусламж хүсэн үргэлж залбирч байхыг бидэнд хэлсэн билээ.

Ярилцлага

- Яагаад бидний өдөр тутмын бодол санаа, үйл ажиллагаа маань чухал байдаг вэ?
- Та өөрийн бодол санаа, үг яриа, үйл ажлыг сайжруулахын тулд юу хийж чадах вэ?
- Яагаад төгс төгөлдөр болоход бидэнд Тэнгэр дэх Эцгийн маань тусламж хэрэгтэй вэ?
- Яагаад гагцхүү Исүс Христэд итгэснээр бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт амьдрахад тэнцэж чадах вэ?

Лавламж

Биднийг Үхсэний Дараа Сүнс Маань Амьдарна

- Лук 23:43 (Исүс загалмай дээр байсан хулгайчид тэд удахгүй хамтдаа диваажинд байх болно гэдгийг амлажээ.)
- Алма 40:11 (Биднийг үхэхэд сүнс маань Тэнгэр дэх Эцэгт эргэн очдог.)

Сүнсний Ертөнц Бол Сурч Хөдөлмөрлөх, Хүлээх Газар Юм

- 1 Питер 3:18-20 (Шорон дахь сүнснүүдэд Исүс сургаал хайрлажээ.)
- Алма 40:12-14 (Муу хүмүүсийг шоронд асар ихээр энэлэн гашуудаж байхад, сайн хүмүүс диваажинд аз жаргалтай байх болно.)

Бид Бүгдээрээ Эцсийн Шүүлтээр Шүүгдэх Болно

- Үйл явдал 17:31; Ромынхан 14:10 (Хэзээ нэгэн өдөр Исүс Христ бүх хүмүүсийг шүүх болно.)

- Үзэгдэл 20:12 (Бид тэнгэр, газарт хадгалагдсан ном бичгийн дагуу шүүгдэх болно.)

*Үхлийн Дараа Бидэнд Юу Тохиолдохыг Бид Өдөр Тутмын Үйл
Ажиллагаагаараа Шийдэж Байдаг*

- Матвей 25:31-46 (Исүс Христ биднийг үйл ажиллагаагаар маань шүүнэ.)
- 2 Нифай 29:11 (Бид судар номын дагуу шүүгдэх болно.)
- Жейкоб 6:9 (Хэрэв бид наманчлаагүй бол ичгүүртэйгээр, асар их буруутай зогсох болно.)
- Алма 12:14 (Хэрэв тэдгээр нь буруу байсан бол биднийг бодол санаа, үг яриа, үйл хөдлөл маань шийтгэх болно.)
- 2 Нифай 31:19-20 (Мөнхийн амьдралд орохын тулд бид амьдралынхаа эцсийг хүртэл Исүс Христэд итгэж, гэм нүглээ наманчлан байх ёстой.)

МӨНХИЙН АМЬДРАЛ

36-р бүлэг

Эцсийн Шүүлтийн дараа бид хаана амьдрахаар явах вэ?

Хүн Бүр Өөрт нь Бэлтгэгдсэн Газар луу Явах Болно

Тэнгэр дэх Эцэг маань биднийг амьдрахад зориулж хэд хэдэн газар бэлтгэснийг Исүс заажээ. Бид Исүс Христэд хэр итгэлтэй байснаасаа хамааран дөрвөн газарт хуваарилагдах болно. Бидэнд бэлтгэгдэж байсан хаант улсууд руу бид өөрсдийн хийсэн сонголтын дагуу очих болно. Эдгээр дөрвөн газрыг селестиал хаант улс, террестриал хаант улс, телестиал хаант улс, гадаад харанхуй гэж тус тус нэрлэдэг.

Селестиал Хаант Улс

Энэ нь Тэнгэр дэх Эцэг маань болон Исүсийн амьдардаг газар юм. Энэ нь бидний төсөөлөхөөс хавьгүй илүү гайхамшигтай сайхан бөгөөд тэнд хүмүүс аз жаргалтай байх болно. Энэ хаант улсад амьдрах хүмүүс Тэнгэр дэх Эцэг, Исүсийг хайрлаж, тэднийг дагахаар сонгох болно. Тэд бүх нүгэл хилэнцээ наманчилж, Исүсийг өөрсдийн Аврагч хэмээн хүлээн зөвшөөрсөн байх ёстой. Тэд усан баталгаа хийлгэж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсан байх ёстой. Тэд Исүс бол Аврагч мөн гэдэг гэрчлэлийг Ариун Сүнснээс авсан байх ёстой.

Селестиал хаант улсын хамгийн дээд хэсэгт амьдрахыг *өргөмжлөл буюу мөнхийн амьдрал гэдэг. Энэ хэсэгт амьдрахын тулд хүмүүс ариун сүмд гэрлэсэн бөгөөд ариун сүмд хийсэн ариун нандин амлалтаа үнэнчээр сахисан байх ёстой. Тэд Тэнгэр дэх Эцэгт маань



*Эцсийг хүртэл итгэлтэй байсан хүмүүс Тэнгэр дэх Эцэг болон
Исүс Христийн хамтаар өргөмжлөгдөх болно.*

байдаг бүхнийг хүлээн авч, түүнтэй адил болно. Түүгээр ч зогсохгүй тэд өөрсдөө сүнсэн хүүхдүүдтэй болж, тэдэндээ амьдрах шинэ газар ертөнцийг бүтээн өгч, Тэнгэр дэх Эцгийн маань хийсэн бүхнийг хийж чадах болно. Ариун сүмд гэрлээгүй хүмүүс селестиал хаант улсын өөр хэсгүүдэд амьдарч болох боловч тэд өргөмжлөлийг хүртэхгүй.

Террестриал Хаант Улс

Энэ хаант улс нь селестиал хаант улс шиг гайхамшигтай сайхан биш юм. Хэдий Исүс террестриал хаант улсад айлчилсаар байх боловч, тэнд амьдарч буй хүмүүс Тэнгэр дэх Эцэгтэй маань хамт амьдарч, түүнд байдаг бүхнийг хүлээн авч чадахгүй. Террестриал хаант улсад очих хүмүүс хүндтэй хүмүүс байх бөгөөд тэдний зарим нь Сүмийн гишүүд, зарим нь биш байж болно. Тэдгээр нь газар дэлхийд байхдаа Исүсийг хүлээн зөвшөөрөөгүй боловч хожим нь сүнсний ертөнцөд түүнийг хүлээн зөвшөөрсөн хүмүүс юм. Тэнд амьдрах хүмүүс мөнхийн гэр бүлийн нэг хэсэг байж чадахгүй, гэр бүлгүйгээр ганц ганцаар амьдрах болно. Тэнгэр дэх Эцэг маань эдгээр хүмүүст тэдэнд тохирсон аз жаргалыг нь хайрлах болно.

Телестиал Хаант Улс

Энэхүү хаант улс нь селестиал болон террестриал хаант улсууд шиг гайхамшигтай байж чадахгүй. Тэнгэр дэх Эцэг болон Исүсийн хэн нь ч тэнд амьдарч буй хүмүүс дээр айлчлан очихгүй. Бурхны элчүүд тэдэнд айлчилж, тэд Ариун Сүнсний нөлөөг мэдэрсээр байх болно. Телестиал хаант улсад амьдарч буй хүмүүс нь газар дэлхий дээр ч, сүнсний ертөнцөд ч, Исүсийн евангели болон гэрчлэлийг хүлээн зөвшөөрөөгүй хүмүүс юм. Мянган жилийг дуустал тэд сүнсний шоронд өөрсдийн нүгэл хилэнцийн өмнөөс эмгэнэн гашуудах бөгөөд эцэст нь дахин амилах болно.

Энэ дэлхий дээр байхдаа тэд худалч, хулгайч, алуурчин, хуурамч зарлагууд, завхайрагчид, мөн ариун нандин зүйлсийг доромжлон тохуурхагчид байжээ. Тэдгээр нь Исүсийн сургаалаас илүүтэйгээр энэ хорвоогийн итгэл бишрэлийг хүлээн авсан хүмүүс байлаа. Олон хүн энэ хаант улсад амьдрах бөгөөд Тэнгэр дэх Эцэг маань тэдэнд тохирох аз жаргалыг нь хайрлах болно.

Гадаад Харанхуй

Гадаад харанхуй гэдэг нь Сатан болон түүнийг дагаж байсан хүмүүсийн амьдрах газар юм. Тэдгээр нь Сатантай хамт амьдрахаар сонгосон хүмүүс байх болно. Тэд өршөөл үзэхгүй бөгөөд мөнхийн уй гашуу, харанхуйд амьдарч, Сатан болон түүнийг дагасан сүнснүүдийн хамтаар шаналан зовох болно.

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт амьдрахын тулд бид ямар хаант улсад бэлтгэгдсэн байх ёстой вэ?
- Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил амьдрахад тэнцэхүйц байхын тулд бид энэ дэлхий дээр байхдаа ямар зүйлсийг хийх ёстой вэ?

Биднийг Селестиал Хаант Улсын Мөнхийн Амьдралд Бэлтгэхийн Тулд Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Евангелийг Өгсөн

Тэнгэр дэх Эцэг маань хүн бүрт өөртэйгөө хамт мөнхөд амьдрах бололцоог олгож байдаг. Мөнхийн амьдрал гэдэг нь Тэнгэр дэх Эцэг болон Исүсийн амьдралтай адил юм. Тэнгэр дэх Эцэг маань төгс төгөлдөр. Тэр бүгдийг мэднэ. Түүнд бүхнээс илүү хүчин чадал байдаг бөгөөд тэрээр бүгдийг захирдаг. Тэрээр мөнхийн хууль ёс, үнэний дагуу амьдардаг.

Исүс Тэнгэр дэх Эцгээ дуулгавартай дагасан тул Тэнгэр дэх Эцэгтэй маань хамт амьдарч байна. Хэрэв бид Исүсийн бидэнд заасан зүйлсийг хийх юм бол Тэнгэр дэх Эцэг болон түүний адилаар амьдрах боломжтой болно. Тэнгэр дэх Эцгийнхээ хамтаар мөнхөд амьдрах гэдэг нь түүний бидэнд өгч чадах хамгийн том бэлэг юм. Энэ нь бидэнд юу юунаас илүүтэй аз жаргалыг авчрах болно.

Евангели нь бидэнд мөнхийн амьдралыг хүлээн авахад мэдэх, хийх хэрэгтэй бүгдийг хэлж өгдөг. Мөн Тэнгэр дэх Эцэг болон Исүсийн тухай мэдэхэд маань тусалж, хэрхэн тэдний адил амьдрахыг сургадаг. Судруудыг уншин судалж, залбирснаар бид тэднийг илүү сайн мэддэг болно. Бид тэднийг мэдэж, хайрласнаар үгийг нь дуулгавартай дагахыг хүсэх болно. Ийнхүү дуулгавартай дагаснаар бид тэдэнтэй адил байж, тэдэнтэй хамт мөнхөд хамт амьдрахад тэнцэхүйц болж чадна.

Ярилцлага

- Мөнхийн амьдрал гэж юу вэ? Хэн түүнийг хүлээн авах вэ?
- Евангели хэрхэн биднийг мөнхийн амьдралд бэлтгэдэг вэ?

Бид Евангелийг Дагахаар Сонговол Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Тусална

Бид бүгдээр евангелийн сургаалыг дагаж, мөнхийн амьдралыг хүлээн авах боломжтой гэдгийг Тэнгэр дэх Эцэг маань мэддэг. Бид нэгэнт түүний хүүхдүүд учраас бидэнд түүнтэй адил болох чадал байгаа. Тэрээр хүн бүрийн сул дорой зан байдал, түүнчлэн ямар зүйлст уруу татагдаж болохыг мэддэг. Тэрээр сурч мэдэж, сайн зүйлийг хийж бүтээх бололцоог бидэнд олгож чадахуйц газар дэлхийн тодорхой орон нутаг, цаг үед биднийг ирүүлсэн юм.

Одоо бид мөнхийн амьдралыг хүлээн авахын тулд хэрэгтэй бүгдийг хийх ёстой билээ. Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хайртай, биднийг амжилт гаргахыг хүсч байна. Тэрээр бидний төлөө өөрийн чадах бүхнийг хийсэн. Тэр биднийг дээр нь сурч мэдэж, өсөн дэвжиж чадах газар дэлхийгээр хангаж, өөрийн Хүү, Исүс Христийг бидний Аврагч байж, бидэнд евангелийг заахаар илгээжээ. Тэрээр биднийг өөрт нь хандан залбирч байхыг урьж, Ариун Сүнснийг бидний удирдан жолоодогч байх боломжийг өгсөн юм. Бид одоо зөв зүйлийг хийх хэрэгтэй болжээ. Хэрэв бид Исүс Христэд итгэж, түүнийг дагахаар сонговол, Тэнгэр дэх Эцэг маань бидэнд тусалж, ятгалга болон амьдралд маань тохиолдох өөр бусад олон асуудлыг даван гарах хүч тэнхээг хайрлах болно.

Тэнгэр дэх Эцэг маань биднээс евангелийг хүлээн зөвшөөрөхийг хүсчээ. Үүний тулд бид юуны өмнө Исүс Христэд итгэх итгэлтэй байх хэрэгтэй. Дараа нь бид гэм нүглээ наманчлан, усаар батлуулж, Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр батлагдсан байна. Бид ийнхүү батлуулах үедээ зэрэгтний хүч бүхий нэгнээс Ариун Сүнсний бэлгийг хүлээн авдаг. Ариун Сүнс бидэнд Исүсийн биднээр юу хийлгэхийг хүсч байгаа болон мөнхийн амьдралыг хүлээн авахын тулд бид бүх амьдралынхаа туршид түүнийг дуулгавартай дагаж, түүнд үйлчлэх ёстойг хэлж өгдөг.

Бидэнд Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж, хамт амьдрахад маань туслахын тулд Исүс биднээс зарлиг тушаалуудыг дуулгавартай дагахыг шаарддаг. Тэдгээрт ариун явдлын хуулийг сахих, аравтын татварыг төлж, өргөл өгөх, Мэргэн Үгсийг дагах, үргэлж үнэнч шударга байх, мөн Ням гаригийг ариун байлгах зэрэг багтана.

Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болохын тулд бид ариун сүмд хийгддэг *хишиг хэмээх зан үйлүүдийг хүлээн авах ёстой. Тэнд бид гэрлэлтээ батлуулснаар гэр бүлтэйгээ үүрд хамт байх болно. Мөн нас барсан төрөл төрөгсдийнхөө өмнөөс шаардлагатай зан үйлүүдийг ариун сүмд гүйцэтгэхийн тулд тэдэнд хамаарах нэр хаяг, мэдээллийг эрж хайн, тэдгээрийг Сүмд өгөх хэрэгтэй.

Исүс бидэнд олон зүйл хийхийг тушаасан. Үүнд, бусдад евангелийг таниулах, бусдыг хайрлаж, тэдэнд туслах, тэдэнд сайн үлгэр дуурайл үзүүлэх зэрэг орно.

Түүнчлэн бид Тэнгэр дэх Эцэгтээ өгсөн бүх амлалтаа биелүүлж, сүмийн цугларалтад байнга оролцож, судар номыг өдөр тутам судалж, гэр бүлийнхэндээ евангелийг зааж, ганцаар болон гэр бүлийн хамтаар өдөр бүр залбирч байх хэрэгтэй.

Хэрэв бид Исүс Христэд итгэж, түүний бүх тушаалыг дагахыг хичээвэл бид мөнхийн амьдралыг хүлээн авч, Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болно.

Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болох нь шатаар авирахтай адил юм. Бид ёроолоос нь эхлээд оройг нь хүртэл нэг нэг гишгүүрээр авирах ёстой билээ. Хэрэв бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болохыг хүсч байгаа бол бид түүнийг хэрхэн мэдэрч, бодож сэтгэж, ажиллаж буйг мэдэх хэрэгтэй юм гэж Зарлага Жозеф Смит хэлжээ. Бид түүний тухай эдгээр зүйлсийг мэдвэл, түүний талаар бусад бүх зүйлийг мэдэж чадах бөгөөд улмаар хэрхэн түүнтэй адил болохоо ухаарах болно.

Энэ нь бидэнд Тэнгэр дэх Эцэг маань хэзээ нэгэн цагт бидний адилаар газарт амьдарч байсан хүн гэдгийг санахад туслах болно. Тэрээр энэ газар дэлхий дээр бидэнд тулгарч байгаагийн нэгэн адилаар төвөгтэй асуудлуудыг даван туулах замаар бидний Тэнгэр дэх Эцэг болж чадсан юм. Гэхдээ бид хэрэгтэй бүх зүйлсээ энэ

дэлхий дээр сурч мэдэж чадахгүй гэж Зарлага Жозеф Смит хэлжээ. Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болохын тулд мэдэх шаардлагатай бүх зүйлсийг мэдэх нь энэ амьдралын дараа ч гэсэн урт удаан цаг хугацааг шаардах болно.

Бид Тэнгэр дэх Эцгийнхээ бүх зарлиг тушаалыг дагахыг сурсан үед, түүнд эргэн очихдоо бид ямар их баяр баясгалантай байхыг бодогтун. Тэрээр бидний амьдарсан амьдралд баяртай буйгаа хэлж, бид түүнтэй адил болж, түүнтэй хамт мөнхөд хамт амьдрах болно.

Ярилцлага

- Яагаад хүн бүр Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болох боломжтой байдаг вэ?
- Тэнгэр дэх Эцгийнх шигээ амьдралтай байхын тулд бид ямар зүйлсийг хийх ёстой вэ?
- Түүнтэй адил болоход Тэнгэр дэх Эцэг маань бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Тэнгэр дэх Эцэг маань таныг сайшааж, танд хайртай гэдгээ хэлэхийг сонсоход өөрт тань ямар сэтгэгдэл төрөхийг хэлнэ үү.

Лавламж

Хүн Бүр Өөрт нь Бэлтгэгдсэн Газар луу Явах Болно

- Жон 14:2 (Исүс бидэнд Эцгийнхээ гэрт байр бэлтгэсэн буй.)

Биднийг Селестиал Хаант Улсын Мөнхийн Амьдралд Бэлтгэхийн Тулд Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Евангелийг Өгсөн

- Мосайяа 4:26-27 (Мөнхийн амьдралыг өвлөн авахын тулд хийх ёстой зүйлийг маань бидэнд хэлжээ.)
- Алма 34:32-34 (Одоо Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт амьдрахад бэлтгэх цаг боллоо.)

Бид Евангелийг Дагахаар Сонговол Тэнгэр дэх Эцэг Маань Бидэнд Тусална

- Матвей 25:32 (Тэнгэр дэх Эцэг маань итгэлтэй хүмүүсийг олон зүйлийн захирагчдаар томилно.)

ИТГЭЛИЙН ТУНХАГ

1842 оны хавар зарлага Жозеф Смит, *Чикагогийн Ардчилсан Үзэлтэн* сонинны эрхлэгч Жон Уэнтворф гэгч хүнд нэгэн захидал илгээжээ. Уг захидал Сүмийн түүхэн үйл явдлуудтай холбогдох олон баримтыг агуулсан байлаа. Тэрхүү баримт бичигт Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн итгэл бишрэлийг тодорхойлсон арван гурван зүйлийг мөн хавсаргасан байв. Тэдгээр нь Итгэлийн Тунхаг хэмээн нэрлэгдэх болсон бөгөөд доор сийрүүлэв.

Итгэлийн Тунхаг нь Сүмийн албан ёсны сургаал бөгөөд Хожмын Үеийн судруудын нэг хэсэг мэтээр тооцогддог юм. Энэ нь гишүүдэд Сүмийн итгэл бишрэлийн үндсэн зарчмуудыг ойлгож, тэдгээрийг бусдад тайлбарлахад нь тус дөхөм болохуйц, итгэл бишрэлийг тодорхойлсон товчлол юм. Гэвч энэ нь Сүмийн бүхэл бүтэн сургаалын бүрэн эмхэтгэл болж чадахгүй билээ. Амьд сэрүүн зарлагуудын ачаар Сүм маань байнгын үзэгдэл, нөлөөллийн дор удирдагдсаар байна.

1 Бид Бурхан-Мөнхийн Эцэг, түүний Хүү, Исүс Христ болон Ариун Сүнсэнд итгэдэг.

2 Хүмүүс Адамын нүглийн төлөө биш, харин өөрсдийн гэмийн төлөө шийтгэгдэнэ гэдэгт бид итгэдэг.

3 Исүс Христ өөрийгөө золиосолж нүглийг цагаатгаснаар, мөн Евангелийн сургаал, ёс жаягийг сахин мөрдсөнөөр хүн төрөлхтөн аврагдана гэдэгт бид итгэдэг.

4 Евангелийн үндсэн зарчмууд, зан үйлүүд бол: нэгт, Их Эзэн Исүс Христэд итгэх; хоёрт, нүглээ наманчлах; гуравт, нүглээс ангижирч, усан баталгаа хийлгэх; дөрөвт, гар тавьж, Ариун Сүнсний бэлэг өгөх явдал мөн гэдэгт бид итгэдэг.

5 Аливаа хүн Евангелийн сургаалыг номлож, зан үйлийг удирдан явуулахын тулд Бурхан түүнийг сонгож, зөгнөлийн дагуу эрх мэдэл авсан хүмүүс толгой дээр нь гараа тавьж баталсан байх ёстой гэдэгт бид итгэдэг.

6 Бид анхны Сүмийн зохион байгуулалтад, тухайлбал, төлөөлөгчид, зарлага, пасторууд, багш, евангелистууд болон бусдад итгэдэг.

7 Хэл сурах, зөгнөн хэлэх, далдыг мэдэх, харах, эмчлэх, аливаа хэлийг тайлбарлах зэрэг авьяас билиг байдаг гэдэгт бид итгэдэг.

8 Библи нь зөв орчуулагдсан учраас Бурхны үг мөн гэдэгт бид итгэдэг, мөн Мормоны Ном бол Бурхны үг мөн гэдэгт бид итгэдэг.

9 Бурхны нээсэн, одоо ч нээж байгаа бүх зүйлд бид итгэдэг, мөн Бурхны хаант улсад хамаарах аугаа их, чухал олон зүйлийг Тэрбээр нээнэ гэдэгт бас итгэдэг.

10 Израиль жинхэнэ ёсоор нэгдэж, Арван Омог нь дахин сэргэж, мөн Сион (Шинэ Иерусалим) Америк тивд буй болж, Христ газар дэлхийд өөрийн биеэр эзэгнэн сууж, газар дэлхий шинэчлэгдэн диваажин болон цэцэглэнэ гэдэгт бид итгэдэг.

11 Бид өөрсдийн сүсэг бишрэлийн дагуу бүхнээс хүчит Бурхнаа хүндэтгэн дээдлэх эрхтэйгээ тунхаглаж байгаа бөгөөд бусад хүмүүс ч гэсэн хэнийг, хаана, яаж бишрэн шүтэх нь тэдний эрх гэж үзнэ.

12 Бид хаан, ерөнхийлөгч, төр засгийн удирдагчид, албан хаагчдад захирагдаж, хуулийг хүндэтгэн дээдэлж, дагаж мөрдөх ёстой гэдэгт итгэдэг.

13 Бид үнэнч шударга, ариун, сайныг эрхэмлэгч, сахилга баттай байж, хүн болгоны төлөө сайн үйл бүтээх ёстой гэдэгт итгэдэг. Чухамдаа “бид бүх зүйлд итгэдэг, бүх зүйлд найддаг, бид олон бэрхшээлийг давж туулсан бөгөөд бүгдийг даван туулж чадна гэж найдаж байна. Хэрэв ямар нэгэн ач тустай, сайн сайхан, хүндэтгэн бахархууштай тийм зүйл байдаг бол бид түүнд тэмүүлж байдаг” гэсэн номлогч Паулийн гэрээслэлийг бид дагадаг гэж хэлж болно.

Жозеф Смит

БСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

